



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Дэд хурандаа Д.Идэшноров ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D), дэд профессор

Редакцийн гишүүд:

Дэд хурандаа Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор
Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор
Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Техник редакцийн гишүүд:

Д.Энх-Од Редактор
М.Даваасүрэн Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас/факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: tsats@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн ЭШИХ-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief:

Colonel Ulziikhuyag.B Deputy Director for Research and cooperation, MNDU, Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief:

Lieutenant Colonel Ideshnorov.D Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D

Editorial Panel:

Lieutenant Colonel Odmaa.L Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D

Baatarsuren.B Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D

Orkhonchimeg.Kh Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

Technical Editor:

Enkh-Od.D Technical editor
Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ
БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2024

№ 29/52/

СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

Санхүүгийн аюулгүй байдал, түүнийг хангах хэрэгцээ шаардлага	6
Үндэсний аюулгүй байдлыг хангах болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үндсэн зарчмууд, тэдгээрийн харилцан нөлөөлөл	11
Энхийг дэмжих ажиллагаанд дахь Монгол цэргийн албан хаагчдын оролцоо: зарим үр дүн, дүгнэлт	16
ОХУ–ын хүүхэд залуучуудад эх оронч төлөвшил олгож буй байдал	22
БНХАУ–ын батлан хамгаалахын шинэчлэл	26
Үндэсний хэв шинж, түүний бүрдэл	34
Ашигт малтмалын эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөө	40
Онцгой нөхцөл байдал үүссэн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажиллагаа	44
Мэдээлэл сэтгэл зүйн дайн	47

Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт

Цэргийн хөгжмийн политехник коллежийн элсэлтийн чанарыг сайжруулах арга зам	53
ОХУ–ын ВА РХБЗ академийн сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын ҮБХИС–ЦНДС–ийн Цацраг хими биологийн хамгаалалт, хангалт хөтөлбөртэй харьцуулсан судалгаа	58

Судалгаа боловсруулалтын ажил

Цэргийн алба хаагчдын амиа хорлолтод нөлөөлөх хүчин зүйлс ба урьдчилан сэргийлэх арга замууд: олон улсын судалгааны үр дүн	61
Ялгаварлан гадуурхалтаас эмэгтэйчүүдийг сэргийлэх арга зам	67
Байг мэргэн онох бодлогод физик математикийн тулгуур ойлголтууд болон экстремаль бодлогын онолыг хэрэглэх нь	74
Монгол Улсын төрийн бодлогын шийдвэр гаргалтад тинк танк байгууллагын үйл ажиллагаа нөлөөлөх нь	78
Удирдах ажилтны манлайллын онолын судалгаа	85

Цэргийн зэвсэглэл, техник, инновац судлал

Мотобуудлагын бригадын артиллерийн сум зарцуулалт, целийн хүлээгдэж буй хөнөөлийн зэргийг тооцох аргачлал	92
Артиллерийн дивизионы байлдаанд нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах боломж	96
Хамгаалалтын IP, MIL–STD810– стандартууд	104
Зэвсэгт тэмцлийн үйл ажиллагаа ба радио электроникийн технологи	109
Сониrhoгчийн радио хүлээн авагч угсарч турших нь	118
Дотоод баллистик	122

Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж

Уулын Карабахын районд явагдсан байлдааны туршлага, сургамж	126
---	-----

САНХҮҮГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Б.ЮМААЖАВ /Дотоод хэргийн их сургуулийн ахлах багш, ахлах дэслэгч, докторант/

Түлхүүр үг: Үндэсний аюулгүй байдал, санхүүгийн аюулгүй байдал, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлт.

Key words: National Security, Financial security, Green development, Climate change

Дэлхий дахинаа уур амьсгалын өөрчлөлт, улс төрийн хурцадмал байдал, улс орнуудын хоорондын харилцаа хурдацтай өөрчлөгдөж энэ нь улс үндэсний ашиг сонирхлоо тууштай хамгаалах, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататгах, эдийн засгийн дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэхийг зүй ёсоор шаардах болсон. Ийм үед улс орон бүр дотооддоо санхүүгийн аюулгүй байдлаа хангаж, аливаа улсаас хараат бус үйлдвэрлэл үйлчилгээг явуулах, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах чадвартай байх шаардлагатай.

Үндэсний аюулгүй байдлыг хангах нэг чиглэл нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдал байдаг бол сүүлийн үед санхүүгийн аюулгүй байдлын судалгаа, санхүүгийн аюулгүй байдлыг хангах арга зүй, хэлбэрийн шинэчлэл тогтмол явагдаж судалгааны шинэ чиглэл бий болж байгаа билээ.

Өнөөгийн практикт санхүүгийн аюулгүй байдлын эрсдэлийн онол, арга зүйн судалгаа манайд хөгжөөгүй байгаа, хувь хүний, байгууллагын, төрийн санхүүгийн эрсдэлд үнэлгээ дүгнэлт хийдэггүй шинжлэх ухаанч бус байдлаар хандаж буй байдал нь хүний амьдралын чанарыг алдагдуулах, байгууллагыг дампууралд хүргэх, төрийн санхүүгийн аюулгүй байдал алдагдах үндэс болж байна. Иймд: эдийн засгийн аюулгүй байдалд санхүүгийн аюулгүй байдал чухал байр суурь эзлэх болсонтой; аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаагаа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон хөгжилд чиглүүлж, санхүүгийн асуудлаа төлөвлөх шаардлагатай болсонтой; санхүүгийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн бууруулах онол, арга зүй хөгжиж байгаатай; олон улсын хэмжээнд төр, аж ахуйн ямар ч байгууллага аж ахуйн нэгж эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ,

дүгнэлтгүй, эрсдэлийн удирдлагагүй явагдахаа больж буйтай; аюул, түүнээс учруулах хохирлыг бууруулж, тогтвортой хөгжлийг хангахад НҮБ анхаарлаа хандуулж байгаатай холбоотойгоор энэхүү сэдвийг судлах шаардлага тулгарч байна.

Иймд эдгээр асуудалд шинжлэх ухаанч хандаж эдийн засгийн аюулгүй байдлын бүрэлдэхүүнд төсөв, санхүүгийн байгууллагын аюулгүй байдлаас гадна илүү өргөн хүрээнд санхүүгийн аюулгүй байдлын асуудлыг авч үзэхийг зорилоо.

Санхүүгийн аюулгүй байдлын тухай онол, үзэл баримтлал

Санхүүгийн аюулын томоохон хэлбэр нь санхүүгийн хямрал бөгөөд энэ нь бодит эдийн засгийн хямралд хүргэж, Улс орны эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тул санхүүгийн аюулгүй байдал нь улсын эдийн засагт маш чухал үүрэгтэй. Аж ахуйн нэгжүүд зах зээлийн тогтворгүй байдал, төлбөрийн чадваргүй байдлаас эхлээд үйл ажиллагааны доголдол, улмаар дампуурах зэрэг олон төрлийн эрсдэлд өртдөг. Эдгээр эрсдэлийг үр дүнтэй удирдаж чадахгүй байх нь зөвхөн аж ахуйн нэгжүүдэд төдийгүй улс орны эдийн засагт өргөн хүрээгээр нөлөөлж, макро эдийн засгийн түвшинд нөлөө бүхий сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм¹.

Эдийн засаг нь өргөн хүрээний ойлголт бөгөөд түвшнээр нь микро, макро, мега гэж ангилж үздэг. Микро эдийн засаг нь өрх гэр, худалдан авагчийн зан төлөв, аж ахуйн нэгжүүдийн үйл хөдлөл, зан төлөв, тэдгээрийн харилцан үйлчлэлээр явагддаг зах зээлийн төлөвийг судалдаг бол макро эдийн

¹—<https://www.researchgate.net/publication/379363316>, The_Current_State_and_Challenges_of_Financial_Risk_Managemen



засаг нь улс орны хэмжээний нийт эрэлт, нийт нийлүүлэлт, бодлогын хүү, мөнгөний бодлого, сангийн бодлого, үндэсний тооцооны систем, ажилгүйдэл, ядуурал, инфляц зэрэг асуудлуудыг судалдаг. Харин мега эдийн засаг нь олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын худалдаа, дэлхийн эдийн засгийн төлөв хандлага, дэлхийн худалдаа, эдийн засгийн эрх зүйн зохицуулалтын асуудлуудыг судалдаг. Улс орон бүр өөрийн эдийн засгийн тогтолцоогоо тодорхойлж, түүнд нийцүүлж төрийн эдийн засгийн бодлогоо тогтоож, хэрэгжүүлдэг. Эдийн засгийн тогтолцооны хэлбэрээс хамаарч төрийн эдийн засгийн бодлого, аж ахуйн нэгж, хувь хүний шийдвэрүүд өөр байна.

Гадаадын зарим судлаачид эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн аюулгүй байдлын асуудлыг системийн үүднээс олон талаас нь тайлбарласан.

ОХУ-ын эрдэмтэн Г.Вечканов эдийн засгийн аюулгүй байдалд эдийн засгийн салбаруудын тогтвортой хөгжил, тухайлбал, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, хөрөнгө оруулалтын оновчтой хувилбарууд, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, шинжлэх ухаан технологи, инновацын идэвхтэй байдал, улсын мөнгө, санхүүгийн бодлого, зохицуулалт, экспорт, импортын зохистой харьцаа зэргийг оруулан ойлгож болно гэж үзсэн бол Н.Гловацкая “Эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь хүн амын амьжиргааны хэвийн нөхцөл, үндэсний аж ахуйн нэгжид шаардлагатай нөөц баялгийг тогтвортой хангах болон улс гүрэн, үндэсний ашиг сонирхлыг илтгэгч эдийн засгийн системийн чухал шинж чанар болно” гэж үзжээ. Мөн В.Паньков, В.А.Савлин болон И.Абалкин нар эдийн засгийн аюулгүй байдал нь эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, нийгмийн зорилтыг үр ашигтай бөгөөд амжилттай шийдвэрлэх, эдийн засгийн хараат бус бодлого боловсруулж амьдралд хэрэгжүүлэх төрийн эдийн засгийн тогтолцооны төлөв” байдлыг хэлнэ гэж эдийн засгийн аюулгүй байдлын системийн хэмжээнд авч үзсэн.

В.Бурцев эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад түүний систем болох бүрэлдэхүүн: хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдал, санхүүгийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн салбарын аюулгүй байдал,

тээвэр, харилцаа холбооны аюулгүй байдал, эдийн засгийн нийгмийн хүрээний аюулгүй байдал, гадаад худалдааны салбар дахь аюулгүй байдал зэргийг тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн байдаг.

Эрдэмтэд улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалахад санхүүгийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг тал бүрээс нь тодорхойлжээ.

Санхүүгийн аюулгүй байдлын тухай ойлголт нь нарийн төвөгтэй бөгөөд үйл ажиллагааны гадаад, дотоод орчны сөрөг нөлөөг харгалзан үзэх, улсын хөгжлийн стратегийг үндэслэл болгох, гадаад орчны өөрчлөгдөж буй нөхцөл байдал, санхүүгийн нөөцийг харгалзан үзэх шаардлагатай. Санхүүгийн аюулгүй байдал нь эдийн засгийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олон шалгуур үзүүлэлт бүхий тоон болон чанарын үзүүлэлтүүдийн системээр тодорхойлогддог ба тодорхой түвшинд аж ахуйн нэгжийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах ёстой гэдгийг анхаарах нь чухал.

Судлаачдын бүтээлээс үзэхэд эдийн засгийн энэ ангиллын талаар нэлээд олон янзын тайлбар байдаг бөгөөд энэ нь хэлэлцэж буй асуудлын талаар эрдэмтдийн дунд зөвшилцөлд хүрээгүй байгааг баталж байна. Гэсэн хэдий ч санхүүгийн аюулгүй байдлыг тодорхойлох хоёр үндсэн хандлага байдгийг бид тэмдэглэж болно.

Зарим эрдэмтэд санхүүгийн аюулгүй байдлыг тодорхойлохдоо менежментийн объект болох аж ахуйн нэгжийн зорилгодоо хүрэх асуудалд суурилдаг. Энэ тохиолдолд санхүүгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын мөн чанар, санхүүгийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны үүрэг нь аж ахуйн нэгжийн үр дүнтэй ажиллах чадвар, зах зээл дээрх өрсөлдөх чадварын өсөлтийг хангах явдал юм. Энэхүү хандлагыг дэмжигчид санхүүгийн аюулгүй байдлын шалгуурыг аж ахуйн нэгжийн зорилгодоо хүрэх гэж тодорхойлдог.

Өөр нэг хэсэг эрдэмтэд аж ахуйн нэгжийн санхүүгийн аюулгүй байдлын тухай ойлголтыг судлахдаа түүний дотоод болон гадаад аюул заналыг эсэргүүцэх чадварт анхаарлаа хандуулдаг.

Судлаачид санхүүгийн аюулгүй байдал нь аж ахуйн нэгжийн бүх бүтцийн элементүүдийг



аюулаас хамгаалах явдал гэж хүлээн зөвшөөрдөг.

Хориачева судалгаандаа аж ахуйн нэгжийн санхүүгийн аюулгүй байдлын ангиллын талаар дараах тодорхойлолтыг санал болгосон байна. "Санхүүгийн аюулгүй байдал нь санхүүгийн хэрэгсэл, технологи, үйлчилгээний тэнцвэрт байдал, чанар, аюул заналыг тэсвэрлэх чадвараар тодорхойлогддог. Санхүүгийн аюулгүй байдал нь аж ахуйн нэгжийн санхүүгийн тогтолцоо нь өөрийн санхүүгийн ашиг сонирхол, эрхэм зорилго, даалгаврыг хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэрээр хангах, түүнчлэн энэхүү санхүүгийн системийн үр дүнтэй, тогтвортой хөгжлийг хангах чадвар" гэжээ.

Лаврова "Аж ахуйн нэгжийн санхүүгийн аюулгүй байдал нь аж ахуйн нэгжийн хөгжлийн санхүүгийн чухал хэсгүүдийн тогтвортой байдлыг хангадаг систем бөгөөд түүний санхүүгийн ашиг сонирхлын аюулгүй байдлыг эдийн засгийн агентуудын санхүүгийн ашиг сонирхолтой тэнцвэржүүлдэг" гэж тодорхойлжээ.

Судлаач Jia Dia өөрийн бүтээлдээ хүлэмжийн хийг бууруулахтай холбоотойгоор байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 93 аж ахуйн нэгжийн санхүүгийн эрсдэлд шинжилгээ хийсэн. Судалгаагаар аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эрсдэлийн түвшин өөр өөр байсан ба санхүүгийн эрсдэлд аж ахуйн нэгжийн ашигтай ажиллагаа, төлбөрийн чадвар илүү нөлөөлдөг байгааг тогтоосон байна.²

Shijie He, Xiaoyu Yang нарын судлаачид цахилгаан бараа үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эрсдэлийн шинжилгээг хөрөнгө, өр төлбөрийн харьцаа, ашгийн харьцаа, эргэцийн харьцаа, хөрөнгийн эргэц зэрэг үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан хийсэн ба санхүүгийн тогтвортой байдал нөлөөлж болзошгүй зах зээлийн дарамт, өрийн удирдлага, инновацийн асуудлуудыг сайжруулах нь зүйтэй талаар санал дэвшүүлсэн.³


² Jia Dia. Financial risk assessment of environmental protection enterprises under the background of carbon peak and carbon neutrality. //Academic journal of Business&Management/Journal/.-UK., 2024., т.282

³ Shijie He, Xiaoyu Yang. Financial risk assessment analysis and countermeasures of household appliance manufacturing

Кудрицагийн хэлснээр аж ахуйн нэгжийн санхүүгийн аюулгүй байдлыг "тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлж болох ба дотоод сөрөг нөлөөнд тэсвэртэй байдлаар тодорхойлогддог тусдаа эдийн засгийн систем ба түүний элементүүд болон дэд системийн тэнцвэртэй байдал" гэж тодорхойлсон. Гадаад орчин, түүний үр дүнтэй үйл ажиллагаа, хөгжлийн тогтвортой байдал, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах чадамж" хэмээн тайлбарласан байдаг. Тэрээр судалгаандаа санхүүгийн аюулгүй байдлыг тусдаа систем гэж үзэж санхүүгийн аюулгүй байдал нь бүхэлдээ санхүүгийн системийн шинж чанар хэмээн тодорхойлсон.

Н.Давыденкогийн хэлснээр, корпорацуудын санхүүгийн аюулгүй байдлыг гурван түвшинд хангах ёстой: нэгдүгээрт, санхүүгийн эх үүсвэрийг татах; хоёрдугаарт, тэдгээрийг үйлдвэрлэлийн процесст үр дүнтэй ашиглах; гуравдугаарт, орлого, ашгийн хуваарилалтаас үүдэлтэй ногдол ашгийн үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх зэрэг болно.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны зүй тогтол болон дээрх эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнг харьцуулан судалсны дүнд судлаачдын зүгээс системийн хандлагаар авч үзвэл эдийн засгийн аюулгүй байдал нь өөрөө үндэсний аюулгүй байдлын системийн нэг дэд систем ба өөртөө санхүүгийн аюулгүй байдал гэсэн дэд системийг агуулж байгаа бөгөөд санхүүгийн аюулгүй байдал нь өөрөө уялдаа холбоо бүхий хэд хэдэн дэд системүүдээс бүрдсэн цогц систем болохыг 1 дүгээр зурагт дүрслэв.



1 дүгээр зураг. Санхүүгийн аюулгүй байдлын дэд enterprises. //Frontiers in business, economics and management /e-book/.-USA., 2023.,т.283



СИСТЕМҮҮД

Санхүүгийн аюулгүй байдал нь төрийн санхүүгийн аюулгүй байдал, хүний санхүүгийн аюулгүй байдал, аж ахуйн нэгжийн аюулгүй байдал, банкны салбарын аюулгүй байдал, даатгалын салбарын аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын дэд системүүдээс бүрдэж байгааг зургаар харуулав.

Улс орны хэмжээнд татварын орчны аюулгүй байдал маш чухал. Зурагт татварын орчны аюулгүй байдал төр, хүн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын орчин, банк, даатгал гээд бүхий л дэд системүүдэд нөлөө бүхий дэд систем болохыг дүрслэв.

Татвар нь улсын төсвийг бүрдүүлэгч үндсэн эх үүсвэр боловч татварын төрөл тус бүр өөр өөрийн зорилго, чиг үүрэгтэй ба татварын хувь хэмжээг тогтоох асуудал нь эдийн засгийн зохицуулалттай салшгүй холбоотой явагддаг. Иймд татвар нь тусдаа дэд систем байж төсвийн болон эдийн засгийн аюулгүй байдал чухал үүрэг гүйцэтгэдэг.

Иймд санхүү, төсвийн бодлогын үр нөлөөг дээшлүүлж, эдийн засгийн бүтцийн оновчтой, үр ашигтай тогтолцоо бүрдүүлж, хүчин чадлыг зүй зохистой ашиглах замаар эдийн засгийн аюулгүй байдлыг хангана. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь олон талт асуудлыг хамарсан цогц ажиллагаанаас бүрдэх ба түүнийг шуурхай, тасралтгүй, цаг үеэ олж оновчтой явуулж чадсанаар гадаад, дотоод орчинд болж буй өөрчлөлтүүдэд зөв хариу үйлдэл үзүүлж, аюул заналыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжтой болох юм.

Аливаа улс санхүүгийн аюулгүй байдлаа хангахын тулд нэмүү өртөг бий болгож чадах салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, санхүүгийн хувьд бэхжүүлэх шаардлагатай. Харин аж ахуйн нэгжүүд өөрсдийн санхүүгийн аюулгүй байдлаа хангахын тулд дотоод орчны сул тал, эрсдэлээ тодорхойлох, түүнээс хамгаалах, зайлсхийх, багасгах бодлого боловсруулж ажиллах шаардлагатай.

Дүгнэлт

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцааны нөхцөл байдал нь улс

орныг санхүүгийн хувьд санхүүгийн чадавхаа сайжруулж, санхүүгийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөтэй байхыг шаардаж байна. Иймд бид санхүүгийн аюулгүй байдлын онол, үзэл баримтлалд тулгуурлан санхүүгийн аюулгүй байдлыг системийн хувьд авч үзэх, санхүүгийн аюулгүй байдал нь систем учраас дотоод, гадаад орчны сөрөг нөлөөг судалж, үнэлэх асуудлын хэрэгцээ шаардлага үүссэн. Санхүүгийн аюулгүй байдлыг хангахад эрдэс баялаг, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлэн гэж заасан нь хэт ерөнхий төдийгүй, шалгуур үзүүлэлтгүй зэрэг олон дутагдалтай тал ажиглагдлаа.

Манай Улсын санхүүгийн аюулгүй байдал алдагдаж санхүүгийн хямралд өртөх давтамж нэмэгдэх болсон. Тухайлбал, Улсын валютын нөөц 2 дахин буурсан, улсын өрөө төлж чадахгүй байна, төсвийн найдвартай орлогын эх үүсвэрээ алдаж болохгүй гэх тайлбарыг үе үеийн сангийн сайд нар хийх болсон нь үүний баталгаа юм.

Мөн төр дотоодын нийт бүтээгдэхүүний 38 хувьтай тэнцэх хэмжээний зардалтай байгаагаас төр ихэнх зах зээлд бизнес эрхэлж байгааг илтгэж байгаа төдийгүй манай Улс зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байна. Энэ мэт асуудлаас эдийн засгийн аюулгүй байдлын талаар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга замд өөрчлөлт оруулах, шинэчлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Санхүүгийн аюулгүй байдал хангагдах нь улс орны санхүүгийн бие даасан байдал, чадавхыг дээшлүүлэх, өрийн хараат байдлаас зайлсхийх ба ингэснээр эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

Улс орны хувьд санхүүгийн аюулгүй байдлыг хүний, төрийн, байгууллагын түвшинд авч үзэж, тэдгээрт тохирох шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох нь чухал байна. Өөрөөр хэлбэл, ямар түвшинд хүрсэн үед аюулд өртсөн гэж үзэх вэ? гэдэг маш чухал. Улсын өрийн хувьд тааз тогтоож байгаатай адил хүний, байгууллагын санхүүгийн аюулгүй байдлыг ямар үед алдагдсан гэж үнэлэх вэ? гэсэн асуудал шийдлээ хүлээсээр байна.



Ашигласан материал:

1. <https://www.researchgate.net/publication/379363316>,The_Current_State_and_Challenges_of_Financial_Risk_Manag
2. Jia Dia. Financial risk assessment of environmental protection enterprises under the background of carbon peak and carbon neutrality.–//Academic journal of Business&Management/Journal/.–UK., 2024., т.282
3. Shijie He, Xiaoyu Yang. Financial risk assessment analysis and countermeasures of household appliance manufacturing enterprises.–//Frontiers in business, economics and management /e-book/.–USA., 2023.,т.283
4. Nadiia D., Natalia W., Titenko Z., Mirosław W., Substantiation of the Risk Neutralization Mechanizm in the Financial Security Management of Agricultural Enterprises. Sustainability, p–18
5. Iryna Kalina, Viktoriia Khurdei, Vira Shevchuk, Tetiana Vlasiuk, Ihor Leonidov., Introduction of a Corporate Security Risk Management System: The Experience of Poland., Risk and Financial Management, 2022
6. О.Власюк., DOI10.55643/fcapt.6.53.2023.4162
7. Nadiia Davydenko., Natalia Wasilewska., Zoya Titenko., Mirosław Wasilewski. Substantiation of the risk neutralization mechanism in the financial security management of agricultural enterprises.–//Sustainability / Journal/–Switzerland., 2024., т.
8. Zenovii Mykhialo Zadorozhnyy, Svitlana Zhukevych, Tetiana Portovaras, Victoria Rozelyuk, Natalia Zhuk, Iryna Nazarova. Analysis of risks in the financial security management system of business entities.–//Финансово–Кредитная деятельность: проблемы теорий и практики /Академик сэтгүүл/.–АНУ., 2023., т.82
9. Barbara G,Dorota K. Sustainable Metrics in Project Financial Risk Management[J]. Sustainability,2022,14(21).



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОЛОН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРИЛЦАН НӨЛӨӨЛӨЛ

Ж.ЦЭСЭН /УБХИС-ийн Эрдмийн сургуулийн докторант/

Удирдагч **Б.ӨЛЗИЙХУЯГ** /УБХИС-ийн дэд захирал, доктор (Sc.D), профессор, хурандаа/

Түлхүүр үг: Хэвлэл мэдээлэл, аюулгүй байдал, зарчим, харилцан хамаарал

Key words: Public media, national security, principle, interdependence

Оршил

Энэхүү өгүүлэлд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн ойлголтууд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үндсэн зарчмуудын харилцан хамаарлын асуудлыг шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлалын хүрээнд судлан тогтоов. Аюулгүй байдлыг хангах аливаа үйл ажиллагаанд баримтлах философи агуулгатай үнэн бодитой байх, шуурхай хүртээмжтэй байх, ил тод, олон ургалч шинжтэй байх, даяаршлын хүчин зүйлийг харгалзах гэсэн дөрвөн үндсэн зарчмын үндэслэлийг тодорхойлов.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хэд хэдэн зарчмыг томъёолж баталгаажуулсан нь түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн юм. Гэвч эдгээр зарчмуудыг салбарын онцлогоос хамаарч хэрхэн хэрэгжүүлэх, хөгжүүлэх талаарх арга зүйн асуудлыг судлан боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үндсэн хэсэг

Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.¹

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг удирдах болон практик үйл ажиллагаа явуулахад хамгийн чухал ойлголт бол зарчим юм. ОНМХ-ийн үндсэн чиглэл, шинж чанар, үйл ажиллагааны үр дүн нь зарчмыг онолын хувьд зөв шийдвэрлэж, системтэй бөгөөд нарийн дэс дараалалтай, бүтээлчээр хэрэглэхээс шууд шалтгаалдаг.

Зарчим бол онолын хийсвэр ойлголт биш,

¹ 'Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал' УБ., 2010. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/.

харин юмс үзэгдэл, ухагдахууны мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлон тогтоохын үндэс болдог. Философийн толь бичигт: “Зарчим нь удирдлага болгох санаа, дагаж мөрдөх үндсэн дүрэм, эх үндэс юм. Логик утгаар нь авч үзвэл зарчим нь тэр салбарын бүх үзэгдэлд ямар нэгэн үндэслэлийг дэлгэрүүлсэн, дүгнэсэн системийн гол ойлголт юм”² гэжээ. Иймд зарчим нь аливаа үйл ажиллагааны эхлэлийг заахгүй, харин төгсгөлийн үр дүнтэй холбогдож байдаг бөгөөд шинжлэх ухаан, нийгэм хөгжихийн хэрээр байнга боловсронгуй болон өөрчлөгдөж байдаг.

Нэвтэрхий толь бичигт болон судлаачдын бүтээлд энэ ойлголтыг гол төлөв “зарчим” гэдэг үгийн уг гаралд тулгуурлан тайлбарласан бөгөөд янз бүрийн тодорхойлолт өгч “баримт, ойлголт, категори, үзэл санаа, хууль, концепц, онол” зэрэг ойлголттой адилтган үзсэн байдаг. Сэтгүүл зүйн нэрт онолч Е.П.Прохоров “өөрийнхөө үүргийг биелүүлэх явцад баримталж буй мэдээллийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм журам, хэм хэмжээ бол сэтгүүл зүйн зарчим мөн”³ гэсэн ерөнхий тодорхойлолт өгчээ. Судлаач А.Ф.Бережной “зарчим бол сэтгүүл зүйн төрөл бүрийн хэв маягийн ялгааг илэрхийлдэг шинж тэмдэг буюу ОНМХ-ийн хөгжил, үйл ажиллагааны хамгийн ерөнхий зүй тогтлуудыг агуулдаг”⁴ гэсэн бол судлаач Л.М.Крутовская “зарчмыг хууль эсвэл зүй тогтлын нэгэн адил утгаар хэрэглэх нь чухал”⁵ гэж үзсэн байна. Дээрх судлаачдын бүтээлээс үзэхэд ихэнх нь зарчим бол объектив шинжтэй бөгөөд түүний цаана объектив зүй тогтлууд агуулагддаг гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Зарчимд шинжлэх ухааны ойлголтын

² Философийн толь. УБ., 1990. х165.

³ Прохоров Е.П. Введение в теорию журналистики. М.2003. с141;

⁴ Бережной А.Ф. Газета, опыт, проблемы. М., 1996. с 30..

⁵ Крутовская Л.М. О содержание понятия "принцип" в теории журналистики //Вестник МГУ. Журналистика. 1989.№2.с.49



үүднээс хандвал түүнд бодит байдлын хамгийн гол шинжүүдийн (хуулиуд) тухай төсөөллүүд, түүнийг танин мэдэхүйн болон практик үйл ажиллагаанд хэрэглэх аргуудын нийлбэр цогц багтдаг. Ингэхлээр зарчим нь **нэгдүгээрт**, тодорхой шинжлэх ухааны ололтыг өөртөө нэгтгэн дүгнэж, түүний үндэс суурь болохуйц өндөр түвшинд боловсруулагдсан мэдлэг **хоёрдугаарт**, практик үйл ажиллагаагаар шалгагдан нотлогдож үр дүнгээ өгсөн суурь мэдлэг **гуравдугаарт**, үйл ажиллагааны үйл явцыг зохион байгуулах, нэгтгэн дүгнэж бүхэл бүтэн үзэл санаа бүрэлдэн бий болоход тустай танин мэдэхүйн онцгой хэлбэр болдог.

Зарчим нь байгаль, түүхийн хууль, зүй тогтолд тохирч буй нөхцөлд ямагт үнэн байдаг бөгөөд шинжлэх ухааны мэдлэг, түүний дүгнэлтэд үндэслэгдэж байдаг онцлогтой. Зарчмын талаарх эрдэмтдийн бүтээл, нийгмийн практик үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зарчим бол шинжлэх ухаан, нийгэм, улс төр, аюулгүй байдал, уран бүтээлийн хүрэн дэх бүх үйл ажиллагааны онол, арга зүйн үндэс мөн гэсэн дүгнэлт хийж болно.

Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль (2001)-ийн 4.1-д үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчимд “улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх; хүний эрх, эрх чөлөөг хамгаалах; хууль дээдлэх; нэгдмэл, харилцан уялдуулан зохицуулагдсан байх; шуурхай, тасралтгүй байх; бодит мэдээлэлд үндэслэх; төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх; үндэсний эв нэгдлийг эрхэмлэх; нээлттэй байх” гэсэн зарчмуудыг авч үзсэн байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)-ын 1.2-д үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмыг “эх оронч үндэсний үзлийг дээдлэх; төр, иргэний хамтын ажиллагаа; аюулгүй байдлын бодлого цогц байх; мэдлэгт суурилах; бодитой хандах; даяаршлын хүчин зүйлийг харгалзах” гэж зааж өгсөн.

Түүнчлэн олон нийтийн радио, телевизийн тухай Монгол Улсын хууль (2005)-ийн 4.1-д олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зарчмын талаар “хараат бус байх, бодит мэдээлэл олж авах, иргэний эрхийг хүндэтгэх, олон ургалч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан,

хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх” гэсэн заалтуудыг оруулж хуульчлан баталгаажуулжээ.

Өнөө үед сэтгүүл зүйн гүйцэтгэж байгаа үүрэг, нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс сэтгүүл зүй буюу

ОНМХ хэд хэдэн үндсэн зарчимтай байх талаар сэтгүүлч, судлаач М.Зулькафиль өөрийн бүтээлдээ тодорхойлжээ.

Үүнд: 1) үнэн бодитой байх зарчим, 2) шуурхай хүртээмжтэй байх зарчим, 3) ил тод, олон ургалч шинжтэй байх зарчим, 4) олон нийтэд байх зарчим, 5) хүнлэг байх зарчим, 6) тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг зарчмууд бөгөөд эдгээр нь онол, практикийн олон асуудалтай салшгүй холбоотой маш өргөн хүрээг хамарсан ойлголт билээ. ОНМХ-ийн зарчим нь тухайн мэдээллийн хэрэгслийн онцлог шинж, нийгмийн хөгжлийн тухайн үе шатны онцлогоос хамааран тооны хувьд янз бүр байж болох боловч түүний агуулга нь бүх мэдээллийн хэрэгсэлд адил тэгш үйлчлэх бөгөөд сэтгүүл зүйн үүрэг зорилго, гадаад дотоодын хүчин зүйлүүдээс шалтгаалан улам бүр баяжин гүнзгийрэхийг үгүйсгэх аргагүй юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим болон дээр дурдсан сэтгүүл зүй буюу ОНМХ-ийн зарчмуудыг

1.1 дүгээр хүснэгтэд харьцуулан авч үзэв.

Сэтгүүл зүй буюу ОНМХ-ийн зарчмуудын мөн чанар, агуулгыг аюулгүй байдал ба үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар баяжуулж, тэдгээрийн харилцан нөлөөлөл, хамаарлын талаар шинжлэн судлав.

1. Үнэн бодитой байх зарчим

Энэхүү зарчим сэтгүүл зүйн зарчмуудын дотроос нэлээд сайн судлагдсан бөгөөд олон түмнийг үнэн бодитой мэдээллээр хангахад чиглэгдэнэ. Аливаа үзэгдэл, юмсын мөн чанарыг тодорхой, бүрэн гүйцэд харуулахын тулд амьдралаар шалгагдсан бодит баримтад түшиглэх нь зарчмын ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд ОНМХ-ийн тогтолцоо өөрчлөгдөж, мэдээллийн хэрэгслүүдийн шинэ хэв маяг бий болсон нь сэтгүүл зүйн зарчмуудыг, түүний дотор үнэн бодитой байх зарчмыг зөрчихөд хүргэж байна. Тухайлбал, баримтыг нягтлан шалгахгүй өнгөцхөн хандах, дутуу цуглуулах, судалгааны аргыг буруу хэрэглэх, тухайн үеийн нөхцөл байдалд үл нийцэх том дүгнэлт хийх, дам яриа цуурхлын дагуу материал бичих, бусдад хувийн үзэл бодлоо тулгах зэрэг



дутагдал нэлээд түгээмэл байна.

1 дүгээр хүснэгт
Үндэсний аюулгүй байдлыг хангах ба ОНМХ-ийн зарчмын харьцуулалт

Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль (2001)	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)	Орчин үеийн сэтгүүл зүйн зарчим (М.Зулькафил 2007)
1. улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх; 2. хүний эрх, эрх чөлөөг хамгаалах; 3. хууль дээдлэх; 4. нэгдмэл, харил-цан уялдуулан зохицуулагдсан байх; 5. шуурхай, тасралтгүй байх; 6. бодит мэдээлэл үндэслэх; 7. төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх; 8. үндэсний эв нэгдлийг эрхэмлэх; 9. нээлттэй байх.	1. эх оронч үндэсний үзлийг дээдлэх; 2. төр, иргэний хамтын ажиллагаа; 3. аюулгүй байдлын бодлого цогц байх; 4. мэдлэгт суурилах; 5. бодитой хандах; 6. даяаршлын хүчин зүйлийг харгалзах.	1) үнэн бодитой байх 2) шуурхай хүртээмжтэй байх 3) ил тод, олон ургалч шинжтэй байх 4) олон нийтэч байх 5) хүнлэг байх 6) тэнцвэрт байдлыг хадгалах

ОНМХ-ийн нэр хүндийг бууруулсан, мэдээллийн үнэн бодитой байх зарчмыг зөрчсөн тохиолдлууд ардчиллын анхны жилүүдэд цөөнгүй гарч байсныг уншигч, үзэгч олны дунд явуулсан судалгааны үр дүнгүүд нотолж байдаг. Энэ нь тухайн мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн нэр хүнд болон үзэгчдийн тоог бууруулахад нөлөөлөх хүчин зүйл бөгөөд сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар, боловсрол, нийгмийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээтэй шууд холбоотой юм. Сэтгүүл зүйн үнэн бодитой байх зарчмаас бусад бүх зарчим нь шууд шалтгаална. Мэдээлэл үнэн биш бол түүнийг хэчнээн шуурхай, хүртээмжтэй мэдээлсэн ч ямар үр дүнд хүрэхгүй.

ОНМХ-ийн энэхүү гол зарчим нь мэдээлэл үнэн бодитой, үндэслэл сайтай байхыг хатуу номлодог бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудтай харьцуулан үзэхэд мэдлэгт суурилах; бодитой хандах гэсэн хоёр зарчмын агуулгатай нийцэж байна.

Эдгээр зарчмын агуулгыг задлан үзвэл “аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна (мэдлэгт суурилах зарчим); болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна (бодитой хандах зарчим); аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүд харилцан

уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна (аюулгүй байдлын бодлого цогц байх)” гэсэн нь ОНМХ-ийн “үнэн бодитой байх” гол зарчмын үзэл санааг шингээсэн байна. Тодруулбал, “үнэн бодитой байх” зарчмыг аюулгүй байдал ба үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх ойлголтоор баяжуулан тодорхойлох (1.1 дүгээр зураг) боломжтой гэж үзэв.



1.1. дүгээр зураг. Үнэн бодитой байх зарчмын агуулга

Энэ зарчмыг хэрэгжүүлэхэд сэтгүүлчийн аюулгүй байдал, болзошгүй аюул, онцгой нөхцөл байдлын тухай ойлголт, мэргэжлийн ур чадвар, ёс суртахууны төлөвшил ихэд нөлөөлөх ба бодит байдлын юмс үзэгдлийг хөгжлийн дотоод хуулийн дагуу задлан шинжлэх чадвартай, мэдээллийн нийгмийн зүй тогтлыг сайн ойлгож гэмээ нь олон түмнийг үнэн бодитой мэдээллээр хангах болно.

2. Шуурхай, хүртээмжтэй байх зарчим

Мэдээллийн нийгэмд мэдээллийг анх тарааж, олон түмэнд түгээж байгаа субъект нийгмийн харилцаанд давуу эрхтэй байдаг. Энэ зарчим нь нэгэнт сэтгүүл зүйн үйл ажиллагааны арга зүйн үндэс болохоор шуурхай байх явдал сэтгүүлчийн үйл ажиллагааны бүх шатанд нэгэн адил хамаарна. Шуурхай байх нь сэтгүүлчийн боловсрол, мэдлэгийн ур чадвар, мэдээллийн хэрэгслийн шинж чанар, мэдээллийн багтамж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Дэлхийн улс орнууд мэдээллийн багтаамжийг аль болох багасгах, өгч байгаа мэдээллийн сэдэв, газар зүйн хүрээг өргөтгөх, идэвхтэй болон хүртээмжтэй байдлыг чухалчлах болсон.

Мэдээллийн хүртээмжтэй байх эсэхээс түүний үр нөлөө, өгөөж нь шууд шалтгаална. Хүртээмжтэй байх гэдэг бол нэг талаас, тухайн мэдээлэл нэгэн зэрэг олон хүнийг хамрах боломжтой нөгөө талаас, ямар ч хүн унших, үзэх, сонсоход ойлгомжтой байхыг хэлнэ.



ОНМХ–ээр дамжуулж буй аливаа мэдээлэл нь энгийн ойлгомжтой, товч тодорхой байх нь цаг үеийн чухал шаардлага болж байна.

Ийнхүү ОНМХ–ийн шуурхай, хүртээмжтэй байх зарчим нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төр, иргэний хамтын ажиллагааны зарчмын гол санааг агуулж байгаа тул “иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарах” гэсэн тодорхойлолтоор баяжуулж тодотгох (1.2 дугаар зураг) боломжтой юм.



1.2 дугаар зураг. Шуурхай, хүртээмжтэй байх зарчмын агуулга \

Онцгой нөхцөлийн үед энэ зарчмын дагуу ОНМХ зарлан мэдээлэх үйл ажиллагаагаа шуурхай, олон түмэнд хүртээмжтэй зохион байгуулбал төр аюулгүй байдлыг хангах анхдагч үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ ард иргэд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд цаг алдалгүй хувь нэмрээ оруулж, авран туслах ажил бодит үр дүнгээ өгөх болно.

3. Ил тод, олон ургалч шинжтэй байх зарчим

Нийгэм өөрийнхөө бүх үйл ажиллагааг ардчилах, ил тод байлгах үйл явц эрчимтэй өрнөж, хэвлэл мэдээлэл нь бие даасан нийгмийн институт буюу дөрөв дэх засаглалын үүрэг гүйцэтгэх болсон. ОНМХ нь үйл ажиллагаандаа ил тод байдлыг чанд баримтлах замаар нийгмийг ардчилах үйл явцад нөлөөлдөг бөгөөд ил тод байдал олон ургалч үзэлтэй салшгүй холбоотой юм.

Ардчилсан нийгэмд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр, нам, улс төрийн бүлэглэлд харьяалагдан үйлчлэхэд бус харин нийт иргэний хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хангахад үйлчлэх ёстой гэж үздэг⁶.

⁶ Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг. УБ..2021.т.759.

Өрнөдийн судлаачид ОНМХ–ийн гол үүрэгт олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх асуудлыг оруулдаг. Аливаа нэг асуудалд олон янзын үзэл онолоор хандаж, жинхэнэ үнэнийг олох, түүний утга учрыг бүрэн тайлах, шалтгаан үр дагаврын талаар тодорхой төсөөлөл бий болгодог. Тухайлбал, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эх оронч үндэсний үзлийг дээдлэх зарчмыг нэрлэж болно.

ОНМХ–ийн ил тод, олон ургалч шинжтэй байх зарчимд иргэдийн үндэсний үнэт зүйлээрээ бахархах сэтгэл болон эх оронч үндэсний үзэл, улс үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа багтана. Энэ утгаараа үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болдог (1.3 дугаар зураг).



1.3 дугаар зураг. Ил тод, олон ургалч шинжтэй байх зарчмын агуулга

Ийнхүү ил тод, олон ургалч үзлийг нийгмийн амьдралд нэвтрүүлснээр монголын иргэд, залуу үе үндэсний үнэт зүйлээ танин мэдэх, эх оронч үндэсний үзлээ сэргээх, улс орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзэх зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явагданав. Энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж, цаг хугацааны явцад тодорхой үр дүн өгөх болно.

4. Тэнцвэрт байдлыг хадгалах зарчим

Сүүлийн жилүүдэд Өрнөдийн болон Оросын сэтгүүл зүйд энэ зарчмын тухай олонтоо ярих болсон. Олон намын тогтолцоо бүхий ардчилсан нийгэмд ОНМХ асуудлын нэг талыг барьж туйлшрах, хэт дөвийлгөх, адил тэгш хандахгүй байх нь иргэдийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлдэг. Мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудал сэтгүүл зүйд чухал ач холбогдолтой. Мэдээлэл хүлээн авах, сонголт хийх боломж нь эрс нэмэгдсэн өнөө үед даяаршлын хүчин зүйлийг ч харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай билээ.



ОНМХ–ийн мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах зарчим нь нэг улсын зөвхөн дотоод асуудал төдийгүй дэлхий улс орнуудын дунд эзлэх байр суурь, тэднээс хамаарах хамаарлын эерэг ба сөрөг талыг тооцоход хүргэж байна. Ийм учир ОНМХ–ийн тэнцвэрт байдлыг хадгалах зарчмын агуулгыг ҮАБ–ыг хангах үйл ажиллагааны даяаршлын хүчин зүйлийг харгалзах зарчмаар өргөтгөн нэгтгэж хэрэглэх нь зүйтэй байна.

Даяаршил нь улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэстний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгохын зэрэгцээ тухайн нэг улсын зөвхөн дотоод асуудал болох мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах нарийн төвөгтэй үйл явцад хамаарах юм (1.4 дүгээр зураг).



1.4 дүгээр зураг. Даяаршлын хүчин зүйлийг харгалзах зарчмын агуулга

Энэхүү зарчим нь ил тод, олон ургалч шинжтэй байх зарчимтай шууд холбогдох бөгөөд түүнчлэн дээрх зарчмуудыг бүх төрлийн мэдээллийн хэрэгсэлд адил тэгш үйлчлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг тууштай хэрэгжүүлэх, мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг боломжийг бүрдүүлдэг.

ОНМХ–ийн олон нийтэч байх, хүнлэг байх зарчмуудын агуулга дээрх зарчмуудад шингэж байгаа нөгөө талаас, үндэстний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эдгээр зарчмыг тусгайлан хэрэглэх шаардлагагүй юм.

Үндэстний аюулгүй байдлыг хангах ба ОНМХ–ийн зарчмуудыг харьцуулан судалснаар ОНМХ–ийн зургаан зарчмын гуравд ҮАБ–ыг хангах үйл ажиллагааны агуулгыг багтаан нэгтгэж, ҮАБ–ыг хангах үйл ажиллагааны “даяаршлын хүчин зүйлийг харгалзах” зарчмыг ОНМХ–ийн “тэнцвэрт байдлыг хадгалах зарчим”–аар өргөтгөн ОНМХ–ийн “олон нийтэч байх”, “хүнлэг байх” гэсэн зарчмуудын ач холбогдол судлан буй асуудалд нөлөөлөхгүй гэж үзэв.

Дүгнэлт

“Үндэстний аюулгүй байдлыг хангах болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үндсэн зарчмууд, тэдгээрийн харилцан нөлөөлөл”–ийг судалж үндэстний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудыг сэтгүүл зүй буюу ОНМХ–ийн үндсэн зарчмын мөн чанар, агуулгатай харьцуулснаар тэдгээрийн харилцан нөлөөлөл, хамаарлыг тогтоов. Үүний үр дүнд үндэстний аюулгүй байдлыг хангах аливаа үйл ажиллагаанд баримтлах философи агуулгатай үнэн бодитой байх, шуурхай хүртээмжтэй байх, ил тод, олон ургалч шинжтэй байх, даяаршлын хүчин зүйлийг харгалзах гэсэн үндсэн зарчмуудыг тодорхойлсон болно.

Ашигласан материал:

1. “Монгол Улсын Үндэстний аюулгүй байдлын үзэл баримтлал” УБ., 2010. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. / Legalinfo.mn/
2. Философийн толь. УБ., 1990. х165.
3. Прохоров Е.П. Введение в теорию журналистики. М.2003. с141.
4. Бережной А.Ф. Газета, опыт, проблемы. М., 1996. с 30.
5. Крутовская Л.М. О содержание понятия “принцип” в теории журналистики //Вестник МГУ. Журналистика. 1989.№2.с.49.
6. Зулькафиль М. “Орчин үеийн сэтгүүл зүй”. УБ., 2007. т.110.
7. Прохоров Е.П. Введение в теорию журналистики. М., 1998.с.185.
8. Зулькафиль М. “Сэтгүүлзүйн онолын үндэс”. УБ., 2013. т.73.
9. Хмара Г.И. Печать в системе массовых коммуникаций. Новосибирск.1988.с188
10. Вестник МГУ: Журналистка. М., 1994. 3. с34.



ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНД МОНГОЛЫН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ОРОЛЦОО: ЗАРИМ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Г.ОЮУНТУЯА /УБХИС-АБДС-ОУХНУТ-ийн ахлах багш/
Л.БОЛОРМАА /УБХИС-АБДС-ИМТ-ийн дэд профессор багш/

Түлхүүр үг: НҮБ, Энхийг сахиулах ажиллагаа, монгол цэргийн албан хаагчид, энхийг сахиулагч, эрсдэл, эерэг нөлөө, сөрөг нөлөө

Key words: UN, Peacekeeping operations, Mongolian military personnel, peacekeepers, risks, positive effects, negative effects.

Оршил

Дэлхий нийтийн өмнө улс орнуудын хоорондын зөрчилдөөнүүд зэрэг олон асуудлууд тулгамдаж байна.

Эдгээр олон асуудал зэвсэгт мөргөлдөөнүүдийг эрсдэлт нөхцөл, түвшин бууруулах, болзошгүй аюул заналыг арилгах зайлшгүй шаардлагатай байна. Энхийг сахиулагчид дотоод зөрчилдөөнийг зохицуулах, тухайн орны иргэний хууль эрх зүйг мөрдөж дэмжиж ажиллагааг явуулдаг.

НҮБ-ын энхийг сахиулагчдын үйл ажиллагааны үндсэн зорилго бол аюулгүй байдлын эрхт байдал, хүн амын эрх, эрх чөлөөг сахин хамгаалах, байнгын хоригийг хэрэгжүүлэхдээ тусдаа улс орнуудын геополитикийн болон эдийн засгийн сонирхлуудын хөдөлгөөнийг хэрэгсэл болгодог.

Эдгээрийг бий болгоход НҮБ-ын гишүүн орнуудын зүгээс энхийг сахиулах ажиллагааг дэмжих нь тодорхой үйл явц, улс төрийн тогтвортой байдал, санхүүгийн дэмжлэг шаардагддаг аж.

Монгол Улсад өнгөрсөн зууны –90ээд онд болсон ардчилсан хувьсгалын үр дүнд гадаад болон дотоод улс төрийн бодлого шинэчлэгдэж, олон улсын харилцаа өргөжиж, цаашлаад олон улсын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг оролцуулах тухай шийдвэрийг (1998 онд) гаргасан. Өнгөрсөн үед хуримтлуулсан туршлагаас харахад энэ ажиллагаанд оролцсоноор эерэг үр дүн гарч байгаа хэдий ч энхийг сахиулагчдын нийгмийн харилцаа болон сэтгэл зүйн эрүүл мэнд, зан байдалд өөрчлөлтүүд гарч байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Энэхүү өгүүллийн гол зорилго нь эдгээр үр дүнг тодорхойлж, дүгнэлт бичихэд оршино.

Энхийг сахиулах ажиллагааны талаар
 Энхийг сахиулах ажиллагаа нь бүхэлдээ НҮБ-

ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр НҮБ-ын дүрэмд нийцсэн бусад бүсийн байгууллагууд эсвэл тодорхой улс орнууд түүний удирдлага дор явагдаж буй олон улсын үйл ажиллагаа гэж ойлгогддог.

Гэвч энэхүү үйл ажиллагаанд олон нэмэлт тодорхойлолтууд байна. Тэдгээрийг 4 хэсэгт хуваана:

1) хууль ёсны /юуны түрүүнд, олон улсын хууль эрх зүйн хүрээнд/

2) бүтэц-үүргийн /улс төрийн, гадаад харилцааны, зөрчилдөөний гэх мэт/

3) цэргийн /цэргийн-ажиллагааны, цэргийн-техникийн/

4) Үзэл суртлын¹. Үүнд өөр олон талаас нь авч үзэх эсвэл өөр чиглэлүүдийг энхийг сахиулах ажиллагаанд тэмдэглэсэн байна.

Энэхүү өгүүлэлд 3 дахь хэсгийн тухай бичсэн, түүний дагуу энхийг сахиулах ажиллагаа цэргийн албаны нэг төрөл гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл энхийг дэмжих үйлдлийг гүйцэтгэж буй “цэргийн албан хаагчдын идэвхтэй үйл ажиллагаа юм”.

Энхийг сахиулах ажиллагаанд монголын цэргийн албан хаагчдын оролцоо: зарим шалтгаан, үр дүн. Монгол Улсын цэргийн алба хаагчдын энхийг сахиулах ажиллагаа нь НҮБ-ын дүрэм, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Батлан хамгаалах яамны эрх зүйн актаар тодорхойлогддог. Тодруулбал, 1998 онд батлагдсан “Төрийн цэргийн бодлогын үндэс”-ийн тухай сургаалд Монгол Улс “Энхийг сахиулах хүчний бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх НҮБ-ын үйл ажиллагааг дэмжих” үүргийг тусгажээ.

¹ Николая Баранова. Персональный сайт. Миротворческая деятельность государств и организаций. <https://www.nicbar.ru/politology/study/57-kurs-mezhdunarodnye-konflikty-v-xxi-veke/588-tema-4-mirotvorcheskaya-deyatelnost-gosudarstv-i-organizatsij> (дата обращения: 22.09.2018)

Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын цэргийн албан хаагчдыг оролцуулахыг зохицуулсан эрх зүйн хамгийн чухал баримт бичиг бол 1999 оны есдүгээр сард гарын үсэг зурсан "НҮБ, Монгол Улс хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг" бөгөөд Монгол Улсын цэргийн анги, цэргийн албан хаагчдыг НҮБ-ын байнгын зэвсэгт хүчинд оролцуулах тухай заасан байдаг.

Энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь "Монгол Улсын Зэвсэгт хүчний зорилт"-ын нэг гэдгийг онцолсон².

Энэ шийдвэрийг гаргахад хүргэсэн хэд хэдэн шалтгаанууд байна. Тэднээс хамгийн гол шалтгаан нь -20р зууны төгсгөлөөр геополитикийн нөхцөлд Монголын ард түмэн амар мэнд, аюулгүй ирээдүй рүү тэмүүлэх үйл явц юм. Үүний тулд улсын тусгаар тогтнолоо бэхжүүлэх, түүний зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдлыг өндөржүүлэх, эдийн засгийн холбоог өргөсгөх, аж ахуйн нэгж байгууллагуудын нэмэлт хөрөнгө оруулалтуудыг татах гэх мэт. Мөн улс орны газар зүйн, геополитик, демографическийн онцлогуудыг харгалзан үзсэн. Монгол Улсын далайд гарцгүй асар том газар нутагтай орнуудын нэг юм. Хойд хэсэг нь ОХУ-тай урд талдаа БНХАУ-тай хиллэдэг. Монгол Улс байгалийн баялагтай, хүн амын хувьд цөөн орон. Өөрийн хөрш орнуудтай харилцах харилцаанд өмнөх үеийн эдийн засгийн үзэл санааны үндэс орхигдож олон улсын харилцаа холбоо зайлшгүй шаардлагатай болсон. Монгол цэргийн албан хаагчдын уламжлалт, угшилтай сэтгэл зүй, физиологийн чанаруудыг бас анхааралдаа авсан: биеийн эрүүл мэнд, хүч мөн тэсвэртэй байдал, эр зориг, биеэ даасан чанар, дасан зохицох чадвар (адаптация), сахилга баттай зэргийг маш олон жишээнүүдээс харж болно.

Өнгөрсөн зууны -90ээд онд болсон ардчилсан хувьсгалын үр дүнд улс орны гадаад, дотоод улс төрийг шинэчилсэн нь энэхүү шийдвэр гарахад түлхэц болсон.

Нэр бүхий санамж бичиг нь Монгол Улсын

² Резолюция парламента Монголии от 15 мая 1998 г. Резолюция №56. «Основы государственной военной политики Монголии» // Вооруженные силы Монголии. – 2014. // Обновлено и подтверждено. Основа Оборонной Политики Монголии. Генеральный штаб Вооруженных сил Монголии. №85/ URL: <https://gsmaf.gov.mn/index.php?comp=post&id=196> (дата обращения: 04.06.2014)

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна" гэсэн заалтад тулгуурладаг. Монгол Улс олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр энхийг эрхэмлэгч гадаад бодлого баримталж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах үүрэг хүлээдэг.

Энэхүү санамж бичгийг батлахад өмнө нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас НҮБ-ын байнгын ажиллагаатай Зэвсэгт хүчинд оруулах хувь нэмрийг тусгасан төслийг боловсруулсан бэлтгэл ажил чухал түлхэц болж өгсөн. Санамж бичгийн төслийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн байдаг.

Энэхүү төслийн үндсэн дээр дараах баримт бичиг, хуулиудыг боловсруулан баталсан:

–"Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай" 115 дугаар тогтоол. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газраас 1999 оны 7 дугаар сарын -28ны өдөр баталсан. Үүнд:

–Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын иргэд сайн дураараа оролцох тухай НҮБ-тай байгуулсан хэлэлцээр;

–НҮБ-ын практикийн дагуу энхийг сахиулах ажиллагаанд оролцох дүрэм, нөхцөлийг дагаж мөрдөх амлалт зэрэг болно.

Дараа нь Монгол Улсын Зэвсэгт хүчнийг олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахаар заасан Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль (2002), мөн энхийг сахиулах ажиллагаанд оролцохтой холбогдсон бүх төрлийн харилцааг зохицуулах тухай Монгол Улсын Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль (2010), тус хуулийн шинэчилсэн найруулга Монгол Улсын Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /шинэчилсэн найруулга/ (Монгол улсын хууль, 2024) тус тус батлагдсан.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн зохицуулалтыг 2011 оноос хойш Батлан хамгаалах бодлогын хүрээнд, ялангуяа Монгол Улсын БХЯ-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон "Засгийн газрын 2016–2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т үргэлжлүүлэн боловсруулж, боловсронгуй болгосон.

БХЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хэсэгт "Зэвсэгт хүчний олон улсын



энхийг сахиулах ажиллагаанд оролцох үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, мөн энхийн цагт цэргийн тусгай үүрэг гүйцэтгэх чадвартай цэргийн анги нэгтгэлүүдийн тоог нэмэгдүүлэх тухай...” шаардлага тусгагдсан байдаг³.

Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдод холбогдох дээрх эрх зүйн үндэслэлүүдээс гадна “Алсын хараа 2050–” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” гэж алсын хараагаа чиглүүлж, ялангуяа “Дэлхийн Монгол” зорилтын хүрээнд дэлхий дахинд Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, Монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь Монголчууд, Монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө” хэмээн тусгаж өгсөн байна.

НҮБ–ын тавцанд буюу олон улсын энхийн ажиллагаанд Монгол цэргүүд монгол үндэсний үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, гадаадад өөрсдийн дайчин ур чадвар, ухаанаар тэргүүлж байгаа нь энхийг сахиулагчдын үүрэг гүйцэтгэл ажиллагааны ур чадвар, эрдэм мэдлэгийн түвшнийг харуулж байна.

Энхийг сахиулах ажиллагааны оролцоог үнэлсэн Монголын энхийг сахиулагчдын үнэлэмж. Энхийг сахиулагчдын нийгмийн аюулгүй байдлын үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль \1992 он\, үүнд Монгол Улсын үндэсний гол сонирхлыг гүйцэтгэх гадаад болон дотоод таатай нөхцөл бүрдүүлэх мөн улс орноо хамгаалах нөхцөлийг хангасан Зэвсэгт хүчний бэлэн байдлыг тусгасан байдаг⁴

Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд аюулгүй байдлын таатай бус хүчин зүйлүүд зарим ажиллагааны үед шууд бус байдлаар гарч ирж байна. Ажиллагааны үеэр энхийг

сахиулагчдын аюулгүй байдалд заналхийлэл, түрэмгийлэл үүсэх тохиолдлууд тэдний өөрсдийн үндсэн үүргээ гүйцэтгэх үед тохиолдох магадлалтай. Энэ нь:

–мөргөлдөөнтэй талуудын бүлэглэлүүдийг зогсоох;

–энгийн иргэдэд хүмүүнлэгийн тусламж хүргэхийн тулд мөн зөрчилдөөний бүсээс тэднийг нүүлгэн шилжүүлэхийн тулд таатай нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааны үеэр

–олон улсын хамтын нийгэмлэгийн гаргасан хориг арга хэмжээг гүйцэтгэх зорилготойгоор мөргөлдөөний дүүргүүдийг хаах

–улс төрийн тохиролцооны болон зориулсан урьдчилсан нөхцөл байдлыг бий болгох зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэхтэй холбоотой.

Хэд хэдэн тусгай арга хэмжээ авснаар эдгээр үүрэг хариуцлагууд тодорхой болно: хоол хүнс тараах мөн ахлагч нарын нийтийн болон тосгоны асуудлуудын тухай ярианууд, эргүүл хийх, цэргүүдийн байрлах бүсийн эвлэрлийн тухай гэрээн дээрх хяналт, дайн байлдааны үйл ажиллагаанд саад болох зорилготойгоор зуучлах, зохицуулах арга хэмжээ авах, эмх цэгцгүй байдлыг таслан зогсоох, дүрвэгсдийг нүүлгэн шилжүүлэхэд оролцох, гэрээ хэлэлцээр хийх, нийтийн тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийх, хууль бус, дүрэмд нийцэхгүй ажиллагааг явуулахгүй хяналт тавих.

Энхийг сахиулагчдын энэхүү ажиллагаанд хандах ерөнхий хандлагыг (350) 2010 цэргийн албан хаагчид) болон (850) 2018 цэргийн алба хаагчид) онуудын харьцуулсан судалгаанаас харж болно. Судалгаанд оролцогчид энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаадаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байв. Харин олон нийтийн санал асуулгаас нийт санал асуулгад оролцсон иргэдийн 67,7 хувь нь энэ ажиллагаанд оролцох нь буруу гэж үзэж байсан. Санал асуулгад оролцогсдын 21,8 хувь нь улс орны эрх ашигт нийцүүлэн цэргийн ажиллагаанд оролцох нь зөв, гэхдээ цэргийн албан хаагчдад учрах эрсдэлийг бууруулахын тулд тодорхой бус аюулыг нарийн тооцох хэрэгтэй гэсэн саналаа илэрхийлсэн. Тэгэхээр олон нийт болон ажиллагаанд оролцож буй цэргийн албан хаагчдын энхийг сахиулах ажиллагааны талаарх үзэл бодол зөрүүтэй байгаа нь харагдаж байна.

Цэргийн албан хаагчдад тус ажиллагааг ямар байдлаар нөлөөлж байгааг дараах асуулгаас харж болно, тухайлбал, гадаадад алба

³ Закон Монголии от 20 мая 2010 г. «Об участии в мироподдерживающих операциях» Единый информационный юридический сайт., 2017.09.02. // Электрон. Дан. Режим доступа URL: <https://www.legalinfo.mn/law/details/84?lawid=84>

⁴ «Концепция национальной безопасности Монголии»// Генеральный штаб Вооруженных сил Монголии. №48. УБ.-2010. Общие основания. 1.1.1. Режим доступа URL: <http://www.nsc.gov.mn/sites/default/files/National%20Security%20Concept%20of%20Mongolia%20MN.pdf> (дата обращения: 15.07.2010)



хааснаар биеийн хөгжил 54,8 хувь, мэргэжлийн ур чадвар, чадамж дээшилсэн 75,9 хувь, нийгэм соёлын өөрчлөлт (хэл ярианы чадамж, компьютерын мэдлэг, манлайлах ур чадварууд дээшилсэн.) 70,1 хувь (2010). Харин цэргийн албан хаагчдад сөрөг нөлөөлсөн зүйл нь (23,4 хувь) гэрээ санагалзах (носталгия), толгой өвдөх, халуунд бүгчмидэх, халуурах, тухайн орчинд дасан зохицоходоо удаан зэрэг сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд тайван бус хүчин зүйлүүд байв. Харин 2018 онд санал асуулгад оролцогчдын (52,6 хувь) энэхүү ажиллагаанд олон удаа дараалан явах нь сэтгэл зүйн болон эрүүл мэндийн хувьд сөрөг нөлөөлөх магадлалтай байгааг харуулжээ. Тиймээс цэргийн албан хаагчдыг тус ажиллагаанд илгээхдээ нэг албан хаагч 3–2 удаа явах нь хамгийн тохиромжтой эрэмбэ юм.

2018 оны судалгаанаас Монгол цэргийн албан хаагчид ажиллагаа ахих тусам харьцангуй туршлагажиж өөр орчин, халуун уур амьсгал, цаг агаарын нөхцөлд тэсвэр тэвчээртэй, дасан зохицох нь бусад орны цэргүүдтэй харьцуулахад хурдан, ажлын ур чадвар сайжирсан, биеийн хүчний болон цэргийн ур чадвар өндөр болсон нь харагдаж байна.

2018 онд авсан ижил төстэй судалгаагаар эерэг нөлөө үзүүлсэн үзүүлэлтүүд нэлээн доогуур байсан. Гадаадад цэргийн алба хааснаар бие бялдрын хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн гэж энхийг сахиулагчдын 34,7 хувь үзэж байна, тэдний 60,3 хувь нь мэргэжлийн туршлага, цэргийн албан хаагчдын 55,0 хувь нь эдийн засгийн чадамжид сайн нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Олон улсын энхийн ажиллагаанд алба хаах нь цэргийн албан хаагчдын хувьд шийдвэрлэж болохгүй, гэнэтийн асуудлууд гарах тохиолдлууд их байдаг. Энэ нь тухайн цэргийн албан хаагчдад шууд сөргөөр нөлөөлдөг (38,0 хувь) хэмээн олон хүмүүс саналаа илэрхийлсэн. Сэтгэл зүйн болон бие бялдрын эрүүл мэнд муудах нь дараах шинж тэмдгээр илэрдэг, тухайлбал, айх, сандрах, ажиллагааны гүйцэтгэл муу байх, алдаа гаргах, бодлогогүй нөхцөл байдал үзүүлэх, баг, хамт олонтойгоо харилцаа муу байх, хурдан ханиад хүрэх, толгой эргэх, бөөлжих гэх мэт.

Энхийг сахиулагчдын нийгмийн амьдралын янз бүрийн үйл ажиллагаанд эерэг эсвэл сөрөг нөлөөллийн дараах үр дүн ажиглагдаж байна. Үүнд:

–Мэргэжлийн ур чадвар, оролцоо, туршлагын түвшин дээшлүүлэх нь эерэг нөлөө үзүүлснээр өмнөө тавьсан зорилтууд, практик ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд бусаар оролцох мөн дараагийн энхийг сахиулах ажиллагаанд оролцох урьдчилсан бэлтгэл болно. Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хөшүүрэг нь цол нэмэх мэргэжлийн алба шат шатаар ахиулах, карьер өсөх гэх мэт.

–Үүнээс гадна, гэр бүлийн амьдралын материаллаг хэрэглээний түвшин сайжирч, эх орон руугаа буцсаны дараа мөнгөн урамшуулал зэрэг авдаг.

–Энхийг сахиулагч нарын амьдралд эерэг нөлөө үзүүлж олон улсын төлөөлөгчдийн дунд найз нөхдийн хүрээ өргөжиж, гадаад хэлний мэдлэг сайжирдаг. Ерөнхийдөө монголын цэргийн албан хаагчдыг энх тайвныг дэмжих үйл ажиллагаанд ирээдүйд оролцуулахын тулд урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг.

–Бие махбодын хөгжилд бусад орнуудын адил үндэсний цэргийн хэсгүүдийн дунд зохион байгуулдаг биеийн тамирын дасгал, спортын уралдаан тэмцээнд амжилтаар манлайлан оролцдог нь тэдэнд эерэг нөлөө үзүүлдэг.

–Өглөөний дасгал хөдөлгөөн, байнгын спортын бэлтгэл, сар бүрийн уралдаан тэмцээн нь тухайн орчинд дасан зохицоход болон хамт олон бусадтайгаа хамтран ажиллагааг гүйцэтгэх идэвхжүүлэлт болдог.

–Харин Монгол орноос эрс тэс, халуун уур амьсгалтай оронд, хүнд нөхцөл байдалд шууд очоод дасан зохицоход хүндрэлтэй, дасах үйл явц удаанаас болоод биеийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, хэтэрхий халуун эсвэл ажиллагааны нөхцөл аюултай газарт үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд энхийг хамгаалагчид хамгаалах хэрэгсэл удаан өмсөж явах, 50+ – 40+ градусын хэмд зэвсэг хэрэглээний төмөртэй хэсэг нь гарыг халааж түлэх магадлалтай учир, байнга бээлий өмсөх зэрэг хүндрэл учирдаг аж.

–Хэт их халуунаас болоод толгой өвдөх, амьсгаадах, хоолой аргахад байнга эм уух асуудлууд гардаг. Энэ нь хэвшил болох талтай хэмээн зарим албан хаагчид ярих.

–Гаднын гэнэтийн дайралт, халдлага ирнэ гэсэн байнгын айдастай байдаг нь цэргийн албан хаагчийн сэтгэл зүйд сөрөг нөлөөлж, яг дайралт болоход хэт их түгшүүрт автаж, үүнээсээ болоод хугацаанаасаа өмнө эх орон, гэр бүл рүүгээ эсэн мэнд буцах, санаа зовниох асуудал тулгардаг.



Гэрээ санах зэрэг нь сэтгэл зүйн ийм байдалд ороход бас их нөлөөлдөг. Сэтгэл зүйн ачаалал нь сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг бий болгодог; депрессдэх, ууртай эсвэл бухимдуу, цухалдсан харилцаатай болдог.

–Энхийг сахиулагчид мөн захирагчдын тэдний тушаал, шийдвэрийг эсэргүүцэх, биелүүлэхээс татгалздаг. Тэд хоорондоо маргалдаж, өөрийнхөө үүрэг хариуцлага биелүүлэхгүй, тэдний ажлын хариуцлага алдагдаж, ажиллагааг гүйцэтгэх чадвар нь буурдаг. Тэдний зарим нь энхийг сахиулах ажиллагаанд өөрийн оролцоог сөргөөр үнэлж энэ чиглэлд засаг төрийг шүүмжилж, улс төрийн оролцоог буруутгадаг. Тиймээс энэ байдал ажиллагааны явцад ажиглагдвал даруй арга хэмжээ авч өөрийгөө болон бусдыгаа зөв зэрэг хандлагаар удирдан манлайлах нь зүйтэй.

–Энхийг сахиулагчдын албан тушаалын зэрэг дэвээс шалтгаалаад байлдааны үеийн ээлж, харуул, шөнийн манаа зэрэг нэг өдрийн турш ажил гүйцэтгээд амралтгүйгээр үргэлжлүүлээд ахуйн жижиг ажлууд гүйцэтгэх тохиолдлууд байдаг нь тэдэнд ажлын ачаалал нэмэгдэж, стресс үүсгэж улмаар нойргүйдлийн шалтгаан болдог байна.

Энхийг сахиулагчдын ерөнхий байдалд 2 төрлийн эрсдэл нөлөөлсөн:

–эрсдэл болох гэж буй ажиллагааны өмнөх мөн өндөржүүлсэн биеийн хүчний бэлтгэлтэй холбоотой эрсдэлүүд

–Түүнчлэн ажиллагаанд шууд бус оролцуулах эрсдэл. Эдгээр эрсдэлүүдтэй хамт сэтгэл санааны байдал, хувийн зан араншин, сэтгэлийн хөдөлгөөний огцом илрэл үзэгддэг. Эдгээр эрсдэлүүд Цэргийн албан хаагчдад нөлөөлөх хэмжээ нь тэдний бодит гүйцэтгэх үүргээс хамаарна.

Энхийг сахиулах ажиллагааны эрсдэлийн нөлөөллүүд энхийг сахиулагчдын байдалд ерөнхий байдлаар нөлөөлөхөөс гадна, тодорхой, тааламжтай бус хүчин зүйлүүдийн өөр бусад талууд нөлөө үзүүлдэг. Энд зөвхөн цэргийн албан хаагчдын нийгэм–сэтгэл зүйн сөрөг нөлөөллийг дурдлаа, тэдний бие махбод, эрүүл мэнд, мөн амьдралд нөлөөлөх өөр бусад эрсдэлт хүчин зүйлүүд байна.

Цаг агаарын ялгаатай байдал, байгаль орчин, экологийн байдал зэргээс шалтгаалан илүү аюултай халдварт өвчин, өөр бусад өвчнөөр өвдөх тохиолдлууд байгаа. Тухайлбал, Энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдоос өвчний

улмаас амь насаа алдсан, мөргөлдөөний үеэр хэд хэдэн цэргийн албан хаагчдын амь амьдрал заналхийлэл дор байсан зэрэг нь гэнэтийн аюул осол ажиллагааны үеэр гарах тохиолдлууд байдаг.

Энхийг сахиулагчдад албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд материал техникийн талын хүндрэлүүд хааяа саад учруулдаг. Тухайлбал, цэргийн албан хаагчдын хэт их хувцас хэрэглэл, хэрэгцээгүй хувийн эд зүйл ажиллагаа болж буй газрын цаг агаарын нөхцөлд тохирохгүй, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж, техник хэрэгсэл эвдэрч гэмтэх, мин болон сум дэлбэрэлтээс үүдээд гэнэтийн довтолгооны үеэр хамгаалж буй объектын инженерийн хэрэгслүүд эвдэрч гэмтэх тохиолдлууд гардаг.

Бүхэлдээ, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож буй албан хаагчдын эрсдэлийн орчин 3 үеэр тооцоолбол: ажиллагааны өмнөх үе, ажиллагааны үе, ажиллагааны дараах үе гэж ангилж болно. Тухайлбал, 2015 оны судалгаанаас нийт 7 энхийг сахиулах ажиллагаанаас 550 гаруй респондентоос 3 үеийн аль үед нь илүү эрсдэл учирдаг эсэхийг тодруулахад, гэвч тодорхой ажиллагаа болгон дээр респондентийн 63.6 хувь 1350 албан хаагчид ажиллагааны үеэр эрсдэлтэй хэмээн хариулжээ. Ажиллагаа явагдаж дууссаны дараа буюу ажиллагааны дараах үед үлдсэн 36.3 хувь 1200 гаруй албан хаагчид нь эрсдэл үүсдэг хэмээн хариулжээ. Магадгүй энэ нь ажиллагаанаас ачааллаас шалтгаалсан эрүүл мэндийн болон сэтгэл зүйн эрсдэлүүд үүсдэг. Тиймээс ямар үед эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах, эрсдэлийг зайлуулах арга хэрэгслийг мэддэг, хэрэглэх чадвартай байх нь энхийг сахиулагчдын мэдрэмж, цэргийн ур чадварын нэг онцлог юм. Энэ тал дээр ч анхаарал хандуулах нь зүйтэй.

Дүгнэлт

НҮБ–ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол цэргийн албан хаагчдын оролцооны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

–Монголын энхийг сахиулагчдыг энхийн ажиллагаанд оролцуулах олон улсын байдлаар, улс орны суурь үндэсний сонирхлоор зөвтгөх,

–цэргийн албан хаагчид боломжит эрх зүйн хэм хэмжээгээр, нийгмийн хамгааллын цогц чадамжаар хамгаалагддаг,

–энхийг сахиулах үйл ажиллагаанд өөрсдийн оролцоог зөвгөөр үнэлсэн байдаг,

Цаашид энхийг сахиулагчдыг ажиллагаанд



илгээхдээ судалгааны үр дүнгээс гарсан хэд хэдэн саналууд байна.

–Энхийг сахиулах ажиллагааны бүх үед Монголын цэргийн албан хаагчдыг оролцуулахаар илгээхдээ ажиллагаа бүрийн бүх учирч болох эрсдэлүүдийг тооцоолж, үнэлэх хэрэгтэй. (Эрсдэлийн шинжээчдийн хамтарсан баг) Ингэснээр гарч болох эрсдэлийг бууруулах болно.

–Энхийг сахиулагчдын нийгмийн халамж үйлчилгээ, нийгмийн хамгаалал,

гэр бүл, амьдралын түвшин харгалзан үзэж ялгаварлалгүй төрийн хяналт, анхаарал халамжийг цаг алдалгүй хүртээх.

–Ажиллагааны үеэр болон дараах үеийн сөрөг хүчин зүйлүүдийг арилгах, бууруулах боломжийг “цэргийн албан хаагч–социологич–сэтгэл судлаач–эмч нар”–ын багийг бүрдүүлж судалгаанд үндэслэн зөвлөмж гаргах

–Залуу болон анх явж буй албан хаагчдад тэсвэр хатуужил, эр зоригийн тест, сэтгэл зүйн сорил, ярилцлага авах гэх мэт.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 1994.
3. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал . УБ., 1994.
4. Монгол Улсын гэрээний тухай хууль. УБ., 1993.
5. Монгол Улсын Зэвсэгт Хүчний тухай хууль. (2016.09.01). Бүлэг 1.6–1, 2.4, Бүлэг 2.7, 2.5. //QRZ: сервер радиолоубителей Монголии. 2015. URL: <http://www.legalinfo.mn/law/details/12123>
6. Монгол Улсын Цэргийн Албаны тухай хууль (Закон о военнослужании Монголии). Глава 1, 3.1.5, 2, 10.5.// QRZ: Единная информационная система законодательства Монголии. УБ. 2015. URL: <http://www.legalinfo.mn/law/details/12124> (дата обращения: 01.09.2016)
7. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын хууль. Шинэчилсэн найруулга. (Закон об участии в мироподдерживающей деятельности. Новый пересмотренный). Глава I. П.3.1.1.УБ., 2024.06.
8. Баабар Б.(Батбаяр). ХХ зууны Монгол ба нүүдэл, суудал (Монголия ХХ века и кочевье, оседлость). УБ., 1996. 533с.
9. Баянтур М, Батцэнгэл В. Геополтик (Геополитика). УБ., 2000.
10. Баярсайхан.Д. Иракийн дайн (Иракская война). УБ., 2007. 425с.
11. Борбаатар М. Батлан хамгаалахын 2010 оны бодлого, зорилго, үйл ажиллагаа, түүний шинэчлэл (Политика обороны 2010 года, задача, деятельность, ее реализация). МО, ОА., 2010. 357с. – С.201–202.
12. Дугарсүрэн М, Хосбаяр О. Олон улсын эрх зүй (Международное право). УБ., 1999.
13. Мягмар Д, Түмэн Д. Энхийг дэмжих ажиллагаа (Операции мира поддержания). УБ., 2002. 96с.
14. Мягмаржав Г. Сэтгэл зүйн бэлтгэл (Подготовка психологии). УБ., 2005. 90с.
15. Мягмаржав Г. Цэргийн сэтгэл зүйн ухаан (Военная психология). УБ., 1989.
16. НҮБ ба Монголын хамтын ажиллагаа (ООН и сотрудничество Монголии). УБ., 2005.
17. Тогоо Ц., Мягмарсүрэн Я., нар НҮБ–ын Энхийг сахиулах ажиллагаа. Сурах бичиг (Миротворческая деятельность ООН). Учебник. УБ., 2008. 292с.УБ., 2021
18. Тогоо Ц. Монгол Улсын Аюулгүй байдлын хүчин орчны өөрчлөлт ба Зэвсэгт хүчний шинэчлэлт (Модификация Вооруженные силы и изменение сектора безопасности Монголии). УБ., 2009. 167с.
19. Чойжамц Я. Монгол Улс НҮБ–ын Энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсэн нь, НҮБ ба Монгол Улс (Начало участия Монголии в миротворческой деятельности ООН, ООН и Монголия), УБ., 2005. – С.61.
20. Паламдорж Ш, Цэдэв П, Гэрэлтцолмон Н, Олзвой Ш. Оюунбаатар Д. Гамшгийн эрсдлийг үнэлэх арга зүй (Методологи оценить риска повреждения). УБ., 2010. – С.34–36.
21. Отгонбаяр Б. НҮБ–ын Энхийг дэмжих ажиллагаа. Энхийн үйлст зүтгэсэн 181 хоног (Миротворческие операции ООН. 181 день мира). УБ., 2007.
22. Энхтайван С, Баянжав Д. Цэргийн сэтгэл зүй (Военная психология). УБ., 2007. 87с. – С.55.
23. Эрдэнэчулуун Ч. Иргэн– Цэргийн харилцаа (Гражданско–военные отношения). УБ., 2009.
24. Батлан хамгаалах судлал. Сэтгүүл. УБ, 2005. №3, 2008. №10, 2009. №11.
25. Болдбаатар З. Үндэсний стратегийн аюулгүй байдлын үзэл баримтлалын цэрэг–стратегийн асуудал. Стратеги судлал. Сэтгүүл. УБ. 2008. №43.
26. Цолмон Д. Даяаршил ба буурай хөгжилтэй орнуудын эрх ашиг, аюулгүй байдлын зарим асуудал. Стратеги судлал. Сэтгүүл. УБ. 2002. №1.
27. Цэргийн шинэчлэл. Сэтгүүл. УБ. 2009. №1



ОХУ–ЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЭХ ОРОНЧ ТӨЛӨВШИЛ ОЛГОЖ БҮЙ БАЙДАЛ

Д.БАТ-ЭРДЭНЭ /БХЭШХ-ийн БХСТ-ийн ЭШАА, доктор (Ph.D), хурандаа/

Түлхүүр үг: эх орон, үзэл, боловсрол, хүмүүжил

Key words: motherland, ethos, education, nurture

Орчин үед нийгэм–эдийн засаг, улс төр, оюун санааны салбарт нэлээд өөрчлөлтүүд гарч байна. Нийгмийн давхраажилтын нөлөө, оюун санааны үнэт зүйлсийн өөрчлөлт болон бусад олон хүчин зүйлүүд хүүхэд залуучуудад сөргөөр нөлөөлж байна. Улс орнуудын хүүхэд гэр бүл, төр, бусад олон субъектууд, тэдгээрийн үүргийн талаар өөр ойлголттой болсон бөгөөд энэ нь ихээр нөлөөлж байна. Орчин үеийн залуучуудын оюун санаа, ёс суртахуун, сэтгэл зүй, бие махбодод ихээхэн өөрчлөлт гарч байна. “Монголчууд эртнээс ард иргэдээ эх орон үнэ цэнийг ойлгуулах үйлийг бага наснаас нь олгож ирсэн. Энэ онцлогийг судлан тодорхойлон гаргах нь чухал юм”¹. Мөн дэлхийн олон улс орнууд хүүхэд залуучууддаа эх оронч төлөвшил олгоход ихээхэн анхаарч ирснийг судлан тодруулах нь чухал байна. Энэ өгүүлэлд ОХУ–ын хүүхэд залуучуудад эх оронч төлөвшил олгож буй байдлын талаар товч авч үзэхээр зорилго.

Сургуульд эх оронч төлөвшлийг олгох нь маш чухал бөгөөд учир нь залуучуудын цаашид эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх эсэх нь үүнээс шалтгаална. Тэдэнд энэ талын мэдлэг төдийгүй оюун ухаан цэрэг–эх оронч хүмүүжлийн үйл явцын үндэс олгох нь чухал юм.

ОХУ–д хүүхэд залуучуудын ёс суртахуун, эх оронч төлөвшил нь боловсролын байгууллагуудын хичээлээс гадуурх үйл ажиллагааны гол элемент болж байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүд, сургуулийн сурагчид, их дээд сургуулийн оюутнуудын ёс суртахуун, эх оронч хүмүүжлийг зохион байгуулах зорилго, хэлбэр, арга барил нь сурталчилгаа болж байна. 2022 оны есдүгээр сарын сүүлчээр Владимир Путин ОХУ–ын Аюулгүйн зөвлөлийн төлөөлөгчидтэй уулзаж, тус улсын боловсролын байгууллагуудад эх оронч үзэл, ёс суртахууны боловсрол олгох ажлыг

зохион байгуулах асуудлыг хэлэлцсэн. 2023 оны есдүгээр сарын 1–нээс эхлэн боловсролын хөтөлбөрүүдэд өөрчлөлт оруулж, эх оронч төлөвшилд гол анхаарлаа хандуулж байна. ОХУ–ын Ерөнхийлөгчийн 2021 оны 7 дугаар сарын 2–ны өдрийн 400–р “Оросын үндэсний аюулгүй байдлын стратегийн тухай” зарлигаар эх оронч үзэл нь улс орны аюулгүй байдалд дотоод болон гадаад аюул заналхийлэхэд үзүүлэх гол хүчин зүйл юм гэсэн. Хүүхэд залуучуудын эх оронч төлөвшлийг хөгжүүлэх боловсролын агуулга нь иргэний, эх оронч, оюун санааны болон ёс суртахууны, гоо зүйн, бие бялдар, хөдөлмөр, байгаль орчны талаарх мэдлэг олгоход чиглэгддэг. Оюутнуудад Орос Улсын дэлхий дээрх байр суурь, түүний түүхэн үүрэг, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын талаарх системчилсэн мэдлэгийг бий болгох зорилт тавьсан. Үүнтэй холбогдуулан ОХУ–д эх оронч үзэл, оюун санааны–ёс суртахууны сэдэвт арга хэмжээнүүд онцгой ач холбогдолтой болж байна.

“Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх нь Оросын боловсролын гол зорилтуудын нэг юм. Бага наснаасаа л эх орноо хайрлах мэдрэмж төрүүлэх нь чухал гэж үзэж байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд цаг тухайд нь эх орны талаарх мэдлэгийг олгох нь чадварлаг ёс суртахуун, эх оронч төлөвшил бүхий иргэн бэлтгэх бүх боловсролын ажлын үндэс суурь гэж үзсэн. Цэцэрлэгт бүх нийтийн амралтын өдрүүдэд зориулсан арга хэмжээнүүд тухайлбал Ялалтын өдөр, Үндэсний эв нэгдлийн өдөр, Эх орон хамгаалагчдын өдөр, Оросын өдөр, ОХУ–ын Төрийн далбааны өдөр болон бусад баяруудаар багш нар баярын түүхийн талаар ярьж, хүүхдүүд хэнд, юунд зориулж байгааг ойлгуулахад чиглэдэг. Ялалтын баярын өмнөхөн хүүхдүүд “Энх тайвны тагтаа” арга хэмжээний хүрээнд цаасан дээр цагаан тагтаа хийж, цэргийн дуу сурдаг (“Катюша”, “Ялалтын баяр”). Мөн ахмад дайчидтай уулзалт зохион байгуулж, хүүхдүүд

¹ Орхончимэг. Монголчуудын цэрэг бие хүнийг төлөвшүүлж ирсэн зарим онцлог. ҮБХИС–ийн Цац сэтгүүл. №27(50). т.35



эх орноо хамгаалагчидтай бодитоор харилцдаг. Сургуулийн өмнөх насны хүүхдүүд холбогдох сэдвээр шүлэг сурч, "Бидэнд энх тайван хэрэгтэй" үзэсгэлэнд зориулж зураг бэлтгэдэг байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд харилцан яриа чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээр нь янз бүр байж болох ч хүүхдийн насны онцлогт тохирсон байх ёстой. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш нар ихэвчлэн эх оронч яриа өрнүүлдэг. Тухайлбал Москва бол бидний эх орны нийслэл гэсэн сэдвийн дор Москва болон улс орныг хайрлах хайрыг төлөвшүүлэх, алсын хараагаа өргөжүүлэх, түүхэн уламжлалыг судлахад чиглэдэг бол "Эхийн өдөр" сэдвээр хүүхдийн хамгийн хайртай хүнд халуун дулаан сэтгэл, талархлыг бий болгохыг зорьдог. "Манай арми" сэдвээр цэргийн салбарууд, эх орноо хамгаалагчдын тухай анхны санаа бодлыг бий болгодог. Анхны сансрын нисгэгч сэдвээр Ю.А.Гагарины эр зоригийг хүүхдүүдэд танилцуулах, сансарт танин мэдэхүйн сонирхлыг хөгжүүлэхэд чиглэдэг бол Миний дуртай цэцэрлэг сэдвийн хүрээнд цэцэрлэгээ хайрлах, багш нарт ээлтэй хандлагыг төлөвшүүлэхийг зорьдог байна.

Эх орны тухай зүйр цэцэн үг, шүлэг, дуу сурах нь ард түмний уламжлалыг тусгасан байдаг тул эх оронч хүмүүжлийн чухал элемент юм. Тэд эх орноо хайрлах мэдрэмжийг товч хэлбэрээр илэрхийлж, хүүхдүүдийг Оросын түүхтэй танилцуулдаг. Ингэхийн тулд "Манай эх орноос илүү сайхан орон дэлхий дээр үгүй", "Төрөлх нутаг бол сэтгэлийн диваажин", "Хүн нэг эхтэй, нэг эх орон" гэсэн зүйр цэцэн үгсийг ашигладаг байна. Шүлэг нь эх орноо хайрлахтай холбоотой яруу найргийн сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг. Алдартай яруу найрагчдын тухайлбал С.Есенин, К.Симонов, Р.Гамзатов, В.Боков, С.Михалков бичсэн эх оронч шүлгийг ашигладаг байна. Хүүхдийн эх орны тухай дууг тухайлбал "Бородино", "Орос бол хөлөг онгоц", "Эрх мэдэл", "Эх орондоо хайртай учраас", "Орос бид хоёр", "Оросын төлөөх дуу", "Оросын хүүхдүүд", "Эх орон", "Хайрт Орос минь", "Би Оросыг тэвэрнэ", "Орос бол тэнгэрлэг газар" гэх мэт олон дууг ёс суртахуун, эх оронч төлөвшилд ашиглан сургадаг.²

Сургуулийн сурагчдад эх оронч төлөвшил

² Нравственно-патриотическое воспитание в 2024—2025 году. <https://www.kp.ru/edu/shkola/nravstvenno-patrioticheskoe-vospitanie/>

олгох нь чухал байдаг.

Хүүхдүүдийн эх оронч төлөвшил нь сургуульд үргэлжилдэг, учир нь энд тасралтгүй байдлыг хангах нь чухал юм. Иргэний болон ёс суртахуун-эх оронч төлөвшлийн тогтолцоо нь сургуулийн бүх насныханд зориулагдсан байдаг. Энд хүүхдүүдийн насны онцлог, сургалтын түвшинг харгалзан үздэг. Эдгээр хичээлийн зорилго нь сургуулийн сурагчдад эх орноо хайрлах, эх оронч үзэл, эх орноороо бахархах сэтгэлийг төлөвшүүлэхэд оршино.

ОХУ-ын эх оронч төлөвшилтэй иргэн бэлтгэх бүрэн дунд боловсролын сургалтын агуулга нь дараах байдалтай байна. Үүнд:

"Эхний шат нь урьдчилсан шат бөгөөд эх оронч үзэл, эх орон, түүнийг хамгаалагчдын үнэт иргэн байх хүслийг төлөвшүүлэх үндэс суурийг тавих зорилготой юм. 1–4 дүгээр ангид 4 жил орчим хугацаатай олгогдоно. Насны хувьд 7–10 хүртэлх. Энэ үе шатын гол агуулга, анхаарал хандуулах зүйл бол хүүхдийн танин мэдэхүйн болон хүсэл эрмэлзлийн хэрэгцээ, сонирхлыг бүрдүүлэх, хөгжүүлэх явдал юм. Эдгээр хэрэгцээ, сонирхол нь эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд эх орноо хамгаалах оролцох эерэг хандлага төлөвшүүлэх, сэтгэлзүйн танин мэдэхүйн үйл явцыг бүрэн идэвхжүүлэх замаар юуны түрүүнд тоглоомын янз бүрийн хэлбэр, боловсролын хөгжлийн үйл ажиллагааны арга, техникээр дамжуулан хүргэхэд чиглэдэг. Хоёр дахь шат бол бэлтгэл үе шат юм. Энэ явцад эх орноо батлан хамгаалах, цэргийн алба хаахад бэлтгэх үндсэн элементүүд бүрэлдэн бий болох бөгөөд энэ нь зөвхөн залуучуудын хэрэгцээг ойлгоход төдийгүй хувийн бэлтгэлийн түвшинг ойлгохын ач холбогдолтой юм. Сургалтын үргэлжлэх хугацаа нь 4 жил, 5–9-р ангийн 11–14 насны өсвөр үеийнхнийг багтаасан. Сургалтын зорилт бол бэлтгэгдсэн цэрэг-хүмүүнлэгийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх явдал юм. Гурав дахь шат нь ёс суртахуун, эх оронч үзэл, залуучуудын үзэл бодол, зарчимч чанарыг төлөвшүүлэх тэднийг иргэн болгон бэлтгэх үе юм. Сургалтын үргэлжлэх хугацаа нь 2 жил, 10–11-р ангийн 15–17 насны хүүхдийг хамарна. Сургалтын зорилт нь эх оронч иргэн бэлтгэн төлөвшүүлэхэд чиглэж байна."³

³ Киреев Д.Г., Сухина Ю.В. Особенности военно – Патриотического воспитания молодежи в российской федерации. Теория и практика современной науки" №6(84) 2022. стр.136–137



Орчин үед эх оронч үзэл сайн төлөвшөөгүй байгаа байдал нь ялангуяа гэр бүл, сургууль бага үүрэг гүйцэтгэх болсон статистик тоо баримтууд нь санаа зовоож байгаа бөгөөд Оросын өрсөлдөгчдийн геополитикийн ашиг сонирхол нь тэднийг заавал бие сэтгэл зүйн төлөвшилтэй байхыг шаардаж байна. Үндэсний салан тусгаарлах үзэл, зах хязгаар, үндэстэн хоорондын болон шашин хоорондын мөргөлдөөн, залуучуудын сэтгэлгээ, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж байна. Өсвөр насныхны амьдралын хэмнэл, орчин үеийн хэв маягийг янз бүрийн шашны үзэлтэн, хэт даврагчид ашиглаж байгаа нь Оросын хувьд соёлын орон зайг сүйтгэх аюулд өртөж байна. Боловсролын тогтолцооны хямралт байдал нь тэдний эх оронч иргэн болон төлөвших үйл явцад сөрөг нөлөө үзүүлж байна. Орос хүн гэж хэн бэ? амьдралын утга учир юу вэ? гэсэн "мөнхийн асуултын" хариултыг олоход хэн ч хүүхдүүдэд тусалдаггүй байдал нь асуудал дагуулж байна гэж үзэх болсон. Боловсролын сургалтын чанаргүй байдал, эцэг эх нь амьдралаа залгуулах завгүй байдгаас үүдэн хүүхдүүдийн эх оронч иргэн болж төлөвших үйл явцад саад учрах болсон. Сургуулийн хүүхдүүд материаллаг үнэ цэнийг оюун санааны үнэт зүйлээс илүү эрхэмлэх эрүүл бус хандлага хөгжиж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ чиглэлийн мэдээлэл бүх талаар өдөөгдөж байна. Залуу хойч үеэ хүмүүжүүлэх нь төрийн тулгамдсан асуудлын нэг гэдгийг нийгмийн эрүүл хэсэг ойлгож байна. Гэхдээ орчин үеийн нэгэнт бий болсон сөрөг хандлагыг даван туулахын тулд нийгэм, ёс суртахууны асуудлыг хурдан шийдвэрлэх шаардлагатай байна. Нийгмийн гишүүн бүрийн идэвхтэй амьдралын байр суурь, эцэг эх, багш нарын эрч хүчийг дайчлах, нэгтгэх шаардлагатай байна. Эх оронч үзлийн мөн чанар нь хийсвэр биш бөгөөд энэ нь тодорхой гэр бүл, найз нөхөд, эх нутгаа хайрлах сэтгэл зүй дээр суурилдаг. Хүүхэд эх орноо хайрлах, хамгаалах сэтгэлтэй төрдөггүй. Энэ бүхнийг нийгмийн орчноос суралцдаг.

Иймд ОХУ-д нийгмийг бүрдүүлэгч байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэх, насны бүх бүлэг, гэр бүлийн хоорондын уялдаа холбоог зохицуулах, чиглүүлэхийн тулд төрийн нэгдсэн бодлого шаардлагатай байна. Энэхүү олон талт ажлыг нэгтгэх нь иргэдэд цэрэг-эх оронч төлөвшил олгох төрийн бодлогоор уламжлагдан боловсрол, сургалтаар үнэт зүйлс, иргэншил, эх оронч үзлийг

төлөвшүүлэх, хөгжүүлэх боломжийг олгодог. Бүх шатны боловсролын байгууллагад эх оронч хүмүүжлийн асуудлыг авч үзэх, тусгах, иргэн, эх орноо хамгаалах шинж чанарыг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн агуулгыг тусгах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шинжлэх ухааны болон бусад байгууллага, бүтээлч холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх явдлын чухлыг бүгд бичих болжээ. Ялангуяа залуучуудыг эх орноо хамгаалах хамгийн онцгой нөхцөл байдалд бэлтгэх, түрэмгийлэгчийн эсрэг зэвсэгт тэмцэлд бэлтгэх, Зэвсэгт хүчинд алба хааж, энх тайвныг хамгаалахын төлөө тэмцэхэд бэлэн байдлыг хөгжүүлэх, эх оронч хүмүүжлийг боловсролын үйл явцын бусад чиглэлтэй хослуулах нь түүний мөн чанар, бие даасан чиг үүргийг тодорхойлох нь чухал гэж үзэх болжээ.

ОХУ-д эх орноо хамгаалахад бэлтгэгдсэн хүнд тавигдах шаардлага, зөвхөн цэрэгт бэлтгэгдсэн шинж чанар, хүн төрөлхтний үнэт зүйлсийн тогтолцоогоор тодорхойлогддог бөгөөд дотоодын сурган хүмүүжүүлэх ухаан, уран зохиолд залуучуудын эх оронч хүмүүжлийн асуудал тусгагдсаар ирсэн. Өөр нэг зүйл бол өөр өөр түүхэн цаг үед энэ талаарх үзэл бодол үүрэг, хэрэгжүүлэх хэлбэр, арга нь өөр байв. 1990 оноос өмнө багш, зохиолч, эх оронч үзэл, эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөөх хүсэл эрмэлзэл нь тэдний оюун санааны амьдралын үндэс суурь, "жинхэнэ хүн, эх орны хүү хоёр нэг юм" гэж үзэж байсан. Хүн бүр төрөлх чанараараа "эх орныхоо ганц нэрэнд зүрх сэтгэл нь догдолж, баярлахгүй байхын аргагүй" болгож хүмүүжүүлэхэд чиглэж байх ёстой гэж үзэж байсан. Нийгмийн ёс суртахуун нь иргэний журамт үүргээ мэддэг залуучуудыг бэлтгэхэд чиглэгддэг.

Тэр үеийн эх оронч боловсрол нь В.А.Сухомлинскийн бүтээлүүд дээр суурилж, сургууль нь залуучуудад эх орондоо харамгүй үйлчлэх, идэвхтэй хөдөлмөр, нийгмийн үйл ажиллагаа явуулах хүслийг төлөвшүүлэх ёстой гэж үзэж байсан. Өсвөр насны хүүхэд бүрд эх орондоо хандах хувийн хандлага, түүний нэр төр, агуу байдал, хүч чадлыг батлах хүсэл эрмэлзэл, оюун санааны түлхцийг хөгжүүлэхийг хичээж байсан. Хувь хүний шинжүүд нь тэднийг нийгмийн төлөө амьдрах сэтгэл зүрхтэй болгоход чиглэх болсон. Нийгэм-эрх зүйн талаас нь эх оронч үзэл нь төр, засгийн газрын иргэний нийгмийн институци, хувь хүмүүстэй харилцах хэм хэмжээ, зарчмыг тодорхойлдог. Тухайн үеийн



зөвлөлтийн эх оронч үзлийг зөвлөлт хүний бусад хүмүүс, социалист нийгэм, түүний материаллаг болон оюун санааны баялаг, төрөл бүрийн үйл ажиллагаа, сайн сайхны төлөөх үйлсэд хандах хандлагыг илэрхийлдэг хувь хүний цогц шалшгүй чанар гэж тодорхойлж байжээ.

ОХУ–д аливаа улсын батлан хамгаалахын үндэс нь ард түмэн байдаг ба ихэнх дайн, зэвсэгт мөргөлдөөний явц, үр дүн нь эх оронч үзэл, чин сэтгэл, зүтгэлээс хамаардаг гэтэл залуучууд эх орноо хамгаалахад бэлэн биш байгаа нь санаа зовоож байгаа тухай их ярих болжээ. Өнөөдөр улс орон цэргээ залуучуудыг зэвсэгт хүчинд элсүүлж чадахгүй байгаа нь үүний нотолгоо юм. Үүнтэй холбогдуулан цэрэг–эх оронч төлөвшилд зарчмын өөрчлөлт хийх шаардлагатай байгаа ба төрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хамгаалахын тулд амиа золиослоход бэлэн байх иргэдийг бэлтгэх асуудал тулгамдах болжээ.

Орос Украины дайн өрнөснөөс хойш тус улсад цэрэг эх оронч үзлийг чухалчлах болсон. Хүүхэд залуучуудыг энэ ажлыг ойлгох дэмжихэд чиглүүлэн тусгайлан ажлуудыг хийх болсон. Залуу хойч үеэ цэрэгт бэлтгэхийн тулд эх оронч боловсрол, мэдлэг олгоход анхаарах болсон.

ОХУ–д Хүйтэн дайны дараа эх оронч цэргийн хүмүүжил олгохыг анхаарах болсон.

Ийнхүү дээрх бүгдийг товч дүгнэхэд ОХУ–д энэ асуудлыг төр бодлогын түвшинд анхаарч, эх орны дайны үед цэрэг эрс ямар үзэл санаагаар зоригжсон байсан, хэрхэн ялж өнөөдрийн эх нутаг, тусгаар тогтнолоо авч үлдсэнийг хүүхэд, залуучуудад ойлгуулж, тэд цаашид сонор сэрэмжтэй байж эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстойг ухамсарлуулах ажлыг боловсролоор дамжуулан олгоход ихээхэн анхаарах болжээ. Дэлхийн хоёрдугаар дайны тухай түүхэн ялалтыг нийгэмд дахин ярьж эхэлсэн нь ОХУ–ын Украин руу явуулсан ажиллагааг зөвтгөх, ард иргэддээ энэ талаар ойлгуулах ажлын үзэл санааны гол цөм болж байна. Ийнхүү ОХУ–д ямар ч цаг үед эх орноо хамгаалах үзэл ухамсар бэлэн байх шаардлагатайг ойлгуулах явдлыг чухалчлах болсон. Манай улсад ч залуучууд цэргийн алба хаах хүсэл сонирхол буурах болсон нь эх оронч үзэл ухамсар суулгах, үүрэг хариуцлагаа ухамсарлуулахад төр бодлогын түвшинд анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Ашигласан материал:

1. Орхончимэг. Монголчуудын цэрэг бие хүнийг төлөвшүүлж ирсэн зарим онцлог.ҮБХИС–ийн Цац сэтгүүл.№27(50).т.35.
2. Нравственно–патриотическое воспитание в 2024—2025 году. <https://www.kp.ru/edu/shkola/nravstvenno-patrioticheskoe-vospitanie/>
3. Киреев Д.Г, Сухина Ю.В.Особенности военно – Патриотического воспитания молодежи в российской федерации. Теория и практика современной науки" №6(84) 2022.стр.136–137



БНХАУ–ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН ШИНЭЧЛЭЛ

Ж.АЛТАНХУНДАГА ГҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн магистрант/
Б.ЭРДЭНЭЧИМЭГ /Эрдмийн сургуулийн багш, доктор (Ph.D), профессор/

Түлхүүр үг: батлан хамгаалах бодлого, цэргийн шинэчлэл, батлан хамгаалах төсөв, цэргийн номлол, цэргийн стратеги

Key words: Defense Policy, Military Reform, Defense Budget, Military Mission, Military Strategy

Оршил.

БНХАУ–ын хувьд одоогоос 40 гаруй жилийн өмнө эхэлсэн эдийн засгийн шинэчлэл амжилтыг дагуулж, эдийн засаг, цэргийн хүчээ бэхжүүлэх, улмаар дэлхийн их гүрэн болж хүчирхэгжих суурийг тавьсан. Шинэчлэл эхлүүлсэн 1970–аад оны сүүлч үед олон улсын эдийн засагт нөлөөгүй шахам байсан Хятад улс өнөөдөр дэлхийд АНУ–ын дараа орох хоёр дахь том эдийн засаг, дэлхийн хамгийн нөлөө бүхий их гүрний нэг болжээ.

Хятад улс нь эдүгээ Монголын хувьд хамгийн том хөрөнгө оруулагч, ОХУ–ын хувьд стратегийн том түнш, АНУ–ын хувьд хамгийн том өрсөлдөгч, Япон, Солонгос, Тайланд зэрэг улсын хувьд аюул, дундад Азийн хувьд хөрөнгө оруулагч, Африкийн хувьд хандивлагч зэрэг дэлхийн хэмжээнд бүхий л улс гүрэнд нөлөөлж чадахуйц том гүрэн болжээ.

БНХАУ–ын батлан хамгаалах хүчин чадал байнга өсөж, бүтцийн болон зэвсэглэл техникийн шинэчлэлт тасралтгүй хийн, хуурай газар болон далай тэнгист явуулж буй цэргийн сургуулийн давтамж улам нэмэгдсээр байна. Тэрээр бүс нутагт стратегийн давуу байдал олж аван тэргүүлэх гүрэн болохын төлөө хүчирхэг зэвсэгт хүчнийг байгуулж, эдийн засаг, цэрэг гэсэн хоёр хатуу хүчээ ихээхэн өсгөж, тасралтгүй шинэчлэн бэхжүүлж байгаагаас гадна дипломат болон соёлын хамтын ажиллагаа зэрэг зөөлөн хүчийг ч ашиглаж байна.

Үндсэн хэсэг

Хятадын Засгийн газраас баримталж буй эдийн засгийн шинэ бодлого нь “дэлхийн үйлдвэрлэгч”–ээс “дэлхийн хэрэглэгч” “хурдацтай өсөлт”–өөс “тогтвортой өсөлт”, “дотоод эрэлт”–ээс “гадаад хэрэглээ” болон өөрчлөгдөж, улмаар дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, “тооноос чанарт шилжихэд” чиглэж байна.

Ши Жиньпин 2012 оны 11 дүгээр

сард Хятадын 5 дахь үеийн удирдагчаар сонгогдсоныхоо дараа Хятадын Коммунист Намын ХҮИИ Их хуралд хэлсэн үгэндээ “Хятад мөрөөдөл” буюу “Хятад үндэстний агуу их сэргэлт” –ийг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэх нь улсын хэтийн зорилго гэдгийг ард иргэддээ болон дэлхийн ард түмэнд хандан тунхаглан зарласан.

XXI зуунд Хятадын дэвшүүлж буй “Хүчирхэг армитай баян улс” байгуулах уриалга нь “эдийн засгийн хүч”, “цэргийн хүч” хоёрыг эн зэрэгцүүлэн өсөн нэмэгдүүлэхэд хүргэж байна. Учир нь “Дэлхийн зах зээлд хүчирхэг, том байгаад байлдааны талбарт өчүүхэн жижиг байвал хүчирхэг улс орнуудын идэш болно” хэмээн үзэж буйтай холбоотой¹.

БНХАУ–ын Хятад мөрөөдлөө хэрэгжүүлэх гол стратеги бол “Бүс ба зам” бөгөөд БНХАУ–ын жин нөлөөг бүс нутаг, цаашлаад дэлхийд бэхжүүлэх зорилготой худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, “зөөлөн хүч”–ний бодлогыг холбосон стратеги юм.

“Нэг бүс, нэг зам” санаачлагыг анх дэвшүүлэхэд “бүс” буюу эх газар “зам” буюу далай тэнгисийг төмөр зам, авто зам, усан замаар холбоно хэмээн тайлбарлаж байсан бол өдгөө цахим ертөнц, цахилгаан сүлжээ, улмаар Умард туйлаас эхлээд огторгуйн уудамд хүртэл өргөжин тэлж байна. Хятадын “Сансрын торгоны зам”, “Туйлын торгоны зам”, “Дижитал торгоны зам” зэрэг олон нийтийн анхаарлыг татсан нэр томъёонууд нь итгэхэд бэрх сонсогдох боловч хэдийн ажил хэрэг болж эхлээд байна. “Нэг бүс, нэг зам”–ын сансрын мэдээллийн коридор байгуулах шийдвэр гарч Зүүн Өмнөд Азийн орнууд Хятадын 200 гаруй хиймэл дагуулын тусламжтайгаар харилцан мэдээлэл солилцох механизмд нэгдэж, улмаар АСЕАН–ий орнуудын худалдааны сансрын хөлгүүд “сансрын торгоны зам”–аар нислэг үйлдэх боломжтой болоод

¹ 刘明福。 “中国梦”, 2015



байна.

Мөн Зүүн Өмнөд Азид дижитал торгоны замын дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимтэй хөгжиж, Хуавэй компани шумбагч кабелийн систем буюу усан доогуурх хэдэн арван кабелийн систем барьж, улмаар 5G сүлжээг нэвтрүүлээд байна. 2018 онд “Умард туйлын талаар баримтлах Хятадын бодлого”-ыг танилцуулж, “Туйлын торгоны зам”-ыг байгуулсан. Дэлхийн дулаарлын нөлөөгөөр туйлын мөс хайлж буй нь Умард туйл ирээдүйн худалдааны гол усан замуудын нэг болох боломжийг бий болгож байна.²

Хятадын цэргийн шинэчлэл

Өдгөө Хятад улсын баримталж буй өөрийн онцлогтой гадаад бодлого нь “хүчээ нөөж, даруу байх” стратегиас “идэвхтэй ажиллах” стратеги руу шилжиж байна. Тодруулбал эх газраас далай болон сансар руу, Ази тивээс Африк, Латин Америк руу чиглэсэн далайцтай үйл ажиллагаа явуулж, бүтээн байгуулалт нь эдийн засаг, батлан хамгаалахыг хослуулсан байдалтай болж өөрчлөгдөж байна.

Хятадын “Үндэсний стратеги”-ийн зорилго нь ХКН байгуулагдсаны 100 жилийн ой буюу 2021 онд дундаж чинээлэг нийгмийг бүрэн байгуулах, БНХАУ байгуулагдсаны 100 жилийн ой буюу 2049 онд баян, хүчирхэг ардчилсан соёл иргэншилтэй, орчин үеийн социалист улсыг байгуулах³ явдал юм. Энэ нь Хятад үндэстний агуу их сэргэн мандалтад хүрэх мөрөөдөл бөгөөд хүчирхэг улс, хүчирхэг зэвсэгт хүчнийг байгуулах нь энэхүү Хятад мөрөөдлийн салшгүй нэг хэсэг нь юм.

Хятад улс 2020 он гэхэд Азид тэргүүлэх гүрэн, 2035 он гэхэд Ази, Номхон далайн хүчирхэг гүрэн, 2049 он гэхэд даян дэлхийн энх тайвныг сахиулах гол нөлөө бүхий гүрэн болно гэсэн зорилго тавин ажиллаж байна. Энэхүү зорилгодоо хүрч дэлхийд тэргүүлж, жанжлах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Зэвсэгт хүчнийхээ чадавхыг нэмэгдүүлж, АНУ-ыг давж гарах Зэвсэгт хүчинтэй болох стратеги баримталж байна.

Энэхүү газрын зурган дээр (ягаан өнгөөр тэмдэглэсэн) тэдний ашиг сонирхол нь АНУ-ын Вэйк арал хүрч, бүр Австралийг хүртэл оруулсан байна⁴.

² Belt and Road Space information corridor, China daily, 23.09.2018 <http://www.chinadaily.com.cn/a/201809/13/WS5b99b2c5a31033b4f4655bde.html>

³ The State Council Information Office of the People's Republic of China “China's Military Strategy”, May 2015, Beijing <http://eng.mod.gov.cn/Database/WhitePapers/index.htm>


⁴ Hisao Motomura. “The hegemony strategy and the aerospace power of China in preparation for 2020”. 2013.



1 дүгээр зураг. Хятад улсын гол ашиг сонирхлын газар нутаг

2021 оны 3 дугаар сарын 11-нд БХАТИХ-аас XIV Таван жилийн төлөвлөгөө батлав. XIV Таван жилийн төлөвлөгөөнд цэрэг, батлан хамгаалахын салбарт 2021–2025 онд “**Үндэсний батлан хамгаалах болон зэвсэгт хүчний шинэчлэлийг түргэтгэх, хүчирхэг армитай баян улс болох үйл хэргийг гүйцээх**” –ийг зорьж буй гэжээ.

Батлан хамгаалах төсөв БНХАУ-ын батлан хамгаалах төсөв 2024 онд өмнөх оныхоос 7,2 хувиар нэмэгдэв.⁵⁶



2 дугаар зураг. Хятадын батлан хамгаалах төсөв

Эх сурвалж: Глобал таймс, 2022

Батлан хамгаалах төсөв нь нэгд, сургалт, дадлага, хоёрт, бие бүрэлдэхүүний хангалт, гуравт, зэвсэглэл, техник гэсэн чиглэлд төсвийг зарцуулагдаж буй. Хамгийн чухал нь “БНХАУ-ын батлан хамгаалах төсөв нь ‘идэвхтэй хамгаалалт’ хэмээн томъёолсон бодлогын хэрэгжилтийг хангах хэрэгсэл” гэж зарим судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл, Хятадын стратегийн ашиг сонирхол бүхий “эмзэг цэг” гэгддэг Тайваний хоолой, Өмнөд Хятадын тэнгис зэрэг чиглэлээр учирч болох аюул заналыг таслан зогсооход хүчин чадлыг бэхжүүлэх зорилгын хүрээнд батлан хамгаалах төсвийн нилээдгүй хувийг зарцуулдаг ажээ.

⁵ China raises defense budget by 7.2% for 2024, 'conducive to peace, stability' – Global Times. China raises defense budget by 7.2% for 2024, 'conducive to peace, stability'

⁶ 中国合理确定2023年国防支出规模 比上年执行数增长7.2% <http://www.mod.gov.cn/gfbw/xwfy/zjtzh/16206779.html>



Батлан хамгаалах төсөв 2019 оноос хойш анх удаа огцом өгссөн нь ковид-19 цар тахлын үеийн хоёр жилд төсөв хумигдаж эргээд сэргэсэн гэж харгагдахаар байна. Нөгөөтэйгүүр Хяадын Ардын Чөлөөлөх Армийн төрлийн цэргийн командлалууд, бүсийн командлалуудаас сүүлийн хоёр жилд зохион байгуулсан сургуулиуд болон бусад цэргийн ажиллагааг идэвхижсэнийг үзвэл өнгөц дүгнэх боломжгүй юм. Тухайлбал, Хятадын Зэвсэгт хүчин 2020 оны зуны буюу ковид-19 цар тахлын оргил үед Өмнөд болон Зүүн Хятадын тэнгис дэх сургууль, дадлагаа ердийн үеэс эрс нэмэгдүүлж, далай тэнгист 30 гаруй цэргийн сургууль дадлага явуулсан ажээ. Мөн Тайваний хоолой дахь цэргийн ажиллагаага нэмэгдүүлж байгаагаас харж болно. Тиймээс Хятадын батлан хамгаалах төсвийн өсөлтийг цар тахлын нөхцөл байдалтай холбож үзэхээс илүүтэй бүс нутгийн аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлттэй уялдан дээр дурьдсан Хятадын “идэвхтэй хамгаалах” стратегийн чиглэлийн хэрэгжилтийг хангахад зориулж төсвөө нэмэгдүүлсэн гэж үзэх үндэстэй юм.

Цэргийн номлолд гарч буй өөрчлөлт



3 дугаар зураг. Хятадын цэргийн номлолууд

Мао Зедуны 1930-аад онд боловсруулсан “Ардын дайны (人民战争)” үзэл баримтлал нь БНХАУ-ын цэргийн номлол, стратегийг тодорхойлж ирсэн. **“Ардын дайны” цэргийн номлолд** зэр зэвсэг, технологийн хувьд давуу дайсны эсрэг байлдааны ажиллагаанд “хүний хүчин зүйл”-ийг чухалчилж үзсэн байдаг.

Улмаар 1969 оны Зөвлөлт-Хятадын хилийн мөргөлдөөний дараа ХАЧА 1970-аад онд Зөвлөлтийн эсрэг болзошгүй дайнд эрчимтэй бэлтгэж, хуучны цэргийн номлолыг ашиглах нь ялагдалд хүргэнэ гэж үзсэн учир цэргийн номлолоо шинэчилж, “Ардын дайн”-ны шинэчилсэн хувилбар болох “Орчин цагийн нөхцөл дэх Ардын дайн” гэсэн шинэ номлолыг баталсан.

БНХАУ-ын цэргийн номлол 1949 оноос

хойш 9 удаа шинэчлэгджээ.

Орчин үеийн цэргийн номлолын тухайд 1993 онд “Орчин үеийн өндөр технологийн нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах”, 2004 онд “Мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялах”, 2014 онд “Мэдээлэлжсэн хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” гэсэн номлолуудыг тус тус боловсруулан баталсан.

“Орчин үеийн өндөр технологи бүхий нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” 1993 оны номлол: 1990–1991 оны Персийн булангийн дайны дараа Хятадын цэргийн шинжээчид орчин үеийн байлдааны ажиллагаанд дэвшилтэт технологи чухал болохыг соргоогоор мэдэрч, ирээдүйн дайн шинэ технологийн дайн байх тул цэргийн номлолдоо шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага буйг мэдэрч, 1993 онд **“Орчин үеийн өндөр технологи бүхий нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах” нэртэй шинэ цэргийн номлолыг баталсан.**

Нэйн Ли “хязгаарлагдмал дайн”⁷ гэдгийг:

–Хязгаарлагдмал дайн нь илүү “улс төрийн нөлөөтэй” байдаг. Өөрөөр хэлбэл, цэргийн хүч ашиглах явдлыг илүү улс төр, дипломат хүчин зүйлсээр хязгаарлах хандлагатай болсон.

–Хязгаарлагдмал дайн нь хязгаарлагдмал зорилттой ажээ. Дайсныг бүрэн устгах, газар нутгийг нь эзлэх, дэглэмийг нь унагах зэргээс илүүтэй дипломат яриа хэлэлцээ, тохиролцоонд санаачлагыг гартаа авах, дайсныг сэтгэл зүйгээр цочроох, эдийн засгийн нөөц, баялагийг олж авах зэргийг зорьдог болсон.

–Хязгаарлагдмал дайн нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал орон зай, цаг хугацаанд явагдах болсон.

–Хязгаарлагдмал дайн нь технологид суурилсан буюу дэвшилтэт технологийн дайн юм.

Хамгийн чухал нь тус шинэ цэргийн номлолоор ирээдүйд дайн хаана дэгдэж болзошгүй гэдгийг тодорхойлохыг зорьсон.

Өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал дайн нь хил орчмын бүс нутаг эсвэл усан хилийн ойролцоох орон зайд үүсэх зөрчил, мөргөлдөөний тухай юм.

Хятадын хуучин цэргийн номлол нь Зөвлөлтийн эсрэг болзошгүй хуурай замын байлдаанд бэлтгэхэд зориулагдсан “эх газрын” стратеги давамгайлж байсан бол 1993 оны

⁷ Li, Nan. "The PLA's Evolving Warfighting Doctrine, Strategy and Tactics, 1985–95: A Chinese Perspective." The China Quarterly, no. 146 (1996): 443–63.



цэргийн номлолоор “стратегийн хил хязгаар” хэмээх шинэ ойлголт гарч ирсэн. Энэ нь далай тэнгис дэх газар нутгийн маргаан, ашиг сонирхлыг хамгаалахад анхаарал хандуулах болсоныг харуулж байгаа болно.

Мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах 2004 оны номлол:

Тус номлолын өмнөх цэргийн номлолоос ялгагдах гол онцлог нь “өндөр технологи” гэдэг үгийг “мэдээлэлжсэн” гэсэн үгээр сольж, дэвшилтэт технологид суурилсан дайны гол шинж нь мэдээлэлжих явдал тул Зэвсэгт хүчний анхаарлыг энэ чиглэлд хандуулахыг зорьсон.

Мэдээлэлжих гэдэг нь нэгдсэн ажиллагаа явуулахад Зэвсэгт хүчний төрлийн цэргүүд хоорондын мэдээллийн урсгалын уялдаа холбоог хангах тухай юм. “Мэдээлэлжсэн нөхцөл” дэх дайн гэдгийг товчоор цэргийн ажиллагааны бүхий л талбарт мэдээллийн технологийг ашиглахыг хэлнэ гэж ойлгож болно.⁸

Өөрөөр хэлбэл, мэдээлэлжсэн дайн гэдэг нь электрон–соронзон болон газар, ус, агаар, сансар, кибер орон зайд Зэвсэгт хүчин төрлийн цэргүүдийн нэгдсэн байлдааны ажиллагаа явуулахад мэдээлэл олж авах, дамжуулах, боловсруулах, ашиглах үйл явцтай холбоотой юм.


2004 оны Цагаан номонд “мэдээлэлжсэн цэргийн хүчин” байгуулах тухай тусгасан нь арваад жилийн дараа бүрэн утгаараа хэрэгжиж, 2015 оны цэргийн шинэчлэлээр тагнуул, сансар, кибер болон электроникийн дайны чиглэлээр мэргэшсэн Хятадын Ардын Чөлөөлөх Армийн төрлийн цэргүүдийн нэгдсэн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн дайнтай тэмцэх “Стратегийн дэмжлэг үзүүлэх цэргийн хүчин байгуулагдсан. Харин 2024 оны 4 дүгээр сард Стратегийн дэмжлэг үзүүлэх цэргийн хүчнийг нэрийг нь өөрчилж, “Мэдээллий дэмжлэгийн хүчин байгуулсан.

Хятадын цэргийн хүчний талаар жил тутам гаргадаг Америкийн судалгаанд мэдээлэлжсэн нөхцөл дэх дайн гэдгийг “дэвшилтэт технологи бүхий дайсны эсрэг “түргэн”, “эрчимтэй” дайн явуулахыг хэлж буй гэж тайлбарласан байдаг.

2004 оны цэргийн номлол нь шинэ гэхээсээ илүүтэйгээр 1993 оны цэргийн номлолын стратегийн үндсэн чиглэлүүдийг бататгасан гэж үзэж болно. Тус хоёр номлол нь хоёулаа

⁸ M. Taylor Fravel, Active Defense: China’s Military Strategy since 1949 (Princeton, NJ: Princeton University Press, 2019).

хязгаарлагдмал дайны тухай бөгөөд Зэвсэгт хүчнийг хязгаарлагдмал дайн буюу Хятадын хил дагуух бус нутаг болох “зах хүрээ” газар оронд (2 дугаар зураг) зэвсэг, технологийн өндөр чадавхтай өрсөлдөгчтэй тулгарах болзошгүй зөрчил, мөргөлдөөнд бэлдэхэд удирдамж, чиглэлээр хангасан. Үүнийг барууны цэргийн судлаачид Хятадын ардын чөлөөлөх арми Тайваний хоолойд Тайвань болон АНУ–ын эсрэг болзошгүй зэвсэгт мөргөлдөөнд бэлтгэж буй хэмээн тайлбарлаж буй.



4 дүгээр зураг. Аюулын зэрэглэлийн 4 тойрог.

Мэдээлэлжсэн хязгаарлагдмал дайнд ялалт байгуулах 2014 оны цэргийн номлол:

Хятадын Зэвсэгт хүчин удирдлага, хяналт, холбоо, компьютер, тагнуул, тандалт, туршуул (C4ISR)–ын технологид хөрөнгө оруулалт хийж, энэ чиглэлд чадавхыг сайжруулахад анхаарал хандуулахыг чухалчилсан. “Мэдээлэлжсэн дайн” болоод “мэдээллийн дайн” гэсэн хоёр ойлголт нь ялгаатай бөгөөд мэдээллийн дайн нь мэдээлэлжсэн дайны зөвхөн нэг хэсэг гэж үздэг⁹

1990–ээд оноос хойш цэргийн номлолд гарсан өөрчлөлтийг дүгнэж хэлвэл, ирээдүйн дайны шинж чанар нь технологижсон, мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал орон зайд буюу хил дагуух зах хүрээ бус нутагт богино хугацаанд “түргэн” бөгөөд “ширүүн” дайн өрнөх магадлалтай тул шинэ технологи, инновацийг дэмжих, мэдээллийн ажиллагааны чадавхыг сайжруулах төрлийн цэргүүдийн нэгдсэн ажиллагааг сайжруулах, дайны бус цэргийн ажиллагааг дэмжихэд батлан хамгаалах бодлого, цэргийн стратегийг чиглүүлж байна.

Хятадын Ардын Чөлөөлөх Арми “Мэдээлэлжсэн дайн”–д бэлтгэхэд ач холбогдол өгч байгаагийн нэг илрэл нь иргэн–цэргийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр эрчимтэй ажиллаж буй явдал юм. Иргэн–цэргийн хамтын ажиллааг сайжруулах гэдгийн цаад учир нь Зэвсэгт хүчин иргэний салбар дахь шинжлэх ухаан, технологийн нээлтэд чөлөөтэй

⁹ Б.Эрдэнэчимэг. “Хятадын цэрэг, батлан хамгаалах бодлого шинэ зуунд”. 2020 он. т20



нэвтрэх, ашиглах болон шинэ технологийн чиглэлээр хамтран ажиллах замаар цаг тутам өөрчлөгдөн буй мэдээлэл, технологийн хөгжлөөс хоцрохгүй байх

Сүүлийн жилүүдэд Хятадын цэргийн номлол “мэдээлэлжсэн” дайнаас “ухаалагжсан” дайнд аажимдаа шилжих төлөв ажиглагдаж байна. Одоогийн байдлаар цэргийн номлол албан ёсоор өөрчлөгдөөгүй ч бодлогын баримт бичгүүдэд “ухаалагжсан дайн”-д бэлтгэхийг чиглэлээ болгож буй. 2019 оны Батлан хамгаалах цагаан номонд “мэдээлэлжих, механикжих чиглэлээр дэвшилт гаргахын сацуу “ухаалагжсан” цэргийн хүчнийг байгуулах ажлыг урагшлуулах” чиглэлээр анхаарч ажиллахыг тусгасан. XIV таван жилийн төлөвлөгөөнд “Байлдааны ажиллагаанд шинэ тутам гарч буй инновац болон стратегийн чиглэлтэй уялдуулан цэргийн онолын шинэчлэлийг хурдасгаж, шинэ эриний цэргийн стратегийн системийг сайжруулан, ажиллагааны онолыг шинэчлэнэ” гэж заасан.

“Ухаалагжсан дайн”-ыг Хятадын Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн судлаачид “Ухаалаг зэвсэг, төхөөрөмж болон түүнтэй холбоотой байлдааны ажиллагааны аргыг ашиглан газар, ус, агаар, сансар, электрон-соронзон, кибер, мэдээллийн орон зайд ‘зүйлсийн интернет (IoT)-’ ийн мэдээллийн системд тулгуурлан явагдах нэгдсэн байлдааны ажиллагаа”-г хэлнэ гэж тодорхойлжээ.

Хятадын Зэвсэгт Хүчин хиймэл оюун ухааныг цэргийн технологийн салбарт нэвтрүүлэхэд анхаарал хандуулж буй нь “ухаалагжсан дайн”-д бэлтгэж буйг илтгэж байна. Цэргийн шинэчлэлийн хүрээнд төрөл бүрийн робот технологи, ухаалаг систем зэвсэглэлд нэвтрүүлж, ирээдүйн дайнд хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан илүү “мэдээлэлжсэн” цэрэг, “ухаалагжсан” зэвсэг, техниктэйгээр оролцохоор бэлтгэж буй төлөв ажиглагдаж байна.

Орчин цагийн дайн ба шинэ талбар дахь Хятадын цэргийн стратеги

Кибер цэрэг Хятадын Ардын Чөлөөлөх Арми кибер орон зайд ажиллагаа явуулах чадавхаа сайжруулахад ихээхэн анхаарч буй. Мэдээллийн дэмжлэг үзүүлэх цэрэг нь кибер тагнуул, кибер халдлага, кибер хамгаалалтыг нэгтгэн кибер баг үүсгэж, ажиллагааг хурдтай явуулах нөхцлийг бүрдүүлжээ. Энэхүү хүчин нь Хятадын “Гурван дайн”-ны номлолыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Хятадын Ардын Чөлөөлөх Арми дахь сэтгэл зүйн дайн хариуцсан цорын ганц төдийгүй чухал нэгжид тооцогддог.



5 дугаар зураг. Хятадын Ардын Чөлөөлөх Армийн кибер цэргүүд

Эх сурвалж: USNI News 2018

Хятадын кибер дайн 1) кибер хориглолт 2) кибер орон зайд тагнан турших ажиллагаа 3) кибер халдлага 4) кибер хамгаалалт гэсэн дөрвөн ажиллагаанд хуваагддаг¹⁰.

Сансрын цэрэг ХАЧА Сансар дахь цэргийн хүчин чадавхиа нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж Хятад маягийн GPS гэж нэрлэгдэх дотооддоо үйлдвэрлэсэн хиймэл дагуулын навигацийн “Бэйдоу” сүлжээг улам бүр боловсронгуй болгож, цэргийн тагнуулын ажиллагаанд ашиглагдах ажиглалтын хиймэл дагуулыг дотооддоо үйлдвэрлэж, ашиглаж байна. Дэлхийд глобал навигацийн хиймэл дагуулын дөрвөн систем байдаг нь АНУ-ын “GPS”, Европын Холбооны “Галилео”, ОХУ-ын “Глонасс”, БНХАУ-ын “Бэйдоу” юм. БНХАУ тойрог замд 363 хиймэл дагуултай ба хиймэл дагуулын тоогоороо АНУ-ын дараа 2 дугаарт бичигдэж буй¹¹.


Сарны судалгаа Сүүлийн жилүүдэд сарны судалгааг идэвхтэй явуулж “Чаньез” цуврал аппаратыг сарнаас дээж авхуулахаар удаа дараалан хөөргөсөн. Сарнаа явагч “Чаньез-4” аппаратыг 2018 онд хөөргөж 2019 онд сарны цаад талд буюу сарны хамгийн судлагдаагүй, дэлхийгээс харагдаагүй талд зөөлөн газардсан анхны сансрын төхөөрөмж болсон. “Чаньез-5” аппаратыг 2020 онд хөөргөж сарнаас 1,731 гм дээж дээж авчирсан. Энэ нь Хятад улсын сарнаас дээж авсан анхны амжилттай ажиллагаа болж АНУ, Оросын дараа сарнаас

¹⁰ China Aerospace Studies Institute, “In Their Own Words: Science of Military Strategy 2013,” February, 2021, <https://www.airuniversity.af.edu/Portals/10/CASI/documents/Translations/2021-02-08%20Chinese%20Military%20Thoughts-%20In%20their%20own%20words%20Science%20of%20Military%20Strategy%202013.pdf>

¹¹ Lina Zvetski, “China wants to dominate space, and the US must take countermeasures”, <https://www.defensenews.com/opinion/commentary/2020/06/23/china-wants-to-dominate-space-and-the-us-must-take-countermeasures/>




дээж авсан дэлхийн 3 дахь улс болсон. 2024 он гэхэд “Чаньеэ-6” аппаратыг саран дээр буулгасан¹²



6 дугаар зураг. Хятадын сарны судалгааны хөтөлбөрийн 3 алхам

Хятадын сарны судалгааны цаашдын хөгжлийн төлвийн тухайд нь сарнаа явагч Чаньеэ-6/7/8 цуврал ажиллагаагаар сарны Өмнөд туйлд **нисгэгчгүй сарны судалгааны станц** байгуулахаар төлөвлөж байгаа ажээ¹³.

Саран дээр шинжлэх ухааны судалгааны станцыг 2030 он гэхэд байгуулж дуусгахаар төлөвлөж байгаа ажээ. Энэхүү судалгааны станц нь нэгдсэн удирдлага, мэдээллийн харилцаа холбоо, ухаалаг ажиллагаа шинжлэх ухааны хайгуул зэрэг чиг үүрэгтэй байх бөгөөд эхний ээлжинд сарны, нөөцийг олж авах, ашиглах, боломжтой болно. Энэхүү ажиллагаа нь цаашид урт хугацаанд нисгэгчгүй ажиллах сарны судалгааны станц барих үндэс суурь болох юм.



Хятад улс 1) сарны нөөцийг ашиглах 2) сансрын хүчин чадавхаа нэмэгдүүлэх 3) Хятад улс сансрын судалгаанд дэлхийд манлайлагч гэж үндэсний нэр хүндээ өсгөх гэсэн гурван гол шалтгааны улмаас сүүлийн жилүүдэд сарны судалгааны чиглэлээр идэвхийлэн сонирхох болсон гэж судлаачид үзэж буй.

¹² “China aims to launch Chang'e-6 lunar probe around 2024,” http://www.xinhuanet.com/english/2021-04/24/c_139903600.htm

¹³ Dengyun YU “China Deep Space Explorations: Achievements and Prospects,” https://www.unoosa.org/documents/pdf/psa/activities/2022/UN-China/Presentations/1a-2_Dengyun_Yu_en.pdf

Хятад улс 2045 он гэхэд сансрын хүчин чадавхаараа дэлхийд тэргүүлэгч болохоор зорьж буй бөгөөд энэ хүрээнд 2030 онд 100 тонныг зөөвөрлөх тээвэрлэгч пуужин хөөргөх, 2035 онд дахин ашиглах зориулалттай тээвэрлэгч пуужин бүтээх, 2040 онд цөмийн цэнэгт сансрын хөлөг бүтээхээр тус тус төлөвлөж байгаа ажээ.

Иргэн цэргийн хамтралын стратеги Хятад улс “Ухаалагжсан дайн”-д шилжиж буйн илрэл нь “иргэн-цэргийн хамтрал”-ыг сайжруулах чиглэлээр эрчимтэй ажиллаж байгаа явдал юм. Иргэн-цэргийн хамтын ажиллагааг сайжруулах гэдгийн цаад учир нь иргэний салбар дахь шинжлэх ухаан, технологийн нээлтэд Зэвсэгт хүчин чөлөөтэй нэвтрэх, ашиглах, болон шинэ технологи, инновацын чиглэлээр хамтран ажиллах замаар цаг тутам өөрчлөгдөн буй шинжлэх ухаан, технологийн хөгжлөөс хоцрохгүй байх бодлого баримтлах хандлагатай байна.



7 дугаар зураг. Тархи-Компьютерийн интерфейс

Иргэн-цэргийн хамтрал”-ын хүрээнд хиймэл оюун ухааны талбар дахь Америкийн эсрэг өрсөлдөөнд Байду, Алибаба, Тенсент зэрэг корпорациуд гол тоглогчийн үүрэг гүйцэтгэж буй. Америк болон барууны орнууд хиймэл оюун ухааны талбар дахь өрсөлдөөнд Байду, Алибаба, Тенсент буюу “БАТ”-ын гэсэн гурвалаас сэрэмжлүүлж буй. 2017 онд Байду “Хиймэл оюун ухааны үндэсний лаборатори”-ийг удирдахаар сонгогдсон ба үндэсний судалгааны төслийн тэргүүлэх чиглэлд автоматжуулсан технологи багтаж байна.

БНХАУ-ын 2017 оны “Шинэ үеийн хиймэл оюун ухааны хөгжлийн төлөвлөгөө”-нд Хятад улс 2030 он гэхэд хиймэл оюун ухаанаар “дэлхийд тэргүүлэгч” болно гэж заасан байдаг¹⁴

Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх чиглэлд ач холбогдол өгч жолоочгүй танк, хуягт техник

¹⁴ “Full Translation: China's 'New Generation Artificial Intelligence Development Plan' (2017),” <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/full-translation-chinas-new-generation-artificial-intelligence-development-plan-2017/>

зэрэг робот технологийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх талтай. 2021 оны 12 сард БНХАУ НҮБ-ын “Зарим ердийн зэвсгийг хориглох, хязгаарлах тухай конвенц” –ийг хэлэлцэх 6 дугаар хурлаар хиймэл оюун ухааныг цэргийн зориулалтаар ашиглахад хяналт зохицуулалт тавих санал өргөн барьсан. Энэ нь Хятадын хиймэл оюун ухааныг цэргийн зэвсэглэлд нэвтрүүлэх ажил эрчимтэй урагшилж буйтай уялдан олон улсын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоход анхаарч буй хэрэг юм.



8 дугаар зураг. Шанхай дахь “Хиймэл оюун ухааны хурал”-ын үеэр хүншүүлсэн робот Уолкер Икс шатар тоглож байна

БНХАУ-ын дарга Ши Жинпин Цэргийн төв хорооны Иргэн цэргийн хамтралын хөгжлийн хороог даргалдаг ба тус хороон нь ухаалагжсан автомат систем, биотехнологи, шинжлэх ухааны салбар хоорондын технологи, квантын шинжлэх ухаан, технологийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээ болгодог.

Хятадын Ардын Чөлөөлөх Арми хиймэл оюун ухааны тусламжтай цэрэг, зэвсгийн технологийг дэвшилтэт түвшинд авчирч буй хэдий ч бие бүрэлдэхүүнийг хурдацтай өөрчлөгдөж буй технологийн шинэчлэлээс хоцролгүй сургаж бэлтгэх асуудал чухлаар тавигдаж буй. Өөрөөр хэлбэл, технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад богино хугацаанд дасан зохицох, технологийн өндөр чадвартай бие бүрэлдэхүүнтэй байх шаардлага тулгарч буй. Тиймээс энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах чиглэлээр сургалт, бэлтгэлийг эрчимжүүлэх төлөвтэй байна.

“5G” технологи ба зэвсэг техникийн хөгжүүлэлт

Тав дахь үеийн хөдөлгөөнт холбоо гэгдэх “5G” сүлжээг сүүлийн жилүүдэд Хятад улс хөгжүүлэхэд нилээдгүй хөрөнгө зарж буй. Хятад, Америк хоёр улс “5G” технологийн салбарт өрсөлдөж байгаа нь тус сүлжээ цэргийн

технологийн салбарт хувьсал авчирна хэмээн үзэж байгаа ажээ. Тухайлбал, “5G” нь зэвсэг, техникийн автомажуулалт, дуунаас хурдан зэвсгийн холбоо, цөмийн удирдлага, хяналт, холбоог сайжруулахад чухал үүрэгтэй ажээ¹⁵. Мөн 5G технологийг тагнуул, тандалт, туршуулын (ISR) систем, боловсруулалтыг сайжруулах, байлдааны ажиллагааны командлалын шинэ арга хэрэгслийг боловсруулах, логистикийн системийг бүтээмжийг сайжруулах, автомат жолоодлоготой техник, зэвсэг, техникийн засвар үйлчилгээ зэрэг цэргийн зориулалтаар ашиглагдах боломжтойн дээр өгөгдлийн хурдыг сайжруулж, цаг хугацааны хоцрогдлыг багасгах давуутай талтай юм.

Иргэн-цэргийн хамтралын хүрээнд Хятадын засгийн газраас хувийн компаниудыг “5G” технологийн хөгжүүлэлт, худалдан авалтад хөрөнгө оруулж буй. Засгийн газрийн санхүүгийн дэмжлэгтэй тул Хятадын компаниуд дэлхийн 5G нийлүүлэлт, хөгжүүлэлтийн зах зээлд тэргүүлэх байр суурь эзэлдэг. Тухайлбал, Хуавей Исланд, Турк, Унгар зэрэг 30 орчим оронд 5G дэд бүтцийг барих гэрээ байгуулсан.

Хятад улс “6G”-г хөгжүүлэх судалгааг хэдийн эхэлж, 2030 оноос Зэвсэгт хүчинд нэвтрүүлэхээр төлөвлөж буй бөгөөд ирээдүйн дайн “6G” технологийн тусламжтайгаар илүү автомажсан болж байлдааны тактик, зэвсгийн хөгжүүлэлт, байлдааны талбарын холбоо зэрэг цэргийн талбарт хувьсал авчрах ажээ. Хятадын цэрэг “6G” технологийг өрсөлдөгч нараасаа урьтаж эзэмшнээрээ олон давуу талыг эзэмших юм. Байлдааны ажиллагааны үед тагнуулын мэдээлэл олж авах тал дээр илүү чадавхтай болж зэвсгийн хувьд дрон, автомажсан дайны-машин, робот зэрэг ухаалаг зэвсэг, техникийг өргөнөөр ашиглах боломж бүрдэж дайнаасаа “илүү хурдтай”, “илүү мэдээлэлжсэн” байх давуу байдал үүсэх юм.

Дүгнэлт

ХАЧА уламжлалт дайны тухай ойлголтоос хэдэн нүүдлийн цаадахыг харж, сэтгэж ирээдүйн болзошгүй дайнд бэлтгэж буй. Хятад улс ирээдүйн дайнд хиймэл оюун ухаан, технологийн дэвшлийг ашиглан илүү

¹⁵ “Fast forward with 5 G” <http://www.airforcemag.com/MagazineArchive/Pages/2019/July%202019/Fast-Forward-with-5G.aspx>



“мэдээлэлжсэн” цэрэг “ухаалагжсан” зэвсэг, техниктэйгээр оролцохоор эрмэлзэж байна. Цэргийн шинэчлэлийн хүрээнд Зэвсэгт хүчинд төрөл бүрийн робот технологи, ухаалаг зэвсэг, техникийг нэмж улмаар 2030 он гэхэд “6G” технологийг зэвсэглэлд нэвтрүүлвэл дайснаасаа хэд дахин илүү “мэдээлэлжсэн”, илүү “ухаалаг” зэвсэгтэйгээр давуу байдлыг эзэмших боломжтой болно гэж үзэж байна. Гэвч технологийн хувьд давуу байдал эзэмшлээ гэхэд бие бүрэлдэхүүнийг хурдацтай өөрчлөгдөж буй технологийн шинэчлэлээс хоцролгүй сургаж бэлтгэх асуудал чухлаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад богино хугацаанд дасан зохицох, технологийн өндөр чадвартай

бие бүрэлдэхүүнтэй байхыг шаардаж буй. Энэ тухайд Хятадын Ардын Чөлөөлөх Арми тусгай үүргийн цэргийн төрлийг нэмэгдүүлж чиглэл, чиглэлээр мэргэшсэн багуудыг бэлтгэж байна. Хятадын Ардын Чөлөөлөх Армийн нүсэр бүтцээс улбаалсан шат дараалсан хүнд суртал зэрэг асуудал нь зэвсэг, техникийн хөгжилтэй зэрэгцэн цаг тутам өөрчлөгдөж буй байлдааны шинэ орчин нөхцөлд бие бүрэлдэхүүнийг богино хугацаанд чадавхжуулж, бэлэн байдлыг хангахад хүндрэл учруулж байна. Тиймээс ч Хятадын Ардын Чөлөөлөх Армид хийж буй шинэчлэлийн хүрээнд цэргийн байгуулалтын шинэчлэл явагдсан бөгөөд үр дүнг нь нарийн тодорхойлоход арай эртдэх бизээ.

Ашигласан материал:

1. Б.Эрдэнэчимэг. “Хятадын цэрэг, батлан хамгаалах бодлого шинэ зуунд”. 2020 он. т20
2. Belt and Road Space information corridor, China daily, 23,09,2018 <http://www.chinadaily.com.cn/a/201809/13/WS5b99b2c5a31033b4f4655bde.html>
3. China raises defense budget by 7.2% for 2024, 'conducive to peace, stability' – Global Times. China raises defense budget by 7.2% for 2024, 'conducive to peace, stability'
4. China Aerospace Studies Institute, "In Their Own Words: Science of Military Strategy 2013," February, 2021, <https://www.airuniversity.af.edu/Portals/10/CASI/documents/Translations/2021-02-08%20Chinese%20Military%20Thoughts-%20In%20their%20own%20words%20Science%20of%20Military%20Strategy%202013.pdf>
5. "China aims to launch Chang'e-6 lunar probe around 2024," http://www.xinhuanet.com/english/2021-04/24/c_139903600.htm
6. Dengyun YU "China Deep Space Explorations: Achievements and Prospects," https://www.unoosa.org/documents/pdf/psa/activities/2022/UN-China/Presentations/1a-2_Dengyun_Yu_en.pdf
7. Hisao Motomura. "The hegemony strategy and the aerospace power of China in preparation for 2020". 2013.
8. Li, Nan. "The PLA's Evolving Warfighting Doctrine, Strategy and Tactics, 1985-95: A Chinese Perspective." The China Quarterly, no. 146 (1996): 443-63.
9. Lina Zvetski, "China wants to dominate space, and the US must take countermeasures", <https://www.defense-news.com/opinion/commentary/2020/06/23/china-wants-to-dominate-space-and-the-us-must-take-counter-measures/>
10. "Fast forward with 5 G" <http://www.airforcemag.com/MagazineArchive/Pages/2019/July%202019/Fast-Forward-with-5G.aspx>
11. "Full Translation: China's 'New Generation Artificial Intelligence Development Plan' (2017)," <https://www.newamerica.org/cybersecurity-initiative/digichina/blog/full-translation-chinas-new-generation-artificial-intelligence-development-plan-2017/>
12. M.Taylor Favel, Active Defense: China's Military Strategy since 1949 (Princeton, NJ: Princeton University Press, 2019).
13. The State Council Information Office of the People's Republic of China "China's Military Strategy", May 2015, Beijing <http://eng.mod.gov.cn/Database/WhitePapers/index.htm>
14. 刘明福。 “中国梦”， 2015
15. 中国合理确定2023年国防支出规模 比上年执行数增长7.2% <http://www.mod.gov.cn/gfbw/xw-fyr/ztzh/16206779.html>



ҮНДЭСНИЙ ХЭВ ШИНЖ, ТҮҮНИЙ БҮРДЭЛ

П.МӨНХБААТАР ЛУБХИС-ийн Эрдмийн сургуулийн докторант/
Б.ТАМЖИДДОРЖ ЛУБХИС-ийн Эрдмийн сургуулийн магистрант

Түлхүүр үг: Үндэсний эв нэгдэл, үндэсний хэв шинж, үндэсний үнэт зүйл, үндэстэн

Key words: National Unity, National Identity, National Values, Nation

Оршил

Үндэсний эв нэгдэл нь иргэдийг эх орноо хайрлах сэтгэл, нутаг дэвсгэр, уламжлал, зан заншил, нийгэм, соёлоор нь нэгтгэдэг бөгөөд тэдний үндэсний үзэл, үнэт зүйлсээ хуваалцах боломжийг олгодог.

Өнөө цагт монголчуудад үндэсний хэв шинжээ хадгалж үлдэх, гадны нөлөөллөөс хамгаалж, аливаа сорилтыг тэсэж гарах дархлаа бүхий үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг хангах шаардлага тулгарч байна.

Иймд энэ өгүүлэлд үндэсний эв нэгдлийн суурь болсон үндэсний хэв шинж, түүний бүрэлдэхүүн хэсгийн тухай өгүүлнэ.

Үндэсний эв нэгдэл (national unity) гэж тухайн улсын иргэдийн хамтын үнэт зүйл, түүх, зорилгод тулгуурласан нэгдмэл холбоог хэлнэ^{1,2}. Энэ нь харьяалал, хамтын ажиллагаа, хамтын хариуцлагын мэдрэмжийг төрүүлдэг учраас нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой³. Үндэсний эв нэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлд нийтлэг уламжлал, нутаг дэвсгэр, нийгэм-соёлын нэгдмэл байдал багтаж байгаа⁴ хэдий ч энэхүү ойлголт нь цаг

хугацааны явцад хэл, эдийн засаг, соёл, сэтгэл зүй зэрэг элементүүдийг багтаан хувьсан өөрчлөгдөж байна⁵. Ийм учраас үндэсний эв нэгдэл нь зөвхөн бэлгэдлийн илэрхийлэл төдийгүй тухайн үндэстний доторх олон үндэстний бүлгүүдийн бодит хамтын ажиллагаа, харилцан ойлголцол⁶ учраас энэ нь улс орны ард түмний дунд аюулгүй байдал, хөгжил дэвшил, ижил төстэй байдлын мэдрэмжийг дэмжихэд нэн чухал үүрэгтэй.

Дээрхээс үзэхэд, үндэсний эв нэгдэл гэдэг нь нийгэм, соёлын өөр өөр гарал үүсэлтэй янз бүрийн бүлгүүдийг нийгмийн нэг систем, нэг тогтоц болгон нэгтгэх үйл явц, түүнийг дэмжих төрийн бодлогын зорилт юм. Гол үзэл баримтлал нь гарал үүсэл, хэв шинж, ашиг сонирхлын ялгаатай бүлгүүдийг нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйл, ашиг сонирхлын хүрээнд нийгмийн нэг системд нэгтгэхэд оршино.

Үндэсний нэгдмэл байдал нь нийгмийн дэг журмыг бий болгох, түүний суурь үзэл баримтлал, үнэт зүйлсийг хөгжүүлэхэд тусалдаг. Үндэсний хэмжээнд эв нэгдэл нь улс орны тогтвортой байдлыг бэхжүүлж, хөгжил цэцэглэлтийг дэмжиж, үндэстнээ нэгтгэх үйл явц юм. Эв нэгдэл нь нэг талаас нийгэм, соёлын нэгдмэл байдлыг бий болгох замаар хүчирхэг, нэгдмэл улс байгуулах үндэсний ашиг сонирхол дээр тулгуурладаг.

Үндэсний эв нэгдэл нь үндэсний тогтвортой

Ahmad; Mohd Murshidi Mohd Noor; Sedek Ariffin; Ahmad K. Kasar; Selamat Amir & Mohd Roslan Mohd Nor. (2012). National Unity and Development from Islamic Point of Views., Middle-East Journal of Scientific Research 12 (6): 767–773, 2012 ISSN 1990–9233 © IDOSI Publications, 2012 DOI: 10.5829/idosi.mejsr.2012.12.6.1759;

¹ Jilani Ben Touhami Meftah; Hazem.H.H. Zyoud; Ishak Suliaman; Mustaffa Abdullah; Faisal Ahmad Shah; Mohd Yakub Zulkifli Mohd Yusoff; Munirah Abd Razzak; Fauzi Deraman; Khadher Ahmad; Mohd Murshidi Mohd Noor; Sedek Ariffin; Ahmad K. Kasar; Selamat Amir & Mohd Roslan Mohd Nor. (2012). National Unity and Development from Islamic Point of Views., Middle-East Journal of Scientific Research 12 (6): 767–773, 2012 ISSN 1990–9233 © IDOSI Publications, 2012 DOI: 10.5829/idosi.mejsr.2012.12.6.1759;

² Щетинина, А. В.; Семёхина, А. С. (2021). Языковая репрезентация идеи национального единения в медийном дискурсе., Вестник ТГПУ (TSPU Bulletin), 2021. 1 (213). стр. 18–27., УДК 811.161.1'371., DOI 10.23951/1609–624X–2021–1–18–27https://typeset.io/pdf/language-representation-of-the-idea-of-national-unity-in-5fgebxolg1.pdf;

³ Мөн тэнд

⁴ Jilani Ben Touhami Meftah; Hazem.H.H. Zyoud; Ishak Suliaman; Mustaffa Abdullah; Faisal Ahmad Shah; Mohd Yakub Zulkifli Mohd Yusoff; Munirah Abd Razzak; Fauzi Deraman; Khadher

⁵ Gu Boran. (2021). The Role of National Unity under Psychological Vision in the Realization of the Great Rejuvenation of the Chinese Nation., Journal of Sociology and Ethnology (2021) 3: 111–114., Clausius Scientific Press, Canada., DOI: 10.23977/jsoc.2021.030214., ISSN 2616–2318;

⁶ Мөн тэнд



байдалд чухал ач холбогдолтой бөгөөд тогтвортой байдал нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж өгдөг.

Аливаа улс оронд үндэсний эв нэгдэл яагаад чухал вэ гэдэг асуултад хариулахдаа судлаачид дараах дөрвөн үзэгдлийг онцолсон байна⁷.

Үндэсний эв нэгдэл улс оронд баттай тогтсоноор:

1. Үндэстэн, ястан хоорондын сөргөлдөөн тэмцэл багасаж, нэг улс оронд амьдарч буй өөр өөр үндэстэн, ястнуудын хооронд эв найрамдал бий болдог.

2. Эх оронч сэтгэлгээг бий болгодог. Өөр өөр үндэстэн ястны нэг төлөөлөл гэхээс илүүтэйгээр нэг улс орны иргэн гэдгээ ойлгож, эх орноо хайрладаг.

3. Энх тайванч байдал бий болно. Үр дүнд нь улс орныхоо өнцөг булан бүрт тайван амгалан ажиллаж, амьдрах боломж хүн бүрийн өмнө нээгддэг.

4. Өөр өөр угсаатан, ястанууд хоорондоо гэр бүл болохыг дэмждэг. Энэ нь үндэсний эв нэгдлийг илүү ахисан түвшинд гаргаж, бэхжүүлж байдаг.

И.Дамбажав (2010) “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг”-т “үндэстэн – нийтийн нэг хэл, соёл, газар нутагтай, түүхийн урт удааны хугацааны явцад бүрэлдэн тогтсон ястануудын нэгдэл” гэж тайлбарласан байна⁸. Доктор К.Дэмбэрэл “үндэстэн (nation)”⁹ гэдэг нь угсаа гарал, хэл, зан заншил, түүх соёл, амьдралын хэв маяг болон сэтгэл зүйн хувьд нэгдмэл хүмүүсийг нэгэн үндэстэн” гэж тодорхойлжээ¹⁰.

“Үндэстэн” хэмээх ойлголтыг олон улсын харилцаанд оруулж илэрхийлэгч нь үндэсний үзэл (nationalism, национализм) хэмээн

томъёолж болох учраас энэхүү судлагдахуунд үндэсний асуудыг үндэсний үзэл санаа, хуваагдмал үндэстэн хэмээх хоёр томъёоллоор авч үзэх нь судалгааг илүү цэгцтэй болгоно. Тухайн үндэстний эрх ашиг, үнэт зүйл нь өөрийн нь иргэнд бусад улс, үндэстнийхээс ямагт илүү байдаг.

Үндэстэн нь аль болох тусгаар байх, нэн ялангуяа улс төрийн тусгаар байдлаа ямагт хадгалахыг эрмэлздэг нь үндэсний үзэл санааны тулгуур цэг болно¹¹.

1 дүгээр хүснэгт

Үндэстний шинж, эрх ашиг, тусгал

Үндэстний шинж	Үндэстний эрх ашиг	Үндэстний эрх ашгийн тусгал,
1. Угсаа, гарал үүсэл нэг	1. Үндэстэн бүрэн бүтэн, хуваагдмал бус байх	Эдгээр эрх ашгийг хэвийн хэмжээнд хөгжиж, үйл ажиллагааг явуулахад нөлөөлөх гадны нөлөөнөөс хамгаалах
2. Нэг газар нутагт хамтдаа аж төрдөг	2. Үндэстэн аюулгүй байх	
3. Нэгдмэл нэг угсаатан	3. Үндэстэн соёлын хувьд ижил, нэгдмэл байх	4. Улсын дотоодод нийгмийн тогтвортой байдал, дэг журам, хэлхээ холбоог дэмжих
4. Үндэсний эдийн засаг, улс төрийн хэлхээ, холбоо	4. Байгалийн баялгаа ашиглах, хянах боломжоор хангагдах	

Эх сурвалж: К.Дэмбэрэл., т.135

“Үнэт зүйл” гэсэн ойлголт аливаа улс үндэсний хувьд дотоод мөн чанар, ижилсэл-ондоошил (national identity)-той уялдаатай байдаг. Ард түмний оюун санаа, хүсэл эрмэлзэл, дотоод мөн чанарын нэгдлийг олох нь аливаа улс орны хувьд амин чухал асуудал байдаг бөгөөд энэ нь улс орнуудын оршин тогтнох, хөгжин дэвжихийн үндэс болдог (Зураг 1)



1 дүгээр зураг. Үндэсний аюулгүй байдал хийгээд олон улсын харилцааны хамаарал дахь үндэсний эв нэгдэл

Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжлийн үндэс нь үндэсний эв нэгдэл бөгөөд түүний

¹¹ Мөн тэнд, т.152


⁷ Social Studies by Simiyu Wandibba, pp. 231–233;

⁸ Дамбажав, И. (2010). Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж. II боть. Нэмж, засварласан хоёррдахь хэвлэл. –УБ., Өнгөт хэвлэл ХХК., ISBN 99929–10–65–8., 75.88 х.х., т.481;

⁹ Латин хэлний “nation” гэдэг нь “нийт ард түмэн” хэмээх нэршил. Анхны утга нь хар уу, цагаан уу, орос уу, хятад уу гэдгээ үл хамаараад нийт иргэд гэдгийг нэрлэсэн

¹⁰ Дэмбэрэл, К. (2018). Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс. –УБ., Эдмаркет ХХК., ISBN 978–99978–3–783–7., 35.5 х.х., т.150

амин чухал хүчин зүйл нь үндэсний үнэт зүйлс юм (Зураг 1).



2 дугаар зураг. Үндэсний эв нэгдэл

Үндэсний эв нэгдэл нь хүмүүсийг улс төрийн харьяалал гэхээсээ илүү эх орноо хайрлах сэтгэл, нутаг дэвсгэр, уламжлал, зан заншил, нийгэм-соёл, тухайлбал, монголчуудын эрхэмлэн дээдэлбэл зохих монгол хүн, төрт ёс, гэр бүл, эх нутаг, монгол хэл, эрдэм боловсрол, ёс суртахуун, өв соёл, нүүдэлчин ухаан нэгтгэх бөгөөд хүмүүсийн үндэсний үзэл, үнэт зүйлсээ хуваалцах боломжийг олгодог байна¹².

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “нийгмийн үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно” бөгөөд “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн¹³.” гэж онцлон тэмдэглээд, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчимд “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх. Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх, эх оронч үндэсний үзэл, улс үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэж заасан нь Монгол Улсын иргэдийн оюун санаанд гадаад хэл соёл, үзэл санаа, сэтгэлгээний нөлөөгөөр монгол үндэсний хэв шинж бүдгэрч, үзэл бодол, сэтгэлгээнд өөрчлөлт орж байгаа өнөө үед чухал ач холбогдолтой болоод байна.

Өдгөө үндэсний хэв шинжээ хадгалж

үлдэх, гадны нөлөөллөөс хамгаалж, аливаа сорилтыг тэсэж гарах дархлаа бүхий үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай тулгарч байна.

Үндэсний хэв шинж бүрэлдсэн тохиолдолд үндэсний ашиг сонирхлоо дээдлэн нутгархах, намчирхах үзэл арилж, эв нэгдэл бий болсноор төрийн бодлогын залгамж чанар хадгалагдах бөгөөд үндэсний хэмжээний асуудлаар нэгдмэл байр суурьтай байх боломж бүрдэнэ.

Үндэсний хэв шинж, түүний бүрдэл хэсэг.

Даяаршил, мэдээллийн эрин үед улс орнууд үндэсний хэв шинжээ хадгалж үлдэх, гадны нөлөөллөөс хамгаалж, өнөө ба ирээдүйн сорилтыг тэсэж гарах дархлаа бүхий үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай тулгарч байна.

Угсаатан бүрэлдэх, задрах үйл явц нь нийгмийн бүх үйл явцтай ямар нэг хэмжээгээр холбоотой. Угсаатан бүрэлдэн бий болж, төр улс оршин тогтноход нэгтгэх нэгэн хүч нь эв нэгдлийн үзэл санаа юм. Угсаа гарвал, аж ахуй, хэл, соёл, зан үйл, сэтгэл зүйн нийтлэг шинж бүрэлдэн нэгдсэнээр үндэсний эв нэгдлийн үзэл санаа бүрэлддэг.

Монгол хэлний тайлбар толь бичигт “эв нэгдэх – санаа явдал зохицон нийлэлцэх, хавсралцах” гэж тайлбарласан байна¹⁴.

Бромлей, Ю.В. “хүмүүс өөрсдийгөө ямар нэгэн ард түмэнд хамааруулан ухамсарлах явдал нь үндэстнийг бүрэлдүүлдэг^{15,16}.” Зөвлөлт Холбоот Улс болон ОХУ-ын эрдэмтэн, зохиолч ба орчуулагч, дорно-дахин судлаач эрдэмтэн Лев Николаевич Гумилёв “Хүмүүсийн ухамсраас үл хамааран угсаатан бүрдэх үйл явц явагдах бөгөөд эерэг таарамж, нийлэмжийн чанартай хүмүүс өөр хоорондоо ойртон нийлж, угсаатны нийтлэгүүдийг бүрэлдүүлдэг байна. Аливаа ард түмнийг нэгтгэж байгаа хүчин зүйлс нь гарал үүсэл зэрэг илэрхий гадаад зүйлст байдаггүй, харин тухайн ард түмний гишүүн бүхэн өөрийгөө нэг ард түмэн гэж үзэх явдал юм¹⁷.” гэжээ.

¹² ССХ. (2021). “Монгол Улсын үндэсний эв нэгдэлд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замууд” судалгааны тайлан. –УБ., Стратеги судалгааны хүрээлэн., х.49;

¹³ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо. Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын талаарх төрөөс баримтлах бодлогын эмхэтгэл. –УБ. Колор Ланд: 2018. т.4–31. (1.1.6);

¹⁴ Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. –УБ., “Мөнхийн үсэг” ХХК, 1311х., т.1193, ISBN: 978-99973-2-165-7;

¹⁵ Бромлей, Ю.В. (1983). Очерки теории этноса. Академия наук СССР. Издательство “Наука”. –М., стр.418;

¹⁶ Дэлгэржаргал, П. (2005). Монголчуудын угсаа гарвал. –УБ., Соёмбо принтинг. т.22

¹⁷ Гумилев, Л.Н. (1994). Этногенез и биосфера. М. стр.621



Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийгөө тухайн улсын ард түмэнд хамааруулж ойлгох, өөрийгөө тэр ард түмний нэг эд эс гэж үзэх үзэл санаан дээр үндэслэн оршин тогтнодог.

Аливаа угсаатан, үндэстэн бусдаас гарал үүсэл, түүх, хэл соёл, газар нутаг, нөөц баялаг, түүнийгээ эзэмших, захиран зарцуулах, тусгаар тогтнох эрх зэрэг олон шинжээр онцгойрон ялгардаг бөгөөд эдгээр нь нийтдээ угсаатны эсвэл үндэстэний хэв шинжийг бүрдүүлдэг.

Үндэстний хэв шинж бүрэлдсэн тохиолдолд үндэстний ашиг сонирхлоо урьтал болгон нутгархах, намчирхах үзэл арилж, эв нэгдэл бий болсноор төрийн бодлогын залгамж чанар хангагдана. Түүнчлэн үндэстний эдийн засгийн сэтгэлгээг төлөвшүүлж, үндэстний хэмжээний асуудлаар нэгдмэл байр суурьтай байх боломж бүрдэнэ.

Үндэстний хэв шинж (national identity) хэмээх ойлголт нь өргөн утгатай. Оксфордын англи хэлний тайлбар толь бичигт “identity – адил/ижил байдал; шинж тэмдэг, мэдрэмж, итгэл үнэмшлээрээ ялгах, ондооших: үндэстний хэв шинж (өвөрмөц байдал)” гэж тайлбарласан байна¹⁸. Өөрөөр хэлбэл, энэ нь монгол хүн, монгол үндэстэн гэсэн ухагдахууныг бусад улс үндэстнээс ялгарах онцгой шинж тэмдэг буюу тус ухагдахууныг агуулна. Онцлох хэв шинжүүдээрээ хоорондоо адилсан нэгдэх үйл явцыг үндэстний ижилсэл¹⁹ (national identification) гэдэг.

Үндэстний хэв шинж нь угсаатны болон иргэнлэг хэв шинжүүдийн тэнцвэрт хослол бүхий өргөн агуулгатай ухагдахуунаар тодорхойлогдож байна. Энэ тэнцвэр алдагдан, үндэстний хэмжээний нийтлэг хэв шинжийг орхигдуулан, угсаатны хэв шинжүүдэд, зарим тохиолдолд ястаны хэв шинжид явцууран хуваагдаж, иргэншлийн, иргэнлэг хэв шинжүүдийг орхигдуулж байгаа нь сөрөг үр дагавартай юм.

Үндэстэний хэв шинж ба иргэнлэг хэв шинж, тэдгээрийн хослол нь үндэстний хэв

¹⁸ Oxford Advanced Learner's Dictionary. New 9th Edition. (2015). Oxford University Press. 1820p., 779p ISBN: 978-0-19-4799485: identity – the characteristics, feelings or beliefs that distinguish: national identity

¹⁹ Даваадорж, Ц. (2016). Үндэстний аюулгүй байдлыг хангах нийгэм, соёлын хүчин зүйлс: эрсдэл ба сорилт. “Монгол хэл соёлын дархлааг буй болгох зарим арга зам” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. –УБ., т10

шинжийг тодорхойлдог. Үндэстний хэв шинжийн бүрдэлд орох үндэстний буюу угсаатны хэв шинжийг дотор нь биологийн, ухамсрын гэж ангилдаг бол иргэнлэг хэв шинжийг дотор нь материаллаг, эрх зүйн ба цаг хугацааны гэж хувааж болно (Хүснэгт 1.2).

2 дугаар хүснэгт

Үндэстний хэв шинжийн бүрдэл

Хэв шинжийн төрөл	Хэв шинжийн ангилал	Хэв шинжийн бүрдэл			
Үндэстний /угсаатны	Биологийн	Гарал үүсэл	Удмын сан	Насжилт	Арьсны өнгө төрх
	Ухамсрын	Хэл	Соёл уламжлал	Шашин шүтлэг	Үзэл бодол
Иргэнлэг	Материаллаг	Газар нутаг	Байгалийн нөөц баялаг	Эдийн засаг	Биет өмч
	Эрх зүйн	Иргэншил	Төр засаглал	Үндсэн хууль	Эрх зүйн систем
	Цаг хугацааны	Гадаад хэмнэл /дэлхийн/	Дотоод хэмнэл /системийн/	Бүлгийн хэмнэл	Хувьс-лын үе шат

Биологийн хэв шинжийн хувьд гарал үүсэл, удмын сан ижил бол нэгэн омог, ястан, угсаатан, үндэстнийг бүрдүүлдэг. Тухайн улс, үндэстэн, нийгмийн гишүүдийн физиологийн онцлог, арьсны өнгө, дүр төрх, бие бялдрын хөгжил, эрч хүч, эрүүл мэнд, түгээмэл өвчин, эмгэгт нэрвэгдсэн эсэх нь онцлог шинж болдог. “Биополитик²⁰ нь улс төрийн бодлого, үйл ажиллагаа биологийн хэв шинжид хэрхэн нөлөөлөх, өөрөөр хэлбэл халдварт өвчин, удмын сангийн доройтол, нийгмийн хөгшрөлт, насжилт зэрэг нь улс төрийн бодлогод хэрхэн нөлөөлөхийг судалдаг.

Ухамсрын хэв шинжийг хэл соёл, зан үйл, уламжлал, шашин шүтлэг, үзэл бодол, улс төр, итгэл үнэмшил тодорхойлно. Улс үндэстнийхээ хэл соёл, удмын сан, эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, хүн амын нөхөн үржихүйн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхийг этнополитик гүйцэтгэнэ.

Материаллаг хэв шинжийг газар нутаг, байгалийн нөөц, хүний нөөц, санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн нөөц бүрдүүлж, үндэстний эдийн засгийн харилцаа системийг бий болгодог.

Эрх зүйн хэв шинж нь заяагдмал болон үүсмэл эрх зүйгээр тодорхойлогдож, тухайн ард түмэн болон иргэн газар нутаг, баялаг, нөөцөө

²⁰ Thomas Lemke. (2011). Biopolitics: An Advanced Introduction. NYU Press. pp 9–10

захиран зарцуулах бүрэн эрхтэй эсэх, өөрийн төр засаглал, нийгмийн тогтолцоо, эрх зүйн хэм хэмжээ нь нэн чухал хэв шинж болж байдаг.

Тухайн улс үндэстэн нь нийгмийн системийн хэлбэрийн хувьд дотоод хэмнэл болон хөгжлийн үе шатны буюу хувьслын хэмнэл гэсэн цаг хугацааны онцлог хэв шинжийг агуулна. Систем бүр үүсэх, бүрэлдэн тогтох, хөгжих, уурах, сарних гэх зэрэг хувьслын үе шатуудыг дамжих бөгөөд үе шат бүр нь өвөрмөц хэмнэлтэй байдаг тул тухайн нийгмийн, үндэстний хэсэг бүр хөгжлийн ижил үе шатанд ижил дотоод хэмнэлтэй оршиж байвал нэгэн хэмнэлээр ижилссэн цаг хугацааны хэв шинж бүрэлдэснийг харуулна.

Дээрх 5 төрлийн хэв шинж нь бүгд бүрдсэн үндэстэн нь ижил гарвал, үүсэл, шашин, үзэл санаа, газар нутаг, эрх зүйгээр нэгдэн адилсаж, хөгжлийн ижил хэмнэлээр амьдарч, тусгаар тогтносон үндэстний нэгдмэл улс үндэс (nation state)–ийг бүрдүүлнэ.

Үндэстний хэв шинжийн зарим хэсэг нь заяагдмал (үндэс, угсаа, хэл, соёл) байдаг бол зарим хэсэг нь үүсмэл (үзэл бодол, шашин шүтлэг, иргэншил) байдаг. Үүсмэл хэв шинжийг тухайн хүнд эрх зүй, дүрэм журмаар тулгаж, эсхүл өөрөө хүлээн зөвшөөрч авдаг²¹. Өөр шашинтай боллоо гэхэд тухайн шашны дэгийг дагах шаардлагатай болох эсхүл сайн дураараа хүлээн зөвшөөрөх болно. Тухайн нийгмийн системийн нэг хэсэг эсхүл гишүүн буюу хувь хүн тодорхой хэв шинжээ өөрөө хүлээн зөвшөөрч, өөр үндэстэн, нийгэм, иргэншил, харьяат, шашны бүлэг гэх мэт ангид хандлага гаргахаас сэргийлэх шаардлагатай.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толинд “Нийтийн нэг хэл соёл, газар нутагтай түүхийн урт удаан хугацааны явцад бүрэлдэн тогтсон ястануудын нэгдэл”²² гэж тайлбарласан байна. “Үндэстэний” гэдэг ойлголтын “үндэстний” гэдгээс ялгагдах гол ялгаа нь үндэстэнд тухайн

нутагт амьдарч буй үндэстний төлөөлөгчдөөс гадна өөр үндэстэн, ястаны нутагт амьдарч байгаа төлөөлөгчид нь бас багтдаг байна. Харин “үндэстний гэдэгт нэг улсад амьдарч буй өөрийн төр улстай ард түмнийг хэлдэг” байна.

Үндэстэн нь өөрийн улс, төр засаг, хууль тогтоомж, эдийн засаг, нөөц баялагтай буюу иргэнлэг хэв шинжтэй байж nation буюу улс үндэс, үндэстний гэсэн тодотголтой болно.

Дүгнэлт Үндэстний эв нэгдэл гэдэг нь гарал үүсэл, хэв шинж, ашиг сонирхлын ялгаатай бүлгүүдийг нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйл, ашиг сонирхлын хүрээнд нийгмийн нэг системд нэгтгэхийг хэлдэг байна. Өөрөөр хэлбэл, үндэстний эв нэгдэл үндэстнээ нэгтгэх үйл явц бөгөөд нийгэм, соёлын нэгдмэл байдлыг бий болгох замаар хүчирхэг, нэгдмэл улс байгуулах үндэстний ашиг сонирхол дээр тулгуурладаг.

Биологийн, ухамсрын, материаллаг, эрх зүйн, цаг хугацааны хэв шинж нь бүгд бүрдсэн үндэстэн нь ижил гарвал, үүсэл, шашин, үзэл санаа, газар нутаг, эрх зүйгээр нэгдэн адилсаж, хөгжлийн ижил хэмнэлээр амьдарч, тусгаар тогтносон үндэстний нэгдмэл улс үндэс (nation state)–ийг бүрдүүлнэ.

“Үндэстний” гэдэг ойлголтын “үндэстний” гэдгээс ялгагдах гол ялгаа нь үндэстэнд тухайн нутагт амьдарч буй үндэстний төлөөлөгчдөөс гадна өөр үндэстэн, ястаны нутагт амьдарч байгаа төлөөлөгчид нь бас багтдаг байна. Харин “үндэстний гэдэгт нэг улсад амьдарч буй өөрийн төр улстай ард түмнийг хэлдэг” байна.

²¹ Caputti, M. (1996). National Identity in Contemporary World, Political Psychology, Vol. 17, No.4;

²² Дамбажав, И. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. –УБ., :”Өнгөт хэвлэл” ХХК, 2010. 1240., т.481, ISBN: 99929-10-65-8

Ашигласан материал:

1. Бромлей, Ю.В. (1983). Очерки теорий этноса. Академия наук СССР. Издательство "Наука". –М., стр.418;
2. Гумилев, Л.Н. (1994). Этногенез и биосфера. М. стр.621
3. Даваадорж, Ц. (2016). Үндэсний аюулгүй байдлыг хангах нийгэм, соёлын хүчин зүйлс: эрсдэл ба сорилт. "Монгол хэл соёлын дархлааг буй болгох зарим арга зам" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. –УБ., т10
4. Дамбажав, И. (2010). Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж. II боть. Нэмж, засварласан хоёррдахь хэвлэл. –УБ., Өнгөт хэвлэл ХХК., ISBN 99929–10–65–8., 75.88 х.х., т.481;
5. Дэлгэржаргал, П. (2005). Монголчуудын угсаа гарвал. –УБ., Соёмбо принтинг. т.22
6. Дэмбэрэл, К. (2018). Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс. –УБ., Эдмаркет ХХК., ISBN 978–99978–3–783–7., 35.5 х.х., т.150
7. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо. Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын талаарх төрөөс баримтлах бодлогын эмхэтгэл. –УБ. Колор Ланд: 2018. т.4–31. (1.1.6)
8. ССХ. (2021). "Монгол Улсын үндэсний эв нэгдэлд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замууд" судалгааны тайлан. –УБ., Стратеги судалгааны хүрээлэн., х.49;
9. Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл. –УБ., "Мөнхийн үсэг" ХХК, 1311х., т.1193, ISBN: 978–99973–2–165–7;
10. Щетинина, А. В.; Семёхина, А. С. (2021). Языковая репрезентация идеи национального единения в медийном дискурсе., Вестник ТГПУ (TSPU Bulletin). 2021. 1 (213). стр. 18–27., УДК 811.161.1'371., DOI 10.23951/1609–624X–2021–1–18–27https://typeset.io/pdf/language–representation–of–the–idea–of–national–unity–in–5fgebxolg1.pdf;
11. Caputti, M. (1996). National Identity in Contemporary World, Political Psychology, Vol. 17, No.4;
12. Jilani Ben Touhami Meftah; Hazem.H.H. Zyoud; Ishak Suliaman; Mustafa Abdullah; Faisal Ahmad Shah; Mohd Yakub Zulkifli Mohd Yusoff; Munirah Abd Razzak; Fauzi Deraman; Khadher Ahmad; Mohd Murshidi Mohd Noor; Sedek Ariffin; Ahmad K. Kasar; Selamat Amir & Mohd Roslan Mohd Nor. (2012). National Unity and Development from Islamic Point of Views., Middle–East Journal of Scientific Research 12 (6): 767–773, 2012 ISSN 1990–9233 © IDOSI Publications, 2012 DOI: 10.5829/idosi.mejsr.2012.12.6.1759;
13. Gu Boran. (2021). The Role of National Unity under Psychological Vision in the Realization of the Great Rejuvenation of the Chinese Nation., Journal of Sociology and Ethnology (2021) 3: 111–114., Clausius Scientific Press, Canada., DOI: 10.23977/jsoc.2021.030214., ISSN 2616–2318;
14. Oxford Advanced Learner's Dictionary. New 9th Edition. (2015). Oxford University Press. 1820p., 779p ISBN: 978–0–19–4799485: identity – the characteristics, feelings or beliefs that distinguish: national identity
15. Social Studies by Simiyu Wandibba, pp. 231–233;
16. Thomas Lemke. (2011). Biopolitics: An Advanced Introduction. NYU Press. pp 9–10



АШИГТ МАЛТМАЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Б.БЯМБАСАЙХАН /ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн магистрант/
Б.ЭРДЭНЭЧИМЭГ /ҮБХИС-ийн Эрдмийн сургуулийн багш, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, ашигт малтмал, байгалийн баялаг

Key words: Security, Economic Security, Mining, Mining, Natural Resources

Оршил

Ашигт малтмал, байгалийн баялгаа хэрхэн зүй зохистой ашиглахаас тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил хамаардаг. Улс орны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг харгалзан ашигт малтмалын нөөцийг ашиглах үндсэн чиглэлийг тодорхойлсноор улсын бүрэн эрхт байдал, эдийн засгийн бие даасан байдал баталгаажна. Өөрөөр хэлбэл, тухайн улс өөрт байгаа байгалийн баялаг, бүтээх чадвар, дотоод хуримтлал, хүмүүний чадавх болон бусад нөөцийг үр ашигтайгаар зарцуулах, үүнд чиглэсэн төрийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар эдийн засгийн бие даасан байдлаа бэхжүүлдэг. Мөн гаднаас ирэх хатуу, зөөлөн хүчний бодлогыг саармагжуулах, нөлөөллийг багасгах, тэсч гарах чадавхтай болно.

Байгалийн баялагтай орнуудын хувьд эдийн засгийн өсөлт авчирна гэхээсээ илүүтэй байгалийн баялгаас хувь хүртэх гэсэн дотоодын улс төрийн бүлэглэлүүд талцаж, нийгэмд ажилгүйдэл, ядуурал баян хоосны ялгаа гүнзгийрч, иргэдийн эсэргүүцэл тэмцэл идэвхжин эмх замбараагүй үймээн самуун үүсэж, улмаар зэвсэгт мөргөлдөөнд хүрэх байдал ч бий болж болно. Энэ нь тухайн улс орны эдийн засгийн өсөлтөд таагүй нөхцөлийг бий болгоод зогсохгүй улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолд ч ноцтой уршиг учруулах эрсдэл бий болгодог байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өнөөгийн байдлаар 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий 1000 гаруй орд газар, 8000 гаруй илрэл бүртгэгдээд байна. Монгол Улсын зөвхөн 17 нэр төрлийн¹ ашигт малтмалын нөөцийн одоогийн

үнэлгээ 3.1 их наяд ам.доллартай тэнцүү буюу 1 хүнд 1 сая ам.долларын байгалийн баялгийн нөөц ногдож байна. Үүнээс 708 тонн алтны нөөцийн зах зээлийн үнэлгээ 29.9 тэрбум ам.доллар, 460 сая тонн төмрийн хүдрийн үнэлгээ 32.1 тэрбум ам.доллар, 1.2 тэрбум тонн коксжих нүүрсний нөөцийн үнэлгээ 296.4 тэрбум ам.доллар, 31.5 тэрбум тонн эрчим хүчний нүүрсний үнэлгээ 1.9 их наяд ам.доллар, 79.5 сая тонн зэсийн нөөцийн үнэлгээ 529.5 тэрбум ам.доллар, 101.6 сая тонн хайлуур жоншны нөөцийн үнэлгээ 39.6 тэрбум ам.доллар, 332.6 сая тонн газрын тосны нөөцийн үнэлгээ 21.8 тэрбум ам.доллар, 11.5 сая тонн молибдений нөөцийн үнэлгээ 277.1

тэрбум ам.доллар тус тус бүрдүүлж байна (үүний 30 орчим сая тонн нь Оюу толгой ордод хамаарна)². Өөрөөр хэлбэл, бид байгалийн баялгаа оновчтой удирдаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, “зөв” хөрөнгө оруулалт хийж чадвал манай улсыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх арвин их санхүүгийн нөөц газрын хэвлийд байна.

Ашигт малтмалын эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг дараах байдлаар тодорхойлов.

Эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөө.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл³ нь эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн

ховор элемент, цагаан тугалга, хар тугалга, гянтболд орно..

² Алсын хараа-2050”. Монгол Улсын хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал”. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол. “Ногоон хөгжил” дэд бүлэг.

³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дугаар зүйл.

¹ Эдгээрт алт (үндсэн), алт (шороон), мөнгө, төмрийн хүдэр, коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс, цайр, зэс, хайлуур жонш, газрын тос, уран, фосфорит, молибден, газрын

загварыг бий болгоход орших бөгөөд түүнчлэн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ гэж заасан байдаг.

Байгалийн баялгийн орлого нь гадаад валютаар бүрдэх тул төсвийн зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг болж валютын дотогшлох урсгал, валютын нөөцийг нэмэгдүүлдэг. Улс орнууд тухайн баялгийн ажил эрхлэлт, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд шаардлагатай хүмүүн болон капитал руу шилжүүлэхийг зорьдог. Гэхдээ бодит байдал дээр байгалийн баялгийг капитал, бүтээмж болон институцийн хөгжил рүү шилжүүлэх ажил туйлын болох нь батлагдсан. Байгалийн баялгаар арвин хөгжиж буй орнуудын эдийн засгийн дундаж өсөлт нь байгалийн баялаггүй орнуудын өсөлтөөс бага байдаг гэсэн эмпирик баримтыг Ауы (1993) “байгалийн баялгийн хараал” гэж нэрлэсэн. Үүнийг төсвийн сахилга батгүй байдал, сул засаглалын бодит үр дагавар гэж дүгнэсэн⁴.

Ашигт малтмал, байгалийн баялагийн орлого нь үр дүнтэй ашиглагдсан хэдий ч, баялгийн экспорт дотоодын валютын ханшийг чангаруулж, уул уурхайн бус бусад худалдаалагддаг салбаруудад (боловсруулах салбар, хөдөө аж ахуйн салбар гэх мэт) сөрөг нөлөө үзүүлэх тохиолдол гардаг. Үүнийг “голланд өвчин” гэж нэрлэдэг. Үүний үр дагаварт байгалийн баялгийг экспорт өндөртэй орнууд нь цорын ганц, хэлбэлзэл өндөртэй орлогын эх үүсвэртэй болж үлдэх бөгөөд орлогын хэлбэлзэл нь макро эдийн засгийн тогтворгүй байдалд мөн хөтөлдөг. Өөрөөр хэлбэл “голланд өвчин” нь “байгалийн хараал” бий болох зөвхөн нэг суваг юм. Манай орны хувьд “голланд өвчин” –ний шинж тэмдгүүд илэрдэг хэдий ч боловсруулах салбарын уналт нь өвчний шинж тэмдэг илрэхээс өмнө буюу 1990–ээд оны эхэн үеийн өмч хувьчлалаас эхтэй байдаг. Харин тус өвчний нөлөөгөөр боловсруулах салбар эргэн сэргэхэд хүндрэлтэй, эдийн засаг гадаад шоконд хэт өртөмхий гэж тайлбарлах нь илүү

зохистой юм⁵.

Уул уурхай, ашигт малтмал нь хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбаруудын хамт Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдалд нэн чухал ач холбогдолтой ба эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч юм.

Эдийн засагчдын зүгээс төсвийн орлого уул уурхайгаас өндөр хамааралтай байгаа тул орлогыг бүрдүүлэх төлөвлөгөө чухал гэж онцолж байна.

Байгалийн баялагтай орнууд амжилттай хөгжиж чаддаггүй олон төрлийн шалтгаанууд байдаг хэдий ч, нийтлэг 2 шалтгаан бий. Эхнийх нь хэлбэлзэлтэй, цаг хугацааны тодорхой үед л орж ирдэг нөөцийн орлогыг зөв удирдаж, захиран зарцуулахад хүндрэл учирдаг. Хоёрдох нь, засаглал хангалттай сайн бүрдээгүй явдал буюу нөөцийн орлогыг богино хугацааны зарцуулалтын дарамтаас хамгаалж, урт хугацааны хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд чиглүүлж чаддаггүй явдал юм⁶.

Манай улсын хувьд энэ хоёр шалтгаан хоёулаа “асуудал” болж байна. Иймд байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжихийн тулд нөөцийн орлогыг зохистой хуримтлуулж, зарцуулах, тухайн улсын засаглал, институцийг бэхжүүлэх явдал туйлын чухал юм. Үүний тулд нэгд; нөөцийн орлогыг нэмэгдүүлэх, тогтвортой байх татварын зохистой тогтолцоог бүрдүүлэх (шаардлагатай реформыг хийж, дараагийн том ордууд дээр мөрдүүлэх), хоёрт; нөөцийн орлого, түүний зарцуулалтыг ил тод байлгах, нөөцийн орлогыг баялгийн санд хуримтлуулж, зарцуулах төсвийн дүрмийг чанд мөрдөх, өнөөдөр хэрэглэхээс илүүтэй ирээдүйн тогтвортой өндөр өсөлтийг бий болгох хөрөнгө оруулалт болгох, гуравт; төсвийн сахилга батыг хангаж хяналт тавих, засаглалыг бэхжүүлж, улс төрөөс хараат бус байх эрх зүйн орчин хэрэгжилтийг бүрдүүлэх шаардлагатай юм.

⁴ Энхчимэг.Д, Мөнх-Оргил.Т “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам: онол, аргазүй, туршлага, шинжилгээ, боломж”, УБ 2021 он, ISBN:978-9919-24-353-1.

⁵ Ө.Мөнххишиг. “Үндэсний аюулгүй байдлыг хангахад уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөлөл” аюулгүй байдлын ухаанаар магистрын зэрэг горилсон ажил. 2021 он.

⁶ Мөн тэнд



ШИГТГЭЭ:

Өндөр хөгжилтэй улс орнуудын байгалийн баялаг, ашигт малтмалын импортын хэрэгцээ өсөн нэмэгдэж, хөгжиж байгаа ба буурай хөгжилтэй орны уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх, байгалийн баялгийг олборлох, ашиглах бодлогыг хэрэгжүүлж байна. Энэ нь Монгол Улсад дэлхийн томоохон улс орнууд болон үндэстэн дамнасан корпорациудын ашиг сонирхолыг бий болгож байна. Иймд дэлхий нийтийг хамарсан хөрөнгийн урсгалын чиг хандлага, олон улсын интеграци, үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа, хөдөлгөөнийг анхааралтай ажиглан, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын үр ашгийг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг өрөөсгөл байдлаар, өөрөөр хэлбэл нэг салбар (уул уурхай ашигт малтмал)–т хэт их төвлөрүүлснээс эдийн засагт сөрөг үр дагавар бий болж буйг анхааран, эдийн засгийн аюулгүй байдлын гадаад, дотоод орчны өөрчлөлтөд байнга дүн шинжилгээ хийж байхыг шаардаж байна.

Манай улс “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” –ийг анх 1993 онд баталж, үүнээс хойш нийгэмд бий болсон шинэ нөхцөл байдлыг харгалзан 1998, 2001, 2002, 2008, 2011 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн. Харин 2013 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг хүчингүй болгож, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын харилцааг зохицуулах “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийг баталсан.

Аюулгүй байдлын гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт, ашигт малтмал, байгалийн баялагийн талаарх хууль эрх зүйн орчин тогтворгүй, дэлхийн зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөн зэрэг хүчин зүйлтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт 2011 оноос ихээхэн хэмжээгээр буурсан байна. Мөн 2013 онд “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийг хүчингүй болгосон.

БХЭШХ–ийн судлаачдын багийн гүйцэтгэсэн “Эрдэс баялгийн олборлолт ба үндэсний аюулгүй байдал сэдэвт судалгааны ажилд дараах үр дүн гарсан байна. Уул уурхай, ашигт малтмалын эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөлөл^{1,7}”

Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Нөлөөгүй буюу маш бага	бага	дунд	их Онц аюултай
Эдийн засгийн олон тулгуурт бүтэц;			+	
Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого;			+	
Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал;			+	

Дээрх хүснэгтээс харахад Уул уурхай, ашигт малтмалын эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг 3 үзүүлэлтээр авч үзсэнээс бүгд дунд зэргийн нөлөөтэй гэсэн байна. Энэ нь ашигт малтмалыг эрэх хайх,

олборлох асуудал эдийн засгийн олон тулгуурт бүтэц,хөрнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, төсөв санхүүгийн салбарын аюулгүй байдлын бодлогод дунд зэргийн нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Ашигт малтмал, эрдэс баялгийн олборлолт нь улс оронд эдийн засгийн хувьд үр өгөөжөө өгөх боловч орлогын тэгш бус хуваарилалт, улс төрийн буруу бодлогын улмаас үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг

Олон улсын туршлага, сургамажаас харахад дараах эрсдэлүүд тулгарч болзошгүй байдаг байна. Үүнд:

- Стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийг ашиглах, хяналтандаа байлгах зорилго бүхий байгалийн баялгаас үүдэлтэй зөрчил, сөргөлдөөний эх сурвалж нь баялгийн шударга бус хуваарилалт байдаг байна. Хэрэв тухайн улсын эдийн засаг нэг гол төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байдаг бол тухайн улсад зэвсэгт мөргөлдөөн гарах магадлал нэмэгддэг байна.

- Орлогын тэгш бус байдал нь нийгмийн тогтворгүй байдал, зөрчлүүд, хүчирхийллийн шалтгаан болдог бөгөөд баян ядуугийн ялгаа ихэсдэг. Сүүлийн жилүүдэд зарим стратегийн шинжтэй эрдэс, баялгийн нөөц хомсдож, үнэ огцом өсөн нэмэгдэж байгаа нь өрсөлдөөнийг улам ширүүсгэж сөргөлдөөний хэлбэрт оруулж байна.

- Манай улсын уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, стратегийн ордуудыг ашиглаж буй өнөө үед үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг аль алиныг нь эрхэмлэн тэнцвэржүүлж, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан тогтвортой хамтын ажиллагааг бий болгох нь чухал. Тогтвортой хамтын ажиллагаа нь хөрөнгө оруулагчийн болон үндэсний эрх ашиг хоёрын тэнцвэрийг хангасан үед бий болдог ба тэнцвэр алдагдвал зөрчил үүсдэг байна.

- Төр засаг нийгэмдээ хэт их зүйлийг амлаж, уул уурхайн ашгаас хүртэх хүлээлт үүсгэдэг бөгөөд амлалт, нийгмийн хүлээлт хоёрын зөрүү их байх тусам зөрчил аажим үүсч, иргэдийн бухимдал нэмэгдэж, сөргөлдөөнд огцом хүргэх эрсдэлтэй.

⁷ “Эрдэс баялгийн олборлолт ба үндэсний аюулгүй байдал . Судалгааны ажлын тайлан. БХЭШХ. 2019. т52



- Байгалийн нөөц ихтэй манай улсын хувьд бүс нутгийн геостратегийн ашиг сонирхлын солбилцол болж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох эрсдэлтэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтыг хэт дэмжин ард иргэдийнхээ амьдралыг доройтуулах эсвэл үндэсний эрх ашгаа хэт дөвийлгөж, гадны нөлөө бүхий улс орнуудын эрх ашгийг үл харгалзах аль аль нь зөрчил үүсгэх түгээмэл нөхцөл болдог байна.

- Уул уурхайн үйлдвэр хүрээлэн буй орчинд хүчтэй, олон талын нөлөө үзүүлдэг үйлдвэрийн тоонд ордог. Ашигт малтмал олборлолтонд газар нутгийг идэвхитэй ашиглах нь газрын гадаргууг сүйтгэх, уулын боловсруулалт, уулын газар шорооны ажил, голын гидрологи горим алдагдах, хөрсний бохирдол, гадаргуун болон гүний ус бохирдох, экологийн системийн бүрэн бүтэн байдал алдагдах, байгалийн тогтоцод

эвдрэл гарах зэрэг таагүй нөлөө үзүүлдэг.

Дүгнэлт

Ашигт малтмал, эрдэс баялгийн олборлолт нь улс оронд эдийн засгийн хувьд үр өгөөжөө өгөх боловч орлогын тэгш бус хуваарилалт, улс төрийн буруу бодлогын улмаас үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг. Иймд ашигт малтмал, эрдэс баялгийн түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр урт хугацаанд хэлбэлзэх, уул уурхайн гарцаагүй тохиолдох уналтууд, эдийн засгийн томоохон савалгаа болзошгүй эрсдэлд улс орон ямагт бэлэн байх учиртай.

Манай улсын тухайд эдийн засгийн бүтэц эмзэг, төрөлжилт муутай үндсэндээ ашигт малтмал, эрдэсийн салбараасаа шууд хамааралтай дэлхийн зах зээлийн үнээс хэт хараат болсон гэдэг нь судалгааны явцад ажиглагдлаа.

Ашигласан материал:

1. Алсын хараа–2050". Монгол Улсын хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал". УИХ–ын 2020 оны 52 дугаар тогтоол. "Ногоон хөгжил" дэд бүлэг.
2. Мөнхшиг.Ө "Үндэсний аюулгүй байдлыг хангахад уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөлөл" аюулгүй байдлын ухаанаар магистрын зэрэг горилсон ажил. 2021 он.
3. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дугаар зүйл.
4. Энхчимэг.Д, Мөнх–Оргил.Т "Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам: онол, аргазүй, туршлага, шинжилгээ, боломж", УБ 2021 он, ISBN:978–9919–24–353–1.
5. "Эрдэс баялгийн олборлолт ба үндэсний аюулгүй байдал". Судалгааны ажлын тайлан. БХЭШХ. 2019. т526. Adolfson, M Laseen, S, Linde, and Villani, M2008 "Evaluating an estimated New Keynesian Small open model", Journal of International Economics vol 32, pp2960–2721.



ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ИРГЭДИЙГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

/Бүгд Найрамдах Солонгос Улсын жишээн дээр/

Э.НАЦАГДОРЖ /Доктор (Ph.D), дэд профессор/
Б.ПҮРЭВСҮРЭН /ҮБХИС-ийн магистрант/

Түлхүүр үг: Онцгой нөхцөл байдал, нүүлгэн шилжүүлэлт, урьдчилан сэргийлэх, арга хэмжээ, тээвэрлэлт,

Key words: Emergency situation, relocation, preventive measures, transportation

Оршил

Солонгосын Хойгийн асуудал нь нийгмийн хоёр өөр тогтолцоотой, хүйтэн дайны үеийн болон түүхэн улбаатай үзэл суртлын зөрчилдөөнтэй; шашин соёл иргэншлийн олон хэлбэртэй, хөгжлийн түвшин, чадавхын ялгаа ихтэй улс орнууд оршин тогтнож байгаа нь олон улсын тавцанд геополитикийн олон талт байдлыг бий болгож байна.

БНАСАУ–ын цөмийн зэвсгээс үүдэн Солонгосын хойг дахь цэргийн тогтворгүй байдал нь цэргийн хурцадмал байдлыг үүсгэж, БНАСАУ нь цөмийн зэвсгийг ашиглах үед Өмнөд Солонгос чирэгдэхээс өөр аргагүй болно гэсэн болгоомжлолыг төрүүлж байна¹.

Цөмийн хүчин чадалтай Хойд Солонгос цэргийн итгэл найдвартай байгаа нөхцөлд Өмнөд Солонгосын эсрэг илүү зоригтой орон нутгийн ердийн өдөөн хатгалга явуулна гэж зарим шинжээч үзэж байна².

Цаашид Хойд Солонгос Өмнөд Солонгосыг онилсон стратегиа үргэлжлүүлж, цэргийн болон цэргийн бус өдөөн хатгалга явуулсаар байх болно³.

Иймд бус нутагт болон улс оронд тохиолдсон олон нийтийг хамарсан үймээн самуун, томоохон террорист халдлага, мөргөлдөөн, зэвсэгт түрэмгийлэл бий болж онцгой нөхцөл байдал үүсэх магадлалтай байна.

Онцгой нөхцөл байдал нь хууль сахиулах болон төрийн бусад байгууллага, газрууд, тусгай алба, гүйцэтгэх засаглалын зүгээс нөхцөл байдлыг хэвийн болгоход чиглэсэн хойшлуулшгүй, тэргүүн зэргийн арга хэмжээ авахыг шаарддаг⁴.

¹ Сон Жэюун , Зүүн хойд азийн бус нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд хийсэн судалгаа, 48т

² Эш –1

³ Эш –1

⁴ Цэргийн нэр томъёоны тайлбар толь 175т

БНСУ–д онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажиллах үндсэн арга хэмжээнүүд нь төлөвлөгөөний дагуу хийгдэх бөгөөд гадаад иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг тус улсын Засгийн газар болон холбогдох байгууллагууд удирдан зохион байгуулдаг байна.

Онцгой байдлын төлөвлөгөө: БНСУ–ын Засгийн газар онц нөхцөл байдлын үед гадаад иргэдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг урьдчилан боловсруулсан байдаг. Энэ нь нүүлгэн шилжүүлэлтийн явцыг үр дүнтэй, аюулгүй байдлаар зохион байгуулахад чиглэгддэг. БНСУ–ын Онцгой байдлын төлөвлөгөө нь дараах үндсэн зарчмуудад тулгуурладаг:

–Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

Онцгой нөхцөл байдал үүсэхээс өмнө гадаад иргэдийг аюулгүй газар руу нүүлгэн шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд тухайн улсаас гарахыг зөвлөдөг байна.

Эрсдэлийн үнэлгээ хийх, анхааруулга, зөвлөмж өгөх, консулын үйлчилгээг үзүүлж мөн мэдээллийн солилцоог идэвхтэй явуулдаг байна. Үүнд: БНСУ–ын Гадаад хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагууд үнэлж, эрсдэлийн түвшинг тодорхойлож, гадаад иргэдэд анхааруулга, зөвлөмж өгч, аюулгүй байдлаа хангах арга хэмжээ авахыг зөвлөхөөс гадна гадаад улсуудын Засгийн газартай солилцож, хамтран ажилладаг.

–Нүүлгэн шилжүүлэлтийн бэлтгэл:

Шаардлагатай тохиолдолд БНСУ–ын Засгийн газар гадаад иргэдийг нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, тээврийн хэрэгсэл, нөөцийг бүрдүүлдэг.

Хэл, соёлын бэрхшээлийг даван туулах, гадаадын иргэд юу хийх ёстойг тайлбарласан гарын авлага, видео хичээл, хэл, соёлын онцлогийг харгалзан анхааруулга, зөвлөмжийг олон хэлээр бэлтгэж, хүртээмжтэй байдлаар



түгээдэг байна.

Мөн нүүлгэн шилжүүлэлтийн цэг, маршрут, шаардлагатай баримт бичиг зэрэг мэдээллийг багтаана.

БНСУ–ын Онцгой байдлын төлөвлөгөөний Урьдчилан сэргийлэх арга хэмжээний Шуурхай анхааруулга, мэдээлэл нь дараах байдлаар хэрэгждэг:

Шуурхай анхааруулга, мэдээлэл өгөх зориулалттай анхааруулгын систем байдаг. Энэ систем нь гар утас, телевиз, радио, чанга яригчаар дамжуулан мэдээлэл түгээдэг ба мөн мэдээллийн агуулга /онцгой байдлын түвшин, төрөл, байршил, цар хүрээ/ давтамж ба хүртээмжийг тодорхой болгодог⁵ байна.

–Нүүлгэн шилжүүлэлтийн цэг, маршрут:

Тодорхой байршлуудад нүүлгэн шилжүүлэлтийн цэгүүдийг байгуулж, гадаад иргэдийг аюулгүй байдлаар тээвэрлэх маршрутыг төлөвлөнө.

Нүүлгэн шилжүүлэлтийн цэг: Аюулгүй, хүртээмжтэй байршил, хангалттай зай талбайтай, олон хүнийг хүлээн авах боломжтой, ус, цахилгаан, бие засах газар зэрэг дэд бүтцээр хангагдсан, эмнэлгийн анхан шатын тусламж үзүүлэх боломжтой байх шаардлагыг хангасан байна.

Нүүлгэн шилжүүлэлтийн цэг рүү очих замыг нүүлгэн шилжүүлэлтийн маршрут гэнэ. Эдгээр маршрутууд нь аюулгүй, хүртээмжтэй зам, замын тэмдэглэгээ, чиглүүлэгчтэй, замын хөдөлгөөнийг зохицуулах боломжтой, яаралтай тусламжийн тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой байх шаардлагыг хангасан байна.

Дээрх цэг, маршрутын төлөвлөхдөө БНСУ–ын засгийн газар нь онцгой байдлын үеийн нүүлгэн шилжүүлэлтийн цэг, маршрутын байршил, тоо хэмжээ, цэг, чиглэлийн дэд бүтцийн нөхцөл, хүчин чадал, нүүлгэн шилжүүлэлтийг удирдан зохион байгуулах байгууллага, ажилтнууд, нүүлгэн шилжүүлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан тооцоолсон⁶ байдаг.

–Тээвэрлэлт, ложистик:

Нүүлгэн шилжүүлэлтийн цэгээс аюулгүй газар руу гадаад иргэдийг тээвэрлэх автобус, галт тэрэг, онгоц зэрэг тээврийн хэрэгслийг

⁵ БНСУ–ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд

⁶ БНСУ–ын Онцгой байдлын удирдлагын агентлаг (<https://ndmi.go.kr>)

бэлдэнэ. Мөн шатахуун, хоол хүнс, эм тариа зэрэг зайлшгүй шаардлагатай нөөцийг бүрдүүлнэ. БНСУ–ын Онцгой байдлын төлөвлөгөөнд урьдчилан сэргийлэх арга хэмжээний тээвэрлэлт, ложистикийг дараах байдлаар тусгадаг байна.

Тээвэрлэлтийн төлөвлөгөөнд тээврийн хэрэгслийн төрөл, тоо хэмжээ (автомашин, автобус, галт тэрэг, усан онгоц гэх мэт), тээвэрлэх ачаа, зорчигчдын тоо, хэмжээ, маршрут, цагийн хуваарь, удирдан зохион байгуулах байгууллага, ажилтнууд зэрэг асуудлуудыг урьдчилан боловсруулдаг.

Агуулах, ачаа тээшний байгууламжийн байршил, хүчин чадал, хангамжийн сүлжээ, нийлүүлэлтийн эх үүсвэрүүд, ачаа тээшийг хадгалах, ачих, буулгах, тээвэрлэх журам, ложистикийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах байгууллага, ажилтнуудыг мөн төлөвлөсөн байдаг. БНСУ–ын засгийн газар нь онцгой байдлын үеийн тээвэрлэлт, ложистикийн үйл ажиллагаанд орчин үеийн технологийг ашигладаг. Жишээлбэл: GPS, RFID зэрэг мэдээллийн технологи ашиглан тээвэрлэлт, ложистикийн үйл ажиллагааг хянах, удирдах. Автоматжуулсан агуулах, роботжуулсан ложистик систем⁷ ашиглах гэх мэт.

–Эрүүл мэнд, анхны тусламж:

Нүүлгэн шилжүүлэлтийн явцад гадаад иргэдийн эрүүл мэндийг хангах, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх эмч, эмнэлгийн ажилтнуудыг бэлтгэнэ. Үүнд: Эмнэлгийн байгууллагуудын бэлэн байдал, хүчин чадал, эмч, эмнэлгийн ажилтнуудын тоо, ур чадвар, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, хангамж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ, мөн анхны тусламжийн багийн бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөц, хангамж, анхны тусламж үзүүлэх заавар, журам, сургалт, дадлага гэх мэт ордог байна.

Эрүүл мэндийн үйл ажиллагаанд алсын зайн оношилгоо, эмчилгээний технологи, эрүүл мэндийн мэдээллийн удирдлагын систем ашигладаг.

–Аюулгүй байдал:

Нүүлгэн шилжүүлэлтийн цэг, тээвэрлэлтийн

⁷ БНСУ–ын Онцгой байдлын менежментийн төв (<https://nema.go.kr>)



замыг цэрэг, цагдаагийн хүчнийхэн хамгаалж, гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангадаг. Үүнд:

Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ / хамгаалалтын бүс тогтоох, хяналтын цэгүүд байгуулах/, аюулгүй байдлын хүчний бүрэлдэхүүн, үүрэг хариуцлага, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөц, хангамж зэргийг тодорхой тусгасан байдаг. Аюулгүй байдлын технологи нь биометрийн таних технологи / хурууны хээ, нүүрний таних/, дроны технологи /аюулгүй байдлын тандалт, хяналтад ашиглах/, кибер аюулгүй байдлын технологи⁸ зэрэг болно.

–Олон улсын хамтын ажиллагаа:

Шаардлагатай тохиолдолд БНСУ нь олон улсын байгууллагууд, гадаад улсуудтай хамтран ажиллаж, нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулдаг ба НҮБ болон НҮБ–ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)–тай онцгой байдлын менежментийн чиглэлээр идэвхтэй хамтран ажилладаг.

Мөн Зүүн Азийн орнуудтай хамтран "Зүүн Азийн гамшгийн менежментийн төв",

⁸ БНСУ–ын Дотоод хэргийн яам, (<https://www.mois.go.kr>)

ASEAN+3 (АСЕАН–ы 10 орон + БНХАУ, Япон, БНСУ) орнуудтай хамтран "ASEAN+3 Гамшгийн менежментийн төв"–ийг байгуулсан⁹ байдаг.

АНУ–тай "Онцгой байдлын менежментийн хамтын ажиллагааны санамж бичиг", Европын Холбоотой "Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг" байгуулжээ.

–Эх орондоо буцахад дэмжлэг үзүүлэх:

Нүүлгэн шилжүүлэлтийн дараа гадаад иргэд эх орондоо буцахад нь дэмжлэг үзүүлдэг. Үүнд тээврийн зардал, визний асуудал, эх орондоо дасан зохицох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, эх орондоо бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг багтдаг байна.

Гадаадын иргэд эх орондоо буцаж очихдоо ажил эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх, зарим гадаадын иргэд эх орондоо буцаж очихдоо бизнес эрхлэх сонирхолтой байдаг зэрэг асуудалд БНСУ–ын Засгийн газар энэ асуудлыг шийдвэрлэхийн сургалт, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулдаг байна

⁹ БНСУ–ын Гадаад хэргийн яам, (<https://www.mofa.go.kr>)

Ашигласан материал:

1. Цэргийн нэр томъёоны тайлбар толь УБ, 2014
2. Монгол Улсын гамшгийн тухай хууль
3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт/ Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам/
4. Сон Жэюун , Зүүн хойд азийн бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд хийсэн судалгаа, магистрын ажил
5. БНСУ–ын Гадаад хэргийн яам (Ministry of Foreign Affairs вэбсайт (<https://www.mofa.go.kr>))
6. БНСУ–ын Дотоод хэргийн яам (Ministry of the Interior and Safety (<https://www.mois.go.kr>))
7. БНСУ–ын Үндэсний Онцгой Комисс (National Emergency Management Agency (<https://www.nema.go.kr>))
8. БНСУ дах гадаад улсын Элчин сайдын яамдын сайт
9. БНСУ–ын Онцгой байдлын удирдлагын агентлаг (<https://ndmi.go.kr>)
10. БНСУ–ын Онцгой байдлын менежментийн (<https://nema.go.kr>)



МЭДЭЭЛЭЛ СЭТГЭЛ ЗҮЙН ДАЙНЫ НӨЛӨӨЛӨЛ

Б.АМАРТӨР /БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан магистр/

Түлхүүр үг: мэдээлэл ба сэтгэл зүйн дайн, сэтгэл зүйн нөлөө, ташаа мэдээлэл, бодлогын нөлөө, танин мэдэхүйн дайн

Key words: information and psychological warfare, psychological influence, disinformation, influencing policy, cognitive warfare

Оршил.

Мэдээллийг сэтгэл зүйн ажиллагаатай хамт авч үзэж, мэдээллийн технологийг ашиглан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах болсон. Мэдээлэл нь тухайн улс орны ард иргэдийн оюун санаа, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, төөрөгдөл, эргэлзээ төрүүлэх үйл явц өрнөж бидний өдөр тутмын амьдралд илрэх болоод байна. Мэдээлэл зүйн ажиллагаагаар дамжуулж, тухайн улс орны ард иргэдийн оюун санаа, сэтгэл зүй, уламжлалт өв соёл, засаглалыг мэдээллээр дамжуулж өөрчлөх замаар стратегийн зорилгодоо хүрэх үйл явц гадаад орчинд идэвхжих болов.

Үндсэн хэсэг

“Дайн” нь хүний тархинд үй олноор сүйтгэдэг цус урсгасан тэмцэл гэх ойлголтыг шууд өгдөг. Дэлхийн I дайн зэвсэглэсэн хүмүүс хоорондын дайн, II дайн нь моторжуулсан зэвсэг, байлдааны техник ашигласан улс төр, үзэл суртал хоорондын дайн болж өнгөрсөн.

Харин дэлхийн II дайн дууссан үеэс эхэлсэн хүйтэн дайн XX зууны сүүлийн хагаст 40 гаруй жил үргэлжилсэн бөгөөд суртал ухуулга, мэдээлэл, сэтгэл зүйн тэмцлээр өрнөж байсан.

Хүйтэн дайны үед АНУ-ын соёлын дипломат ажиллагааны хөтөлбөрүүдийг Тагнуулын төв газар болон Төрийн департамент санхүүжүүлэн зохион байгуулж ЗХУ-ын эсрэг явуулж байсан нь АНУ-ын “аварга том мэдээлэл, суртал ухуулга, сэтгэл зүйн довтолгоо” байсан.

Сүүлийн арван жилийн хугацаанд дайн нь ердийн дайны физик аюулаас холдож, эрс өөрчлөгдсөн. Энэхүү дайны аюул нь одоо олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, технологийн дэвшлээс үүдэлтэй нийгэм болон ард иргэдийн үзэл бодол, оюун санааны бай болгож байна.

Энэхүү шинэ төрлийн дайн гарч ирсэн нь бидний өмнө нь харж байсан бүх зүйлээс өөр юм.

Хэдийгээр энэ нь өмнөх төрлийн хосолмол дайны элементүүдийг өөртөө агуулсан боловч

түүний нөлөөллийн хүрээ, түвшин нь хосолмол дайны аюулаас илүү өргөн хүрээнд нөлөөлж байна.

Мэдээлэл-сэтгэл зүйн дайн нь мэдээллийн урсгалыг хянахын төлөөх тэмцлээс эхэлдэг бөгөөд түүний гол зорилго нь хүмүүсийн мэдээлэлд хандах хандлагыг хянах, өөрчлөхөд оршдог.

Мэдээлэл-сэтгэл зүйн дайн нь стратегийн сонирхол бүхий улс орныг дотроос нь оюун санаа, сэтгэл зүйн хувьд сулруулахад чиглэгддэг бөгөөд төрийн бодлогод нөлөөлөх, төрийн байгууллагыг тогтворгүй болгох зорилгоор гаднын байгууллага, улс төрчдийг ашиглан олон нийтийн санаа бодлыг өөрчлөх системтэй үйл ажиллагаа явуулдаг.

Мэдээллийн хяналтгүй тархалт, дижиталчлал, тархи судлал, сэтгэл зүй судлалын дэвшлүүд нь нийгэмд асар их ач тусыг өгч шинэ боломжуудыг бий болгосон ч мөн шинэ аюулыг үүсгээд байгаа болно.

Өнөөдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэдхэн минутын дотор олон тэрбум хүмүүст ямарваа нэгэн мэдээллийг хяналтгүйгээр хүргэх боломж бий болж, энэ нь ихээхэн эрсдэлт байдлыг үүсгээд байна.

Өдгөө энэ ажиллагаа технологийн дэвшлийг ашиглан “мэдээлэл-сэтгэл зүйн дайн” тэмцлийн хэлбэрт шилжээд байгаа бөгөөд үүнийг судлаачид дэлхийн шинэ төрлийн дайны аюул гэж үзэх болсон.

Орчин үеийн улс, нийгмийн хөгжлийн түгээмэл шинж чанар бол мэдээллийн нийгэм, мэдээллийн урсгал болон мэдээллийг хэрхэн хүлээж авахыг хянаж удирдахын төлөөх тэмцэл болоод байна.

Мэдээлэл-сэтгэл зүйн ажиллагаа нь сэтгэл зүйд нөлөөлж, бодол үзэл санаа, ойлголтыг өөрчилдөг эргэлзээ төөрөгдөл бий болгодог хамгийн хүчтэй зэвсэг болоод байна.



Тодорхой зорилго, чиглэлтэй системтэй мэдээллээр сөргөлдөгч улсынхаа удирдлага, хүн ам, хууль тогтоох байгууллага болон цэргийн алба хаагчдын ухамсар, сэтгэл зүйд нөлөө үзүүлэх боллоо.

Мэдээллийн дайн, сэтгэл зүйн дайны арга барилын аюулын талаар ХАЧА-ын агаарын цэргийн хоёр ахлах хурандаа Цяо Лян, Ван Сянсүй нар "Хязгааргүй дайн" (1999) номдоо: "Компьютер байгаа ямар ч өрөөнөөс бүр эсвэл хөрөнгийн биржийн арилжааны талбараас ч харийн улс руу томоохон хэмжээний аюултай халдлага хийх бүрэн боломжтой. Ийм аюул оршин байгаа ертөнцөд тулаан тэмцлийн талбар бус гэх газар үлдсэн үү? Дайны талбар хаана байна вэ? Хаа сайгүй байсаар байна." хэмээн дурдсан байдаг.1

"Мэдээлэл, сэтгэл зүйн дайны мөн чанар нь цаг хугацаа, орон зай, хамрах хүрээ хязгааргүй" болж, нийгмийн бүхий л салбарт оршдог боллоо. Тийм учраас мэдээллийн хамрах хүрээ, нөлөөлөх боломж нь хүний төсөөлөх чадвараас давж улс орнуудын тулгамдсан асуудал болоод байна.

Мэдээллийн дайн болон сэтгэл зүйн дайн, сэтгэл зүйн үйл ажиллагаа гэх эдгээр нэр томъёо нь маш төстэй утга, үүрэгтэй бөгөөд эдгээрийг тус тусад нь ялгаж салгахад ихээхэн учир дутагдалтай ба бүгд нөлөөллийн шинж чанарыг агуулсан байдаг.

Мэдээлэл, сэтгэл зүйн нөлөө нь өнөө үед улс орнуудын геополитикийн өрсөлдөөнд ашиглагдаж, стратегийн давуу талыг буй болгох гол зэвсэг нь болж байгаа бөгөөд хүч хэрэглэх бус тэмцлийн аргаар эсрэг талын нийгэм, улс төрийн амьдралд шууд нөлөөлөх орчин нөхцөлийг бий болгодог.

Улс орнууд олон улс дахь байр суурь, нөлөөгөө тэлэх зорилгоор явуулж буй далд, уламжлалт бус дайны ажиллагааны нэг талбар нь мэдээлэл, сэтгэл зүйн талбар болоод байгаа бөгөөд үүгээр дамжуулан үзэл бодол, оюун санааны өөрчлөлтийн довтолгоог алс хэтийн зорилготой идэвхтэйгээр явуулж байна.

Улс орон, нийгэм хөгжихийн хэрээр аюулгүй байдлын асуудалд зарчмын өөрчлөлтүүд гарч, шинэ төрлийн сөрөг нөлөө, аюул бий болсоор байна. Үүнд кибер цэрэг, кибер зэвсэг, кибер дайн, кибер халдлага, цахим мэдээллийн орчин, өнгөт хувьсгал зэрэг мэдээллийн орон зайн харилцааны шинэ арга хэлбэрүүд гарч ирж, түүний үзүүлэх сөрөг нөлөөллийг судлах, бууруулах асуудлыг судлах хэрэгцээ шаардлага

манайд бий болоод байна.

Эдгээр шинэ төрлийн зэвсэг, түүний дотор физик, сэтгэл зүйн шинэ зарчимд суурилсан зэвсэг ихээхэн бүтээгдэх боллоо. Сүүлийн үед цэргийн судлаачдын ихэнх нь олон зуун мянган цэргийн алба хаагч, танк, их буу оролцсон дайн тулаан холдож, тэдгээрийн оронд зэвсэгт тэмцлийн уламжлалт бус хэлбэр, аргуудаар ялангуяа мэдээлэл-сэтгэлзүй, хуулийн арга хэрэгслүүд, шинэ техник, технологиудыг улс төр, эдийн засгийн зорилгоо хангах чухал хүчин зүйл болгон ашиглах болсон нь сүүлийн үеийн дайн, цэргийн мөргөлдөөнөөс харагдах боллоо.

Мэдээлэл-сэтгэл зүйн дайны ажиллагаа нь гибрид дайны нэг төрөл болж, улам бүр хөгжиж боловсронгуй болсоор байна.

Мэдээллийн эриний өнөө цагт мэдээлэл, түүний технологид хувьслын шинж чанартай өөрчлөлтүүд явагдаж, түүний улс төр, нийгэм эдийн засагт болон цэрэг, батлан хамгаалах хүрээнд үзүүлэх нөлөөлөл нь эрс өсөн нэмэгдэж улс орны аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал болоод байна.

Үүний улмаас зэвсэгт тэмцлийн арга ажиллагаа өөрчлөгдөж байна. Эдүгээ цус ургасан дайн, цусгүй дайнаар солигдож байгааг цэргийн судлаачид хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын ажиллагааны цар хүрээг өргөтгөх шаардлага буй болоод байна.

Мэдээлэл нь өөртөө бүтээн босгох болон устган сөнөөх их хүчийг нэгэн адил тээж явдаг. Цаг хугацааны аясаар мэдээллийн мөн чанар өөрчлөгдөөд зогсохгүй түүний нөлөөллийн эрчим хувьсаж, өргөн хүрээтэй болсоор байна.

Мэдээллийг хэрэглэх контекст ч өөрчлөгдсөөр байна. Тухайлбал, хүний хувийн мэдээлэл нийгмийн шинж чанартай болж, энэ нь алдар цуутай хүмүүс, улс төрийн зүтгэлтнүүд нэгэн адил хамрагдах боллоо. Улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг дайны гэх мэт нийтийг хамарсан аливаа шийдвэр гаргахад мэдээллийн үүрэг өсөж, үүний үр дүнд улс төр, нийгмийн бодлого нь улам бүр олон нийтийн өнгө аястай, болсоор байна

"Хүн цэрэг, армийн довтолгоог нүдээрээ харж аюулыг нь шууд мэдэж мэдэрдэг бол мэдээлэл, оюун санааны довтолгооны аюулыг олж харч чадахгүй байгаа нь дэлхий дээр явагдсан дайн тулаануудаас харагдаж байгаа бөгөөд ямарваа нэгэн мөргөлдөөн, дайн тулаан бий болохын өмнө хамгийн түрүүнд мэдээллийн тэмцэл



эхэлдэг бөгөөд хэрэв энэхүү тэмцлийг зогсоож чадвал томоохон хэмжээний аюулаас бүрэн зайлсхийх боломжтой ба ийм ч учраас энэхүү довтолгоог таньж мэдэх, ялгаж ойлгох, сөрөн тэсвэрлэх чадамжийг бүрдүүлэх, шаардлага тулгарсаар байна

Аюултай байж болзошгүй бүхэн аюул учруулдагтай нэгэн адил мэдээлэл өөрөө аюултай байх тохиолдол улам бүр нэмэгдэж, түүнээс хамгаалах асуудал өнөө үед чухлаар тавигдаж, энэ чиглэлийн бодлого, шийдвэр манайд дутмаг байна.

Мэдээлэл-сэтгэл зүйн дайны аюул нь тухайн улс орон, улс төр нийгэм, цэргийн тогтолцоонд буруу ташаа мэдээллийг тодорхой зорилго чиглэл, үе шаттайгаар явуулж, нийгэм, ард иргэд, цэргийн бие бүрэлдэхүүнийх нь оюун санаа, үзэл бодол, сэтгэл зүйг өөрчлөх эсвэл нийгэмд тогтворгүй байдлыг бий болгох системтэй удаан хугацааны үйл явц болж, эхэндээ анзаарагдахгүй байж байгаад үндэсний аюулгүй байдлын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд болон нийгмийн оюун санаа, сэтгэл зүйг аажмаар сулруулдаг.

Мэдээллийн дайны операцыг АНУ-ын Зэвсэгт хүчин технологийн дэвшлийг өргөн ашиглаж, цахим дайн, кибер дайн, мэдээллийн баталгаа, компьютерын сүлжээний ажиллагаа, халдлага, хамгаалалт зэрэг салбарт өргөн хэрэглэгддэг.

Цэргийнхэн бид мэдээллийн үйл ажиллагаа, мэдээлэл, сэтгэл зүйн хангалт гэсэн нэр томъёог өргөн ашигладаг бөгөөд энэ нь хэдийгээр технологи ашиглаж байгаа ч мэдээллийн ашиглалтын хүний тал, тэр дундаа нийгмийн сүлжээний дүн шинжилгээ, шийдвэрийн дүн шинжилгээ, удирдлагын хүний тал дээр илүүтэй анхаардаг ч оршин тогтнохын үндсэн суурь хүчин зүйлүүдтэйгээ холбож, авч үзэхгүй байдал байсаар байна.

НАТО "Мэдээлэл-сэтгэл зүйн дайн бол дайснуудаасаа мэдээллийн давуу байдлыг олж авах, үндсэн зорилгодоо хүрэхийн тулд мэдээллийг ашиглах" гэж үзэж тайлбарладаг

Мэдээлэл сэтгэл зүйн дайн нь олон хэлбэртэй байж болно. Үүнд:

–Телевиз, интернэт, радио дамжуулалт-(ууд) нь харилцаа холбоог тасалдуулах эсвэл худал мэдээлэл түгээх компани ажил явуулах

–Логистикийн сүлжээ, нийгмийн дэд бүтцүүдийг идэвхгүй болгох

–Дайсны харилцаа холбооны сүлжээг,

ялангуяа орчин үеийн онлайн нийгмийн сүлжээг хаах эсвэл хууран мэхлэх

–Хөрөнгийн биржийн гүйлгээг цахим хөндлөнгийн оролцоо, нууц мэдээллийг задруулах эсвэл худал мэдээлэл байршуулах замаар таслан зогсоох

–Дрон болон бусад хяналтын робот эсвэл веб камер ашиглах.

–Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад онлайн контент үүсгэх платформыг зохион байгуулалттай ашиглах нь олон нийтийн ойлголтод нөлөөлөх чухал арга хэмжээ гэж үздэг.

Мэдээлэл,сэтгэл зүйн дайны орчин үеийн хэрэглээ нь дараах зорилгоор цэргийн ажиллагаанд нөлөөлсөөр байна.

1. Ёс суртахууны доройтолд оруулах,

2. Байлдааны ажиллагаа газар орныг орхиж явахыг дэмжсэн товхимол тараах эсвэл хэрхэн бууж өгөх тухай зааварчилгааг өгөх, цочролд оруулах, айлгах

3. Олон давтамжаар түгшүүр төрүүлэх дуу чимээ болон хөгжмийг бүслэлтэд байгаа цэргүүд рүү урт хугацаанд өндөр дуугаар дамжуулах.

4. Суртал ухуулгын радио станцууд.

5. Эзлэгдсэн хот суурингийн нэрийг өөрчлөх.

6. Хуурамч мэдээллийн ажиллагаа.

7. Терроризм

8. Химийн зэвсгийн нөлөөлөл үзүүлэх.

9. Сэтгэл зүйн дайралтууд хийх

10. Цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг нь бодлогоор сулруулах

АНУ-ын Тагнуулын төв газар нь мэдээлэл, сэтгэл зүйн дайны үйл ажиллагаа амжилттай болох эсвэл бүтэлгүйтэхийг дүгнэн хэлэхийг учир дутагдалтай хэмээн үзэж, мэдээлэл-сэтгэл зүйн дайныг дараах 3 том бүлэгт хуваан ангилсан байдаг. Үүнд:

White propoganda² (цагаан суртал ухуулга) хамгийн ил тод байдаг ба сурталчлагчтай шууд холбоотой байдаг. Мөн хамааралтай дэмжигч болон бодит дэмжигч нь нэг бөгөөд ижил үзэл бодол, нэгэн "шугам"-ыг сурталчилж байгааг нуух гэж оролдохгүй бөгөөд телевизийн ихэнх сурталчилгаа нь арилжааны зорилготой ба цагаан суртал ухуулгын нэг хэсэг болдог.

–Grey propoganda (саарал суртал ухуулга) нь ил тод байдал нь хамгийн дээд хэмжээнээс



арай бага байх ба цагаан суртал ухуулгын нэгэн адил эх сурвалжийг шударгаар нээлттэй байх явдал юм. Гэвч энэ нь сурталчилж буй эх сурвалж ба шугамын хоорондын уялдаа холбоо, суртал ухуулгын статусын талаар бага илэн далангүй байдгаараа цагаан суртал ухуулгаас ялгаатай.

–Black propaganda³ (хар суртал ухуулга) нь жинхэнэ эх сурвалжаас бус худал эх сурвалжаас гардаг гэж үздэг ба энэ төрлийн суртал ухуулга нь сэтгэлзүйн далд ажиллагаатай холбоотой байдаг. Ихэвчлэн эх сурвалжийг нуун дарагдуулж, эсвэл хуурамч эрх мэдэлтнүүдийн нэр дээр шилжүүлж, худал, зохиомол, хууран мэхлэлт тараадаг. Хар суртал ухуулгын гол шинж чанар нь олон нийт, ард иргэд өөрсдөд нь нөлөөлж байгааг анзаардаггүй, тэднийг тодорхой чиглэлд түлхэж байгааг мэдэрдэггүй. Хар суртал ухуулга бол бүх төрлийн заль мэхийг багтаасан "том худал хуурмаг" байдаг. Иймэрхүү төрлийн мэдээллийн ажиллагаа манай нийгэмд явагдаж байгаад төрийн бодлогын хэмжээнд анхаарах нь зүйтэй.

1991 онд Персийн булангийн дайнд цахим болон хэвлэмэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сэтгэцийн болон хууран мэхлэх стратегийг амжилттай ашигласан. 1991 онд АНУ–ын хийсэн "ЦӨЛИЙН ШУУРГА" ажиллагаа нь мэдээллийн дайныг кинетик ажиллагаатай нэгтгэсэн хамгийн сүүлийн үеийн дайн байсан бөгөөд үүнийг "Мэдээлэл, сэтгэл зүйн дайны анхны дайн" гэж үздэг. АНУ тэргүүтэй эвслийн хүчнийхэн мэдээллийн харилцаа холбооны технологи, инновац, технологид суурилсан системийн хувьд Иракийн хүчнийхээс олон тооны давуу талтай байсан. Мэдээлэл, сэтгэлзүйн дайны арга барил болон хууран мэхлэх стратеги нь дайны бүх хүрээг хамарсан бөгөөд үүнд өдөр бүр 18 цагийн араб нэвтрүүлэг, 66 чанга яригч багийг эвслийн бригадын бүрэлдэхүүнд байрлуулсан байв. Холбоотны хүчний үйл ажиллагааг хөнгөвчлөхийн тулд электрон, радио, телевиз (CNN болон бусад мэдээллийн сүлжээ), хэвлэл, ухуулах хуудас, чанга яригчийн хуримтлагдсан нөлөө нь хүмүүсийн зан байдал, хандлага, ойлголтыг удирдахад чухал үүрэг гүйцэтгэдэг байв. Тиймээс "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" –ийг сэтгэл зүй, оюун санааны ухаалаг хэрэглүүр

болгон ашигласнаар "дайныг ялах стратеги"–ийн гол үндэс нь мэдээлэл, сэтгэл зүйн дайн, суртал ухуулга болсон байдаг.

Хятадын мэдээлэл, сэтгэл зүйн дайны үйл ажиллагааны тухай

БНХАУ–ын цэргийн стратегийн чухал хэсэг болох мэдээлэл, сэтгэл зүйн дайн нь Сунь Цзыгийн "Дайны урлаг ба гучин зургаан стратеги" номд дурдагдсан Хятадын дайны урлагаас улбаатай. Хятадын мэдээлэл, сэтгэл зүйн дайны тухай ойлголтыг довтолгооны сэтгэл зүйн дайн, хамгаалалтын сэтгэл зүйн дайн гэж хоёр ангилахаас гадна стратеги, оператив, тактик гэсэн гурван түвшинд хувааж авч үздэг. Хятадын мэдээлэл, сэтгэл зүйн дайны онолуудын ихэнх нь үйл ажиллагааны (байлдааны) түвшинд төлөвлөгддөг..

2006 оны "Байлдааны шинжлэх ухаан"– бүтээлд мэдээлэл, сэтгэл зүйн дайны тухай бүхэл бүтэн бүлэг (战役心理战) байдаг. Гэсэн хэдий ч Хятадын судлаачид мэдээлэл, сэтгэл зүйн дайн (战略心理战) тухайлбал, стратегийн зорилгоор явуулсан мэдээлэл, сэтгэл зүйн дайныг тусгайлан судалж энэ чиглэлийн тусгайлсан төрөл цэрэг байгуулж ихээхэн ач холбогдол өгч байна.

2006 оны "Байлдааны шинжлэх ухаан" бүтээлд мэдээлэл, сэтгэл зүйн дайнд сэтгэл зүйн дайралт, сэтгэл зүйн хамгаалалт багтдаг. "Сэтгэл зүйн цохилтын зорилго нь дайсны ухамсар, сэтгэлийг удирдан байлдааны үр нөлөөг сулруулж, байлдааны ажиллагаа явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд орших" ба "Дайсны танин мэдэхүйн сэтгэл зүйд довтлох", өөрөөр хэлбэл, дайсны командлагчийг хууран мэхэлж, "буруу шийдвэр гаргаж, буруу үйлдэл хийх"; "дайсны итгэл үнэмшлийн сэтгэл зүйд довтлох" гэсэн хоёр үндсэн үйл ажиллагааг хамруулдаг бөгөөд ингэснээр дайсны цэргийг бут цохиж, байлдааны хүсэл зориг, бие бүрэлдэхүүний сэтгэл санааны байдал суларч, дайсны байлдааны үр нөлөө суларна". Эдгээр ажиллагаа нь санаачилгыг гартаа авах, мэргэшсэн команд, боловсон хүчнийг хөгжүүлэх, бодитой (тусгайлан тохируулсан) суртал ухуулга ашиглах, гайхширалд хүрэх гэсэн дөрвөн үндсэн хэрэгцээ шаардлагыг хангах гэж тодорхойлогддог.



Тогтворгүй байдал бий болгох

Мэдээлэл–сэтгэл зүйн дайн нь зорилтот улс орныхоо хүн амын оюун санаа, үзэл бодлыг тогтворгүй болгох явдал юм. Тогтворгүй байдал нь хүн амын тогтолцоо, хүмүүсийн зохион байгуулалт, уламжлалт оюун санааны үзэл баримтлал, эв нэгдлийг алдагдуулах замаар хийгддэг. Үүний үр дүнд ард түмэн дотоодын асуудалд дарагдаж, нэгдмэл зорилгодоо хүрэхэд анхаарлаа төвлөрүүлэхээ больсон учраас бүтээмж эрс буурч, хамтын ажиллагаа алдагдахад хүргэдэг. Дайсны тал хүн амын бүлэг доторх урьдаас үүссэн зөрчил, хуваагдлыг дэвэргэх, эсвэл өөр өөр бүлгүүдийг хооронд нь маргалдуулж, туйлшралыг нэмэгдүүлэх шинэ санааг нэвтрүүлэх замаар зорилтот бүлгийнхээ зохион байгуулалт, эв нэгдлийг алдагдуулдаг. Тогтворгүй байдлын зорилгод нийцсэн мэдээлэл–сэтгэл зүйн дайны нөлөөллийн стратегид дараах зүйлс орох бөгөөд үүгээр хязгаарлагддаггүй.

- Туйлшралыг нэмэгдүүлэх
- Асуудлуудыг дэвэргэж ард түмнийг замбараагүй байдалд оруулах
- Засгийн газрын удирдлага, үйл ажиллагааг шүүмжилж хууль бус болгох
- Хувь хүн ард иргэдийн талцуулах
- Эдийн засгийн гол үйл ажиллагааг тасалдуулах, худал сурталчилгаа явуулах
- Дэд бүтцийг тасалдуулах
- Тогтсон уламжлал харилцааг төөрөгдүүлэх

Төөрөгдөл үүсгэх

Олон нийтийн дунд төөрөгдөл эргэлзээ үүсгэж, нийгмийг тогтворгүй болгохыг оролддог. Ард иргэд нь юу зөв, хэнд итгэхээ мэддэггүй болсон үед эмх замбараагүй байдал, төөрөгдөл үүсдэг ба үүний үр дүнд энгийн иргэд өөрсдийн аюулгүй байдал, эрх чөлөөг хянах зорилготой үндэстний удирдлага, төр засгийн үйл ажиллагаанд итгэх итгэлээ аажмаар алдаж эхэлдэг. Түүхээс харахад төөрөгдөл үүсгэх арга ажиллагаа нь эдийн засгийн чадавх сул, муу засаглалтай улс орнуудад хэрэглэгдсээр ирсэн байдаг. Эдийн засгийн хориг арга хэмжээг төөрөгдөл үүсгэх, нийгмийг тогтворгүй болгох, "нийгмийн бодлого, засгийн газрын үйл

ажиллагааг алдагдуулах, өөрчлөхийг албадах зэрэгт ашигладаг. Чили дэх Альендегийн дэглэмийг жишээ болгон авч үзье. Америкийн олон нийтийн санаа бодол Чилийн засгийн газрын эсрэг илт хүч хэрэглэхийг эсэргүүцэж байв. Чилийн засгийн газрыг түлхэн унагах хамгийн сайн арга бол доройтож буй үндэстний бурууг социализмын буруу бодлогод үүрүүлэх явдал хэмээн шийдсэн бөгөөд Америкийн засгийн газар Чилийн эдийн засаг, нийгэмд хоёуланд нь цохилт өгөх замаар Чилийн засгийн газрыг тогтворгүй болгох хоёр чиглэлийг баримталсан ба эдийн засгийн хямралд олон хүчин зүйл нөлөөлсөн. Америкийн засгийн газар шинэ, хуучин Америкийн бүх хувийн хөрөнгө оруулалтыг зогсоосон. Нэмж дурдахад Америкийн засгийн газар олон улсын санхүүгийн байгууллагуудыг Чилийн аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхгүйн тулд дэлхийн тавцанд урьд өмнө байгаагүйгээр нарийн ажилсан. Чилийн үндсэн үйлдвэрлэл болох зэсийн зах зээлийг Америкийн үндэстэн дамнасан корпорацууд хүч түрэн ноёрхож эхэлсэн нь Чилийн эдийн засагт том цохилт болсон.

Мэдээлэл–сэтгэл зүйн дайны хоёр дахь үндсэн зорилго нь зорилтот хүн амд нөлөөлөх явдал юм. Нөлөөллийн зорилго нь зорилтот улс орны эргэн тойрон дахь ертөнцийн талаарх бодол санаа, ойлголтыг удирдах замаар хэрэгждэг. Дайсагнагч тал зорилтот улсынхаа авч хэрэгжүүлж буй арга хэмжээг өөрийн зорилгод ашигтайгаар ашиглах, удирдаж болох нөхцөлийг бүрдүүлдэг. Нөлөөллийн зорилго нь тогтворгүйжүүлэх зорилгоос ялгаатай бөгөөд эцсийн зорилго нь зорилтот улс оронд аливаа асуудлыг өөрсдийн хүссэнээр ойлгуулж, ижил үзэл бодолтой болгох явдал юм.

Дайсагнагч тал зорилтот улс орны нийт хүн ам эсвэл хүн амын хэсэг бүлэг хүмүүсийн сэтгэхүйд нөлөөлөхийн тулд улс төр, эдийн засаг, эрдэм шинжилгээний болон нийгмийн удирдагчдыг сурталчлан илүү олон хүнд хүргэх чиглэл баримталдаг. Өөрөөр хэлбэл, дайсагнагч тал өөрчлөлтийг өдөөх буюу олны танил эрхмийг онилсноор хангалттай олон хүмүүст хүрч чадна хэмээн тооцдог. Мэдээлэл–сэтгэл зүйн дайны ажиллагаагаар нөлөөлөхийн тулд дараах арга хэмжээнүүдийг сурталчлан хэрэгжүүлдэг ба энэ



нь үүгээр хязгаарлагдахгүй.

- Хэт даврагч үзэл суртлыг сурталчлах
- Иргэний итгэл үнэмшлийг удирдах
- Эдийн засгийн гол үйл ажиллагаанд хяналт тавих
- Засгийн газрын үйл ажиллагааг зохицуулах
- Сонгуулийг будлиантуулах эсвэл хууль бус болгох
- Энгийн иргэдийг улс төрийн бүлэглэлүүдэд элсүүлж, талцалуудыг бий болгох
- Эсэргүүцлийг дарих

Элсүүлэх нөлөөлөл

Мэдээлэл-сэтгэл зүйн дайн нь энгийн иргэдийг ямар нэгэн зорилгод элсүүлэх явдал бөгөөд үүнийг террорист бүлэглэлийн жишээнээс харж болно. Энэ нь Ойрх Дорнод дахь террорист Аль-Каида бүлэглэлийг ашиглаж байсан ба тухайн загварыг "identity entrepreneurs" гэж нэрлэдэг хүмүүс удирддаг бөгөөд улс төр, эдийн засгийн институцид тийм ч их нөлөө үзүүлэх шаардлагагүй ч зорилтот нийгмийн жирийн гишүүдтэй харилцах, холбогдох чадвартай хүмүүс байдаг. Бизнес эрхлэгчид сонгогчдод нийгмийг сайжруулахад гол дүрийн үүрэг гүйцэтгэсэн тухай өгүүлэмжээр дамжуулан хэт даврагч үзэл сурталд энгийн иргэдийг элсүүлдэг ба эдгээр удирдагчид ядуу нөхцөлд амьдарч буй энгийн иргэдийг онилон, тэднийг ганцаараа биш, ядууралд буруугүй, буруутгахуйц илэрхий дарангуйлагч байгаа хэмээн ойлгуулдаг сурталчилдаг.

Бодлого, үзэл хандлагад нөлөөлөл

Мэдээлэл-сэтгэл зүйн дайн нь бодлогод нөлөөлөл асар их боломжуудтай. Дэлхий дахинд нөлөөгөө нэмэгдүүлэхийг эрмэлзэж буй амбицтай үндэстэн АНУ Тухайлбал, Хятад улс экспансионист гадаад бодлого баримталж байгаа нь Хятад-Энэтхэгийн хил, Өмнөд Хятадын тэнгист дайсагнаж байгаагаар харуулж

байна. Мөн ОХУ нь ийм төрлийн арга барилыг АНУ-ын эсрэг хийж байгаа бөгөөд АНУ-ын ард иргэдийн татварын мөнгийг өөр харь оронд зэвсэг худалдаж авахад дэмий зарцуулж байна гэсэн мэдээллийг олон нийтийн сүлжээнд цацсан нь ард иргэд сонгосон их хурлын гишүүддээ мөн шахалт үзүүлэн явуулж буй төрийн бодлогоо өөрчлөх нөхцөл байдал үүсгэж байгаа юм.

Тодорхой бодлого, шинэ санаа гаргаж нөлөөлөл

Ард иргэд, тодорхой салбарууд, ялангуяа хүн амын үндэстний бүлгийнхний эсрэг тодорхой үзэл бодлыг дэвшүүлж, сурталчилдаг. Үүний тод жишээ бол сонгуульд хөндлөнгөөс улс төрийн намуудаар дамжуулан оролцож тодорхой үзэл, концепци дэвшүүлэх явдал юм.

Дүгнэлт

НАТО-ын гишүүн орнууд мэдээлэл, сэтгэл зүйн дайныг мэдээллийн давуу байдлыг бий болгож, мэдээллээр дамжуулан тухайн улс орны нийгмийн оюун санааг сулруулах, тогтолцоог нь эвдэж стратегийн зорилтоо хангах стратеги баримталдаг бол НАТО-ын томоохон өрсөлдөгч болох БНХАУ мэдээлэл-сэтгэл зүйн дайныг танин мэдэхүйн дайн хэмээн үзэж нөлөөллийг нь өргөн хүрээнд судалж, эдийн засгийн харилцаагаар дамжуулж нөлөөлөл бодлого баримталж байна.

Орос-Украины дайн 2022 оны 2-р сарын 22-нд эхэлснээс хойш дэлхийн олон нийтийн санаа бодлын хүрээнд мэдээлэл, оюун санааны талбарт их бууны нүргээн шуугиан дэгдээсэн.

Орос-Украины дайн бол Оросоос АНУ, НАТО болон барууны ертөнцийг бүхэлд нь эсэргүүцсэн цэргийн болон мэдээлэл оюун санааны нөлөөллийн дайн гэж хэлж болох ба Оросын эсрэг дэлхий даяар явуулж байсан урьд өмнө байгаагүй мэдээлэл, сэтгэл зүйн нөлөөлөл "танин мэдэхүйн дайн" шинэ төрөл болоод байна.

Ашигласан материал:

1. Цяо Лян, Ван Шянсүй (1990), Хязгааргүй дайн, Бээжин: ХАЧА-ын Утга зохиол, урлагийн хэвлэлийн газар.
2. "Цагаан суртал ухуулга". АНУ-ын Батлан хамгаалах яам. 2016-03-04-нд архивлагдсан эх сурвалжаас
3. Дуб, Леонард (1950-09-13). "Нацист суртал ухуулгын Геббельсийн зарчмууд". Олон нийтийн санал бодол 419-442



ЦЭРГИЙН ХӨГЖМИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЭЛСЭЛТИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Г.БАТДОРЖ /УБХИС-ийн ЦХПК-ийн ахлах багш, ахлах дэслэгч/

Түлхүүр үг: Элсэлт, төгсөлт, чанар, хөгжимчин, сургалт
Key words: Enrollment, graduation, quality, musician, training

Оршил

Монгол Улсын төр засаг, БХЯ-ны зүгээс цэргийн ёслол хүндэтгэл, соёл урлагаа хөгжүүлэхэд онцгойлон анхаарч 1990 оны нийгмийн тогтолцооны өөрчлөлтийн дараа мэргэжлийн “Цэргийн үлээвэр хөгжимчин” бэлтгэх асуудал дэмжигдэж улмаар Батлан Хамгаалахын сайдын 1991 оны 6 дугаар сарын 17-ны өдөр 346 тоот тушаал гарч 1991 оны 8 дугаар сарын 5-нд сурагчид элсүүлж авах, элсэлтийн шалгалтыг зохион байгуулахаар болсон байдаг.

ЦХПК нь өнөөдөр элсэлтийг зохион байгуулахдаа Монгол Улсын Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12.2 дугаар хуулийн заалт, Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2024 оны А/12 тоот тушаалын 1.3 дахь заалтуудад нийцүүлэн зохион байгуулдаг.

Мөн ЗХЖШ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн А/02 тоот тушаалаар батлагдсан Цэргийн хөгжмийн албаны дүрмийн 2.5.1, 2.6.2 дахь заалт, ҮБХИС-ийн захирлын 2019 оны А/139 тоот тушаалын 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. ЦХПК нь Монгол улсын Зэвсэгт хүчний анги байгууллагууд болон цэргийн урлагийн салбарт мэргэжлийн өндөр ур чадвартай, олон улсын жишигт нийцэхүйц мэргэжилтэн бэлтгэх зорилготой юм.

Үндсэн хэсэг

Сурагчдыг үлээвэр хөгжимд сурагч элсүүлэх талаар Н.Цэрэнпил, С.Батбаяр нар <<Үлээвэр хөгжимд суралцах гарын авлага>> бүтээлдээ “Үлээвэр хөгжимд 10–12, 12–14 насны хүүхдийг авч сургах нь ирээдүйтэй

мэргэжлийн хөгжимчдийг бий болгож чадна. Үлээвэр хөгжмийг сурах нь удаан цагийн хатуужил тэсвэртэй, дасгал, сургууль шаардаж, хүний биеийн эрхтнүүдийг хэвшүүлдэг учраас биеийн өсөлт гүйцээгүй бага насны хүүхдийг авч сургуулилах нь ашигтай болно” гэжээ. Эндээс үзвэл мэргэжлийн хөгжимчин бэлтгэхэд элсэлт, сонгон шалгаруулалт хамгийн чухал зүйл болох нь ойлгомжтой байна.

Хөгжимдөх ур чадварыг дээшлүүлэх асуудал нь багш, суралцагчаас харилцан хамааралтай боловч үлээвэр хөгжимд суралцах анхан шатны сургалтын нэн тэргүүний шийдвэрлэвэл зохих асуудал нь сургалт эхлүүлэх суралцагчийн биологийн насыг зөв тодорхойлох явдал мөн.

Тодруулбал; 1960–1970-аад оны үед Хөгжим бүжгийн дунд сургууль үлээвэр хөгжмийн ангидаа 13–16 насныхнаас сонгон суралцуулж байсан ба жил, жилийн элсэлтийг янз бүрийн наснаас авч туршилт хийж ирсэн байдаг. Харин одоогийн Монгол улсын консерватор нь үлээвэр хөгжмийн мэргэжлийн сургалт эхлэх насыг ойролцоогоор 12 нас хэмээн тогтоосон байна. Үүний үндэс нь нийгмийн хөгжил, хотжилт, цахим орчин илүү хөгжсөнтэй холбоотой байж болох юм.

Монгол Улсад үлээвэр хөгжмийн сургалт явуулж буй байдлыг авч үзвэл энгийн болон цэргийн сургалтын байгууллага хэмээн хоёр хуваан үзэж болохоор байна. Энгийн болон цэргийн сургалтын байгууллагын хөгжмийн ангид суралцаж буй суралцагчдын сургалтын орчин, сурах арга барил, хөгжмийн сургалтын онол, арга зүйн хувьд ижил. Харин үүрэг

¹ Цэрэнпил Н. Батбаяр С., “Үлээвэр хөгжимд суралцах гарын авлага” УБ., 1977. Тал-45;



хариуцлагын хувьд харилцан адилгүй байдаг. Тодруулбал, Цэргийн үлээвэр хөгжимчид нь цаг агаар, газар орны байрлалаас үл хамааран эх орон, цэрэг армийн сэдэвтэй зохиол бүтээлүүдийг ихэнхдээ хөгжимддөг.

Үүнээс гадна Төрийн болон Цэргийн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, гадаадын улс орнуудтай дипломат харилцааг бэхжүүлэх үйл хэрэгт төрийн ёслолын журам, цэргийн дүрэмд зааснаар мэргэжлийн түвшинд үүрэг гүйцэтгэхэд цэргийн хөгжимчдийг бэлтгэдэг байна.

Цэргийн үлээвэр хөгжимд мэргэжлийн өндөр ур чадвартай хөгжимчдийг бэлтгэхийн тулд юуны өмнө элсэлтийн сонгон шалгаруулалт хийгддэг. ЦХПК нь үлээвэр цохивор хөгжмийн ангидаа хөгжмийн хэмнэлийн мэдрэмж, бие эрхтний зохилдлогоо буюу гар хуруу, шүд, уруулын зузаан нимгэн, ой тогтоолт, сонсгол, биеийн эрүүл мэндийг сайтар шалгаж авдаг билээ.

ЦХПК-д элсэгчдэд тавих элсэлтийн ерөнхий шалгуурыг дараах хүснэгтээр харуулав.

1 дүгээр хүснэгт

ЦХПК-ийн элсэлтэд тавигдах ерөнхий шалгуур.

Үлээвэр, цохивор найрал хөгжмийн хөгжимчнөөр мэргэжлээр сонгон шалгаруулах шалгуур	
Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур
–Иргэний харьяалал	–Авьяас чадвар
–Эрүүл мэнд	–Ой тогтоолт
–Монгол хэл	–Ритм
–Математик	–Сонсгол
–Эсээ бичлэг	–Бие бялдын онцлог
–Өөрийгөө хөгжүүлсэн байдал	–Тэсвэр хатуужил
	–Өргөдөл

Дээрхээс үзвэл “Тусгай” шалгуурт, авьяас, сонсгол, бие бялдын онцлог зэрэгт тэнцэж дараагийн шалгалтад хамрагдах боломж үүсдэг байна. Харин “Ерөнхий” шалгуурт Эрүүл мэнд, Математик, Монгол хэлний шалгалтад тэнцсэн тохиолдолд дээрх хоёр шалгуурын голч дүнгээр нь эрэмбэлэн жагсааж тухайн хичээлийн жилд зөвшөөрсөн суудлын тоог үндэслэн тэнцүүлдэг байна.

Ингээд өнгөрсөн хугацаанд ЦХПК-

ийн элсэлтийн чанарыг тодорхойлох эхний алхам бол элсэгчдийн “Элсэлт, төгсөлт”-ийн харьцуулсан тоо судалгааг баримт мэдээлэлд тулгуурлан дараах байдлаар хүснэгтээр үзүүлэв.

2 дугаар хүснэгт

ЦХПК-ийн “Элсэлт, төгсөлт”-ийн харьцуулсан тоо судалгаа

Д/д	Элссэн, Төгссөн он	Элссэн тоо	Төгссөн тоо
1.	1991–1994	38	26
2.	1992–1995	16	9
3.	1993–1996	13	9
4.	1994–1997	21	8
5.	1995–1998	19	13
6.	1996–2000	16	11
7.	1997–2001	15	10
8.	1998–2002	21	11
9.	1999–2003	15	8
10.	2000–2004	22	14
11.	2001–2005	14	7
12.	2002–2006	23	8
13.	2003–2007	25	14
14.	2004–2008	28	9
15.	2005–2009	37	16
16.	2006–2010	31	15
17.	2007–2011	40	14
18.	2008–2012	33	16
19.	2009–2013	28	10
20.	2010–2014	43	11
21.	2011–2015	29	13
22.	2012–2015	34	10
23.	2013–2017	28	17
24.	2014–2018	29	10
25.	2015–2019	35	17
26.	2016–2020	32	9
27.	2017–2021	30	16
28.	2018–2022	43	19
29.	2019–2023	37	24
30.	2020–2024	28	7
31.	2021–	59	Хөтөлбөр дуусаагүй үргэлжилж байгаа
32.	2022–	22	Хөтөлбөр дуусаагүй үргэлжилж байгаа
33.	2023–	33	Хөтөлбөр дуусаагүй үргэлжилж байгаа
34.	Бүгд	928	374

Дээрх хүснэгтээс харвал сургалт явуулж эхэлсэн эхний 10 жилд 193 сурагч элсэн суралцсан байна. Харин эдгээр сурагчдын 119 нь төгссөн бол хоёр дах 10 жилд 302² сурагч

² БХТА, БХЯ-ны сан. Х-85 Х/н –ҮБХИС-ийн тушаалын



элсэн суралцаад 120 нь төгсжээ. Тухайн үеийн элсэгчдийн ихэнх нь цэргийн ангийн хөгжмийн салаанд сурагч, 10 жилийн сургуулийн үлээвэр хөгжмийн дугуйланд 9–12 насандаа хичээллэж байсан хүүхдүүд элссэн байна.

Харин сүүлийн 13 жилд 297³ сурагч элссэнээс 135 нь төгссөн байна.

ЦХПК нь байгуулагдсан цагаас эхлэн нийт 33 удаагийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан ба 792 элсэгчийн 374 нь “Цэргийн үлээвэр хөгжимчин” мэргэжил эзэмшин төгсөж хөгжимчин дэд ахлагч цолтойгоор ЗХ–ний анги, байгууллагуудад хуваарилагдан ажиллажээ. Өөрөөр хэлбэл бид өнгөрсөн хугацаанд сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж явуулахдаа төгсөгчдийн тоонд бус мэдлэг, ур чадвар, хандлага, сургалтын байгууллагын онцлогт тулгуурлан бэлтгэж ирсэн байна.

1991–2023 оныг хүртэлх хугацаанд тухайн хичээлийн жилд сурагчид элсүүлэн авах хяналтын тооны өсөлт, бууралтыг дараах графикаар харуулав.



График 1. ЦХПК-ийн 1991–2024 оны элсэлтийн ерөнхий зураглал

Дээрх судалгаанаас үзвэл ЦХПК нь 34 дэх удаагаа элсэлт зохион байгуулж ирсэн эхний 10 жилийг багцлан авч үзвэл дунджаар 19 сурагч, 2 дахь 10 жилд дунджаар 30 сурагч элсүүлэн авч дипломын боловсрол олгожээ. Мөн сүүлийн 13 жилийн элсэгчдийн тоог дундажлан авч үзвэл 34 сурагч элсүүлэн авсан нь өмнөх үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Бид жил бүр сурагчид элсүүлэх хяналтын тоог батлуулахдаа цэргийн хөгжмийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулсаар ирсэн билээ. Иймд цаашид богино хугацаанд хөгжимчин ахлагчийн хүний нөөцийг бүрдүүлэх боломжтой эсэхэд дараагийн судалгааг хийлээ.

ЗХЖШ–ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 19–ний өдрийн Б/194 тоот тушаалын хавсралтаар Зэвсэгт хүчний анги салбар шинэ

хуулбар;

³ ҮБХИС–ийн сан. Х–85 Х/н –ҮБХИС–ийн тушаалын хуулбар;

бүтэц орон тоо зохион байгуулалтаар зэвсэгт хүчний анги байгууллагуудад батлагдсан хөгжимчин ахлагч орон тооноос одоогоор нөхөн хангалт 43.9 хувьтай хийгдээд байна. Тодруулбал; 2024 оны 3 дугаар сарын байдлаар зэвсэгт хүчинд нийт 517 хөгжимчин байхаас 227 хөгжимчин ахлагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Үүнээс мэргэжлийн сургууль төгссөн 132 хөгжимчин буюу 25.5 хувийг эзэлж байгаа бол тус сургуулийг төгсөөгүй 95 хөгжимчин ахлагч байгаа бөгөөд энэ нь нийт хүний нөөцийн нөхөн хангалтын 18.4 хувийг эзэлж байна.

Өнөөдөр цэргийн хөгжимчдийн хүний нөөцийн нөхөн хангалт Цэргийн хөгжмийн албанаас өгсөн мэдээллийн дагуу цэргийн хөгжимчдийн хүний нөөцийн нөхөн хангалтыг хөгжмийн зэмсэг тус бүрээр нь ангилж дараах хүснэгтээр харуулав.

3 дугаар хүснэгт

Зэвсэгт хүчинд шаардлагатай хөгжимчин ахлагч албан тушаалтны хүний нөөцийн нөхөн хангалтын судалгаа

№	Хөгжмийн зэмсгийн нэр		Улаанбаатар цэргийн хүрээ	Орон нутаг	Нийт
	Англи	Монгол			
1	Flute	Лимбэ	8	15	23
2	Clarnet “B”	Бялар	16	25	41
3	Saxophone	Сакс–бүрээ	9	9	18
4	Horn	Угалзан бүрээ	28	36	64
5	Trumpet	Нарийн бүрээ	26	23	49
6	Trombone	Татах бүрээ	9	7	16
7	Orchestral drum	Цохивор	23	31	54
8	Euphonium “B”	Баргил, цээл бүрээ	7	4	11
9	Tuba B”	Аргил бүрээ	7	7	14
10		Нийт	133	157	290

Эндээс үзвэл бидэнд зэвсэгт хүчний хэмжээнд 290 хөгжимчин ахлагчийн ажлын байр бэлэн байна. Өөрөөр хэлбэл дээрх мэргэжлийн төрлүүдээр хөгжимчдийг сургах шаталсан сургалтыг эрчимтэй зохион байгуулах нь шийдвэрлэх гол арга замын нэг юм. Мөн цаашдаа бид цэргийн хөгжмийн салбарт чадварлаг мэргэжлийн хүний нөөцийг богино хугацаанд бүрдүүлэх шаардлага үүссэн болохыг дээрх судалгаанаас харж болохоор байна.

Дараагийн судалгаа бол хөгжимчин ахлагч бэлтгэх сургалт явуулж буй өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийлээ.



S – Давуу тал	W – сул тал
<ul style="list-style-type: none"> – Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үлээвэр хөгжимчдийг бэлтгэдэг үндэсний хэмжээний цорын ганц сургууль юм; – Бүрэн дунд боловсролын гэрчилгээ хамтатгасан Мэргэжлийн үнэмлэх олгогддог; – Техникийн боловсролын дипломтой төгсдөг; – Мэргэжлийн боловсролын цахим системд сонсогч нарын мэдээлэл бүртгэлд орсон ба мөнгөн тэтгэмж авах эрх нь үүссэн; – Сургалт төлбөргүй, ажлын байраар 100% хангагдана; – Нийт суралцсан хугацааг цэргийн алба хаасанд тооцно; – Хөгжмийн зэмсгээр хангана; – Гадаад хамтын ажиллагаа сайн; – Суралцагчдын дунд урлаг, спортын тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж хэвшсэн; – Багш, суралцагчид БНАСАУ, БНСУ, Герман ОХУ зэрэг гадаад орнуудад зохиогддог цэргийн үлээвэр хөгжмийн наадмуудад оролцдог. 	<ul style="list-style-type: none"> – Элсэгчдийн ихэнх нь хөгжмийн боловсрол эзэмшээгүй; – Хөгжимчин албан тушаалын ахлагч нарыг бэлтгэх мэргэшүүлэх шаталсан сургалтын тогтолцоо бүрдээгүй; – Албан тушаалд нийцсэн мэргэшсэн гоцлол хөгжимчин, дадлагажуулагч багш бэлтгэх боломжгүй; – Сургалтын материаллаг болон бие даан суралцах орчны бүрдэлт бусад сургуультай харьцуулахад дутагдалтай; – Хөгжмийн онол, сонсголын иж бүрэн танхим бүрдээгүй; – Гадаадын хөгжмийн сургуульд суралцах боломж багассан; – Хөгжмийн зэмсгийн нөхөн хангалт тогтмол хийгддэггүй.
O – Боломж	T – Эрсдэл
<ul style="list-style-type: none"> – Хөгжимчин ахлагч бэлтгэх шаталсан сургалтын бодлого, стратегийн төлөвлөгөөг боловсруулах; – Мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээнд оролцох; – Элсэгчдийг төгссөний дараа шаталсан сургалтаар бакалаврын зэрэг эзэмших сургалт бэлтгэлийн шинэ тогтолцоог бий болгох; – Сурагч, эцэг, эх асран хамгаалагч, үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнг үндэслэн, суралцагчид чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлж, элсэлтийн чанарт ахиц гаргах боломжтой; – Элсэлтээр анги дүүргэлтийн тоог 30 (+10) эсвэл 30(а)+30(б) болгон 2 анги хичээллүүлэх. 	<ul style="list-style-type: none"> – Хөгжимчин ахлагч нарыг цаашид шатлан сургахгүй бол мэдлэг, ур чадвар нь нэг хэвийн зогсолтын байлалд орно; – ЗХ-ний өнөөгийн шаардлагыг хангасан, олон улсын жишигт нийцсэн хөгжимчин ахлагчийн хүний нөөц дутмаг байсаар байна; – Хөгжимчин ахлагч нарын онол, практикт чиглэсэн сургалтын орчин нөхцөл хязгаарлагдмал болно; – Хөгжмийн багаж зэмсгүүдэд шинэчилсэн нөхөн хангалт огт хийгдээгүй /төгөлдөр хуур, үлээвэр, цохивор хөгжмийн зэмсгүүд/ байна; – Тасралтгүй сургах шаталсан сургалтын тогтолцоо бүрдэх боломж муутай.

SWOT шинжилгээнээс үзэхэд сургалтын үйл ажиллагаанд хэвшиж тогтсон давуу тал олон байна. Үүнийг сургалт явуулах эрх зүйн орчин, шинээр боловсруулсан боловсролын багц хуулийн заалтуудад нийцүүлж хөгжимчин албан тушаалын ахлагч нарыг бэлтгэх мэргэшүүлэх шаталсан сургалтын тогтолцоо бүрдүүлж сул талаа бууруулна гэж үзэж байна.

Үүний тулд өнөөдрийг хүртэлх хугацаанд бий болсон давуу талаа түшиглэн, хөгжимчин ахлагч нарыг албан тушаалд нийцсэн бакалаврын боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, шинэ тогтолцоо, бодлого, стратеги, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ашиглан арилгаж эрсдэлээс зайлсхийх бүрэн боломж байгаа нь шинжилгээнээс харагдаж байна.

Иймд тус сургуульд элсэхийг хүсэгчдийн тоог нэмэгдүүлж, элсэлтийн чанарыг сайжруулах арга замыг тодорхойлж байна.

Цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх сургалтыг боловсронгуй болгоход нэн тэргүүнд элсэлтийн чанарыг сайжруулах шаардлагатай

хэмээн үзэж дараах 2 чиглэлийг дэвшүүлж байна. Үүнд;

4 дүгээр хүснэгт

Элсэлтийн чанарыг сайжруулахад авах хоёр арга хэмжээ

Д/д	Зохион байгуулах арга хэмжээ	Хамрагдагсдын тоо	Суудлын тоо
1	ЗХЖШ, ЦХА- хамтын ажиллагааг сайжруулах	60–100 хүн	1. 30 сурагч
2	Биетээр болон Цахим сурталчилгаа явуулах	40–50 хүн	2. 30+30=60 сурагч

Дээрх арга хэмжээг зохион байгуулахад дараах байдлаар үйл ажиллагааг тооцон үзлээ. Үүнд;

1. ЗХЖШ, ЦХА-тай хамтран ажиллах-Захиалагч байгууллага болох ЗХЖШ, ЦХА-тай хамтран элсэлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг сайжруулах нь чухал юм. Өөрөөр хэлбэл; Элсэлт зохион байгуулах журмын дагуу суурь боловсрол эзэмшсэн, хөгжимд авьяастай, дур сонирхолтой 5 түүнээс доошгүй сурагчийг



тухайн орон нутагт нь хөгжмийн салааны бүрэлдэхүүнийг түшиглэн сонгон шалгаруулалт зохион байгуулж явуулах нь зүйтэй байна.

Энэхүү арга хэмжээ үр дүнтэй явагдсанаар сонгон шалгаруулалтад тэнцсэн сурагчдыг ЦХПК-ийн нэгдсэн сонгон шалгалтад оролцуулж чадсанаар, авьяастай хүүхдийн тоог бодитоор нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

2. Биетээр болон Цахим сурталчилгаа явуулах– Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн ЕБС–д очиж сургуулийн бие бүрэлдэхүүнд тоглолт үйлчилгээгээ үзүүлэн, боломжит давуу талууд болон хөгжмийн боловсрол эзэмшихийн ач тусын талаар сурталчлан таниулж элсэхийг хүсэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

ЦХПК-ийн гадаадын болон дотоодод зохион байгуулагдсан уралдаан, тэмцээн, наадмуудад амжилттай оролцсон байдлыг нийт ЕБС-ийн дунд ангийн сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагчдад цахим орчинд сурталчлах үйл ажиллагааг идэвхтэй явуулж, хандалтын тоог жил бүр нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл, цахим орчинд сургуулийн үйл ажиллагааны ололт, амжилтыг нийт ард иргэдэд сурталчлан таниулж олон хүнд хүргэх боломж бүрдэх юм.

Дүгнэлт

1. Бид суурь боловсрол эзэмшсэн хүүхдүүдийг сонгон шалгаруулахад хөгжмийн хэмнэлийн мэдрэмж, бие эрхтний зохилдлогоо

буюу гар, хуруу, уруулын зузаан, нимгэн, шүд, сонсгол, ой тогтоолт, бие бялдар, хэл, бичгийн соёл зэргийг сайтар шалгаж авах нь ирээдүйд мэргэжлийн сайн хөгжимчин бэлтгэх амжилтын эхний алхмыг бүрдүүлж өгдөг байна. Иймд дээрх шалгуурыг хангасан сурагчдыг элсүүлэн авч чадсанаар бидний сургалт чанартай илүү үр дүн гарна.

2. Цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх сургалтыг сайжруулахын тулд бид цаашид элсэхийг хүсэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой юм.

Элсэхийг хүсэгчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан эрх зүйн хүрээнд дээрх арга хоёр хэмжээг чанартай зохион байгуулснаар дараах боломжуудыг бий болгоно. Үүнд;

–ЦХПК-ийн элсэлт чанаржих;

–Элсэгчдийн авьяас, ур чадварыг эрэмбэлэн бодитоор үнэлэх;

–Элсэхийг хүсэгчдийн тоо өсөн нэмэгдэх;

–БХ салбар, Зэвсэгт хүчин, сургалтын байгууллагын нэр хүнд өсөн нэмэгдэх зэрэг олон давуу талтай.

3. Цаашид жилд 30 (+10) сурагч элсүүлэн авч сургахад нэг ч суралцагч хасагдахгүй төгсгөсөн тохиолдолд ойролцоогоор 8 жилийн дараа зэвсэгт хүчний анги салбаруудын үлээвэр хөгжимчин ахлагч албан тушаалын хүний нөөцийг 95% бүрдүүлнэ хэмээн үзэж байна.

Ашигласан материал:

1. Ариунболд Ц. “Шаталсан сургалтаар мэргэжлийн хөгжимчин бэлтгэх сургалтын тогтолцооны хөгжил, харьцуулсан судалгаа”. –УБ., 2016 он.
2. Ганбат Г., Гансүх Ч., нар “Цэргийн хөгжмийнхөн” 105 жилийн түүх дурсамж. УБ., 2019 он.
2. Жаргал А., Дамдиндорж Д., нар “Зүрхэнд шингэсэн эгшиг”. УБ., 1992 он
3. Цогтгэрэл Ш. “Монгол цэргийн хөгжим уламжлал орчин үе”. УБ., 2011 он
4. Цэрэнпил Н., Батбаяр С., “Үлээвэр хөгжим сурах арга”. УБ., 1977 он
5. Цэргийн хөгжмийн коллежийн түүхэн замнал. хамтын бүтээл. УБ., 2021 он
6. <https://www.esurgalt.itpd.mn>



ОХУ–ЫН ВА РХБЗ АКАДЕМИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ МОНГОЛ УЛСЫН ҮБХИС–ЦНДС, ЦАЦРАГ ХИМИ БИОЛОГИЙН ХАМГААЛАЛТ, ХАНГАЛТ ХӨТӨЛБӨРТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

У.МӨНХБАТ /ҮБХИС-ийн ЦНДС-ийн багш, доктор (Ph.D), хошууч/

Түлхүүр үг: Хөтөлбөр, цацраг, хими, биологи, хамгаалалт

Key words: training program, radiation, chemistry, biology, defense

Оршил

80 жилийн тэртээ МАХЦ–ийн морьт дивизүүдэд химийн салааг анх байгуулж, хими хамгаалалтын эд хэрэгслээр цэргээ хангаж, сургалт явуулж эхэлсэн цаг үе нь Монгол Улсын Зэвсэгт хүчинд Химийн цэрэг үүсэж хөгжихийн эхлэл болсон юм. Түүхэн хөгжлийнхөө эдгээр он жилүүдэд Химийн цэрэг мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчин болон байлдааны тусгай тоноглолтой техник хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээний хувьд ч чанаржин сайжирч, орчин үеийн болзошгүй дайнд бүх төрлийн байлдаанд химийн хангалтыг чадварлаг зохион байгуулах туршлага дадлагатай тусгай мэргэжлийн цэрэг болон төлөвшиж чадсан юм.

Ийнхүү химийн цэргийн мэргэжлийн боловсон хүчин гадаад, дотоод цэргийн сургууль болон академид бэлтгэж эхэлсэн түүхтэй. Дотооддоо цэргийн химийн мэргэжлийн боловсролтой мэргэжлийн боловсон хүчнийг тухайн үеийн их дээд, сургуулийн нэгэн адил хөтөлбөр боловсруулан бэлтгэж ирсэн. Цэргийн хими хамгаалалт мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаандаа түүнийг сайжруулах замаар хэд хэдэн удаа шинэчлэн, өөрчилж ирсэн бөгөөд тухай бүртээ гадаадын улс орны болон их, дээд сургуулиудын ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулж судлан, боловсруулж байсан.

Үндсэн хэсэг

ОХУ–ын ВА РХБЗ академийн эрхэм зорилго: нь хурдацтай хөгжиж буй цэргийн технологийн салбартай хөл нийлүүлэн алхах техник сэтгэлгээтэй, онол практикийн өндөр мэдлэгтэй, чадварлаг, хариуцлагатай цацраг хими, биологиос хамгаалах мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Тус сургууль нь ОХУ–ын хэмжээнд Цацраг хими, биологиос хамгаалах мэргэжилтэн бэлтгэдэг цорын ганц, дэлхийн хэмжээнд байдаг ижил мэргэжлийн 3 сургуулийн нэг юм.

- Дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх 5 жил, дунд боловсролтой түрүүч нарыг бэлтгэх 3 жилийн хугацаатай сургалтыг явуулдаг.

- Цацраг хими, биологиос хамгаалах /команд/, Цацраг хими, биологиос хамгаалах /инженер/ гэсэн 2 үндсэн мэргэжлээр бэлтгэдэг.

Сургалтдаа Оросын сүүлийн үеийн автоматжуулсан техник, хэрэгслийг түлхүү ашиглан, онол практикийг хослуулан сургалт явуулдаг.

Цацраг хими, биологиос хамгаалах нь: 1–3 курс хүртэл суурь хичээл үзнэ. Математик, физик, хими, экологи, галын бэлтгэл, ЦАХ–ийн эрх зүй, сэтгэл зүй, геометр гэх мэт.

3–5 курс хүртэл мэргэжлийн хичээлүүдийг үзнэ. Ерөнхий тактик, Цэргийн байр зүй, цацраг хими биологиос хамгаалах, цахилгаан холбоо, цэргийн хээрийн бэхлэлт, тэсэлгээний ажил, химийн тусгай тактик, гэх мэт хичээлүүд ордог. Нийтдээ 6–н жил сурч дээд болон магистрын боловсролын түвшний, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөнө.

Дараах хүснэгтэд 5 жил судалсан хичээлүүдийг харуулсан болно.

ОХУ–ын цэргийн сургуулийн боловсролын системд хичээлийг багц цагаар дүгнэдэггүй, хонхны цагаар дүгнэж байна. Дипломоос харахад 36–н цагийг нэг багц цагаар тооцож болох юм. Хичээлүүд ихэвчлэн 2–26 багц цагаар буюу 72–936 цагаар тооцогдсон байна.

Хөтөлбөрийн ерөнхий цагийг Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэшүүлэх хичээлүүдээр авч үзвэл цагууд нь дараах байдлаар харагдаж байна. Дадлагын хичээлүүдийг долоо хоногоор



тооцож оруулсан байна.

ОХУ-ЫН ВА РХБЗ АКАДЕМИЙН СУРГАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хичээлийн нэрс, дадлагын төрөл, шалгалт	Хичээлийн цаг
Орос хэл	345 цаг
Биеийн тамир	480 цаг
Оросын түүх	120 цаг
Соёл судлал	169 цаг
Улс төр судлал	60 цаг
Нийгэм судлал	74 цаг
Эрх зүй	112 цаг
Заах арга зүй болон сэтгэл судлал	116 цаг
Философи ба шашин судлал	100 цаг
Эдийн засаг	106 цаг
Цэргийн түүх судлал	106 цаг
Математик	378 цаг
Информатика	150 цаг
Физик	246 цаг
Органик бус хими	150 цаг
Органик хими	150 цаг
Аналитик хими	124 цаг
Физик болон каллойд хими	120 цаг
Экологийн аюулгүй байдал	136 цаг
Тусгай хими	140 цаг
Эрүүл мэндийн бэлтгэл	120 цаг
Инженерийн шугам зураг	90 цаг
Механик	144 цаг
Амьдралын аюулгүй байдал	126 цаг
Удирдах онол	90 цаг
Цахилгаан ба цахилгаан техник	102 цаг
Хөдөлмөр материал хангалт	112 цаг
Амьдрах ухаан	60 цаг
Стандарчлал сертификацлал	102 цаг
Үй олноор хөнөөх зэвсэг	303 цаг
Авто бэлтгэл	285 цаг
Цэргийн автомат удирдлага	102 цаг
Тактика	60 цаг
Цацраг, хими, биологийн хамгаалалт	522 цаг
Цэргийн холбоо	92 цаг
Инженерийн бэлтгэл	92 цаг
Цэргийн байрзүй	120 цаг
Тайван цагт цэргийг удирдах	408 цаг
Хамгаалах хэрэгсэл	327 цаг
Тусгай цэвэрлэгээний техник хэрэгсэл	609 цаг
Тагнуулын техник хэрэгсэл	687 цаг
ЦХБХ ашиглалт хамгаалалт, хадгалалт	398 цаг
Галын бэлтгэл	102 цаг
Цэргийн дүрэм	138 цаг
Жагсаалын бэлтгэл	114 цаг
Дадлага	
Хээрийн	
Засварын	
Цэргийн хэргийн	
Улсын шалгалт	
Цогцолбор шалгалт	
Биеийн тамир	
Дипломын ажил	
	Нийт 6420 цаг

Бакалаврын сургалтын төлөвлөгөө
– Цацраг, хими, биологийн хамгаалалт, хангалт

Д/д	Хичээлийн нэр	Багц цаг
ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ		36
ЗААВАЛ СУДЛАХ		33
1	Монголын түүх, соёл, ёс заншил	3
2	Монгол хэл бичиг, найруулга зүй	3
3	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй	3
4	Философи	3
5	Математик–1	3
6	Математик–2	3
7	Физик–1	3
8	Физик–2	3
9	Биеийн тамир	4
10	Мэдээллийн технологийн үндэс	3
СОНГОН СУДЛАХ		2
11	Англи хэл–1	3
12	Англи хэл–2	2
13	Инженерийн зураг зүй	2
МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ		30
ЗААВАЛ СУДЛАХ		25
14	Ерөнхий хими	3
25	Органик биш хими	3
16	Органик хими	3
17	Аналитик хими	3
18	Физик, коллойд хими	3
19	Усны хими	2
20	Радиохими, экологи	2
21	Полимер хими	3
22	Экологи, байгаль хамгаалал	3
СОНГОН СУДЛАХ		5
23	Цахилгаан техник электроникийн үндэс	2
24	Хэрэглээний механик	2
25	Эдийн засгийн онолын үндэс	3
26	Мэргэжлийн англи хэл	2
МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ		64
МЭРГЭШҮҮЛЭХ СУУРЬ ХИЧЭЭЛ		26
27	Ерөнхий тактик–1.2	4
28	Галын бэлтгэл	2
29	Цэргийн байр зүй	2
30	Тайван цагт цэргийг удирдах	2
31	Байлдааны цагт цэргийг удирдах	1
32	Цэргийн сэтгэл зүйн хангалт	1
33	Сургалт, судалгааны арга зүй	1
34	Артиллерийг байлдаанд хэрэглэх	1
35	Агаарын довтолгооноос хамгаалах	1
36	Цэргийн инженерийн хангалт	1
37	Цэргийн холбоо, кибер аюулгүй байдал	2
38	Цэргийн эрх зүй	1
39	Цэргийн материал, техникийн хангалт	2
40	Эрүүл мэндийн хангалт	1



41	Цэргийн биеийн тамир	4
МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛ		38
42	Үй олноор хөнөөх зэвсэг	2
43	Нэг бүрийн ба нийтийн хамгаалах хэрэгсэл	2
44	Химийн хорт бодис ба цэргийн токсикологи	2
45	Цацраг, химийн тагнуулын техник хэрэгсэл	3
46	Тусгай цэвэрлэгээний техник хэрэгсэл	3
47	Тусгай цэвэрлэгээний бодис уусмал	2
48	Шатаах, утаат болон сургалтын дуурилган үзүүлэх хэрэгсэл	2
49	Цэргийн экологи	2
50	Химийн тусгай тактик-1	2
51	Химийн тусгай тактик-2	2
52	Химийн тусгай тактик-3	2
53	Химийн техник, эд хэрэгслийн ашиглалт, хадгалалт, засвар үйлчилгээ	2
54	Химийн хангалт	2
55	Хээрийн гаралт, мэргэжлийн дадлага	6
56	Удирдах ур чадварын дадлага	3
ДИПЛОМЫН АЖИЛ		3
57	Бакалаврын дипломын ажил	3
СУРГАЛТЫН НИЙТ БАГЦ ЦАГ		
ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ		36
МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ		28
МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ		64
ДИПЛОМЫН АЖИЛ		3

ҮБХИС–ийн 2022–2023 оны хичээлийн жилээс эхлэн дөрвөн жил /цэргийн/–ээр сургалт явуулах бөгөөд “Цацраг хими, биологиос хамгаалах, хангалт” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр нь 130–н багц цаг байхаар төлөвлөсөн байна. ОХУ–ын ВА РХБЗ академийн цагийг кредит цаг руу шилжүүлбэл ойролцоогоор 178 кр болж байна. Энэ нь 5 жил сурдаг, мөн хагас сайн өдөр хичээл ордогтой холбоотойгоор 48 кредитийн зөрүү гарч байна.

Дүгнэлт

ОХУ–ын Кострома хотын цацраг, хими, биологийн хамгаалалт академийн хөтөлбөр, Монгол улсын ҮБХИС “цацраг, хими, биологийн хамгаалалт, хангалт” хөтөлбөрүүдийг

харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргаж байна.

Сургалтын орчин нөхцөлийн хувьд ОХУ–ын сургалтад ашиглагддаг техник хэрэгсэл нь өөрийн улсынх, сүүлийн үеийн загварынх байгаа бөгөөд анги, танхим, дадлагын байр нь бүрэн автоматжсан суралцагчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мөн судалгаа шинжилгээ явуулдаг шинжлэх ухааны тусгай роттой байна. Манай улсын хувьд техник хэрэгсэл хоцрогдсон, сургалтын орчин нөхцөл танхим, дадлагын байр нь суралцагчдын хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй дутагдалтай байна.

Сайн тал:

- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулдаг
- Сургалтыг тасралтгүй зохион байгуулан явуулж байгаа
- Хөтөлбөрүүдтэй харьцуулан, судалж дүн шинжилгээ хийгддэг

Сул тал:

- Сургалтын орчин, анги танхим суралцагчдын суралцах таатай нөхцөлийг бүрэн хангаагүй
- Сургалтад ашиглагдаж байгаа техник, эд хэрэгсэл хоцрогдсон дутмаг
- Материаллаг хэрэгсэл хангалтгүй, санхүүжилт болон хангах нөхцөл муу
- Дадлагын байрны нөхцөл шаардлага хангадаггүй, хээрийн сургалтын төвд мэргэжлийн дадлага явуулах материаллаг бааз байхгүй
- Багшлах бүрэлдэхүүнийг эхнээс нь сургаж авдаггүй
- Тэнхимүүдийн хичээлийн харилцан ажиллагаа дутмаг
- Хөтөлбөрийн элсэлтэд өндөр шаардлага тавьдаггүй.

Ашигласан материал:

1. <https://varhbz.mil.ru/more/Novosti/item/39812/> Отравляющие вещества Александров В.Н., Емельянов В.И. г.Москва 1990г
2. Судлахуйн үндэс Ш.Паламдорж, Н.Жалбажав Улаанбаатар, 2009



ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН АМИА ХОРЛОЛТОД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД: ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ш.МАРАЛМАА /ШУТИС, БУХС-ийн магистрант/
А.НАРАНГЭРЭЛ /ШУТИС, БУХС-ийн ахлах багш доктор (Ph.D)/

Түлхүүр үг: Амиа хорлох оролдлого, урьдчилан сэргийлэлт, цэргийн алба хаагч, Монгол улсын зэвсэгт хүчин, сэтгэцийн эрүүл мэнд

Key words: Attempted suicide, prevention, military personnel, Mongolian armed forces, mental health

Оршил

Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэнд нь улс орны батлан хамгаалах чадавхад чухал нөлөө үзүүлдэг. Олон улсын судалгаагаар цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал хангалтгүй байгаагаас үүдэн сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, өөрийгөө гэмтээх оролдлого, улмаар амиа хорлох үзэгдэл ихсэж буй нь батлан хамгаалах салбарт тулгарч буй томоохон сорилтуудын нэг болж байна.

Эдгээр асуудлын үндсэн шалтгаан нь сэтгэл зүйн дарамт, нийгмийн дэмжлэгийн дутагдал, мөн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй байдалтай шууд холбоотой гэж олон судлаачид үздэг. Иймд цэргийн алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг гүнзгий судалж, шалтгаан болон нөхцөл байдлыг тодорхойлох нь зөвхөн тухайн салбарын тогтвортой байдлыг хангахаас гадна урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой.

Энэхүү өгүүллийн зорилго нь Өмнөд Солонгос, АНУ, Австрали зэрэг цэргийн бүтэц, зохион байгуулалт, нийгэм, соёлын өвөрмөц онцлогтой улсуудад хийгдсэн судалгааны үр дүнг ашиглан цэргийн алба хаагчдын амиа хорлох шалтгаан, нөхцөл байдлыг судлах, Монгол Улсад туршлага болохуйц цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих сургалт, хөтөлбөр, урьдчилан сэргийлэх арга хэмжээг онцлох, цаашдын судалгааны чиглэлүүдийг тодорхойлох явдал юм.

Үндсэн хэсэг

Олон улсын цэргийн алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндэд тулгарч буй асуудлыг гүнзгийрүүлэн судлахын тулд цэргийн бүтэц, зохион байгуулалт, нийгэм, соёлын өвөрмөц онцлогоороо ялгаатай, батлан хамгаалах салбарт чухал байр суурь эзэлдэг дараах гурван улсын судлагдсан байдлын судалгааг хийсэн болно.

Өмнөд Солонгос улс: 18–28 насны бүх эрэгтэй иргэд хугацаат цэргийн алба хаах хууль ёсны үүрэгтэй бөгөөд алба хаах хугацаа нь салбар тус бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, хуурай замын цэрэгт 18 сар, тэнгисийн цэрэгт 20 сар, агаарын цэрэгт 21 сар, иргэний хамгаалалтын албанд 21 сар ба түүнээс дээш хугацаагаар алба хаадаг.

Цэргийн алба хаагчид эх орноо хамгаалах үндсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ цэргийн дүрэм, сахилга бат, ёс зүйн хатуу шаардлагыг чандлан мөрдөх ёстой. Мөн алба хаах явцад батлан хамгаалахын ур чадвар эзэмшиж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах тактик болон ёс зүйн зарчмыг сурч эзэмшдэг. Өмнөд Солонгосын цэргийн бодлого нь сахилга бат, ёс зүйг гол цөм болгож, цэргийн үйл ажиллагааны үр ашиг, алба хаагчдын ёс суртахууны түвшнийг дээшлүүлэхэд чиглэгддэг¹.

АНУ: Цэргийн алба хаах нь сайн дурын үндсэн дээр зохион байгуулагддаг бөгөөд

¹ Ministry of Government Legislation. (n.d.). Military Service Act.



иргэд өөрсдийн хүсэлтээр зэвсэгт хүчинд элсэх бөгөөд иргэд өөрсдийн хүсэлтээр зэвсэгт хүчинд элсэх боломжтой. АНУ–ын зэвсэгт хүчин дараах үндсэн салбаруудаас бүрдэнэ. Үүнд:

- Хуурай замын цэргийн хүчин: Дэлхий даяар байлдааны болон батлан хамгаалах үүрэг гүйцэтгэдэг үндсэн салбар.
- Тэнгисийн цэргийн хүчин: Тэнгисийн стратегийн аюулгүй байдал, хяналт, байлдааны ажиллагааг хариуцдаг хүчин.
- Агаарын цэргийн хүчин: Агаарын болон сансрын үйл ажиллагаанд төвлөрч, үүрэг гүйцэтгэдэг.
- Тэнгисийн явган цэрэг: Хурдан хариу үйлдэл үзүүлэх, агаарын болон хуурай замын үйл ажиллагааг зохицуулах чадвартай хүчин.
- Усан цэрэг: Хилийн аюулгүй байдал, эргийн хамгаалалт, аврах ажиллагаа, далайн хяналтыг хариуцдаг тусгай хүчин.

Цэргийн албанд элсэгчид мэргэжлийн цэргийн сургалтад хамрагдаж, тухайн салбарын онцлогт тохирсон тусгай ур чадварыг эзэмшдэг. Үүний зэрэгцээ тэд ёс зүйн хатуу дүрэм, журмыг мөрдөж улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг¹.

Австрали улс: Австралийн зэвсэгт хүчин нь сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дотоодын батлан хамгаалах үүргээс гадна энхийг сахиулах болон олон улсын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд идэвхтэй оролцдог. Зэвсэгт хүчин нь дараах үндсэн салбаруудаас бүрдэнэ. Үүнд:

- Хуурай замын цэргийн хүчин: Байлдааны ажиллагаа явуулах, батлан хамгаалах үүргийг гүйцэтгэх үндсэн салбар.
- Тэнгисийн цэргийн хүчин: Далайн аюулгүй байдлыг хангах, хяналт, аврах ажиллагааг зохион байгуулах хүчин.
- Агаарын цэргийн хүчин: Агаарын болон сансрын аюулгүй байдал, нисэх хүчний үйл ажиллагаанд төвлөрсөн хүчин.
- Нөөцийн алба: Бэлтгэгдсэн, шаардлагатай

үед дайчлагдах боломжтой иргэдээс бүрдсэн салбар.

Австралийн зэвсэгт хүчин нь энх тайвныг сахиулах, бүс нутгийн болон дэлхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг².

Олон улсын судалгаа

1. Shim, E. J., et al. (2020). Соматик шинж тэмдэг болон нойрны чанар нь Өмнөд Солонгос улсын хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл гутрал болон амиа хорлох эрсдэлийн үзүүлэлтүүд болох нь. (Somatic symptoms and sleep quality as indicators of depression and suicide risk among Korean military conscripts. Journal of Affective Disorders).

Энэхүү судалгаа нь Өмнөд Солонгосын хугацаат цэргийн алба хаагчдын дунд сэтгэл гутрал болон амиа хорлох эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн. Судалгаанд 2016 оны байдлаар нийт 1937 хугацаат цэргийн алба хаагчид оролцож, дараах үнэлгээний арга хэрэгслүүдийг ашигласан³. Үүнд:

- PHQ–9: Сэтгэл гутралын үзүүлэлтийг хэмжих асуумж;
- PHQ–15: Соматик буюу бие махбодын шинж тэмдгийг үнэлэх асуумж;
- MIN: Сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага;
- Питтсбургийн нойрны чанарын индекс (PSQI): Нойрны чанарыг үнэлэх арга.

Судалгааны үр дүнд сэтгэл гутрал болон амиа хорлох эрсдэлтэй цэргийн алба хаагчдын дунд соматик шинж тэмдэг илүү ноцтойгоор илэрч байгааг баталсан. Харин нойрны чанар муудах нь сэтгэл гутралын өндөр эрсдэлтэй холбоотой болохыг тайлбарласан байна. Амиа хорлох эрсдэлийг зөвхөн сэтгэл гутралын үзүүлэлтээр тайлбарлах нь хангалтгүй тул

² Australian Government, Department of Defence. (n.d.). Defence Policy and Regulation. Retrieved from <https://www.defence.gov.au>

³ Shim, E. J., et al. Somatic symptoms and sleep quality as indicators of depression and suicide risk among Korean military conscripts. Нидерланд Амстердам., “Elsevier” хэвлэл 2020. Affective Disorders сэтгүүл. 273–р дугаар. т.1–3

¹ Selective Service System. (n.d.). Selective Service Act. Retrieved from <https://www.sss.gov>



нойрны чанар, соматик шинж тэмдэг зэрэг бусад үзүүлэлтүүдийг харгалзан үзэх шаардлагатайг онцолсон⁴.

Иймд хугацаат цэргийн алба хаагчдын соматик шинж тэмдэг болон нойрны чанарт хяналт тавьж байх нь алба хаагчдын сэтгэл гутрал болон амиа хорлох эрсдэлийг эрт илрүүлэх, үрдүнтэй дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн⁵.

2. U.S. Department of Defense. (2023). Annual report on suicide in the military: Calendar year 2023. Department of Defense Suicide Event Report (DoDSER).

АНУ-ын Батлан хамгаалах яам (DoD) 2023 онд цэргийн алба хаагчдын амиа хорлолтын тохиолдол, шалтгаан, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нарийвчлан судалсан.

2023 онд амиа хорлолтын нийт 523 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд:

- 363 нь идэвхтэй алба хаагч;
- 69 нь нөөц хүчнийхэн;
- 91 нь үндэсний хамгаалагч байсан⁶.

Идэвхтэй алба хаагчдын амиа хорлолтын тохиолдол 2011–2023 оны хооронд тогтвортой нэмэгдсэн бөгөөд 2023 онд өмнөх жилүүдээс илүү өндөр түвшинд хүрсэн. Харин нөөцийн болон үндэсний хамгаалагчдын хувьд жил бүр хэлбэлзэл ажиглагддаг ч урт хугацааны чиг хандлага тогтвортой байна.

Нас, хүйс, нийгмийн хүчин зүйлс:

- Амиа хорлосон тохиолдлын ойролцоогоор 60 хувийг 18–30 насны эрэгтэй алба хаагчид эзэлсэн.

⁴ Shim, E. J., et al. Somatic symptoms and sleep quality as indicators of depression and suicide risk among Korean military conscripts. Нидерланд Амстердам., "Elsevier" хэвлэл 2020. Affective Disorders сэтгүүл. 273–р дугаар. т.4–6

⁵ Shim, E. J., et al. Somatic symptoms and sleep quality as indicators of depression and suicide risk among Korean military conscripts. Нидерланд Амстердам., "Elsevier" хэвлэл 2020. Affective Disorders сэтгүүл. 273–р дугаар. т.8

⁶ U.S. Department of Defense. Annual report on suicide in the military., Вашингтон., 2023. т.5;

• Гэр бүлээ цуцлуулсан алба хаагчдын амиа хорлох эрсдэл харьцангуй өндөр байгаа нь тогтоогдсон.

• Галт зэвсэг нь амиа хорлолтын хамгийн түгээмэл арга хэвээр байна⁷.

Шалтгаан ба нөлөөлөх хүчин зүйлс (2023 он):

- 42 хувь нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал (PTSD, сэтгэл гутрал гэх мэт);
- 44 хувь нь харилцааны асуудал (гэр бүл салалт, хүүхэд асрах маргаан гэх мэт);
- 24 хувь нь ажлын байрны стресс;
- 29 хувь нь захиргааны болон хууль эрх зүйн асуудал;
- 12 хувь нь санхүүгийн асуудал;
- 2 хувь нь хүчирхийлэл эсвэл дарамтад өртсөн гэж бүртгэгдсэн.

2022 оны гэр бүлийн амиа хорлолт:

- 93 тохиолдол алба хаагчдын эхнэр/нөхөр;
- 53 тохиолдол хамааралтай хүүхэд болон асран хамгаалагч байсан⁸.

Амиа хорлолтын тохиолдол идэвхтэй цэргийн алба хаагчдын дунд тогтвортой нэмэгдэж байгаа нь цэргийн ажиллах орчин, стресс, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой болох нь харагдаж байна.

Урьдчилан сэргийлэх 5 гол чиглэл:

АНУ-ын Батлан хамгаалах яам амиа хорлолтыг бууруулах дараах гол арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэх:

- Ажиллаж, амьдрах тогтвортой нөхцөлийг хангах.
- Удирдлагын дэмжлэг, ажлын цагийн уян хатан байдлыг сайжруулах.
- Нийгмийн халамж, гэр бүлийн зөвлөгөөний үйлчилгээг өргөжүүлэх.

2. Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх:

- Эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулах.

⁷ U.S. Department of Defense. Annual report on suicide in the military., Вашингтон., 2023. т.12;

⁸ U.S. Department of Defense. Annual report on suicide in the military., Вашингтон., 2023. т.44;



- Цахим болон утасны сэтгэл зүйн тусламжийг өргөжүүлэх.

- Бие даан эмнэлгийн үйлчилгээ авахад саадгүй болгох.

3. Сэтгэл зүйн тусламж авах саад бэрхшээлийг арилгах:

- Гутаан доромжлолыг бууруулах.
- Анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Үйлчилгээ авах хүлээлгийн хугацааг багасгах.

4. Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх сургалтыг шинэчлэх:

- Сургалтыг орчин үеийн судалгаанд тулгуурлан шинэчлэх.
- Удирдах албан тушаалтнуудад стрессийн менежмент, зөв харилцааны арга барилыг заах.

5. Галт зэвсгийн аюулгүй байдлыг хангах:

- Аюулгүй хадгалалтын хяналтыг сайжруулах.
- Галт зэвсгийн хадгалалтын стандартыг нэмэгдүүлэх.
- Цоож болон аюулгүй байдлын хэрэгслийг үнэ төлбөргүй тараах⁹.

Эдгээр арга хэмжээнүүд нь АНУ-ын цэргийн алба хаагчдын амиа хорлолтыг бууруулах, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, гэр бүлийнх нь аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн үр дүнтэй алхам гэж үзэж байна.

3. Australian Institute of Health and Welfare. (2023). Австралийн Батлан хамгаалах салбарт 1985 оноос хойш алба хааж байсан ба идэвхтэй алба хааж буй цэргүүдийн 1997–2021 оны байдлаарх амиа хорлох тохиолдлын судалгаа. Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021.

Австралийн Батлан хамгаалах хүчин (ADF) 1985–2021 оны байдлаар халагдсан, нөөцөд бүртгэлтэй, идэвхтэй алба хааж буй цэргийн алба хаагчдын амиа хорлолтын түвшнийг судалж, эрсдэлтэй бүлгүүдийг тодорхойлсон.

⁹ U.S. Department of Defense. Annual report on suicide in the military., Вашингтон., 2023., т.48;

Судалгаа нь амиа хорлолтын хандлагыг ойлгож, эрсдэлтэй бүлгүүдийг тодорхойлж, Австралийн ерөнхий хүн амтай харьцуулахад чиглэгдсэн¹⁰.

1997–2021 оны байдлаар амиа хорлосон тохиолдол:

- Идэвхтэй алба хаагчид: Нийт 162 тохиолдол (эрэгтэй 152, эмэгтэй 10).
- Нөөцөд бүртгэлтэй: Нийт 120 тохиолдол (эрэгтэй 113, эмэгтэй 7).
- Халагдсан: Нийт 1395 тохиолдол (эрэгтэй 1277, эмэгтэй 118).
- Нийт: 1677 тохиолдол (эрэгтэй 1542, эмэгтэй 135).
- Австралийн нийт хүн ам: 65,675 тохиолдол (эрэгтэй 50,445, эмэгтэй 15,230)¹¹.

Өмнө нь алба хааж байсан халагдсан эрэгтэй алба хаагчдын амиа хорлолтын түвшин ерөнхий эрэгтэй хүн амтай харьцуулахад 26 хувиар өндөр байсан бол халагдсан эмэгтэй алба хаагчдын хувьд энэ түвшин 107 хувиар өндөр байгааг тогтоожээ.

Мөн урт хугацааны турш алба хаасан (20 ба түүнээс дээш жил) эрэгтэй алба хаагчдын амиа хорлолтын түвшин хамгийн бага. Энэ нь дасан зохицох чадвар, сэтгэл зүйн тогтвортой байдалтай холбоотой гэж дүгнэсэн байна.

Идэвхтэй алба хааж буй болон нөөцөд бүртгэлтэй эрэгтэй алба хаагчдын амиа хорлох магадлал нь Австралийн ерөнхий эрэгтэй хүн амтай харьцуулахад хоёр дахин бага байсан ба идэвхтэй алба хаагчдын амиа хорлолтын түвшин 49%–аар, нөөцөд бүртгэлтэй алба хаагчдын түвшин 45 хувиар тус тус бага байв¹².

¹⁰ Australian Institute of Health and Welfare. Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021. Australia., 2023., т.1;

¹¹ Australian Institute of Health and Welfare. Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021. Australia., 2023., т.7–8;

¹² Australian Institute of Health and Welfare. Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021. Australia., 2023., т.10;

**Шалтгаан ба нөлөөлөл:**

Халагдсан цэргийн алба хаагчдын амиа хорлолтын түвшин өндөр байгаа нь тэдний эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, нийгмийн дэмжлэгийн дутагдалтай холбоотой гэж үзсэн.

Судалгааны хүрээнд дэвшүүлсэн зөвлөмж:

1. Сэтгэл зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх: Халагдсан алба хаагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн дэмжлэгийг өргөжүүлэх.

2. Эмэгтэй цэргийн алба хаагчдад чиглэсэн тусгай хөтөлбөрүүд: Эмэгтэй цэргийн алба хаагчдад зориулсан тусгай сэтгэл зүйн дэмжлэг, сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

3. Алба хаах хугацааны туршид эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх: Сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих тогтвортой хөтөлбөрүүдийг алба хаах явцад хэрэгжүүлэх.

Австрали улсын цэргийн алба хаагчдын амиа хорлох асуудал тулгамдсан хэвээр байна. Идэвхтэй болон нөөцийн алба хаагчдын амиа хорлолтын түвшин бага боловч халагдсан алба хаагчдын хувьд эрсдэл өндөр байна. Үүнийг бууруулахын тулд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, тусгайлсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзсэн¹³.

Өмнөд Солонгос, АНУ, Австрали улсын судалгаанд дүн шинжилгээ хийж, цэргийн алба хаагчдын амиа хорлолтод нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлов. Судалгаагаар амиа хорлолтын шалтгаан нь улс орон бүрийн нийгэм, соёлын өвөрмөц онцлог, цэргийн бүтэц зохион байгуулалт, мөн сэтгэл зүйн нөхцөл байдлаас хамааран ялгаатай болохыг харуулсан.

Ижил төстэй хүчин зүйлс:

1. Сэтгэцийн эрүүл мэнд: Сэтгэл гутрал, PTSD зэрэг эмгэгүүд нь цэргийн алба хаагчдын амиа хорлох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

2. Гэр бүлийн асуудал: АНУ болон

Австралийн судалгаанд гэр бүл салалт, харилцааны зөрчил нь амиа хорлолтын гол шалтгаан болж байгааг тогтоосон.

3. Судалгаагаар 18–30 насны эрэгтэй цэргийн алба хаагчдын дунд амиа хорлолтын тохиолдол хамгийн өндөр байгааг онцолсон.

4. Нойрны чанар: Солонгосын судалгаанд нойрны чанар муудах нь сэтгэл гутралын өндөр эрсдэлтэй холбоотой болохыг тодорхойлсон. Энэ нь бусад судалгаануудын үр дүнтэй нийцэж, стресс болон сэтгэл зүйн асуудал амиа хорлох эрсдэлд нөлөөлж болохыг харуулж байна.

5. Галт зэвсгийн хэрэглээ: АНУ болон Австралийн судалгаагаар галт зэвсэг нь амиа хорлолтын хамгийн түгээмэл хэрэгсэл хэвээр байгааг онцолсон.

Ялгаатай хүчин зүйлс:

1. Соёл ба нийгмийн тогтолцоо:

- Өмнөд Солонгосын судалгаа нь соматик шинж тэмдэг болон нойрны чанарыг амиа хорлох магадлалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн нэг гэж үзсэн. Энэ нь бие махбодын шинж тэмдэг, стресс хоорондын хамаарлыг харуулсан.
- АНУ-ын судалгаанд цэргийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн амиа хорлох асуудлыг онцлон авч үзэж, нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатайг онцолсон.
- Австралийн халагдсан цэргийн алба хаагчдын амиа хорлох эрсдэл маш өндөр байсан бөгөөд эмэгтэй алба хаагчдын дунд энэ үзүүлэлт илүү өндөр байгаа нь тусгай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

2. Судалгааны хамрах хүрээ:

- Өмнөд Солонгос улсын судалгаа хугацаат цэргийн алба хаагчдыг хамарсан бол АНУ, Австралид идэвхтэй алба хаагчид, нөөцийн бүрэлдэхүүн, халагдсан алба хаагчдыг хамарсан өргөн хүрээтэй судалгаа хийсэн.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:**Өмнөд Солонгос:**

- Нойрны чанар болон соматик шинж

¹³ Australian Institute of Health and Welfare. Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021. Australia., 2023., т.20;



тэмдгийг тогтмол хянах.

- Сэтгэл гутрал болон стрессийн эрт илрүүлгийг сайжруулах тогтолцоо бий болгох.
- Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

АНУ:

- Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа цэргийн алба хаагчид болон тэдний гэр бүлд зориулсан хөтөлбөрүүдийг өргөжүүлэх.
- Галт зэвсгийн аюулгүй хадгалалт, хяналтыг сайжруулах.
- Гэр бүлийн дэмжлэгийн системийг хөгжүүлж, харилцааны зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх.

Австрали:

- Халагдсан цэргийн алба хаагчид, ялангуяа эмэгтэйчүүдэд зориулсан сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Эрүүл мэндийн тогтмол үзлэг, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг алба хаах хугацаанд тогтмол зохион байгуулах.
- Алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг сайжруулах сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

ДҮГНЭЛТ

Цэргийн алба хаагчдын амиа хорлох

шалтгаан, нөхцөл байдал нь улс орон бүрийн нийгэм, соёлын онцлог, цэргийн бүтэц зохион байгуулалттай нягт холбоотой бөгөөд энэ нь олон улсын түвшинд тулгарч буй нийтлэг, ноцтой асуудал гэдгийг судалгаагаар баталлаа. Өмнөд Солонгос, АНУ, Австрали зэрэг улсуудад хийгдсэн судалгааны үр дүн нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, харилцааны зөрчил, нас залуу алба хаагчдын эрсдэл, нойрны чанар, галт зэвсгийн хэрэглээ зэрэг нийтлэг хүчин зүйлсийг илрүүлсэн төдийгүй улс орон бүрийн соёл, хууль тогтоомж, цэргийн бүтэц зохион байгуулалтаас үүдэлтэй ялгаатай хүчин зүйлсийг онцолсон.

Судалгааны үр дүнд амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэх, сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Монгол Улсын хувьд цэргийн алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих сургалтын хөтөлбөр боловсруулах, амиа хорлох эрсдэлийг эрт илрүүлэх зэрэг арга хэмжээг сайжруулахад мэдээлэл, туршлага өгөх боломжтой. Түүнчлэн Монгол Улсын цэргийн алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, амиа хорлох эрсдэл, ажлын байрны стресс, харилцааны зөрчил зэрэг сэдвээр цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Ministry of Government Legislation. (n.d.). Military Service Act.
2. Selective Service System. (n.d.). Selective Service Act. Retrieved from <https://www.sss.gov>
3. Australian Government, Department of Defence. (n.d.). Defence Policy and Regulation. Retrieved from <https://www.defence.gov.au>
4. Shim, E. J., Hwang, H., Lee, K. M., Lee, J. Y., Lee, S. D., Baik, M. J., Shin, M. S., Moon, H., & Hahm, B. J. (2020). Somatic symptoms and sleep quality as indicators of depression and suicide risk among Korean military conscripts. *Journal of Affective Disorders*, 273, 1–8.
5. U.S. Department of Defense. (2023). Annual report on suicide in the military: Calendar year 2023. Department of Defense Suicide Event Report (DoDSER).
6. Australian Institute of Health and Welfare. (2023). Serving and ex-serving Australian Defence Force members who have served since 1985: Suicide monitoring 1997 to 2021 (Cat. no. PHE 327).



ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

М.ИНДРАБҮД /УБХИС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ын багш/
Г.ДОЛЖИН /УБХИС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ын багш/

Түлхүүр үг: Ялгаварлан гадуурхалт, Үзэн ядалт, Ялгаварлан гадуурхах эс үйлдэл, Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Key words: Discrimination, hatred, Non-discrimination, Crime of discrimination, Violence against women

Оршил

Монгол Улс 1981 онд тус Конвенцид нэгдээд 34 жил, хүний эрх, тэгш эрх, ялгаварлан гадуурхалтыг хориглосон, төр засгийн үүрэг хариуцлагыг тодорхойлж тунхагласан Үндсэн хуулиа батлаад 25 жил болж байна. “Монгол Улсын иргэн хүний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

Монгол Улс ялгаварлан гадуурхалтын эсрэг бие даасан хуульгүй, хуулийн төсөл боловсруулах ажил ч эхлээгүй. Жендерийн тэгш байдлын тухай хуулиар жендерийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон ч хуулийн сурталчилгаа хангалттай бус. Бодит амьдрал дээр нас, хүйс, гадаад төрх байдлаар ялгаварлан гадуурхах явдал түгээмэл гардаг.

Ялгаварлан гадуурхалтын бодит хохирлыг тооцдоггүй, гомдол гаргах үр дүнтэй механизм байхгүй, одоогийн механизм үр нөлөө багатай. Хүний эрхийн чиглэлээр НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжүүдийг нэгдсэн бодлогоор төлөвлөдөггүй, төсөвгүй зэргээс хэрэгжих боломжгүй болж байна.

Гүйцэтгэх засаглал, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдээгүй. Охид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, үл хайхрах байдал олон нийтийн дунд хэвээр байна. Засгийн газрын олон хүүхэд төрүүлэхийг дэмжих бодлогын

үр дүнд төрөлт нэмэгдэж байгаа нь сайн талтай ч цэцэрлэг хүртээмжгүйн улмаас залуу эмэгтэйчүүд гэртээ сууж, ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болж байна. Мөн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэхэд эрэгтэйн нэр дээр бүртгэх явдал нийтлэг байгаагаас эмэгтэйчүүдийн хөрөнгөө барьцаалан зээл авах, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг хаасаар байна.

Иймд хүний үндсэн эрх тэр дундаа эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж, аливаа ялгаварлан гадуурхалтад өртөж буй байдлаас урьдчилан сэргийлж хамгаалах нийгмийн бүлгийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж, хүчирхийлэлд өртөх явдлыг таслан зогсоох асуудлыг чухалчлан гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хэсэг

Ялгаварлан гадуурхах үйлдэл: Нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг ялгаварлан гадуурхалт гэнэ. Боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт, бүх төрлийн үйлчилгээ авахад ямар нэг нийгмийн бүлэгт харьяалагдах мөн чанараар нь буюу үндэс, шашин, үндэс угсаа гэх мэт хүчин зүйлсээр хүмүүсийг ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайн хүнийг эрхээ эдлэх тэгш боломж олгохгүй байхыг хэлдэг. Бусдыг ялгаварлан гадуурхах нь хувь хүний дургүйцэл эсхүл үзэн ядах сэдэлттэй байдаг.

Үзэн ядах сэдэлт: Үзэн ядалт гэдэг латин гаралтай “Одиум” гэсэн үг бөгөөд хүнд дайсагнах, дургүйцэх мэдрэмж болон илэрхийллийг хэлдэг. Үзэн ядалт нь хор



хөнөөлтэй, аюултай үр дагаврыг бий болгодог ба үзэн ядалтын улмаас хүний амь нас ч хохирч болох бөгөөд энэ нь тухайн хүний хийсэн үйлдэл, зан үйлээс үүдэлтэй байдаг. Монгол Улсын Эрүүгийн хуульд зарим төрлийн хэрэгт “Үзэн ядалт”-ыг сэдэлт гэж тодорхойлсон бөгөөд бие даасан гэмт хэргийг мөн хуулийн 14.1 дүгээр зүйлд “Ялгаварлан гадуурхах” гэмт хэрэг гэж хуульчилсан.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг: Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл “Үндсэн гэмт хэрэг” ба хохирогчийг тодорхой мөн чанараар нь ялгаварласан ялгаварлалтад үндэслэсэн “Ялгаварлан гадуурхах сэдэлт” үйлдлийг хэлнэ.

Олон улсын хэм хэмжээ:

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он

2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966 он

3. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц 1965 он

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц 2006 он

5. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1990 он

6. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц 1979 он

7. Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц 1958 он

8. Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц 1960 он

9. Хөгжих эрхийн тухай тунхаглал 1986 он

10. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг олон улсын хүний эрхийн эрх зүйд ашиглах тухай Жогжакартагийн зарчим 2006 он

11. Хүний эрхийн боловсрол, сургалтын талаарх тунхаглал 2011 он

Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн “жендерт суурилсан хүчирхийлэл”-ийн тодорхойлолт: Эмэгтэй хүн, охин, эрэгтэй хүн эсвэл хөвгүүний эсрэг үйлдсэн, тухайн хүндээ биемахбодын, бэлгийн, сэтгэлзүйн эрүүл мэнд, хөгжил,

эсвэл түүний илэрхийлэлд нь сөрөг үр дагавар үүсгэсэн аливаа хор хөнөөл эсвэл шаналал. Хүчирхийллийн шалтгаан нь жендерт суурилсан эрх мэдлийн тэгш бус байдал, жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй байна.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх тухай Истанбулын конвенц дахь “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийн тодорхойлолт

1. Хүний эрхийн зөрчил

2. Ялгаварлан гадуурхсан үйлдэл

3. Эмэгтэй хүнд бие махбодын, бэлгийн эсвэл сэтгэлзүйн хор хөнөөл, шаналлыг албадах, эрх чөлөөг нь хязгаарлах зэрэг аюул заналхийлсэн үйлдлийг оролцуулан нийтэд илээр, мөн хувийн амьдралд нь эсэхээс үл хамааран нэгэнт учруулсан, эсвэл учруулахуйц шинжтэй хүчирхийлсэн үйлдэл

НҮБ-ын “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийн тодорхойлолтод:

Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын эрх мэдлийн тэгш бус түүхэн харилцааны илрэл нь эрчүүд эмэгтэйчүүдийг дарангуйлах, ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн хөгжихөд саад болдог ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээр дамжуулан эрэгтэйчүүдийн дор туслах байр сууринд эмэгтэйчүүдийг аваачдаг нийгмийн ноцтой механизмуудын нэг.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын засгийн газрын ээлжит найм, есдүгээр илтгэлд:

1. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ

2. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд хийгдсэн үйл ажиллагаа

3. Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсооход авсан арга хэмжээ

4. Улс төр, нийгмийн амьдралд эмэгтэй,



эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломжийг хангасан байдал

5. Эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхдэд иргэний харьяаллын тухайд тэгш эрх олгосон байдал

6. Боловсролын салбар дахь жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилт

7. Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилт

8. Эрүүл мэндийн салбар дахь жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилт

9. Эдийн засаг, нийгмийн хамгааллын салбар дахь жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилт

10. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг анхааран үзсэн байдал

11. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хуулийн өмнө болон иргэний харилцаанд адил тэгш эрх, чадамжтай байх эрхийн хэрэгжилт

12. Гэрлэлт, гэр бүлийн харилцаа дахь жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилтийн талаар дурдсан байдаг.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн үндэсний хэм хэмжээ:

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван дөрөвдүгээр зүйл.

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл

хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

– Бүлэглэж;

– Хүч хэрэглэж;

– Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Ялгаварлан гадуурхах үйлдэл эс үйлдэл:

Тодорхой хувь хүнийг мөн чанараар нь ялгаварласны улмаас эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол гэмт хэрэгт тооцогдож байна. Эс үйлдэхүйгээр ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайлбал Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаар заасан боловч энэ үүргээ биелүүлэхгүй байх.

Эмэгтэйчүүдийг ялгаварлах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах талаар авсан арга хэмжээ

–Төрөөс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, дорд үзэх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, эрх мэдлийн тэнцвэрт харилцааг бий болгох талаар дорвитой арга хэмжээ аваагүй. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа зан заншил, үйл ажиллагааг Төр таслан зогсоох, ялгаварлан гадуурхалтын суурь шалтгааныг арилгахын оронд харин ч өөрөө санаачилж, өөгшүүлэн дэвэргэсээр байна.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж,

түүний дагуу авсан арга хэмжээ

–Конвенцийн хэрэгжилтийг тайлагнах хугацаанд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиудыг баталсан, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн батлахаар УИХ дээр хэлэлцэж байгаа зэрэг ахиц дэвшил байгаа ч өмнө нь хэрэгжүүлж байсан бодлогын нааштай алхмуудаасаа ухарсан шийдвэрийг сүүлийн жилд Засгийн газар гаргаж байна.

Хүн амаа өсгөх пронаталист бодлого болон эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн хэрэгсэл мэт харж байгаа Засгийн газрын бодлого, түүний үр дагаврууд

–Хүн амаа өсгөх зорилгоор төрөлтийг урамшуулж, бага хэмжээний бэлэн мөнгө тараах, хүүхэд асрах нь зөвхөн эмэгтэй хүний асуудал гэж үзэх хэвшмэл хандлагыг бэхжүүлсэн бодлогоос шалтгаалан төрөлт дагасан нийгмийн үйлчилгээний дэд бүтэц (төрөх газрууд, ясли, цэцэрлэг) орхигдсон. Ингэснээр эмэгтэйчүүдийн нуруун дээр хөлсгүй хөдөлмөрийн ачаалал бууж ирсэн. Төрийн энэ бодлогоос шалтгаалан эмэгтэйчүүд албан/хөлстэй хөдөлмөрийн зах зээл дээр нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөж, хүүхдээ өсгөх болон орлого хөдөлмөр эрхэлж, олох боломжийг хослуулах, өмчлөх, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломж нь хязгаарлагдаж, улам эмзэг, эрсдэлт байдалд орж байна.

Бодит нөхцөл байдалд бусдыг ялгаварлан гадуурхах үйлдэл, хандлага, үг хэллэг зэрэг хүмүүсийн илэрхийлэл түгээмэл байгаа нь нууц биш. Манайд түгээмэл үйлдэгддэг ялгаварлан гадуурхалтын төрөл:

1.Бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах /бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа өөр хүмүүсийг доромжлох, төрийн албан хаагчдын ялгаварлан гадуурхах хандлагаас айж гэмт халдлагад өртсөн ч гомдол гаргаж чаддаггүй

2.Жендерийн ялгаварлан гадуурхалт /Ихэнхдээ эмэгтэйчүүдийг сул дорой эсвэл эрчүүдээс доогуур гэж үзэх хандлага/

3.Хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалт /50–иас дээш настай хүмүүсийг хөгшин гэж үзэн ажилд орох боломжийг нь бууруулдаг/

4.Цалин хөлсний ялгаварлан гадуурхалт /Статистикийн хорооноос гаргасан мэдээнээс авч үзвэл 2021 оны байдлаар дундаж цалин эрэгтэйчүүдийнх 1.4 сая, эмэгтэйчүүдийнх 1.2 сая төгрөг, Оюутолгойн Монгол ажилчид сард 2–5 сая гадаад ажилчид 20–40 саяын цалин авдаг гэх мэдээлэл

5.Гадаад төрхөөр ялгаварлан гадуурхах /царайны төрх, таргалалт г.м байдлаас болж бусдын доог тохуу болох/

6.Хөгжлийн бэрхшээл, өвчний улмаас ялгаварлан гадуурхах /Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр дэлхийн хамгийн гадуурхагдсан бүлгүүдийн нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Тахир дутуу хүмүүсийг бие махбодь бус нийгмээр хязгаарладаг гэж үздэг. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар НХХЯ–наас судалж үзэхэд 13 яамд хөгжлийн бэрхшээлтэй 8хүн ажилладаг бөгөөд 6 яам хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй гэжээ. Хот дотор тэргэнцэртэй хүмүүс нийтийн тээврээр зорчих ямар ч нөхцөл бүрдээгүй буюу тусгай тоноглолтой автобус байхгүй мөн эдгээр хүмүүс барилга байгууламжийн орчинд нэвтрэх боломж хязгаарлагдмал байна/

7.Шашны ялгаварлан гадуурхалт /Шашны итгэл үнэмшил, тэдгээрээс улбаатай зан заншлын хувьд хүнийг гутаан доромжлох/

8.Хэлний ялгаварлан гадуурхалт /Хувь хүн эсвэл нийгмийн бүлгийг тэдний хэл яриа, аялга, аялгууны улмаас доромжлох/

9.Эдийн засгийн ялгаварлан гадуурхалт /Энэ нь хүмүүсийн хооронд мөнгө эсвэл эд хөрөнгийн хэмжээгээр ялгааг бий болгодог бөгөөд нийгмийн анги давхаргад үндэслэн ялгаварлан гадуурхахад хүргэдэг/

10.Нийгмийн давхаргаар ялгаварлан гадуурхах /Энэ нь тодорхой хувь хүмүүсийг нийгэмд авч болох ашиг тусаар нь ялгаж гадуурхдаг. Эдийн засаг, нийгмийн ялгаварлан гадуурхалт нь орлогын тэгш бус байдал эсвэл



боловсролын боломжоос үүдэлтэй/

11. Сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт /Сургуулийн сурагчид үе тэнгийнхнийхээ дунд бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй хандлага/

Ялгаварлан гадуурхах сэдэлт нь хохирогчийн ямарваа нэг бүлгийн харьяаллыг нь илтгэх гүн, үндсэн мөн чанар болох үндэс угсаа, шашин, хэл, хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, мэргэжил гэх мэт мөн чанараар нь ялгаварлах сэдэлт юм.

Заалт 5.1.2. Жендерийн эрх тэгш байдал дараах үндсэн зарчимд тулгуурлана: Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим.

Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: Эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх.

Ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилт

Монгол Улсад эрх тэгш байдал, шударга ёсыг хангах талаар зохицуулсан 81 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр хуулиудад үүрэг болгосон “хориглоно” гэж заасан заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зарим хуулиар тодорхой заагаагүй орхигдуулснаас уг хуулийн заалт хэрэгжих боломж хязгаарлагдмал байна.

Эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа этгээд /Хүснэгт/

№	Эрх ашиг нь хөн-дөгдөж буй бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Нийгмийн бүлэг	Хүний үндсэн эрх зөрчигдөж, аливаа ялгаварлан гадуурхалтад өртөж буй байдлаас урьдчилан сэргийлж хамгаалах нийгмийн бүлгийн хуувь ёсны ашиг сонирхол хөндөгдөж, хүчирхийлэлд өртөх явдлыг таслан зогсоох асуудал чухал байна.
2	Иргэд /18-аас дээш насны иргэний үнэмлэх авсан/	Иргэд үзэл бодол, нас, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг, хүйс, албан тушаал зэргээр ялгаварлан гадуурхалтад өртсөнөөс үүдэн гарах үр дагаврыг багасгах шаардлагатай.
3	Аж ахуйн нэгж байгууллага	Аж ахуйн нэгжүүд хөгжлийн түвшин, хөрөнгө чинээ тухайн аж ахуйн нэгжийн удирдлага нийгэмд эзлэх байр сууриас шалтгаалан ялгаварлан гадуурхалтад өртөх зэргээр тэгш бус байдлын нөлөө нийгэмд тодорхой байр суурийг эзэлжээ.
4	Бусад этгээд	Үндсэн эрхээ эдлэх эрхтэй хүүхэд өөр хоорондоо нэгнийгээ нийгмийн орчин нөхцөлд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, нийтээр хүлээн зөвшөөрөггүй нийгмийн цөөнхийг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах

Цахим орчинд дахь үзэн ядах үг хэллэг хэрэглэсэн байдал

1. Үндэс угсаа – 22
2. Нас хүйс – 5
3. Шашин шүтлэг – 8
4. Нийгмийн гарал байдал – 9
5. Хөрөнгө чинээ – 10
6. Эрхэлсэн ажил, албан тушаал – 63
7. Үзэл бодол – 9
8. Боловсрол – 11
9. Бэлгийн, хүйсийн чиг баримжаа – 13
10. Эрүүл мэндийн нөхцөл байдал – 9
11. Ерөнхий нэр хоч өгсөн, доромжилсон – 9

28

12. Бодит хүнд өгсөн доромж хоч – 2
Нийт – 189 гарсан байна.

Эх сурвалж: Эмэгтэйчүүдийн амьдралын чанар 2021. Судалгааны тайлан

Сүүлийн 6 жилд гарсан гэмт хэргийн нөхцөл байдлыг харьцуулан харуулбал:

Он	Хүний бэлгийн эрх чөлөө, халдлагүй байдлын эсрэг 12.1-12.6	Хүчиндэх 12.1	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 12.2	Хүний халдлагүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.14	Хүн худалдаалах 13.1
2019	591	457	5	136	13
2020	444	360	85	178	10
2021	250	202	219	120	3
2022	540	439	14	210	7
2023	678	550	17	238	11
2024	726	564	11	357	11
Нийт	3229	2572	351	1239	55

Эх сурвалж: Үндэсний статистискийн хороо

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хүмүүс ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. Цаашилбал, Монгол Улсын иргэд хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, хүүхдээ өсгөх, сургах, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй. Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн дагуу эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангагдана. Манай улс эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан, хөхүүлэн дэмжсэн, хангасан бүтцийн шинжтэй алхмуудыг төрийн зүгээс авч байгаа ч үйл явцын талаас бодитой биелүүлэх, хэрэгжүүлэх, зохистой санхүү, техникийн, хүний нөөц дутмаг байсаар байна. Хүний эрхийн зөрчлийн шалтгаан – ялгаварлан гадуурхалттай хэрхэн тэмцсэн талаарх Засгийн газрын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцыг хэрэгжүүлсэн тайланд НҮБ–ын шинжээчдийн 1986 оноос хойш өгсөн дүгнэлт зөвлөмжийг багцлахад:

- Эмэгтэйчүүдийг эдийн засгийн талаас чадавхжуулах, эрх мэдэлтэй болгох, хөдөлмөр эрхлэх боломжоор хангуулах;

- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийг баталгаажуулах;

- Хавчигдсан, гадуурхагдсан охид, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, боломж, бололцоог хангаж, хөхүүлэн дэмжих;

- Шийдвэр, бодлого гаргах түвшний оролцоог хуулиар жишиг тогтоож нэмэгдүүлэх;

- Охид, эмэгтэйчүүдийн талаар нарийвчилсан тоон мэдээлэл, сантай байх тухай зөвлөдөг. Үүнийг төрийн зүгээс эмэгтэйчүүдийн эрхийг хангахын тулд заавал гүйцэтгэх ёстой хэмээн дүгнэж байна.

Ялгаварлан гадуурхах хандлага нь хүний үндсэн эрх, эрх чөлөөнд халддаг бөгөөд хүнийг ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддагийнх

нь төлөө ялгаварлан гадуурхах, ялгаварлан гадуурхалтаа туйлширсан байдлаар илэрхийлж буй үйлдэл түгээмэл байна. Тэр ч утгаараа ялгаварлан гадуурхах хандлага нь хүний эрхэм чанар, хувь хүний онцлогийг үгүйсгэдэг ба хүн бүр хуулийн тэгш хамгаалалтад байх эрхийг зөрчиж байдаг.

Хүнийг хүйсийн баримжаа, бэлгийн чиг хандлагаас нь болж ялгаварлан гадуурхсаны улмаас чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаад улс руу явах, оршин суух боломжгүй болох эсхүл нийгэм болон цахим орчинд өөрийгөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжгүй болох, намын харьяаллаас болж ажлаасаа халагдан ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхээ эдэлж чадахгүй байх зэрэг олон тохиолдлыг энд дурдаж болно. Цаашдаа ч урьдчилан сэргийлэх ажлуудыг идэвхжүүлэх шаардлагатай гэж үзэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Нөгөө талаар олон зууны турш эрхээ эдэлж чадаагүй, соёл, уламжлал, зан заншлын талаас инжээр үнэлэх, эд зүйлээр хэмжих, өөрөө хүсээгүй ч өмнөөс нь шийдвэр гаргаж болно гэж үздэг, эмзэг бүлэгт тооцож ирсэн охид, эмэгтэйчүүдийг хөхиүлэн дэмжиж, эрх тэгш байдлыг хангаснаар эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын хүрээнд ахиц дэвшил гарч, хөгжлийн үйл явцад эерэг нөлөөтэй байх болно. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан ялгаварлан гадуурхалтын эсрэг зөвлөмж, конвенцуудын хэрэгжилтийг хангахад харьяа хороо, дүүргүүд, олон нийтийн болон сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2. Эмэгтэйчүүдийг бүхий л түвшинд чадавхжуулахад холбогдох байгууллагууд шийдвэр боловсруулж ажиллах;

3. Эрх нь зөрчигдөж байгаа эмэгтэйчүүдийг хамгаалах мэргэжлийн байгууллагуудын менежментийг боловсронгуй болгох

**Ашигласан материал:**

1. Монгол улсын үндсэн хууль. УБ.,1992 он
2. Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль.2011 он
3. НҮБ–ийн ерөнхий ассамблей. “Эх дэлийгээ шинэчилъе” Алсын хараа 2050
4. Монгол Улсын Засгийн газар. Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичиг 2013–2016 он
5. Монгол Улсын Засгийн газар. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр. 2002., 2017 он
6. Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичиг. УБ.,2004 он
7. Төрийн албаны зөвлөлийн 2015–2018 оны үйл ажиллагааны тайлан
8. Конрад Аденаурын сан. Төрийн байгуулал судлал. 2021 он
9. НҮБ. Эмэгтэйчүүд.,2017 он
10. Д.Энхжаргал. Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх. 2016 он



БАЙГ МЭРГЭН ОНОХ БОДЛОГОД ФИЗИК МАТЕМАТИКИЙН ТУЛГУУР ОЙЛГОЛТУУД БОЛОН ЭКСТРЕМАЛЬ БОДЛОГЫН ОНОЛЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

Д.САЙНБАЯР /УБХИС-ийн АБДС-БУТ-ийн багш доктор (Ph.D)/

Түлхүүр үг: цэгийн кинематик ба динамик, экстремаль бодлого, байг мэргэн онох оновчлолын бодлого

Key words: kinematics and dynamics, extreme problem, target- wise optimization policy

Оршил

Ерөнхий суурь эрдмийн хичээлүүд болох физик, математикийн үндсэн тулгуур ойлголтууд болон үйлдлийн шинжилгээний экстремаль бодлогын онолыг ашиглан сумны буудах чигийн хэвтээ гадаргуутай үүсгэх өнцөг ямар үед байг мэргэн онох боломжтойг тооцоолон харуулахыг зорилгоо. Суурь шинжлэх ухаан болох физик, математик нь цэргийн төрөл мэргэжлийн хөтөлбөрүүдийн мэргэжлийн суурь болон, мэргэшүүлэх хичээлүүдийг үзэхэд тулгуур үндэс нь болдог. Физикийн шинжлэх ухаан нь байгаль дээрх бүхий л юмс үзэгдлийг нэгдмэл нэг онолын үүднээс тайлбарладаг бөгөөд бид математик аппаратыг ашиглан боловсруулалт тооцооллыг хийдэг. Хүн нийгмийн амьдралд, байгаль шинжлэлд, ер нь шинжлэх ухааны ямар ч салбарт боломжтой бүх хувилбарын дотроос хамгийн оновчтойг нь шилэн сонгох асуудал үргэлж тулгарч байдаг. Тийм хэлбэрийн бодлогыг математик хийсвэрлэлтийн тусламжтайгаар дүрслэн бичихийг экстремаль бодлого гэдэг. Экстремаль бодлогын онол нь ямар нэг этгээдийн (хэн нэгний) эрх ашгийг хамгийн их оновчтой байлгах (максимумчлах) эсвэл хамгийн бага зардалтай байлгах (минимумчлах) асуудлыг судалдаг. Энэхүү өгүүлэлд байг мэргэн онох оновчлолын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах физик, математикийн үндсэн тулгуур ойлголтуудыг томъёолон, экстремаль бодлогын онолыг ашиглан байг мэргэн онох бодлогыг оновчлох тооцооллыг авч үзлээ.

Үндсэн хэсэг

1. Тооцоолол хийхэд хэрэглэгдэх физик

математикийн үндсэн ойлголтууд:

Бид цэргийн төрөл мэргэжлийн ангиудад үзэх ерөнхий физик 1 хичээлийн механикийн бүлгээр материаллаг цэгийн кинематик, динамик гэсэн агуулгыг судалдаг бөгөөд энэ нь байг мэргэн онох бодлогын тооцоо хийхэд гол тулгуур үндэс болдог. Тооцоолол хийхэд хэрэглэгдэх ерөнхий физик-1 хичээлийн давших хөдөлгөөний кинематик, динамик сэдвийн гол тодорхойлолт, хууль, томъёоллыг дараах байдлаар сонсогч, оюутан суралцагсад судалдаг.

Материал цэгийн кинематик¹:

Биесийн харилцан үйлчлэл ба хөдөлгөөний зүй тогтлыг судалдаг физикийн салбарыг механик гэнэ. Тухайн нөхцөлд хэлбэр хэмжээг нь авч үзэхгүй байж болох биеийг материал цэг гэнэ. Тухайн бие болон системийн байрлал сонгож авсан өөр биетэй харьцангуй өөрчлөгдөх үзэгдлийг механик хөдөлгөөн гэдэг. Хугацааны янз бүрийн агшинд бусад биесийн байрлалыг харьцуулан тодорхойлох тооллын бие, түүнтэй бат бэх холбоотой координатын систем, хугацааны тоолол гурав нийлж механик хөдөлгөөнийг тодорхойлох тооллын системийг үүсгэнэ. Ньютоны механикт орон зайн огторгуйн шинж чанар Евклидын геометрээр тодорхойлогдох ба цаашид дэлхийтэй холбосон тооллын системийг авч үзнэ. Координатын системд цэгийн байрлалыг (x,y,z) координатууд ба тооллын эхээс тухайн материал цэг хүртэлх радиус вектор \vec{r} -ээр тодорхойлно. Радиус векторыг координатууд болон нэгж векторын


¹ Долгормаа.Л., Отгонтулга.Б., Өлзийхуяг.Б., Сайнбаяр.Д., "Ерөнхий физик -1". УБ. 2018 он



сууриар $\vec{r} = x\vec{i} + y\vec{j} + z\vec{k}$ гэж задална.

Тооллын системтэй харьцангуй материал цэг шилжихдээ дайрч өнгөрсөн цэгүүдийг холбосон муруйг траектор гэнэ. Тодорхой хугацаанд цэгийн траекторын дагуух туулсан зайг зам гэнэ.

Цэгийн хөдөлгөөнийг тэгш өнцөгт Декартын координатын системээс гадна туйлын, цилиндр, бөмбөрцөг координатын системд доорх параметруудийг ашиглан судална



1 дүгээр зураг. Биеийн хөдөлгөөнийг харьцуулан судлах тооллын системүүд

Тодорхой хугацаанд цэгийн радиус векторын шилжих шилжилтийн хэмжээг цэгийн шилжилт $\Delta\vec{r} = \vec{r}_2 - \vec{r}_1$ гэнэ.

Координатуудын хоорондын хамаарлын тэгшитгэлийг траекторын тэгшитгэл $x = x(y, z)$ гэнэ.

Нэгж хугацаанд өөрчлөгдөх зам ба шилжилтээр тодорхойлогдох физик хэмжигдэхүүнийг дундаж хурд гэнэ.

$$\vec{v} = \frac{\Delta\vec{r}}{\Delta t}$$

Радиус вектор ба шилжилтээс хугацаагаар авсан нэг удаагийн уламжлал буюу дифференциалтай тэнцүү хэмжигдэхүүнийг агшин зуурын буюу хоромхон хурд гэх ба чиглэл нь хөдөлгөөний дагуу траекторт шүргэгчээр чиглэнэ.

$$\vec{v} = \lim_{\Delta t \rightarrow 0} \frac{\Delta\vec{r}}{\Delta t} = \frac{d\vec{r}}{dt}; \nu = \vec{r}'(t) = s'(t)$$

Хурдны өөрчлөлтийг хугацааны өөрчлөлтөд харьцуулсныг дундаж хурдатгал

$$\vec{a} = \frac{d\vec{v}}{dt}$$


гэх ба материал цэгийн эгшин зуурын хурдатгал нь хурдны вектороос хугацаагаар авсан нэгдүгээр эрэмбийн уламжлал буюу дифференциал, радиус вектороос хугацаагаар авсан хоёрдугаар эрэмбийн уламжлал буюу дифференциалтай тэнцүү байна хэмээн томъёолдог.

$$\vec{a} = \frac{d\vec{v}}{dt} = \frac{d^2\vec{r}}{dt^2} = \vec{i} \frac{d^2x}{dt^2} + \vec{j} \frac{d^2y}{dt^2} + \vec{k} \frac{d^2z}{dt^2}$$

Материал цэгийн динамик²:

Нэг биеийн нөгөө биедээ үзүүлж буй үйлчлэлийн хэмжээ болон чиглэлийг заадаг вектор хэмжигдэхүүнийг хүч гэнэ. Хатуу биеийн ямар нэг цэгт $\vec{F}_1, \vec{F}_2, \dots, \vec{F}_n$ хүчнүүд нэгэн зэрэг үйлчлэхэд тэдгээрийн үйлчлэл нь эдгээр хүчний вектор нийлбэртэй тэнцэх тэнцүү үйлчлэгч хүчтэй тэнцүү байна.

$$\vec{F} = \vec{F}_1 + \vec{F}_2 + \dots + \vec{F}_n$$



2 дугаар зураг. Хүчийг нэмэх параллелограммын дүрэм

Хүчний үйлчлэлээр биеийн олж авах хурдатгал нь үйлчилж буй хүчинд шууд, тухайн биеийн массад урвуу пропорциональ хамааралтай байна. Хурдатгалын чиглэл нь хүчний чиглэлтэй давхцана. Үүнийг динамикийн буюу Ньютоны II хууль

$$m\vec{a} = \vec{F}_1 + \vec{F}_2 + \dots + \vec{F}_n = \sum_{i=1}^n \vec{F}_i$$

гэнэ хэмээн Ерөнхий Физик 1 хичээлээр оюутнууд судалдаг.

Экстремаль бодлого³:

Хүн нийгмийн амьдралд, байгаль шинжлэлд, ер нь шинжлэх ухааны ямар ч салбарт боломжтой бүх хувилбарын дотроос хамгийн оновчтойг нь шилэн сонгох асуудал үргэлж тулгарч байдаг. Тийм хэлбэрийн бодлогыг математик хийсвэрлэлтийн

² Долгормаа.Л., Отгонтулга.Б., Өлзийхуяа.Б., Сайнбаяр.Д., "Ерөнхий физик -1". УБ. 2018 он

³ Халтар.Д., "Математик хэрэглээ". УБ. 1996 он



тусламжтайгаар дүрслэн бичихийг экстремаль бодлого гэдэг.

Экстремаль бодлогын онол нь Ямар нэг этгээдийн (хэн нэгний) эрх ашгийг хамгийн их оновчтой байлгах (максимумчлах) эсвэл хамгийн бага зардалтай байлгах (минимумчлах) асуудлыг судалдаг.

Экстремал бодлогын онолыг салбараар нь физик, нийгэм, биологи, эдийн засгийн, математик аппаратаар нь статик ба динамик загварууд, шугаман программчлал, математик программчлал, оновчтой удирдлагын онол гэх мэтчилэн ангилдаг.

Экстремаль бодлогын тавилыг ерөнхий тохиолдолд дараах хэлбэрээр томъёолж болно⁴.

$$f(x) \rightarrow \min(\max); x \in A$$

Энд $f(x)$ нь x огторгуйд A олонлог дээр тодорхойлогдсон тоон функц.


Энэ нь A олонлогт харьяалагдах x цэгүүдийн дотроос $f(x)$ функцийг хамгийн бага буюу их утгад нь хүргэдэг $\bar{x} \in A$ цэгийг олж $f(\bar{x})$ -ын утгыг тодорхойлох математик бодлого тавигдсан байна.

Хэрэв $\min_{x \in A} f(x) = f(\bar{x})$ бол \bar{x} -ыг бодлогын оновчтой шийд гэх ба $f(\bar{x})$ -ыг бодлогын тоон утга гэж нэрлэдэг.

2. Байг мэргэн онох оновчлолын бодлогын тооцоолол

Мэргэн буудагч h өндөр бүхий цамхагийн орой (Н)-оос хэвтээ чигт l зайд алслагдсан байг (К цэг) онох ёстой гэж үзье (3 дугаар зураг)

Буудагчийн зогсож байгаа цэгийг координатын системийн эхлэл болгон авч харвах сумны гарааны байрлалын цэгийг H гэе.



3 дугаар зураг. h өндрөөс хэвтээ чигт l зайд орших байг К цэгийг онох бодлогын тооцоолол хийх схем зураг

Хэрэв сумны анхны хурд v_0 -ын өөрөөр

хэлбэл нисэх чиглэл \vec{HM} -ийн \vec{HK} - тэй үүсгэх өнцгийг α гэж тэмдэглэвэл $0 < \alpha < \pi - \alpha_0$ нөхцөл биелнэ.

Энд α_0 нь $\alpha_0 = \angle(OHK)$ өнцгийн аргументийн утга.

Агаарт шидэгдсэн m масстай бие (сум)-ийн хөдөлгөөний дифференциал тэгшитгэлийн системийг динамикийн үндсэн хуулийн дагуу босоо хавтгай дээр дараах байдлаар (2) бичдэг. Энд агаарын эсэргүүцэл болон салхины хурдыг тооцоогүй. Бид дараагийн тооцоонд тэдгээрийг тооцож энэ бодлогоо өргөтгөж болох юм.

$$\begin{cases} m \frac{d^2 x}{dt^2} = 0 \\ m \frac{d^2 y}{dt^2} = -mg \\ v_{ax} = \frac{dx}{dt} = v_0 \cos \alpha' \\ v_{ay} = \frac{dy}{dt} = v_0 \sin \alpha' \end{cases} \quad (2)$$

Энэ систем тэгшитгэлд захын нөхцөлүүд нь

$$\begin{cases} x(0) = 0 \\ y(0) = h \\ x(t) = l \\ y(t) = 0 \end{cases} \quad (3) \text{ болно.}$$

Энд: t -бууны сум K байнд тусахад зарцуулагдах хугацаа

v_0 - сумны анхны хурдны тоон хэмжигдэхүүн α' - сумны анхны хурдны хэвтээ чигтээ үүсгэх өнцөг

$$\alpha' = \left(\alpha - (\pi - \alpha_0 - \frac{\pi}{2}) \right) \text{ буюу } \alpha' = \alpha - \pi/2 + \alpha_0$$

болно.

Захын нөхцөлүүд (3) - ийг ашиглан (2) систем тэгшитгэлээс дараах адилтгалуудыг гарган авч болно

$$\begin{cases} -\frac{gt^2}{2} + v_0 \sin \alpha' \cdot t + h = 0 \\ v_0 \cos \alpha' \cdot t = l \end{cases} \quad (4).$$

Сүүлийн адилтгалаас t -г олж эхний тэгшитгэлд орлуулбал

$$v_0^2(\alpha') = \frac{gl^2}{2(\sin \alpha' \cos \alpha' l + \cos^2 \alpha' h)} \quad (5) \text{ болно.}$$

⁴ Халтар.Д., “Математик хэрэглээ”. УБ. 1996 он



Энд “сумны анхны хурд хэдий чинээ их байна, сум тавих үед буудагчийн гарын чичиргээ төдий чинээ их байх буюу өөрөөр хэлбэл байг онох боломж бага байх болно⁵” нөхцөлийг тооцон оновчлолыг хэрэгжүүлсэн.

Ийм учраас байг хамгийн мэргэн онох бодлого нь $v_0^2(\alpha')$ функцийн утгыг хамгийн бага байлгах тийм α' өнцгийг $(\alpha_0 - \pi/2, \pi/2)$ нээлттэй олонлогоос олоход оршино.

Өөрөөр хэлбэл

$$v_0^2(\alpha') \rightarrow \min; \quad \text{буюу}$$

$$\alpha' \in (\alpha_0 - \pi/2, \pi/2)$$

Фермагийн зарчим ёсоор

$$(v_0^2(\alpha'))' = \left(\frac{gl^2}{2(\sin \alpha' \cos \alpha' l + \cos^2 \alpha' h)} \right)' = 0$$

$$(v_0^2(\alpha'))' = \frac{gl^2}{2} \left(- \frac{(\sin \alpha' \cos \alpha' l + \cos^2 \alpha' h)'}{(\sin \alpha' \cos \alpha' l + \cos^2 \alpha' h)^2} \right) = 0$$

$$(v_0^2(\alpha'))' = \frac{gl^2}{2} \left(- \frac{(l \cos 2\alpha' - h \sin 2\alpha')}{(\sin \alpha' \cos \alpha' l + \cos^2 \alpha' h)^2} \right) = 0$$

Энэ илэрхийллээс

$$(l \cos 2\alpha' - h \sin 2\alpha') = 0 \quad \text{буюу}$$

$$\operatorname{tg} 2\alpha' = l/h \quad \text{гэж гарна.}$$

$$\text{Энд } \operatorname{tg} \alpha_0 = \frac{l}{h} \text{ тул } \operatorname{tg} 2\alpha' = \operatorname{tg} \alpha_0 \text{ буюу}$$

хамгийн оновчтой харвалтын газрын гадаргуутай (хэвтээ гадаргуутай) үүсгэх өнцөг нь $\alpha' = \alpha_0/2$ байна гэж гаргасан.

$h > 0$ учраас $\frac{\alpha_0}{2} < \frac{\pi}{4}$ нөхцөл биелнэ.

Дүгнэлт, санал

1. Ерөнхий суурь хичээлүүд болох физик, математикийн тулгуур ойлголт, хууль томъёоллууд нь мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн үндэс суурь болох төдийгүй эдгээр дээр үндэслэн үйлдлийн шинжилгээний аргыг ашиглан бид аливаа процесс, үйл ажиллагааг оновчтой явуулах, оновчтой байлгах арга зүйд суралцана.

2. Энэ арга зүйгээр h өндөрт орших мэргэн буудагчийн байг мэргэн онох бодлогын оновчтой шийд нь харвалтын өнцгийн газрын гадаргуутай (хэвтээ гадаргуутай) үүсгэх өнцөг нь агаарын эсэргүүцлийн хүч болон салхины хурдыг тооцоогүй үед $\alpha' = \alpha_0/2$ -тай тэнцүү байна гэдгийг онолын хувьд тооцон гаргалаа. Энд α' болон α_0 -ийг бодлогын тавилд өгсөн байгаа. Үүнийг практикт туршин шалгаж алдааг тооцох боломжтой.

3. Энэхүү бодлогыг бид агаарын эсэргүүцлийн хүч болон салхины хурдыг тооцон цааш өргөтгөн тооцоолох боломжтой юм.

4. Бид их дээд сургуульд үзэх ерөнхий суурь хичээлүүд болох математик физикийн хичээлүүдийн агуулга дээр загварчлал, оновчлолын шинжлэх ухаан түүний математик аппаратуудыг ашиглан цэргийн хэрэгт хэрэглэж цэргийн шинжлэх ухааныг онолын хувьд улам хөгжүүлэн баяжуулах шаардлагатай.

⁵ Халтар.Д., “Хэрэглээний математик”. УБ. 2008 он

Ашигласан материал:

1. Долгормаа.Л., Отгонтулга.Б., Өлзийхуяг.Б., Сайнбаяр.Д., “Ерөнхий физик –1”. УБ. 2018 он
2. Сайнбаяр.Д., “Цэргийн аюулыг үнэлэхэд үйлдлийн шинжилгээний аргыг ашиглах нь”. докторын диссертаци УБ. 2016 он.
3. Халтар.Д., “Математик хэрэглээ”. УБ. 1996 он
4. Тихомиров В.Б., “Планирование и анализ эксперимента” М., 1974.
5. Адлер Ю.П., “Планирование и эксперимента при поиске оптимальных условий” М., Наука, 1987
6. Яворский Б.М., Детлаф А.А., Милковская Л.Б., “Курс лекций по физике, том –1/Сост”. –М., 1960
7. Демидченко В.И., “Физика/Сост”. –Санкт–Петербург, 2012
8. Ландсберга Г.С., “Элементарный учебник физики /Сост”. –М., 1972
9. Explaining physics, Oxford University Press, 1996
10. Волькенштейн В.С., “Сборник вопросов и задач по физике/Сост”. –Санкт–Петербург, 2003
11. Базаррагчаа.Б., Ганбаатар.Д., Дамдинжав.Н., Доржсүрэн.Б., Хүрэлсүх.С., “Физик–1”, УБ. 2000 он



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ТИНК ТАНК БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НӨЛӨӨЛӨХ НЬ

А.ШИНЭСАР /УБХИС-ийн Эрдмийн сургууль, Төрийн удирдлага хөтөлбөрийн магистрант/

Түлхүүр үг: Тинк танк байгууллага, бодлогын шийдвэр гаргалт, бодлогын судалгаа, хувь хүний чадвар, төрийн бодлого

Key words: Tink-tank organization, policy decision-making, policy research, individual ability, state policy

Оршил

Судалгааны байгууллагууд Монгол Улсад хөгжиж байгаа ч боловсруулж гаргасан тэрхүү судалгаануудыг төр засаг, шийдвэр гаргагчид ашиглаж чадаж байгаа эсэх нь тийм ч тодорхой биш байна. Өнөөдрийн мэдээллийн эрин зуунд баримтад суурилсан, үнэн зөв судалгаа урьд өмнөхөөс ч илүү ач холбогдолтой болж байна.

Олон улсын харилцааны нөхцөл байдал, хүчний харьцаа хурдацтайгаар өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд аливаа улсын төрийн бодлого, стратеги нь ямагт шинжлэх ухааны үндэслэл сайтай, баримт нотолгоонд суурилсан, нэгдмэл, залгамж чанараа хадгалсан байх¹ зэрэг шаардлагатай байдаг. Орчин үед хууль тогтоох байгууллага, төрийн тэргүүн, засгийн газар, гадаад хэргийн яам зэрэг бодлогын шийдвэр гаргах механизмд тохируулсан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, бодит мэдээллийн ач холбогдол ба түүнээс урган гарах өвөрмөц шийдлийг бий болгох, бодит байдал дээр хэрэгжих боломжтой, бүтээлч, тогтсон хэв маягаас ангид сэтгэх чадвар бүхий тинк танк байгууллагуудын ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологиуд (NICT) нь уламжлалт нийгмийн босоо парадигмд хувьсал хийсэн нь төр – институц – хэвлэл мэдээлэл – хүн ам хэмээх болсон явдал юм².

Дэлхийн олон улс гүрэн үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, улс төр, эдийн засаг нийгмийн чиглэлээр судалгаа хийдэг Think–Tank буюу Policy Research Institute– тай хамтран ажиллаж байна. Урд хөрш болох БНХАУ–д гэхэд нийт тинк танкуудаа эрэмбэлэн, шилдэг тинк танкуудын төлөөллөөс төрийн бодлогын зөвлөлүүддээ оруулан, судалгааны үр дүнгээс бодлогодоо тусгах зэргээр маш их ач холбогдол өгч байна³.

Монгол Улсын хувьд дэлхийн нийтийн чиг хандлагыг сайтар ажиглан судалж, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж буй судалгааны хүрээлэнгүүдийн ач холбогдол, гүйцэтгэж буй үүргийг судлан бодитой, зөв шийдэл бүхий судалгаанд суурилсан тинк–танк байгууллагуудын үйл ажиллагааг өсөн нэмэгдүүлэх асуудлын зангилааг олох мөн ажиллах нөөц бололцоог чадавхжуулах шаардлага бий болсон. Энэхүү судалгааны ажилдаа дээрх шаардлагыг үндэслэн Монгол Улсын төрийн бодлогын шийдвэр гаргалтад тинк танк байгууллагын үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорилгоо.

Үндсэн хэсэг

Тинк танкийг олон улсад бодлогын судалгаа хийж, тодорхой шийдлийн хувилбарыг боловсруулан санал болгож, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг хэмээн тодорхойлдог

pdf

¹ Доктор Ж.Бор, 2021. Монгол Улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал, хашлага давах боломж 258 х

² CASTELLS, Manuel. La galaxie Internet, Paris: Fayard, 2002. <http://epnologues.free.fr/IMG/pdf/galaxie-internet>.

³ “Баримт мэдээлэл болон тинк танкуудын ач холбогдол” хэлэлцүүлэг 2019. <https://ecrc.mn/think-tank-2019/> Diane Stone, in International Encyclopedia of the Social & Behavioral Sciences (Second Edition), 2015

байна.

Тинк танк байгууллага гэдэг нь нийгэм, улс төр, эдийн засаг, цэрэг–улс төрийн стратеги, соёл хүмүүнлэг, техник технологи зэрэг хэмжээ, эрх зүйн байдал, бодлогын асуудал, зохион байгуулалтын бүтцийн хувьд эрс ялгаатай боловч судалгаа, шинжилгээнд тулгуурлан дүн шинжилгээ хийх, шийдлийг эрж хайх зорилгоор салбар дундын эрдэмтдийн бүлгийг бий болгосон институт юм⁴.

Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын аппарат дахь бодлого боловсруулах чадамж илүү боловсронгуй болсон ч гэсэн тинк танкуудын судалгааг үнэлж үзэх хэд хэдэн үндэслэл байдаг аж.

Нэгт: Засгийн газрын түвшинд тогтсон хандлагыг “эвдсэн” бүтээлч санал бага гардаг байхад тинк танкууд илүү холыг харсан бодитой судалгаа гаргаж чадна гэж үздэг байна.

Хоёрт: Дээрхтэй холбоотойгоор засаг захиргааны түвшинд стандартчилагдсан горимын дагуу “явцуу” хүрээнд шийдэл гаргадаг бол тинк танкууд өөрчлөлтийг зоригтой санал болгож чаддаг байна.

Гуравт: Тинк танкууд сонирхлын зөрчлөөс ангид шинжээчдийг бүрэн дайчилж, хамтран ажиллах бүтэц бий болгож чаддаг давуу талтай юм байна.

1940 оны үед Тинк танк нь өөр өөрийн институцын нэрээр нэрлэгдэж байгаад Дэлхийн 2–р дайны үед “Brain Boxes” хэмээн дуудагддаг байсан ба цаашлаад дайны үед иргэний болон цэргийн мэргэжилтнүүд стратеги боловсруулж, батлан хамгаалах, аюулгүй байдал эсвэл олон улсын харилцааны асуудлыг шийдвэрлэх арга замыг олохын тулд хаалттай, хамгаалалттай орон зайг нэрлэдэг нэршил болох “Think tank” гэсэн үгээр солигдсон⁵. Тухайн үед Германы

өдөр тутмын сонинуудын нийтлэлд дүн шинжилгээ хийн Гитлерийн Германы цэрэг дайны стратеги төлөвлөгөөг ойлгох, түүнд нь тохирсон хариу төлөвлөгөөг боловсруулан ялалтууд байгуулж байсан гэдэг⁶.

Орчин үеийн тинк танк хэмээх ойлголт нь 1960–аад оноос дагнасан институциуд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой. Чухам тэр үед дэлхийд алдартай тинк танк байгууллага болох RAND корпораци цэрэг дайны болон улс төрийн бодлого боловсруулах чиглэлээр байгуулагдсан⁷. Тинк танкийн үйл ажиллагаа нь мэдээлэл дамжуулах, судалгаа шинжилгээний үр дүнг сурталчлах, нийгэмд шинэчлэл хувьсал үүсгэх процесс юм. Орчин үеийн тинк танкууд нийгэм, эдийн засаг, улс төр, бизнесийн бүхий л хүрээнд олон чиглэл, хэлбэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал:

1. Статусаар нь ангилбал:

– Ашгийн ба Ашгийн бус

– Сангуудын, Олон улсын, Үндэстэн дамнасан, Бүс нутгийн, Их сургууль болон тодорхой институцийн гэх мэт.

2. Чиглэлээр нь ангилбал:

– Нийгэм, улс төр

– Шашин, арьс өнгө

– Эдийн засаг, бизнесийн салбарууд

– Мэдээллийн технологийн

– Ухаалаг засаглал, иргэдийн оролцоо

– Бусад

3. Хандлагаар нь ангилбал:

– Глобаль – Сүлжээ хэлбэрийн(CSIS)

– Харилцан ашигтай

– Үр дүнд чиглэсэн гэж ангилна⁸.

Тинк танк байгууллагуудын үйл ажиллагааг

organizations. <https://www.britannica.com/topic/think-tank>

⁶ Мөн тэнд

⁷ A Brief History of RAND <https://www.rand.org/about/history.html>

⁴ Diane Stone, in International Encyclopedia of the Social & Behavioral Sciences (Second Edition), 2015 <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/think-tank>

⁵ The term think tank was first used in military jargon during World War II to describe a safe place where plans and strategies could be discussed, but its meaning began to change during the 1960s when it came to be used in the United States to describe private nonprofit policy research

⁸ Summary of think tank categories related to linkages, scope of operations, outputs and types https://www.researchgate.net/figure/Summary-of-think-tank-categories-related-to-linkages-scope-of-operations-outputs-and_fig7_309465628

дараах үндсэн 5 үзүүлэлтээр дүгнэж байна⁹. Үүнд:

1. Бодлогын шийдвэр: шийдвэр гаргагчдад нөлөөлөх нөлөөлөл, бодлогын төсөл нь батлагдах чадвар

2. Шинжилгээ судалгааны ур чадвар: онол арга зүйг ашиглаж буй байдал, үндэслэл баримт нотолгоотой судалгаа шинжилгээ хийж чадах эсэх

3. Мэдээлэл: мэдээлэл олборлолт, түүний баталгаат эх сурвалж

4. Хүний нөөц: мэдлэг чадварын түвшин, хувь хүний хөгжлийн чадвар

5. Хугацаа: хэдий хэр хугацааг зарцуулах, зохицуулах.

Дээр дурдагдсан үндсэн 5 үзүүлэлт дэх хүний нөөц буюу тинк танк судлаач, эрдэмтэд мэргэжилтнүүд нь аливаа байгууллагын гол хөдөлгөх хүч болдог билээ. Хүний нөөцийг зөв ажиллуулж, үйл ажиллагаа, зорилт, судалгааны хөтөлбөрөө зөв тодорхойлсноор бүтээлч шийдвэр бүхий байгууллагын системийг бүрдүүлж чадна¹⁰. Хүний нөөцийн зөв системийг бий болгоход дараах зүйлс хамаарна. Үүнд:

1. Боломжит стратегийг бий болгох: Хүчирхэг хүний нөөц бололцоог бий болгох нь судалгааны төвийн хувьд зайлшгүй шаардлагатай. Байгууллагын амжилт нь боловсон хүчнийг хэрхэн төлөвлөхөөс ихээхэн хамаардаг. Тинк-танкууд яаран эсвэл төлөвлөгөөгүй ажилд авахаас зайлсхийх хэрэгтэй.

2. Ажилд авах: Ажилд авах үйл явц нь бүтээлч байдлын элементийг агуулсан байх ёстой. Хүчтэй оролцогчид мэдлэгийн талбарт (судлаачдын хувьд), бүтээлч хандлага, шинэ санаачилгыг дэмжин боловсруулах, шүүмжлэлт

сэтгэлгээ ба асуудал шийдвэрлэх хувь хүний чадваруудыг төлөвшүүлсэн байх нь зүйтэй.

3. Сургалт ба хөгжил дэвшил: Мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж байх нь судалгааны төвүүдийн судлаачдын хувьд чухал байдаг. Тэд засгийн газрын шийдэл, зөвлөгөө авах хүсэлтэд хурдан хариу өгөх, ихэвчлэн судалгааны шинэ арга, үзэл баримтлал, ойлголтыг нэвтрүүлэх чадвартай байх нь зүй ёсны хэрэг юм. Судлаачид ихэвчлэн багийн ахлагч, төслийн удирдагч хоёулаа байдаг. Энэхүү давхар үүрэг нь тэднээс мэдлэгээ дэлгэн харуулах, үр дүнтэй харилцах, хөтөлбөр, төслүүдийг үр дүнтэй удирдах, хамгийн чухал нь багаа үр дүнтэй удирдан чиглүүлэхийг шаарддаг. Эдгээр чадварууд нь бүгдэд нь байхгүй байж болох ч тодорхой хугацааны дараа хөгжүүлж болно¹¹.

Ихэнх судалгааны төвүүд хэдхэдэн оролцогч талуудтай, өөр өөр судалгааны чиглэлээр ажилладаг. Судлаачдыг ихэвчлэн техникийн ур чадвар эсвэл судалгааны чиглэлээр мэргэшсэн учраас ажилд авдаг. Гэсэн хэдий ч цаг хугацаа өөрчлөгдөж, техникийн мэдлэг нь карьерын хөгжлийг хангахаа больсон. Жишээлбэл, дунд түвшний судлаачдыг гаднын оролцогч талуудтай хамтран ажиллахыг ихэвчлэн дэмждэг бөгөөд бодлого боловсруулагчид болон хэвлэл мэдээллийнхэнд ажлынхаа үр дүнг танилцуулах, мөн судалгааны төвийг төлөөлөх гэх мэт хандлага бий болж байна.

Монгол Улс бусад улс орнуудын тинк танк байгууллагуудад хийсэн харьцуулалт

Гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг дэлхийн анхны тинк танк байгууллага нь 183 онд Их Британид байгуулагдсан “Батлан Хамгаалах болон Аюулгүй Байдал Судлалын Хамтарсан Хүрээлэн” юм¹². Дэлхий даяар янз бүрийн чиглэлээр бодлогын судалгаа хийдэг 7500 орчим судалгааны хүрээлэн бий болсон нь

⁹ Think Tanks (Research Institutes & Policy Institutes) <https://capd.mit.edu/resources/think-tanks-researchinstitutes-policy-institutes/#:~:text=Think%20Tanks%20are%20looking%20for,the%20subject%20area%20being%20studied>

¹⁰ A new face for HR practices in think tanks BY ANNAPOORNA RAVICHANDER <https://onthinktanks.org/articles/a-new-face-for-hr-practices-in-think-tanks>

¹¹ Мөн тэнд

¹² THE NEW RIGHT THINK TANKS AND POLICY CHANGE IN THE UK 1999 <https://etheses.whiterose.ac.uk/2478/1/DX210716.pdf>



улс орнууд шинжлэх ухааны үндэслэл сайтай судалгаа шинжилгээнд тулгуурласан бодлогын шийдвэр гаргахад анхаарах хандлага жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Тинк Танк судалгааны хүрээлэн нь төрийн болон төрийн бус статустай байх бөгөөд үндсэн санхүүжилт нь зөвлөгөө өгөх, судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх зэргээс бүрддэг ба зарим улсууд төрөөс тодорхой хэмжээний санхүүжилт олгохын зэрэгцээ татварын хөнгөлөлт эдлүүлдэг байна. 2021 оны байдлаар Хятад Улс судалгаа, боловсруулалтын зардлаараа дэлхийд тэргүүлж, судалгаа шинжилгээний зардал 621 тэрбум ам.доллар давах хандлага гарсан бол АНУ судалгаа, хөгжүүлэлтэд 598.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна¹³. Манай улсын шинжлэх ухааны салбарт зарцуулж буй төсөв, хөрөнгийг хөгжиж буй бусад орныхтой харьцуулахад 10 дахин бага байгаа бөгөөд шинжлэх ухааны салбарт зарцуулж буй төсөв, хөрөнгө нь ДНБ-ий 0.1 хувь буюу нэг хувийг 10 хуваасны нэгтэй тэнцэх хэмжээтэй байна¹⁴.

Мөн хөгжингүй улс орнуудын жишээнээс харахад судалгааны хүрээлэн байгууллагууд нь төрийн бодлогын шийдвэр гаргалт, бодлогын зөвлөгөө боловсруулалтад шууд нөлөө үзүүлж чаддаг аж. Тухайлбал, БНХАУ-ын хувьд тинк танк байгууллагуудаа эрэмбэлэн жагсааж, шилдэг эрдэмтэн судлаач, болон судалгааны хүрээлэнгүүдээ бодлого, шийдвэр гаргалтад шууд нөлөө үзүүлэхүйц оролцуулж чаддаг байна. Тус улсын хувьд улсын тинк танк байгууллагууд нь Хятадын дээд удирдагчдад шууд хүрдэг гадаад бодлогын эх сурвалж гэж тодорхойлогддог¹⁵. China Institutes of Contemporary International Relations CICIR нь Хятадын засгийн газрын харьяа байгууллага ба түүний үйл ажиллагаанд төрийн байгууллагуудад

тайлан гаргах, эрдэм шинжилгээний сэтгүүлд судалгаа нийтлэх, БНХАУ-ын засгийн газраас захиалгаар төсөл хэрэгжүүлэх, дотоод гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний солилцоог дэмжих, магистр, докторын хөтөлбөр санал болгох зэрэг үйл ажиллагаа багтдаг¹⁶.

Монгол Улсын хувьд хүйтэн дайны үед Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогыг Москва хотод тодорхойлдог байсан тул тэр үед хараат бус “тинк танк” хүрээлэн байгуулагдах нөхцөл бололцоо хомс, хэрэгцээ шаардлага ч байсангүй гэж тайлбарладаг. Харин Монгол Улс 1990-ээд оноос хойш бодлогын судалгааны хүрээлэн буюу “тинк танк” хэмээх ойлголт судлаачид болон улс төрчдийн дунд хэрэглэгдэх болсон. Гэхдээ энэ үед төрөөс хамааралгүй, өөрсдийн судалгаа болон төсөл хөтөлбөрөөр санхүүждэг бие даасан судалгааны байгууллагын тоо маш цөөхөн байсан¹⁷. Монгол Улс тусгаар тогтнолоо зарласан үеэс гадаад болон үндэсний аюулгүй байдлын зөвлөмж боловсруулах судалгааны шаардлага нэмэгдэж эхэлсэн бөгөөд 1990 онд “Стратеги судалгааны хүрээлэн” байгуулагдаж байсан. Тус хүрээлэнгийн өнөөгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “шинжлэх ухааны үндэслэлтэй, сайтар боловсруулсан судалгаанд тулгуурласан бодлогын хувилбар, стратегиар шийдвэр гаргагчдад зөвлөмж өгөх, мэдлэгийг баяжуулах замаар үндэсний хөгжил, аюулгүй байдалд бодитой хувь нэмэр оруулах” хэмээн тодорхойлсон байна¹⁸.

Манай Улсад судалгааны төвүүдийн хийсэн судалгааны материалууд, бодлогын зөвлөмж багагүй байдаг ч энэ нь бодлого боловсруулагчид болон захиалагч нарын хооронд дахь харилцан зөвшилцөл дутмаг байдал нь төрийн бодлогод нөлөө үзүүлдэг эсэх эргэлзээг бий болгож байдаг. 1990-ээд онтой харьцуулбал өнөөдөр Монголын гадаад

¹³ Leading countries by gross research and development (R&D) expenditure worldwide in 2021

¹⁴ Research and development expenditure (% of GDP) – Mongolia <https://data.worldbank.org/indicator/GB.XPD.RSDV.GD.ZS?locations=MN>

¹⁵ <http://www.cicir.ac.cn/NEW/en-us/index.html>

¹⁶ Profile of MSS-Affiliated PRC Foreign Policy Think Tank CICIR <https://irp.fas.org/dni/osc/cicir.pdf>

¹⁷ <https://www.academia.edu/>

¹⁸ Эрхэм зорилго http://iss.gov.mn/?page_id=612

ба аюулгүй байдлын бодлогын судалгааны хүрээлэн болон судлаачдын тоо нэлээд өсөж, судлаачдын мэдлэг чадвар нэмэгдэн тодорхой туршлага хуримтлуулжээ¹⁹. Аливаа нэгэн сайн дурын үндсэн дээр эсвэл зохион байгуулалттай тинк танк судалгааны хүрээлэн нь оюунлаг сэтгэлгээтэй, бүтээлч хүмүүсийг нэгтгэн нийлүүлж чадахгүй байх аваас энэ нь хэзээ ч үр өгөөжөө өгч чадахгүй нь мэдээж гэдгийг анхаарч байх хэрэгтэй.

Улс орнуудын шийдвэр гаргагчид цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан гадаадын санхүүжилттэй бодлогын судалгааны байгууллагын тайлан, дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэх хандлага мэр сэр анзаарагддаг. Ялангуяа нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй, мөнгө санхүүгийн бодлогын тал дээр энэ байдал нь давамгайлдаг. Харин гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр зөвлөмж боловсруулан төр засагт хүргүүлдэг байдал харьцангуй бага байдаг ажээ. Гаднын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн давуу тал нь санхүүжилтийн хувьд айхтар хүндрэл байдаггүй тул тогтвортой ажиллаж, судалгааны ажлынхаа үр дүнг олон нийт болон төр засгийн шийдвэр гаргагчдад хүргүүлж чаддаг байна. Гэсэн хэдий ч гадаадын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй бодлогын судалгааны хүрээлэнгүүд нэгэнт төрөөс санхүүжилт аваагүй тул үндэсний ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах, хариуцлага хүлээхгүй нь тодорхой билээ. Тэдний цаана гадаад улс орны, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ашиг сонирхол байгааг ямагт санаж байх учиртай²⁰.

Дэлхийн хөгжингүй улсуудад Think-Tank буюу Policy Research Institute ашигладаг жишээ их байна. Салбар салбараараа дагнасан хүрээлэнгүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж төрийн бодлогоо зөв ул суурьтай гарахад чухал нөлөө үзүүлж байгаа юм.

Мэдээ мэдээллийн өнөөгийн эринд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн найдвартай, бодит мэдээллийн ач холбогдол өсөн нэмэгдсээр байгаа аж. Тинк танкийн үйл ажиллагаа нь мэдээлэл дамжуулах, судалгаа шинжилгээний үр дүнг сурталчлах, нийгэмд шинэчлэл хувьсал үүсгэх үйл явц мөн.

Монгол Улсын хувьд ч дэлхийн чиг хандлагыг сайтар ажиглан судалж, өөрсдийн нөөц бололцоогоо зөв зохистой удирдахад судалгаа, баримт мэдээллийн найдвартай байдал чухал үүрэгтэй. Түүнчлэн баримт мэдээлэл, судалгаа, шинжилгээний үр дүнг түгээх, мэдээлэхэд хэвлэл, мэдээллийн үүрэг оролцоо хэзээд чухал байсаар ирсэн байна.

Манай улсын хувьд тинк танкуудыг хөгжүүлэх, одоо байгаа судалгааны байгууллага, хувийн байгууллагуудын мэдээлэл, дата өгөгдлийг нээлттэй хуваалцдаг, хэвлэн нийтэлдэг, бодлогын судалгаанд хэрэглэдэг байх, хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ чиглэлээр дээрх байгууллагуудтай хамтран ажилладаг байх нь чухал юм.

Судалгааны байгууллагуудын хувьд ч мөн хурдтай байх, тулгамдсан асуудлаар богино хугацаанд шийдэл санал болгох чадамжийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний өндөр түвшинд гэхээсээ илүү шийдвэр гаргагчид болон олон нийтийн хувьд энгийн, хялбар байдлаар томъёологдсон дүгнэлт, тайлбар гаргаж хэвших нь оновчтой юм. Төсөв санхүүгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд шинээр судалгааны бүтэц байгуулах гэхээсээ илүү одоо байгаа судалгааны байгууллагын судалгааг олж нэгтгэх, томоохон компаниуд, банкнууд, санхүүгийн байгууллагуудын судалгаа, дүн шинжилгээг нэгтгэх, энгийн хэлнээ буулгах, судалгааны дата бүхий газруудын дүнг нэгтгэн буулгадаг бүтцийг хөгжүүлбэл бэлэн судалгааг бодит бодлогын шийдэл боловсруулахад ашиглах боломж нээгдэх юм.

Дүгнэлт

XXI зуун гарсаар дэлхий дахины шинэ эрин үед улс орнууд хөгжил цэцэглэлт гадаад, дотоод бодлого аюулгүй байдлын асуудлууд

¹⁹ 2019, Scientific Journal of University of the Humanities, Mongolia <https://www.academia.edu/39121853>

²⁰ 2019, Scientific Journal of University of the Humanities, Mongolia <https://www.academia.edu/39121853>



дээр илүү нухацтай хандаж буй өнөө цагт Монгол Улсын хувьд ч мөн адил ихээхэн анхаарч бодлого төлөвлөлтийн судалгааны хүрээлэнгүүдийн судалгаанд анхаарч эхэлсэн. Гэхдээ судалгааны хүрээлэнгүүдээс гарсан бодлогын зөвлөмж, санаануудыг төрийн бодлого боловсруулагчид хангалттай ашиглаж чадах эсэх нь эргэлзээтэй хэвээр байна. Мөн судалгааны байгууллага болон яамнуудын хооронд дахь уялдаа холбоогүй үйл ажиллагаа нь төрийн болон хувийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргалтыг бий болгох орон зайг бий болгож байна.

Тинк танк байгууллагуудын хүний нөөцийн систем хэр зөв ажиллаж явагдаж байгаа, мөн судлаачдын чадвар чадавхын үнэлгээ хэр хэмжээнд явагдаж байгаа талаар, санхүүжилт хэрхэн явагдаж байгаа зэрэг мэдээллийн хувьд дутмаг хаалттай байдал ажиглагдаж байна.

Дэлхийн ихэнх улсуудын хувьд бодлогын судалгааны байгууллагууддаа ихээхэн санхүүжилт, анхаарал тавьдаг нь бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц хэмээн хардаг тул улсын дотоод гадаад бодлогын судлагдахуун, боловсруулалт хэрэгжүүлэлтэд анхаардаг нь харагдаж байна. Монгол Улсын судалгааны хүрээлэнгүүдэд тулгамдаж буй асуудал нь нэн тэргүүнд санхүүжилт байгаа бөгөөд үүнээс үүдэн судлаачдын ажлын чанар

ч буурах хандлага ажиглагдаж байна. Монгол Улсын төрийн бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлөх тинк танк байгууллагуудын үйл ажиллагааг дараах байдлаар өргөжүүлж болох юм. Үүнд:

- Хамтарсан судалгааг өргөжүүлэх
 - Улс төрийн намууд дэргэдээ бодлогын судалгааны хүрээлэнтэй байхыг хуульчилж тэдгээр хүрээлэнгүүдийн хүрээнд улс төрчдийн олон улсын харилцаа, геополитик, гадаад бодлого, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт тогтмол явуулах
 - Судлаачдын чадвар, чадамжийг дээшлүүлэх үүднээс гадна дотнын сургалт уулзалтад тогтмол хамруулах мөн хэлний мэдлэгийг академик түвшинд байх шалгуур тавих
 - Судалгааны байгууллагад оногдох санхүүжилтийг нэмэгдүүлэх
 - Төрийн бодлого, Засгийн газрын гаргаж буй аливаа шийдвэр судалгааны байгууллагуудын хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэсэн байх зэрэг болно.
- Тинк танк байгууллагууд бодлогын судалгаа хийж, тодорхой шийдлийн хувилбарыг боловсруулан, санал болгож, төрийн бодлогын шийдвэр гаргалтад нөлөөллийн үйл ажиллагааг идэвхтэй явуулж байх хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна.

Ашигласан материал:

1. Доктор Бор Ж. Монгол Улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал, хашлага давах боломж. 2021., т. 258
2. CASTELLS, Manuel. La galaxie Internet, Paris: Fayard, 2002 <http://epnologies.free.fr/IMG/pdf/galaxie-internet.pdf>
3. “Баримт мэдээлэл болон тинк танкуудын ач холбогдол” хэлэлцүүлэг 2019 <https://ecrc.mn/think-tank-2019/>
4. Diane Stone, in International Encyclopedia of the Social & Behavioral Sciences (Second Edition), 2015 <https://www.sciencedirect.com/topics/social-sciences/think-tank>
5. The term think tank was first used in military jargon during World War II to describe a safe place where plans and strategies could be discussed, but its meaning began to change during the 1960s when it came to be used in the United States to describe private nonprofit policy research organizations. <https://www.britannica.com/topic/think-tank>
6. A Brief History of RAND <https://www.rand.org/about/history.html>



7. Summary of think tank categories related to linkages, scope of operations, outputs and types https://www.researchgate.net/figure/Summary-of-think-tank-categories-related-to-linkages-scope-of-operations-outputs-and_fig7_309465628
8. Think Tanks (Research Institutes & Policy Institutes) <https://capd.mit.edu/resources/think-tanksresearchinstitutespolicyinstitutes/#:~:text=Think%20Tanks%20are%20looking%20for,the%20subject%20area%20being%20studied>
9. A new face for HR practices in think tanks BY ANNAPOORNA RAVICHANDER <https://onthinktanks.org/articles/a-new-face-for-hr-practices-in-think-tanks>
10. THE NEW RIGHT THINK TANKS AND POLICY CHANGE IN THE UK 1999 <https://etheses.whiterose.ac.uk/2478/1/DX210716.pdf>
11. Leading countries by gross research and development (R&D) expenditure worldwide in 2021
12. Research and development expenditure (% of GDP) – Mongolia <https://data.worldbank.org/indicator/GB.XPD.RSDV.GD.ZS?locations=MN>
13. <http://www.cicir.ac.cn/NEW/en-us/index.html>
14. Profile of MSS-Affiliated PRC Foreign Policy Think Tank CICIR <https://irp.fas.org/dni/osc/cicir.pdf>
15. Эрхэм зорилго http://iss.gov.mn/page_id=612
16. 2019, Scientific Journal of University of the Humanities, Mongolia <https://www.academia.edu/39121853>
17. Энхбайгаль Б. “Ухаалаг төр ба судалгаанд суурилсан бодлого”. УБ., 2014research organizations. <https://www.britannica.com/topic/think-tank>
6. A Brief History of RAND <https://www.rand.org/about/history.html>
7. Summary of think tank categories related to linkages, scope of operations, outputs and types https://www.researchgate.net/figure/Summary-of-think-tank-categories-related-to-linkages-scope-of-operations-outputs-and_fig7_309465628
8. Think Tanks (Research Institutes & Policy Institutes) <https://capd.mit.edu/resources/think-tanksresearchinstitutespolicyinstitutes/#:~:text=Think%20Tanks%20are%20looking%20for,the%20subject%20area%20being%20studied>
9. A new face for HR practices in think tanks BY ANNAPOORNA RAVICHANDER <https://onthinktanks.org/articles/a-new-face-for-hr-practices-in-think-tanks>
10. THE NEW RIGHT THINK TANKS AND POLICY CHANGE IN THE UK 1999 <https://etheses.whiterose.ac.uk/2478/1/DX210716.pdf>
11. Leading countries by gross research and development (R&D) expenditure worldwide in 2021
12. Research and development expenditure (% of GDP) – Mongolia <https://data.worldbank.org/indicator/GB.XPD.RSDV.GD.ZS?locations=MN>
13. <http://www.cicir.ac.cn/NEW/en-us/index.html>
14. Profile of MSS-Affiliated PRC Foreign Policy Think Tank CICIR <https://irp.fas.org/dni/osc/cicir.pdf>
15. Эрхэм зорилго http://iss.gov.mn/page_id=612
16. 2019, Scientific Journal of University of the Humanities, Mongolia <https://www.academia.edu/39121853>
17. Энхбайгаль Б. “Ухаалаг төр ба судалгаанд суурилсан бодлого”. УБ., 2014



УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛЛЫН ОНОЛЫН СУДАЛГАА

Ц.ОДОНГЭРЭЛ /ДХИС-ийн ХАС-ийн доктор (Ph.D)/
Б.ДЭЛГЭРМАА /УБХИС-ийн Төрийн удирдлагын магистрант/

Түлхүүр үг: удирдах ажилтан, манлайлал, ур чадвар, хандлага, харилцаа,
манлайллын хэв маяг

Key words: executives, leadership, skills, attitudes, relationships and leadership styles

Оршил

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь төрийн байгууллагын хувьд захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Тухайн тохиолдолд зэвсэгт хүчний бүх шатны удирдах ажилтнууд нь захиргааны удирдлагыг хэрэгжүүлж буй «менежер»-ийн хувьд байгууллагын хөгжлийн стратеги, тактикийг тодорхойлж, түүний гишүүдийг нэгэн зорилгод чиглүүлж, бүх шатанд удирдлагаар хангаж, оновчтой шийдвэр гаргаж, үр ашигтай харилцаа үүсгэж, ажлын эцсийн хувь заяаг хариуцаж байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, зэвсэгт хүчний янз бүрийн түвшний удирдах ажилтан бүр төлөвлөж, хүний нөөцөө бүрдүүлж, зохион байгуулж, манлайлж, хянаж ажиллана гэсэн үг мөн бөгөөд чухам эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд цэргийн шинжлэх ухааныг удирдахуйн шинжлэх ухааны «манлайлахуйн» арга, зарчимтай оновчтой хослуулан хэрэгжүүлэх ёстой билээ.

Цаашид зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг, чанар, үр дүнг сайжруулахын тулд тухайн салбарын бүх шатны удирдах ажилтнуудын манлайллын хүчин зүйлүүдийг тооцох, удирдах ажилтны манлайлалд шинэ хандлагыг төлөвшүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байгаа бөгөөд эдгээр нь нэн даруй шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Үндсэн хэсэг

Удирдах, манлайлах тухай ойлголт нь удирдлагын харилцаатай холбоотой бөгөөд удирдлагын хамгийн гол зүйл нь үр дүнтэй манлайлах явдал байдаг.

Манлайллыг олон улсад лидершип «Leadership» буюу манлайлал, хүмүүсийг араасаа дагуулах чадвар, жолоодох гэх агуулга¹ илэрхийлдэг гэж үздэг.

Д.Лхашид «Монголын хаад зүтгэлтнүүдийн жолоодохуйн урлаг» номдоо «Жолоодогч», «Манлайлагч» гэсэн ойлголтыг тайлбарлахдаа «Жолоодогч» бол улс үндэстнийхээ тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн төлөө биеэ зориулдаг, ард түмэндээ хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн хэмжээний нэрд гарсан удирдагч байна. Энэхүү жолоодогчийн агуу төлөөлөл бол Чингис хаан, Модун Шаньюй, Атилла хаан, Өгөдэй хаан зэрэг улсын түүхэнд алтан үсгээр тэмдэглэгдэн үлдсэн үе үеийн төр, нийгмийн гарамгай зүтгэлтэн, цэргийн жанжин, оновчтой шийдвэр гаргалтын их мастеруудыг нэрлэж байна. Харин «Манлайлагч» бол байгууллага болон бичил хамт олны дунд нэр хүндтэй, удирдан зохион байгуулах чадвартай, бие, хэл, сэтгэлийн өгөгдөл сайтай удирдагч болон бие хүнийг хэлнэ гэж тайлбарлажээ.

Я.Цэвэлийн «Монгол хэлний тайлбар толь»-д «Манлайлах– 1) манлай болох, тэргүүлэх, 2) дээд сайн, тэргүүн зэрэгт тооцогдох»². «Манлайлал–манлайлах» үйлийн нэр, «Хошуучлах–хошуу болох тэргүүлэх» гэж тайлбарласан³.

Л.Болдын «Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь»-д «Удирдагчийн манлайлал»

¹ Цэнд, Н нар. Дурдсан бүтээл. 245 дахь тал.

² Цэвэл, Я. Монгол хэлний тайлбар толь. Уб.,1981. 331 дэх тал.

³ Мөн тэнд. 702 дахь тал.



гэсэн тайлбар орж ирсэн нь өнөөдөр манлайлал хэмээх үгийг удирдахуйн ухааны хүрээнд өргөн хэрэглэж буйг хүлээн зөвшөөрсний илрэл юм. «Манлайлагч» манлай блогч, тэргүүлэгч, хошуучлагч⁴ нь үг үйлдлээрээ олон хүний санаа бодол, зан үйл, мэдрэмжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чаддаг хүнийг манлайлагч гэж тодорхойлсон байна.

Манлайллыг хувь хүний манлайлал, удирдах ажилтны манлайлал, хамтын манлайлал, салбарын манлайлал гэж дөрвөн хүрээгээр тайлбарладаг. Энэхүү дөрвөн хүрээ нь тус тусдаа хэрэгждэг ч, хоорондоо уялдаатай судлагддаг⁵ ажээ.

Судлаачид манлайллын 1500 гаруй тодорхойлолт, 130 гаруй онол байдаг ба дараах 8 төрлийн онолын хүрээнд хураангуйлан авч үзсэн байна⁶. Үүнд:

- Аугаа хүний онол (1900–аад оноос өмнөх үе);
- Зан байдлын онол (1904 –1947 он);
- Контингенсийн онол (1948 –1980 он);
- Нөхцөл байдлын онол (1948 –1980 он);
- Зан үйлийн онол (1948 –1980 он);
- Оролцооны онол (1948 –1980 он);
- Менежментийн онол буюу «Солилцооны онол» (1978 он оноос хойш);

Харилцаа холбооны онол (1978 он оноос хойш) гэсэн үечлэлээр судалсан байна.

Америкийн «Leader value» компанийн зөвлөх Мик Иеч Их Монгол Улсыг үүсгэн байгуулагч Чингис хааныг тодорхойлох үндсэн шинжүүдийг томъёолж, тэдгээрийг «4 E» гэж нэрлэсэн байна. Түүний үзэж байгаагаар Чингис хаан нь:

- Ер бусын алсын хараатай (Envision)
- Өндөр чадвар, боломжтой (Enable)
- Асар их эрч хүчтэй (Energize)

⁴ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Ерөнхий редактор Л.Болд). Уб., 2008. 1206–1207 дахь тал.

⁵ Стефен, К. Өндөр бүтээмжтэй хүмүүсийн долоон дадал. 1–р хэвлэл, Нью Йорк., 1989.

⁶ Эрдэнэбат, П. МУ–ын прокурорын байгууллагын удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг, чадварт хийсэн шинжилгээ. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2015. 21 дэх тал.

- Эрх мэдлээ шилжүүлэх чадвартай (Empower) удирдагч байжээ⁷.

Манлайлагчид байх үндсэн шинж чанарууд нь бие хүний нийгэмд эзлэх байр суурь, хамт олны дундах нэр хүндийг тодорхойлох, удирдагч хүнийг шилж сонгох гол шинж юм. Уг шинж чанарууд нь хувь хүнд удамшиж, эсвэл түүний хичээл зүтгэлээр бий болдог байна. Манлайлагчийн үндсэн шинж чанаруудыг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

- Үнэнхүү хөдөлмөрч, ажил хэрэгч;
- Удирдан зохион байгуулах авьяастай;
- Мэдлэгийн цар хүрээ өргөнтэй;
- Оюуны өндөр чадавхтай;
- Хувийн зохион байгуулалт сайтай;
- Сэтгэц зүйн хаттай;
- Ёс зүйн өндөр төлөвшилтэй;
- Бие, сэтгэц эрүүл;
- Жинхэнэ соёлыг өөртөө цогцлоосон хүн байна⁸.

Манлайлагчийн зан араншны шинж чанаруудыг мөн тодорхойлох алхмуудыг судлаачид хийсэн байдаг. Зан араншны буюу темпераментын шинж чанарууд нь бие хүний сэтгэцийн үйл, хөгжил, хөдөлгөөнийг тодорхойлогч, хүний зан байдлыг илэрхийлэгч, сэтгэц зүйн төрөлхийн шинж чанар юм. Хүний мэдлэг, чадвар, дадал, амьдралын орчин, хүмүүжлээс хамаарч темпераментын байдал, гадаад илрэлд өөрчлөлт орж болно. Манлайлагчийн зан араншны шинж чанаруудыг дэс дараатай авч үзье. Үүнд:

- Үнэнхүү идэвхтэй, эрч хүчтэй;
- Илэн далангүй, нээлттэй, нийтгэч;
- Өөдрөг сэтгэлтэй;
- Түргэн зохицох чадамжтай;
- Аливаа зүйлд хүлээцтэй, цочир түргэн бус;
- Ухаалгаар аз сорих, үзээд алдах хандлагатай;
- Гүйлгээ ухаан сайтай;
- Эр зоригтой;

⁷ Цэнд, Н., Шуурав, Я. нар. Менежмент. Уб., 2000. 470, 471 дэх тал.

⁸ Цэцэгмаа, О. Дурдсан бүтээл. 36 дахь тал.

- Зөн билигтэй;
- Мэдрэмж сайтай;
- Шаргуу зантай;
- Тууштай байдалтай;
- Эрс шийдэмгий;
- Бие даасан, бусдын ятгалгад үл автах

араншинтай;

Удирдахуйн хөгжлийн явцад менежерийн үйл ажиллагааны агуулга, зорилго өөрчлөгдсөнгүй. Харин түүний ажлын нөхцөл, арга барил, гүйцэтгэх үүрэгт зарчмын шинжтэй хувьсал, өөрчлөлтүүд бий болжээ. Үүнийг үечилж авч үзвэл менежерийн тодорхой дүр зураг, нийтлэг шинж ажиглагдана.

- Дарангуйлагч –менежерийн үе. Үйлдвэржилтийн эхэн үед хатуу чанд шаардлагатай менежерүүд ихээхэн үнэлэгдэж байв. Тэд ямар нэгэн тайлбар сонсохыг хүсдэггүй, үг дуугүй захирагдах ёстойг сануулж, зөвхөн ажлын гүйцэтгэлийг л шаарддаг байсан тул хөдөлмөрийн бүтээмж нь төдийлөн сайнгүй байдаг байв.

- Эцэг – менежерийн үе. XX зууны эхэн, дунд үед ажиллагсдын хөдөлмөрлөх сонирхлыг төрүүлэх шаардлагатай гэдгийг ойлгож эхэлсэн байдаг. Патерналист буюу эцэг – менежерүүдийг олон ам бүлтэй өрхийн тэргүүлэгчтэй зүйрлэдэг бөгөөд тэд ажиллагсдад эцгийн журмаар, «шударга, гэхдээ хатуу байх» гэсэн зарчмаар хандаж байв.

- Зуучлагч –менежерийн үе. Үйлдвэрлэл эрс хурдацтай хөгжиж ирэх үед маклер – менежерүүдийн үе эхэлсэн байдаг. Бүтээгдэхүүнийг аль болох ихээр үйлдвэрлэх, ажиллагсдын бухимдлыг намжаах, бусдын үйлдвэрийг төлөөлөн ажиллах шаардлагаар зуучлагч менежерүүд бий болсон байдаг.

Манлайлагчийн хэв маяг маш олон янз⁹. Эдгээрээс К.Левин, Р.Липпит болон Р.Уайт нарын санал болгосон гурван төрөл бүхий ангилал хамгийн сонгодогт тооцогдоно. Эдгээр нь дараах байдалтай байна. Үүнд:

- Автократ буюу дарангуйлагч удирдагч;
- Демократ буюу ардчилсан удирдагч;
- Либерал буюу чөлөөт удирдагч.

Автократ удирдлагын үед манлайлагч нь захирагдагсдадаа хатуу чанд, шууд захиран тушаасан, эрх мэдлээ мэдрүүлсэн байдлаар хандах бөгөөд бүлгийн гишүүдийн үүргийг сайтар хуваарилсан байна. Манлайлагч шийдвэрийг ганцаарчлан гаргах ба гаргаж буй шийдвэр, хийж буй үйлдлийг нь бүлгийн гишүүд шүүмжлэх, маргах эрхгүй байдаг. Автократ хэв маяг нь захирагдагсдад өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө дэвшүүлэх боломжийг олгодоггүй. Ер нь автократ удирдлагын үед бүлгийн гишүүд ямар нэгэн санаачилга гаргах боломжгүй байдаг түүний онцлог оршино.

Демократ удирдлагын үед манлайлагч нь шийдвэр гаргахдаа бүлгийн гишүүдийг аль болох татан оролцуулах, тэдний санаачилгыг дэмжих замаар удирдлагыг хамтран хэрэгжүүлэх оролдлогыг хийдэг бөгөөд ийм хэв маягийн удирдлагыг «зөвшилцлийн» гэж нэрлэх нь бий. Демократ хэв маяг нь манлайлагч удирдагчийн хэв шинж илрэн гарах өргөн боломжийг нээж өгдгөөрөө онцлог юм.

Либерал буюу чөлөөт удирдлагын үед манлайлагч нь бүлгийг удирдах идэвхтэй үйлдлээс өөрийгөө үндсэндээ чөлөөлж, бие даан шийдвэр гаргах эрх мэдлийг бүлгийн гишүүдэд шилжүүлсэн байдаг.

Автократ удирдагч нь а) хувиа хичээсэн автократ удирдагч; б) өгөөмөр (сэтгэл сайтай) автократ удирдагч гэсэн хоёр хэв шинжтэй. Хувиа хичээсэн удирдагчтай үед ажлын амжилт, эцсийн үр дүн ердийн гэж хэлж болохоор байдаг бол, өгөөмөр удирдагчтай үед сайн үзүүлэлттэй байж болно. Харин демократ болон либерал удирдагчтай үед ажлын амжилт сайн, эсвэл онцгой сайн байх магадлалтай юм.

Судлаач Ц.Одонгэрэлийн бүтээлд манлайлагч, удирдагчийн ялгааг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

⁹ Цэцэгмаа, О. Дурдсан бүтээл. 36 дахь тал.



Хүснэгт 1. Манлайлагч ба удирдагчийн ялгаа

Судлаач	Манлайлагч	Удирдагч
Warren Bennis ¹⁰ (1977)	Манлайлагчид зөв зүйл хийдэг хүмүүс. Тэд хамтын ажиллагааг дэмжих, багийн гишүүдийг чадавхжуулах, таатай орчныг бүрдүүлэх зэргээр багийг удирдаж буй удирдагч.	Аливаа зүйлийг зөвөөр хийхээр тэмүүлэн удирддаг хүн. Тэд үр ашигтай үйл ажиллагааг хангах, томилогдсон ажлынхаа амжилтыг удирдах, шийдвэр гаргах эрх мэдэлтэй байдаг.
John Kotter ¹¹ (1989)	Манлайлагчид алсын харааг гаргаж, өөрчлөлтийг урамшуулж хувь хүмүүсийг нэгтгэж, нэг зорилгод нийцүүлэхийн чухлыг ойлгодог. Чухал үр дүнд хүрэхийн тулд хамтын хүчин чармайлт шаардлагатай гэдэгт анхаардаг.	Удирдагчид тогтвортой байдал, үр ашгийг хадгалан өөрсдийн үүрэг, хариуцлага, хувь хүний хувь нэмэр ерөнхий зорилгод хэрхэн хувь нэмэр оруулж байгааг ойлгодог орчин бүрдүүлэхийн төлөө ажилладаг.
Abraham Zaleznik ¹² (1990)	Манлайлагч нь нэг зорилгод хүрэхийн тулд бүлэг хүмүүсийг чиглүүлж, удирдан чиглүүлж, тэдэнд урам зориг өгдөг хувь хүн. Манлайлагчид зорилгодоо хүрэх хувийн, идэвхтэй хандлагыг баримталдаг.	Удирдагчид байгууллагын чиглэл, зорилгод санаа тавьж, төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтад анхаарлаа хандуулдаг. Тэд хэлтэс хоорондын зөрчилдөөнийг намжааж, бүх талыг тайвшруулж, байгууллагын өдөр тутмын ажил хэрэгч байдлыг хангахад гарамгай байдаг.
Henry Mintzberg ¹³ (1993)	Манлайлагч нь хүмүүсийг удирдан чиглүүлж, багийн зорилгод хүрэхийн тулд гишүүдтэйгээ ажиллаж, чиглэлээ тогтоодог.	Удирдагч нь бүлэг хүмүүсийг удирдан чиглүүлж, тэдний хүчин чармайлтыг багийн зорилгод хүргэхийн тулд уялдуулах үүрэг, хариуцлага хүлээсэн албан ёсны дарга.
John P. Kotter ¹⁴ (2004)	Манлайлагч нь ахиц дэвшилд саад болох, эсвэл зорилгодоо хүрэхэд нөлөөлж болох олон төрлийн асуудал, саад бэрхшээлтэй тулгардаг ч хүмүүстэй харилцах, харилцааны өндөр ур чадвар эзэмшээд зогсохгүй багийн гишүүдийг үйл ажиллагаанд татан оролцуулах чадварыг харуулсан бусдад хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүн.	Удирдагч нь байгууллагын үйл ажиллагааг урьдчилан тодорхойлсон зорилтуудтай нийцүүлэхийн тулд хяналтын системийг бий болгон гүйцэтгэлийг хянаж, үнэлж, стандарт тогтоохын тулд харьцуулж, шаардлагатай бол засаж залруулах арга хэмжээ авдаг. Тэд хяналт тавьснаар асуудлыг үр дүнтэй шийдвэрлэн тухайн салбартаа тогтвортой байдлыг хадгалж, амжилтад хүрэхэд хувь нэмрээ оруулдаг.

Эх сурвалж: Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал, Ц.Одонгэрэл. Хууль сахиулах удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. 54 дэх тал, 2024.

¹⁰ Warren Bennis. On coming a Leader. ISBN–10:0465014089. ISBN–13:978–0465014088

¹¹ Kotter, John(1996). Leading Change. Boston: Harvard Business School. Press. ISBN–10 0585184658, ISBN–13 978–0585184654:

¹² Abraham Zaleznik. (Feb., 1990).The Leadership Gap, Vol. 4, No. 1 p. 7–22 (16 pages) Journal of Academy of Management, <https://www.jstor.org/stable/4164929>

¹³ Mintzberg, Henry (1993). The evolution of a model of managing:Leadership and manager. <http://www.mintzberg.org/sites/default/files/managingmodel.pdf>

¹⁴ John, P Kotter (2005). What Leaders really do Harvard Business Press. ISBN:0875848974, 9780875848976



Дээр дурдсан тодорхойлолтуудаас үзэхэд манлайлагч болон удирдагчийн хооронд ижил төсөөтэй зүйл олон байна. Гэсэн хэдий ч дээрх субъектуудыг хооронд нь сөргүүлэн тавих, эсрэг тэсрэг өнцгөөс үнэлэх хандлага судлаачдын дунд бий. Энэ үзэл нь гол төлөв эдгээр субъектийн эрх мэдэл, эзэлж буй байр суурь зэрэгт үндэслэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, удирдагчийг дээрээс (хүмүүсийг араасаа дагуулах авьяас, чадвар түүнд байгаа эсэхээс үл хамааран) томилдог, харин манлайлагчийг мөн чанартаа доороос (түүний хувийн чанар, зан төлөвийг харгалзан) дэвшүүлэн гаргадаг гэсэн үзэл санаа юм.

Манлайлагч болон удирдагчийн ойлголтын хамгийн гол ялгааг дараах байдлаар авч үзсэн байдаг:

- удирдагч гол төлөв албан ёсоор томилогддог бол манлайлагчийг хамт олон нь тодруулан гаргадаг;
- удирдагч хуулийн дагуу тодорхой эрх, үүргээр хангагдсан байдаг бол манлайлагч ийм эрх, үүрэггүй байж болно;
- удирдагч өөрт оногдсон бусдад нөлөөлөх захиргааны (шийтгэлийн) эрх хэмжээгээр хангагдсан байдаг бол манлайлагч өөрийн хувийн нэр хүндэд түшиглэн бусдад нөлөөлж байдаг;
- удирдагч байгууллагыг гадаад орчинд төлөөлж, албан харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэж байдаг бол манлайлагч байгууллагын дотоод орчны хүрээгээр үйл ажиллагаагаа хязгаарладаг байна.

«Удирдагч», эсвэл «манлайлагч» болж төлөвших үзэгдэл нь удирдлагын харилцааны үйл явц дунд өрнөх бөгөөд эдгээр субъектийн

онцгой чанарууд бүрэлдэх зүй тогтол, тодрон гарах нөхцөл оршсоор байдаг хэмээн үзэж болно. Манлайлагч төрөн гарах үзэгдэл нь бие хүний хувийн, ажил хэргийн, нийгмийн чиг баримжаатай шууд хамааралтай байна.

«Манлайлал» нь хамт олны дотоод зохион байгуулалтаас, түүнчлэн хамт олны хүлээлт хэрхэн хэрэгжиж буй явцаас урган гарах ба бие хүн хоорондын харилцааны тогтолцоон дотор аажимдаа, аяндаа бүрэлдэн бий болдог үзэгдэл юм.

Манлайлагч бүрэлдэн бий болох үзэгдэл нь ялангуяа эхнийхээ үе шатан дээр илүүтэй сэтгэц зүйн шинж чанарууд дээр суурилдаг бол, удирдагч төлөвших байдал нь гол төлөв удирдлагын үүргийн хуваарилалттай холбоотой бүлэг доторх нийгмийн шинж чанаруудаас хамааралтай байна.

«Урсгал сөрж буй» манлайлагчийн үйл ажиллагаа нь хуучинсаг (консерватив) хүчний эсэргүүцлийг гэтлэн давах, шинэ боломж, шийдлүүдийг санал болгох, шаардлагатай хүмүүстэй холбоо тогтоож хамтран ажиллах, байгууллага дахь нийгмийн «архитектор»-ын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй шууд хамааралтай байдаг¹⁵.

Бид манлайлагч болон удирдагчийн (менежерийн) ялгааг тэдгээрийн хувийн шинж чанар, удирдлагын зарим чиг үүргийг хэрэгжүүлж буй онцлогтой уялдуулан тодруулах оролдлогыг зарим нэгэн эх сурвалжид тулгуурлан мөн хийж үзлээ.

15 Лукашева, О.В. Лидерство и организация рыночной экономики. Дисс. ...канд. эконом. наук. –М., 1997. С.19.

2 дугаар хүснэгт. Манлайлагч ба удирдагчийн зан чанарын ялгаа

Манлайлагч	Удирдагч
Заавал өндөр боловсролтой байдаггүй, өөрийн мэдлэг, чадавхыг уламжлалт сургалтын аргаар бус, өөрийгөө хөгжүүлэх байдлаар дээшлүүлэх сонирхол, хандлагатай байдаг.	Өндөр боловсролтой, ухамсартай, хөдөлмөрч, өөрийн мэргэжлийн мэдлэг, шинжлэх ухааны түвшин дээшлүүлэхийн тулд байнга хичээж ажилладаг.
Асуудлын мөн чанарыг түргэн тусгаж, хялбар ойлгож болохуйц, анхаарал татахуйц хэлбэрээр зорилтыг томьёолж чаддаг.	Зорилтыг оновчтой томьёолж, үндэслэл, хүрэх арга замыг тооцоход онцгой анхаарал хандуулдаг.



Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ чанарын үзүүлэлтүүдийг голлох бөгөөд амжилтад хүрэхэд нөлөөлсөн хамт олны хичээл зүтгэлийг чухалчилж үздэг. Чанарын амжилтыг харуулахдаа тоон үзүүлэлтээр илэрхийлж чаддаг.	Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ойрын ирээдүйн зураглал болох тоон үзүүлэлтүүдэд илүүтэй анхаарал хандуулдаг.
Удирдлагын үйл ажиллагааны нарийн, төвөгтэй арга, ажиллагаанд зөвхөн дээд түвшний цөөн удирдах ажилтныг сургах нь зөв гэж үздэг.	Ажилтнуудыг өөрийн үйл ажиллагааг сайжруулах энгийн аргад сургахыг эрмэлздэг.
Ажилтнуудын дунд түүний нэр хүнд ямар байгаад онцгой анхаарал хандуулдаггүй, манлайлагчийн чанар (харизма буюу сэтгэл татам байдал) нь нэр хүнд унах эрсдэлийг үргэлж бага байлгадаг.	Ажилтнуудын дунд түүний нэр хүнд ямар байгаад онцгой анхаарал хандуулах бөгөөд таатай дүр төрх бүрдүүлэхийн тулд их хичээдэг.
Тогтолцооны тогтвортой байдлыг төдийлөн чухалчилдаггүй, шинэ зүйлийг үргэлж эрэлхийлж байдаг ба энэ нь тогтолцоог шинэчлэхэд бэлэн байгаа болохыг харуулж байдаг. Шинэчлэлийг хийхдээ удирдлагын тогтсон номлолыг ч үл хэрэгсэх хандлагатай байдаг. х	Ажиллаж буй тогтолцоондоо үнэнч бөгөөд түүний тогтвортой байдлыг хадгалахын тулд бүх хичээл зүтгэлээ зориулдаг. Өөрчлөлт, шинэчлэлтийг зөвхөн тогтолцооны хүрээнд хэсэгчлэн хийхийг хүлээн зөвшөөрдөг.
Өөрийн алдааг чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч чаддаг бөгөөд түүнийгээ залруулахын тулд ил, нээлттэй алхам хийхээс айдаггүй.	Өөрийн алдааг хүлээн зөвшөөрөхөөс болгоомжилдог. Учир нь мэргэжлийн хувьд гаргасан алдаа нь түүний нэр хүнд, итгэлийг унагахад хүргэнэ гэж айдаг.
Хариуцлагын үр нөлөө нь албан бус харилцаанд тулгуурласан хүндлэл, итгэл үнэмшил дээр суурилна гэж үздэг.	Гүйцэтгэгчийн хариуцлагыг сайтар албажуулсан дүрэм, журам, зөвшилцөж тохиролцсон үнэлгээний шалгууруудтай уяж өгөх ёстой гэж үздэг.
Ажилтнууд амжилт гаргасныг хүлээн зөвшөөрч, тэднийг шагнаж урамшуулахад үргэлж бэлэн байдаг. Шагнах хэрэгцээ үүссэн болон шагнал гардуулах мөч хооронд аль болох бага хугацаа өнгөрсөн байх ёстой гэж үздэг. Тэдний хувьд шагнал гардуулах ажиллагаа нь сэтгэц зүйн хувьд онцгой үлдэцтэй байх нь чухал байдаг.	Ажилтнуудыг шагнаж урамшуулахдаа хойрго байдаг. Ажилтнуудыг үргэлж сэдэлжүүлж байх ёстой бөгөөд тэд амжилт гаргахын тулд удирдагчийн чиглүүлсэн тодорхой заавар, байнгын хяналт шалгалт үргэлж дутагдаж байдаг хэмээн үздэг.
Албан бус харилцаанд ач холбогдол өгөх бөгөөд ажлын үр дүн муу байгаа үед асуудлыг шийдвэрлэх гарцыг хайхаар байгууллагын гишүүд, хамт олондоо ханддаг.	Зөвхөн албан харилцааны сувгийг ашиглах ба асуудлыг шийдвэрлэхийн тулд зөвхөн өөрийн боломж, чадавхад суурилах нь олонтоо.
Дотоод сэтгэлийн чөлөөт байдал нь ажлын эцсийн үр дүнд хүрэхийн тулд тогтсон дүрэм журмаар үл хязгаарлагдан, амьд эрх зүйн хэм хэмжээг мөрдлөг болгох нь олонтоо.	Дотоод сэтгэлийн хүлээснээс үүдэн тогтсон дүрэм журмыг яв цав мөрдөхөөс үл хэтрэх ба энэ нь аажимдаа автократ буюу хатуу захиргаадах арга барилд хүргэдэг.

“Эх сурвалж: Лукашева, О.В.”

Дээр дурдсан манлайлагч болон удирдагчийн шинж чанарын харьцуулалтыг эцсийн үнэн, төгс төгөлдөр зүйл мөн гэж үзэж болохгүй нь ойлгомжтой бөгөөд эдгээр субъектийн мөн чанарыг танин мэдэх, удирдах албан тушаалтны ажлын арга барилд дүн шинжилгээ хийх, тэдний манлайллыг сайжруулахад загвар болгон ашиглах ач

холбогдолтой хэмээн бид үзэж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлээр удирдахуйн ухааны судлагдахуун болох манлайллын талаарх онолын судалгааг харьцуулан судалж дараах дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Өнөөдөр менежмент нийгмийн амьдралын бүхий л хүрээнд өөрийн байр



сууриа эзэлж, аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд эрчимтэй нэвтэрч байна. «Хууль сахиулахуйн менежмент», «Цагдаагийн менежмент», «Аюулгүй байдлын менежмент», «Гамшгийн менежмент», «Хил хамгаалалтын менежмент», «Шинжлэн магадлахуйн менежмент», «Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны менежмент» г.м. нэр томьёо хэдийнээ нийтийн хүртээл болжээ. Эдгээр нь «тусгай» буюу «чиг үүргийн менежмент»-ийн хэлбэрээр хөгжиж байна.

2. Манлайлал гэдэг нь шууд анзаарагдахгүй боловч ажиглагдаж буй зан төлөвөөс урган гарч ирдэг, манлайлагчийн үйл ажиллагааны тодорхой үр дагавар энэ зан төлөвтэй холбоос үүсгэхийн хэрээр ил харагддаг үзэгдэл юм. Манлайлагчийн ойлголтыг нээн гаргах,

тэдгээрийн төрөл, ангиллыг ялган харуулснаар манлайлагчийн мөн чанар, түүний олон талт хэв маяг, шинж чанарууд тодрон гарч ирж байна.

3. Байгууллагын дээд, дунд, доод түвшний менежер нь хамт олныг зөв удирдан чиглүүлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага, ёс зүй, шийдвэр гаргалтын түвшин бүрд манлайллыг үзүүлж, харизматик удирдагчийн хэв маягийг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Иймээс удирдлагын арга барилыг тогтмол сайжруулах нь үр дүнтэй юм.

4. Зэвсэгт хүчний удирдах ажилтны захиргааны удирдлагыг хэрэгжүүлэхэд албан ёсны манлайллыг дээшлүүлэхэд олон арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Ашигласан материал:

1. Цэвэл.Я., Монгол хэлний тайлбар толь. УБ.,1981.,т.332
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Ерөнхий редактор Л.Болд). Уб., 2008. 1206–1207 дахь тал.
3. Цэнд Н. Шуурав Я., нар. Менежмент. УБ., 2000., т. 470, 471
4. Цэнд Н. Менежмент. УБ., 2013. т.14
5. Одонгэрэл Ц. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал. Хууль сахиулах удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2024., т.17
6. Эрдэнэбат П. МУ–ын прокурорын байгууллагын удирдах албан тушаалтны манлайллын хэв маяг, чадварт хийсэн шинжилгээ. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2015., т.21
7. Стефен К. Өндөр бүтээмжтэй хүмүүсийн долоон дадал. 1–р хэвлэл, Нью Йорк., 1989.
8. Лукашева О.В. Лидерство и управление организацией рыночной экономики. –М.,1997., С.52.
9. Warren Bennis. On coming a Leader. ISBN–10:0465014089. ISBN–13:978–0465014088
10. Kotter John(1996). Leading Change. Boston: Harvard Business School. Press. ISBN–10 0585184658, ISBN–13 :978–0585184654
11. Abraham Zaleznik. (Feb., 1990).The Leadership Gap, Vol. 4, No. 1 p. 7–22 (16 pages) Journal of Academy of Management, <https://www.jstor.org/stable/4164929>.
12. Mintzberg, Henry (1993). The evolution of a model of managing:Leadership and manager. <http://www.mintzberg.org/sites/default/files/managingmodel.pdf>
13. John, P Kotter (2005). What Leaders really do Harvard Business Press. ISBN:0875848974, 9780875848976
14. Лукашева О.В. Лидерство и организация рыночной экономики. Дисс. ...канд. эконом. наук. –М., 1997., С.19.



МОТОБУУДЛАГЫН БРИГАДЫН АРТИЛЛЕРИЙН СУМ ЗАРЦУУЛАЛТ, ЦЕЛИЙН ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ХӨНӨӨЛИЙН ЗЭРГИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

М.ЭРДЭНЭТӨГС /УБХИС-ийн ЦНДС-ийн Артиллер, Зэвсгийн тэнхимийн дарга/

Түлхүүр үг: Бригадын артиллерийн бүлэг, тийрэлтэт артиллерийн дивизион, хөнөөлийн зэрэг, байлдааны машин, хуягт тээвэрлэгч, явган цэргийн байлдааны машин, байлдааны иж.
Key words: brigade artillery group, jet artillery division, degree of harm, combat vehicle, armored personnel carrier, infantry fighting vehicle, combat gear

Оршил

Мотобуудлагын бригадын артиллерийн дарга нь артиллерийн гал удирдах үед цельд зарцуулах сум зарцуулалтыг тодорхойлох үүрэгтэй юм.

Сум зарцуулалтыг цельд нормоор заах үед целийн хөнөөлийн зэрэг, галын үүрэг биелүүлэхэд оролцож байгаа дивизионы тоо, буудлагын үүргийг тодорхойлох шаардлагатай. Хэрвээ целийг устгах хөнөөлийн зэрэг өгөгдөөгүй /заагдаагүй/ бол сум зарцуулалтыг салбарт бэлэн байгаа болон цаг хугацаандаа олгогдох галт хэрэглэлээр тодорхойлно.

Дивизионы сум зарцуулалтыг түүний галын боломжийг харгалзан томилно. Энэ үед сум зарцуулалтыг тооцохдоо цельд зарцуулах нормын хэмжээг оролцож байгаа дивизионуудын галын боломжийн нийлбэрт хувааж галт хэрэглэлийн зарцуулалтыг тодорхойлж буй тухайн салбарын галын боломжоор үржүүлнэ.

Үндсэн хэсэг

Целийн хөнөөлийн зэрэг– гэдэг ойлголтод объектод артиллерийн галаар үзүүлэх хохирлын хэмжээ болон түүнд галын хөнөөл үзүүлсний дараах байдал хоорондын харилцан хамаарлаар илэрхийлэгдэнэ.

Целийн хөнөөлийн зэргийн бодит үнэлгээ нь галын үүрэг биелүүлсэн үр дүнгээр илэрхийлэгдэнэ. Энэ нь устгагдсан цэрэг, техник, харвах суурь зэргийн тоогоор хэмжигдэнэ. Гэвч бодит байдалд дээр галын үүрэг биелүүлэх шийдвэр гаргах үед дайсны

цель, объектын хүлээгдэж буй хохирлын хэмжээг мэдэх шаардлага тулгардаг. Үүний тулд буудлагын бүтэмжийн олон төрлийн үзүүлэлтүүд, целийн шинж чанар, хянагдаж байгаа байдал зэргийг харгалзан үзнэ.

Гол төмөрт, тийрэлтэт артиллериар давхарлаж гал явуулах үеийн сум зарцуулалт, целийн хүлээгдэж буй хөнөөлийн зэргийг тодорхойлох

Жишээ №1. Сум зарцуулалтыг нормоор тодорхойлох.

Ил байрласан амьд хүч /фронт 800, гүн 700м/–ийг устгахын тулд /хөнөөлийн зэрэг–55 хувь/ бригадын артиллерийн дарга БрАБ–ын адн–5, ТАДН–1 –ийг оролцуулахаар шийдвэрлэсэн. Буудлагын холын зай 10 км хүртэл. Галын үүрэг биелүүлэх сум зарцуулалтыг тодорхойл. /ТАДН–д $\frac{1}{2}$ залп/

Бодолт:

1. БрАБ–ын бөөгнөрүүлсэн галаар галын үүрэг биелүүлэх целийн хэмжээ /5–9 дивизионд целийн дээд хэмжээ 800x800 байна/

2. Целийн хөнөөлийн зэрэг 55 хувь, галын үүрэг биелүүлэхэд 6 дивизион оролцох бөгөөд **график №1**–ээс харахад сум зарцуулалт цельд $N_{ц} = 3/5$ нормоор гэж авна.

3. ТАДН–д тогтоосон сум зарцуулалтын норм $\frac{1}{2}$ залп/–оор цельд зарцуулах сум зарцуулалтыг тооцно. $S_{ц} = 56$ га /800x700/ бөгөөд өгөгдсөн цельд ТАДН–ны галын боломж /**таблиц №1**/ 18 БМ $S_{адн}^{об} = 21$ га. ТАДН–ны хагас залп өгөгдсөн үед целийн сум зарцуулалтын норм $N_{РА} /$ ыг бодож олно.



$$N'_{\text{ств}} = \frac{S_{\text{реадн}}^{\text{ов}} \times N'_{\text{бк}} \times n_{\text{адн}}}{S_{\text{ц}}} = \frac{9 \times 0,3 \times 5}{40} = \frac{13,5}{40}$$

$n_{\text{реадн}}$ –ТАДН–ны тоо

$N'_{\text{залп}}$ –ТАДН–ны цельд зарцуулахаар өгсөн залпын норм

$S_{\text{ц}}$ –Целийн хэмжээ /га–гаар/

$$N'_{\text{ра}} = \frac{21 \times 1/2 \times 1}{56} = \frac{10,5}{56} = \frac{1}{5} \text{ нормоор}$$

4. Целийг устгахад оролцох гол төмөрт дивизионуудын сум зарцуулалтын нормыг бодно.

$$N'_{\text{ств}} = N_{\text{ц}}' - N_{\text{ра}}' = \frac{3}{5} - \frac{1}{5} = \frac{2}{5} \text{ нормоор}$$

5. Галын үүрэг биелүүлэхэд оролцох гол төмөрт дивизион бүрийн сум зарцуулалтыг тодорхойлно.

$$N'_{\text{адн}} = \frac{N'_{\text{ств}}}{n} = \frac{2}{5 \times 5} = \frac{1}{13} \text{ нормоор}$$

6. Галын үүрэг биелүүлэхэд оролцох гол төмөрт артиллерийн буу бүрийн байлдааны ижээр илэрхийлэх сум зарцуулалтыг тодорхойлно.

$$N'_{\text{бк}} = \frac{S_{\text{ц}}}{S_{\text{ов адн}}} \times N'_{\text{адн}} = \frac{56}{43} \times \frac{1}{13} \approx 0,1 \text{ бк}$$

Дүгнэлт. Гол төмөрт артиллерийн дивизион бүрийн сум зарцуулалт 1/13 нормоор эсвэл 0,1кб байна. Харин тийрэлтэт артиллерт 1/2 залп байна.

Жишээ №2. Целийн хүлээгдэж буй хөнөөлийн зэргийг тооцох

Сөрөг атаканд бэлтгэж байгаа дайсны /800x500 хэмжээтэй талбайд байрлаж байгаа ЯЦБМ, ХТ–тэй/ амьд хүчийг бригадын артиллерийн дарга 6 дивизионоор /гол төмөрт адн–5, Тадн–1/ бөөгнөрүүлсэн артиллерийн галаар хөнөөл үзүүлэхээр бэлтгэж байна. Бүх дивизионууд 18 буутай. Буудлагын холын зай 10км хүртэл.

Бригадын захирагч дээрх галын үүргийг биелүүлэхэд гол төмөрт артиллерт 0,3бк, тийрэлтэт артиллерт 1 залп зарцуулахаар шийдвэрлэсэн.

Целийн хүлээгдэж буй хөнөөлийн зэргийг тодорхойл.

Бодолт:

1. Дивизионы галын боломжийн **таблиц №1**–ээс тийрэлтэт артиллерийн дивизионы галын боломж $S_{\text{реадн}}^{\text{ов}}=4,5$ га, гол төмөрт дивизионд $S_{\text{адн}}^{\text{ов}}=9$ га –г авна.

2. БМ–21–ийн дивизионы залпаар целийн сум зарцуулалтын нормын хэмжээг тодорхойлно.

$$N'_{\text{ра}} = \frac{S_{\text{реадн}}^{\text{ов}} \times N'_{\text{залп}} \times n_{\text{реадн}}}{S_{\text{ц}}} = \frac{4,5 \times 1 \times 1}{40} = \frac{4,5}{40} \text{ нормоор}$$

3. Гол төмөрт артиллерийн 5 дивизионоор целийн сум зарцуулалтын нормын хэмжээг дивизион бүрд 0,3 бк байхаар бодно.

$$N'_{\text{ств}} = \frac{S_{\text{реадн}}^{\text{ов}} \times N'_{\text{бк}} \times n_{\text{адн}}}{S_{\text{ц}}} = \frac{9 \times 0,3 \times 5}{40} = \frac{13,5}{40} \text{ нормоор}$$

4. Целийн нийт сум зарцуулалтын нормыг бодож олно.

$$N'_{\text{ц}} = N'_{\text{ств}} + N'_{\text{ра}} = \frac{4,5}{40} + \frac{13,5}{40} = \frac{2}{5} \text{ нормоор}$$

5. График №1–ээс 2/5 нормын галт хэрэглэлээр 6 адн–ны галаар целийг дарах хүлээгдэж буй хөнөөлийн зэрэг 24 хувь байна.

Дүгнэлт.

Мотобуудлагын бригадын артиллерийн дарга нь бригадын артиллерийн салбаруудыг байлдаанд хэрэглэх талаар саналыг бригадын захирагчид илтгэхдээ галын хөнөөл үзүүлэх цөлүүдийн хөнөөлийн зэргийн заавал илтгэх шаардлагатай.

Иймд энэхүү шаардлагыг хангах үүднээс гол төмөрт болон тийрэлтэт артиллериар давхарлаж гал явуулах үеийн сум зарцуулалт, целийн хүлээгдэж буй хөнөөлийн зэргийг тодорхойлох ажиллагааг тодорхой жишээн дээр тайлбарласан болно. Мөн хавсралтаар гол төмөрт /тийрэлтэт/ артиллерийн дивизионы галын боломжийг тодорхойлох, /га–гаар совадн/ целийн хөнөөлийн зэргийг тодорхойлох хүснэгтийг оруулж өгсөн.




ГОЛ ТӨМӨРТ /ТИЙРЭЛТЭТ/ АРТИЛЛЕРИЙН ДИВИЗИОНЫ ГАЛЫН БОЛОМЖ /га-гаар $S_{адн}^{об}$ /

Дивизион	Целийн шинж чанар /буудлагын үүрэг/	
	Танк, ЯЦБМ, ХТ далдлагдсан амьд хүч, галын хэрэгсэл /дарах/	Ил байрласан амьд хүч, галын хэрэгсэл /устгах/
Гол төмөрт артиллер		
12 буутай адн	6	29
18 буутай адн	9	43
24 буутай адн	12	58
Тийрэлтэт артиллер		
Град 12 БМ-тэй	3	14
Град 18 БМ-тэй	4,5	21
Ураган 12 БМ-тэй	12,8	27/192
Ураган 18 БМ-тэй	19,2	41/288

Тайлбар:

1. Галын боломж /ил байрласан амьд хүчинд 1га хүртэл/ 122мм, 152мм-н калибрын буунд 1 бк /БМ-д 1залп/, АБГУД-д заасан сум зарцуулалтын нормоор, дүүрэн бэлтгэл, буудсан бууны өгөгдөхүүн ашигласан аргаар, тийрэлтэт артиллерт дүүрэн болон хураангуй бэлтгэлийн аргаар, буудлагын холын зай 10км хүртэл зайд тус тус бодогдсон.
2. Буудлагын холын зай 10км түүнээс их үед гол төмөрт артиллерийн галын боломжийг 10км-ээс дээш километр тутамд 1/10-ээр багасгана.
3. Хүртвэрт 9М27Ф, хуваарьт 9М27К тийрэлтэт сум ашигласан үед.

ЦЕЛИЙН ХӨНӨӨЛИЙН ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ



Целийн хөнөөлийн зэрэг нь сум зарцуулалт /цельд нормоор/, цельд хөнөөл үзүүлэхэд оролцож байгаа дивизионуудын тооноос шалтгаална. /дивизионоор давхарлаж буудах үед/



Ашигласан материал:

1. “Артиллерийн буудлага, гал удирдах дүрэм–2022”
2. “Артиллерийн байлдааны дүрэм–2022”
3. “Руководство по управлению огнём артиллерии” МВАА–2008г
4. “Управление ударами и огнём ракетных войск и артиллерии” 2008г
5. “Правила стрельбы и управления огнём артиллерии”–2020г
6. “Управление огнем артиллерийской группы” (дивизиона). Учебник. 2000г

АРТИЛЛЕРИЙН ДИВИЗИОНЫ БАЙЛДААНД НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ

Б.ЦОЛМОНБААТАР /УБХИС-БХУА-ын магистрант/

Түлхүүр үг: Батлан хамгаалах, Нисгэгчгүй нисэх хэрэгсэл, технологи, артиллери

Key words: Defense, UAV Unmanned aerial vehicle, technology, artillery

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн төрөл

Дрон (drone) буюу нисгэгчгүй нисэх хэрэгсэл гэдэг нэршил нь латинаар ажилч зөгий гэсэн утгатай нэр бөгөөд нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь өөрийн үүрэг даалгаврыг биелүүлээд эргэн үүрэндээ ирдэг, хүнгэнэж дугардаг байдлаараа төстэй учраас ийнхүү нэрлэсэн. Тодруулбал дрон гэдэг утга нь нисгэгчгүй нисэх төхөөрөмж, алсын удирдлагатай онгоц, автоматаар нисэх GPS-н байршлын дагуу төлөвлөлт хийх боломжтой програмчлагдсан удирдлагатай систем юм.

Нисэгчгүй нисэх хэрэгслийн ангилал, зориулалт

1. Аврах ажиллагаанд
2. Хил хамгаалах
3. Замын хөдөлгөөнийг хянах
4. Эрэл хайгуул
5. Цаг агаарын хяналт
6. Гал унтраах
7. Нисдэг камерын бичлэг хийх
8. Газар төлөвлөлт
9. Ховордсон ан амьтан, ургамал тоолох

Ашиглагдаж буй салбар

1. Интертаймментийн салбар
2. Хөдөө аж ахуйн салбар
3. Боловсролын салбар
4. Батлан хамгаалах салбар
5. Уул уурхайн салбар
6. Үйлчилгээний салбар
7. Байгал орчин хамгааллын салбар

8. Барилга, хот байгуулалтын салбар

9. Зам тээврийн салбарт өргөнөөр ашиглагдаж байна.

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн түүхэн хөгжил, төрөл, ангилал, зориулалт

1910 онд ах дүү Райтын амжилтад урамшиж бахархсан Чарльз Кеттеринг гэгч Америкийн Огайо мужаас гаралтай цэргийн инженер залуу хүнгүй нисэх хэрэгслийг ашиглах санааг анх дэвшүүлсэн байна. АНУ-ын армиас санхүүгийн дэмжлэг авч хэд хэдэн ийм төхөөрөмжийг бүтээн, угсарч туршсан боловч байлдааны ажиллагаанд ашиглаж чадаагүй байна.

1933 онд Их Британид давхар далавч бүхий Fairy Queen онгоцыг өөрчлөн засварлах замаар олон дахин ашиглах боломжтой Queen Bee гэх анхны нисгэгчгүй нисэх хэрэгслийг бүтээж онгоцны нисдэг бай болгон туршиж эхэлсэн гэдэг. Эдгээр нисдэг байнуудыг усан онгоцноос алсаас удирддаг байсан бөгөөд DH82A Tiger Moth гэх нэрээр 1943 он хүртэл Хатан хааны Тэнгисийн цэргийн хүчинд ашиглаж байжээ. Мөн 1940 оноос ийм төрлийн алсын радио удирдлага бүхий Radioplane OQ-2 нэртэй нисгэгчгүй хэрэгслийг АНУ-ын Арми, ТЦХ-нд “онгоц-бай” болгон ашигладаг байсан байна.

Эдгээр төслүүдийг гүйцээж чадаагүй ч Fritz X ба Hs 293 бөмбөгнүүдийг Газрын дундад тэнгист хуягласан усан онгоцнуудын эсрэг ашиглаж байсан гэдэг. V1 Buzz Bomb маягийн үелсэн тийрэлтэт хөдөлгүүртэй онгоцыг цэргийн





гэхээсээ илүү улс төрийн зорилгоор бүтээгдсэн гэх бөгөөд газраас төдийгүй агаараас харвах боломжтой байжээ.

Зөвлөлт Холбоот Улсад 1930–1940–өөд онд онгоц зохион бүтээгч Никитины удирдлага дор тусгай зориулалтын ПСН–1, ПСН–2 нэртэй торпед тээвэрлэгч хэрэгслүүдийг бүтээх төслийг боловсруулж 1940 оны эхээр бэлэн болгосон боловч 700 км/ц хурдтай, 100 км–ээс цааш нисэх чадвартай эдгээр “нисдэг торпед”–г амьдралд хэрэгжүүлж чадсангүй.

Дэлхийн хоёрдугаар дайны үед АНУ–ын ТЦХГерманы зарим тэнгисийн баазуудад цохилт өгөх зорилгоор В–17 онгоц дээр суурилагдсан алсын удирдлагатай нисэх хэрэгслүүдийг ашиглах оролдлого хийж байв. Дайны дараа ч гэсэн АНУ–д зарим төрлийн нисгэгчгүй нисэх хэрэгсэл зохион бүтээх ажиллагааг үргэлжилсээр бүр Солонгосын дайны үед томоохон гүүрнүүдийг устгахад Tarzon маягийн радио удирдлагат бөмбөг ашиглаж байжээ.

1960–аад оны эхээр АНУ алсын удирдлагатай нисэх хэрэгслүүдийг ашиглан ЗХУ–ын болон Куб Улсын нутаг дэвсгэр дээр пуужин байрлуулах явцыг тагнан туршдаг байсан байна.

Нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийг албан ёсоор зохион бүтээх ажлууд дэлхийн нэгдүгээр дайны үеэс эхэлж, 1930–аад онд алсаас удирдах нисэх хэрэгслүүдийн анхны загварууд бий болсон бөгөөд 1940–өөд онд анхны далавчит пуужингууд, 1950–аад онд нисгэгчгүй тагнуулын хэрэгслүүд, 1960–аад онд цөмийн зэвсэг бүхий алсын тусгалтай далавчит пуужингууд бүтээгдсэн юм. 1970–аад онд байлдааны цохилт өгөх зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг бүтээх судалгаа, шинжилгээний туршилтууд эхэлж, 1980–аад онд агаар, тэнгис, газрын байрлалтай далавчит пуужингуудыг зэвсэглэлд авч, 1990–ээд онуудад маш өндөрт удаан хугацаагаар нислэг үйлдэж, ажиглалт явуулах чадвартай, тагнуул–цохилтын цогцолборын бүрэлдэхүүнд ашиглах нисгэгчгүй нисэх онгоцнуудыг хөөргөж эхэлсэн байна. 2000–аад оноос дэлхийн

тэргүүлэх гүрнүүд газрын объектуудад цохилт өгөх боломжтой нисгэгчгүй байлдааны нисэх хэрэгслүүдийг бүтээхэд ихээхэн анхаарч байна.

Цэргийн салбарт мэдэгдэж байсан хамгийн анхны байлдааны нисгэгчгүй онгоцыг Израил улс “Араб–Израилын дайнд” 1973 онд ашиглаж байсан гэдэг. Тэрхүү дроныг “Ryan Aeronautical” компанийн үйлдвэрлэсэн “Райан Файрби” гэдэг байв. Израилын энэ амжилтаас сэдэл авсан АНУ 1990–ээд оноос цэргийн ажиллагаанд нисгэгчгүй онгоц ашиглаж эхэлсэн.

1783 онд анхны нисэгчгүй онгоц буюу агаарын бөмбөлгийн тухай хэв загварынх нь хувьд авч үзвэл энэхүү төрөлд хамаарахгүй мэт боловч техникийн үүднээс агаарын бөмбөлөг нь хүний буюу нисгэгчийн удирдлага шаарддаггүй анхны онгоц байв. Joseph–Michel ба Jacques–Ytienne Montgolfier нар Францын Анноней хотноо нисгэгчгүй онгоц болох халуун агаарын бөмбөлгийг олон нийтэд танилцуулав.

Нисгэгчгүй агаарын тээврийн илүү өнөөгийн өнгө төрхөө олсон цаг хугацааг 1914 оноос эхлэн ярих нь зүйтэй байна. Тухайн үед Дэлхийн I дайн ид өрнөж байсан ба Их Британийн генерал Кадер, Пичер нар Британийн цэргийн нисэхийн академид нисгэгчгүй, радиоогоор удирддаг, дайсны зорилтот бүс дээгүүр нисэж, тэрхүү жижиг онгоцоороо буудах, дэлбэлэх боломжтой, жижиг онгоцыг зохион бүтээх санал тавив. Энэхүү санаа тухайн үеийн Британийн цэргийн нисэхийн холбооны дарга Сэр Дэй Хендерсонд таалагдсанаар хүлээн авсан гэдэг. Тэрээр профессор А.М.Луо зэрэг хэсэг хүмүүсийг удирдан судалгаа, хөгжүүлэлт хийж эхлэв.

Нисгэгчгүй Агаарын Тээврийн үүслийг түүхэн үечлэлд хуваан авч үзвэл:

1. 1849 он–20–р зууны эхэн үе – Нисгэгчгүй агаарын тээвэр бүтээх оролдлого, туршилтууд, аэродинамикийн онолын үндэс суурийг бүрдүүлэх, эрдэмтдийн бүтээлүүдэд нислэгийн онол, нисэх онгоцны тооцоолол хийж байсан үе.

2. 20–р зууны эхэн үе – 1945 он – Цэргийн зориулалттай нисгэгчгүй онгоцнууд (богино тусгалтай, нислэгийн үргэлжлэх тодорхой

хугацаатай нисэх онгоц–пуужин) бүтээгдсэн үе.

3. 1945–1960 он– Нисгэгчгүй агаарын тээврийн ангиллыг зориулалтын дагуу өргөжүүлэх, төрөлжүүлэх тэдгээрийг ихэвчлэн тагнуулын ажиллагаанд зориулж бүтээсэн үе.

1950–иад оны дунд үед “AN/USD–1” нисгэгчгүй тагнуулын онгоц нь АНУ–ын түүхэн дэх анхны практикт амжилттай туршигдсан тагнуулын онгоц байв. Тэрхүү тагнуулын онгоц нь цэргийн зориулалттай мэдээллийг цуглуулах зорилгоор өдрийн цагаар бичлэг хийх боломжтой камер эсвэл хэт улаан туяаны камертай угсрагдаж байв. 1959–1966 онд АНУ мөн хэд хэдэн тагнуулын онгоц хөгжүүлсэн боловч бүгд бүтэлгүйтсэн.

4. 1960 оноос өнөөдрийг хүртэл– Нисгэгчгүй агаарын тээврийн ангилал, сайжруулалтыг өргөжүүлж, цэргийн бус зорилт, нөхцөл байдлыг шийдвэрлэхэд олноор ашиглаж эхэлсэн үе.

АНУ 2001 онд Афганистанд “Аль Кайда” болон “Талибуудын” эсрэг цохилт өгч эхэлсэн. Энэхүү даалгаварт АНУ–ын цэргийнхэн хагас идэвхт лазертай, “Hellfire” хэмээх пуужингаар зэвсэглэгдсэн, бай руу автоматаар нисэх боломжтой “Predator” гэгч дроныг ашиглав.

Ингэснээр зөвхөн тагнуулын чиглэлээр даалгавар гүйцэтгэж байсан энгийн зориулалт, үйлдлээсээ халин гарч “хяналт тандалт явуулахын сацуу дайралт хийх” хоёр үйлдлийг нэгтгэсэн олон үйлдэлт байлдааны нисэх онгоц болгон өөрчлөгдсөн байна. “Predator” анх удаа газар дээрх байг алсын зайнаас өндөр нарийвчлалтайгаар устгаж болно гэдгийг бодит байдалд жишээ болгон харуулсан. Афганистанд болсон дайны дараа нисгэгчгүй онгоцыг байлдааны талбарт шууд сөрөг дайралт хийж чадах зэвсэг болгон хэрэглэж ирсэн билээ.

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн ангилал

Нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийг:

–Удирдлагагүй

–Автомат

–Алсын нислэгийн гэж ангилж байна.

Жижиг тактикийн дрон

Тагнуул, тандалт, зорилтот бай илрүүлэлт,

тагнуулын чадавхыг сайжруулахад зориулан бүтээсэн. Энэ төрлийн дроны жишээ гэвэл: 12 орчим цагийн хугацаанд, 90 км–ийн зайд нисэх чадвартай хөнгөн жинтэй тагнуулын “FULMAR” дрон юм. “FULMAR” цувралыг бүхэлд нь Францын сансар судлалын үндэстэн дамнасан Thales компанийн дрон. Энэ ангиллын өөр нэг дрон бол Германы EMT компанийн үйлдвэрлэсэн “Аладин” бөгөөд ердөө 15 километрийн тусгалтай. Энэ ангиллын АНУ–ын армийн жижиг тактикийн дрон бол АНУ–ын AeroVironment компанийн үйлдвэрлэсэн “Raven” юм.

Дунд оврын тагнуулын дрон

Цэргийн нисгэгчгүй онгоцнуудын дийлэнх нь буюу Европын гадаад харилцааны зөвлөлийн нисгэгчгүй онгоцны шинжээч Улрике Эстер Франкийн хэлснээр “ажлын морьд” нь ISTAR–ийн зорилгоор ашигладаг дунд оврын, дунд зайн дронууд юм. Энэ ангиллын гол дронуудын нэг бол Израилын сансрын аж үйлдвэрийн (IAI) үйлдвэрлэсэн “Heron” гэх дрон юм. 1000 гаруй кг жинтэй, 16 метр далавчтай энэхүү дрон нь 10,000 метр (35,000 фут) өндөрт 52 цаг нисч чаддаг бөгөөд энэ нь иргэний нисэхийн онгоцтой ижил өндөрт нисч чаддаг гэдгээрээ давуу. АНУ, Канад, Энэтхэг, Турк, Австрали, Марокко улсууд бүгд тактикийн болон тагнуулын зориулалтаар “Herons”–ыг худалдаж авсан. Германы цэргийнхэн мөн Германы EMT Penzberg компанийн үйлдвэрлэсэн “LUNA”–г ашигладаг. Бундесвер 2000 оноос хойш Афганистан, Косовогийн нутаг дэвсгэрт хэдэн мянган цаг нислэг үйлдэж байсан энэхүү тагнуулын нисгэгчгүй онгоц нь “Heron”–оос хамаагүй хямд боловч түүний хамрах хүрээ нь 100 километр юм. Мөн Пакистан, Саудын Араб зэрэг улсууд энэхүү дроныг худалдаж авсан.

Том оврын байлдааны болон тагнуулын дрон:

Энэ ангилалд багтах дронуудаас хамгийн алдартай дроныг АНУ–ын ашигладаг ба удирдлагын төв нь АНУ–ын газар нутаг дээр байрлан хиймэл дагуулын холболтоор удирддаг байна. “Reapers”–ыг агаар болон



газрын янз бүрийн пуужингаар зэвсэглэсэн, 14 цаг тасралтгүй нислэг үйлдэх боломжтой дрон юм. АНУ-аас гадна НАТО-гийн бусад хэд хэдэн агаарын хүчин Их Британи, Испани, Франц, Нидерланд зэрэг "Reapers"-ийг батлан хамгаалах салбартаа ашигладаг. Хятадад үйлдвэрлэсэн CH-4 "Reaper"-тэй тун төстэй гэдэг ба Египет, Ирак зэрэг улсууд худалдаж авсан гэх мэдээлэл байдаг.

Цэргийн нисгэгчгүй онгоцнууд нь алсын удирдлагатай төхөөрөмж эсвэл өөрийн удирдлагатай байдаг. Удирдлагын горимоор нь:

1. радио алсын удирдлага,
2. автомат программын удирдлага,
3. иж бүрэн удирдлага гэсэн гурван төрөлд хувааж болно.

Нисгэгчгүй агаарын тээвэр хэрхэн ажилладаг вэ?

Дрон нь нислэгийн горим, навигаци гэсэн хоёр үндсэн үүрэгтэй.

Нисэхийн тулд дронд зай эсвэл түлш гэх тэжээлийн эх үүсвэртэй байх ёстой. Дрон нь мөн ротор, сэнс, хүрээтэй. Дроны хүрээ нь түүний жинг багасгаж, маневрлах чадварыг нэмэгдүүлэхийн тулд ихэвчлэн хөнгөн, нийлмэл материалаар хийгдсэн байдаг.

Нисгэгчгүй оноцуудыг алсаас удирдахдаа тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн /оператор/ удирдах бөгөөд энэ нь операторыг дроныг хөөргөх, жолоодох, газардуулахын тулд алсын удирдлага ашиглах тэрхүү нөхцөлийг бий болгодог.

2. АРТИЛЛЕРИЙН ДИВИЗИОНЫ БАЙЛДААНД НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙГ ХЭРЭГЛЭСЭН ТУРШЛАГА, ТАВИГДАХ ШААРДЛАГА, СУРГАМЖ

Артиллерийн тагнуул бол артиллерийн байлдааны ажиллагааны хангалтуудын чухал төрөл мөн.

Дайсанд шаардагдах галын хөнөөл үзүүлэхийн тулд цаг тухайд нь дайсан ба газар орны тухай мэдээг олж авах үүднээс бусад төрлийн цэргийн тагнуултай нягт харилцан ажиллагаатайгаар тагнуул явуулна.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглан Үүнд:

- Тагнуул үйлдэх
- Үндсэн чигийг тодорхойлох
- Целийн чигийг хэмжих
- Үндсэн чиг целийн хоорондох өнцгийг хэмжих

- Целийн фронтын өргөнийг хэмжих
- Тэсрэлтийн өндөр хазайлтыг хэмжих

Артиллерийн системд байлдааны ажиллагаанд нисгэгчгүй нисэх хэрэгсэл зайлшгүй шаардагдах ба тагнуулд үйлчлэх, шийдвэр гаргах үйл явцыг хурдасгах, их бууны галын нарийвчлалыг нэмэгдүүлэх, галыг хянаж, дайсны гүнд тагнуул үйлдэх, дайсны байрлалтын районыг 3D болгон дижитал газрын зургийг бий болгодог онцлог шинж чанартай.

Артиллерийн анги салбар нисгэгчгүй нисэх хэрэгсэл хэрэглэсэн тохиолдолд давшилт (хориглолт)-ийн үед өөрийн батарей (дивизион)-г давшилтын галын эрчмийг нэмэгдүүлэх, гал тасалдахгүй байх, байнга галыг хянаж засварлах, галын бүтээмж, нягтралыг дээшлүүлж, ажиллагааны бодлогыг тодорхойлох, зэргэлдээх салбарыг тагнуулын мэдээгээр хангадаг.

Украин Bayraktar TB2 болон DJI зэрэг хямд өртөгтэй дронуудыг ашиглан Оросын байрлалын мэдээллийг илрүүлж, урьдчилан цохилт өгөхөд ашиглаж байна.

Украины цэргийн гол нисгэгчгүй нисэх хэрэгсэл бол Турк улсад үйлдвэрлэсэн Bayraktar TB2 юм. Энэ нь жижиг онгоцны хэмжээтэй ойролцоо камертай, лазераар удирддаг бөмбөгөөр зэвсэглэх боломжтой.



Зураг 1.



Зураг 2

1 дүгээр зураг. Нисгэгчгүй нисэх хэрэгслээр артиллерийн тагнуул үйлдэх хувилбар.

2 дугаар зураг Нисгэгчгүй нисэх хэрэгслийн операторт хянагдах байдал.

Тактикийн сургамж: Эрсдэлтэй байршлуудыг илрүүлэх: Нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашигласнаар урьдчилан тагнуулын мэдээ



цуглуулах нь байлдааны амжилттай ажиллагааг хангаж байна.

Орон зай, цаг хугацааны давуу тал: Хурдан хөдөлгөөн хийх, хариу арга хэмжээ авах боломжийг нэмэгдүүлж байна.

Бага өртөгтэй дайралт: Хямд өртөгтэй дронуудыг өргөнөөр ашиглах нь өртөг багатай томоохон хохирол учруулах арга зам болж байна.

Техникийн сургамж:

Цахим дайн: Нисгэгчгүй нисэх хэрэгслийг системүүд (электрон саад тавих төхөөрөмж) нь дронуудыг амархан сулруулж болохыг харуулсан.

Нөөц хангамж: Дронууд ихэвчлэн эвдрэх, устгагдах магадлалтай тул тогтмол хангалт хэрэгтэй.

ажиллагааны хугацааг багасгах, хохирлыг бууруулахад чиглэгдсэн давуу талтай юм.

Сүүлийн жилүүдэд болж буй цэргийн мөргөлдөөн нь цэргийн ажиллагаа явуулахад шинэ хандлагын үр нөлөөг харуулж байна. Үүний үр дүнд ухаалаг зэвсгийг бүтээх сүүлийн үеийн ололт амжилтыг харгалзан хөгжлийн шинэ хандлагыг боловсруулсан бөгөөд үүнийг тактикийн түвшинд ашиглах нь дайсны зорилтот байдлын талаарх цаг тухайд нь, найдвартай, үнэн зөв, бүрэн гүйцэд тагнуулын мэдээлэлд тулгуурлаж байна.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглан олж авсан тагнуулын мэдээл нь их буу, миномётын галын боломжийг нэмэгдүүлэх боломжтой болсон.

Артиллерийн цэрэгт ННХ хэрэглэсэн туршлага, сургамж

Улс	ННХ төрөл	Үүрэг	Туршлагын онцлог	Жишээ
Украйн	Bayraktar TB2, DJI Matrice, Punisher	Тагнуул, довтолгооны удирдлага	Артиллерийн цель тодорхойлох, тасралтгүй хянах, пуужингийн гал засварлах	Оросын армийн тээвэрт хохирол учруулсан
ОХУ	Орлан-10, Ланцет, Форпост	Цель тагнах, гал засварлах, цохилт	Артиллерийн системд мэдээлэл дамжуулах, цель тодорхойлох, байг чиглүүлэх	Украины барилгын байгууламж руу довтолж ашигласан
АНУ	MQ-9 Reaper, Switchblade	Байг тодорхойлох, цохилтын хяналт	Нарийвчилсан ISR ажиллагаа, артиллерийн урьдчилсан болон дараах хяналтыг хийх	Афганистан, Сирид ашигласан
Турк	Bayraktar TB2	Тагнуул, байг чиглүүлэлд	Хямд өртөгтэй, өндөр үр ашигтай, артиллерийн дайралтад байг илрүүлэхэд түлхэц өгсөн	Карабахын тулаанд үр дүнтэй ашигласан

Аюулгүй байдлын сургамж:

Хямд өртөгтэй дронууд дайсанд олзлогдох магадлалтай тул баталгаажуулалт, хамгаалалт, шифрлэлтийн чанарыг сайжруулах шаардлагатай.

Артиллерийн салбарын буудлагад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах боломж, онцлог

Артиллерийн дивизионы буудлагад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах боломж, онцлог нь орчин үеийн байлдааны ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болоод байна.

Энэ нь артиллерийн галын үр ашиг, нарийвчлалыг нэмэгдүүлэх, байлдааны

Орос-Украины цэргийн ажиллагааны туршлагаас харахад нисгэгчгүй нисэх хэрэгслийг артиллерт хэрэглэхэд 1-2 оператор шаарддаг бөгөөд энэ нь орон тоо болон үүрэг гүйцэтгэх боломжид сөргөөр нөлөөлдөггүй.

Зарим ННХ нь хөөрөх, буухад тусгайлан тоноглогдсон талбай, нэмэлт төхөөрөмж шаарддаггүй чухал давуу онцлог бөгөөд нислэгийн үеэр "өндөрөө авах" чадвар их байдаг байна.

Тагнуул, тандалт

Байршил илрүүлэх: ННХ нь дайсны байрлал, хөдөлгөөн, зэвсэгт хүчин болон логистикийн шугамыг илрүүлж, артиллерийн цохилтын байг



нарийвчлалтай тогтоох боломжийг олгодог.

Тасралтгүй хяналт: Довтолгооны өмнө болон дараа байдал өөрчлөгдөхийг бодит цагт ажиглах чадвартай.

Галын үр дүнг хянах

ННХ нь артиллерийн галын дараах үр дүнг дүгнэж, шаардлагатай бол гал засварлах боломжийг олгодог. Ингэснээр илүү оновчтой буудлага хийх боломжийг бүрдүүлдэг.

Цахим аюулгүй байдлын туслалцаа

ННХ нь радио дохио болон цахим системийг хянан, дайсны холбооны ажиллагааг алдагдуулахад чухал үүрэг гүйцэтгэж болно.

Хөдөлгөөнт байлдааны давуу тал

Хөнгөн жинтэй, хурдан хөдөлгөөнт дронууд нь өөрийн байрлалыг солих артиллерийн ангиудад дэмжлэг үзүүлж, дайсны эсрэг хариу арга хэмжээ авахад тагнуул, гал засварлах, шилжилт хийх боломжийг олгодог.


Зардал хэмнэлт

Харьцангуй бага өртөгтэйгөөр (жишээ нь, арилжааны зориулалттай DJI болон илүү өндөр хүчин чадалтай Bayraktar TB2 гэх мэт) ашиглах боломжтой тул зардлын хувьд хэмнэлттэй.

Гал засварлах нэг дэхь арга: Нисгэгчгүй нисэх хэрэгсэл хэрэглэж буудлага гал удирдахдаа целийг илрүүлж “үндсэн буунаас” нэг сум томилно. Засварыг хүлээн авсны дараа целээс хазайсан тэсрэлтийн хазайлтыг оруулж засварын зөрүүг нүдэн багцаамжаар тодорхойлж, 2 дох буудалтыг үндсэн буунаас өгдөг. Энэ нь целд онолт авагдах хүртэл буюу байгаас 100 метрээс бага радиус дотор хийгддэг.

Онолт авагдсаны дараа сөнөөлтийн буудлагад шилждэг.

Эхний команд: "Онон" Би "Зөгий" цель 215–т гал нээсэн. Явган цэрэг $x=46300$, $y=64700$, өндөр 120. Дарах. Нийлсэн зэрэгцээгээр.



Зураг 3. Сумны хазайлтыг засварлах хувилбар.

Засварыг оператор илтгэхдээ Зүүний 300, хойд +100. Гэж засварыг галт байр руу илтгэнэ. Тэсрэлтийн хазайлт авсан галт байр холын зай, эргүүлэх өнцөг, өндөр өгөгдсөн тохиолдолд тэгшлүүрийн засварыг галлана.

Хоёр дахь арга: "Нисгэгчгүй нисэх хэрэгсэл тухайн целийн дээгүүр яг нисэх ёстой бөгөөд энэ үед оператор түүний координатыг авах боломжтой болно.

Нарийвчлал нь навигацийн системийн хүчин чадал хурдаас хамаарна. Зарчмын хувьд артиллерийн буудлага UAV–д тохиромжтой.

Гурав дахь арга: Холын зай хэмжигч ашиглах. Лазер зай хэмжигч бүхий тогтворжуулсан оптик–электрон системийг өгөгдөл болгон ашигладаг. Навигацийн системээс UAV координатууд байдаг ба UAV–тай харьцуулахад целийн туйлын координатууд байдаг (хүрээ нэмэх өнцөг). Нарийвчлал нь навигацийн төхөөрөмжийн чанар байдал хүчин чадлаас хамаарна. "Илрүүлэх – шийдвэр гаргах" мөчлөгийн хугацаа богино, хэд хэдэн цельд хяналт үйлдэж гал засварлаж хэд хэдэн их бууны батарей (дивиз) –ийн галыг нэгэн зэрэг хянах боломжтой.

Юуны өмнө цаг хугацаа хязгаарлагдмал үед энэ арга нь олон целийн мэдээллийг боловсруулах боломжгүй, ялангуяа сөнөөлтийн буудлага, түүнийг хянах засварлах үед, целийг илрүүлэх, шийдвэр гаргах, цель дарах хугацаа урт байна.

Түүнчлэн түүний эмзэг байдал дайны районд агаарын довтолгооноос хамгаалах хамгийн бага хүчин чадалтай дайсантай тулгарвал нисгэгчгүй нисэх хэрэгсэл удаан хугацаанд ажиллах боломжгүй болно.

Туршлагаас харахад Украинчууд Оросын командын байр, артиллерийн батарей, электрон байлдааны систем, зэвсгийн агуулахын



Зураг 4. ННХ–ийг хөөргөх үеийн операторын ажиллагаа



координатыг илрүүлэхийн тулд тагнуулын нисгэгчгүй нисэх хэрэгслээ байрлуулсан. Дараа нь барууны орнуудаас нийлүүлсэн пуужингийн системүүд тус бай руу харвах үед нисгэгчгүй нисэх хэрэгслүүд дахин нисч, пуужин болон артиллерийн галыг бодит цаг хугацаанд дахин чиглүүлж эсвэл цөлээ онож байсан эсэхийг баталгаажуулж байсан. Зарим тохиолдолд байлдааны нисгэгчгүй нисэх тээврийн хэрэгслүүд өөрсдөө цохилт өгдөг¹.

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙН ДАВУУ ТАЛ

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл өндөр эрсдэлтэй даалгаварт нисгэгчийн амь насыг эрсдэлд оруулахаас сэргийлсэн.

Лазер чиглүүлэгчтэй мэдрэгч нэмэгдэж байгааг харгалзан үзвэл энэ нь маш хэрэгтэй систем юм.

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн операторууд илүү мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжтой, шийдвэр гаргах хугацааг богинсгож, алсаас ажиллуулах нь барьцаалагдах болон бусад хохирлыг багасгадаг.

Технологи тасралтгүй хөгжихийн хэрээр нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, хүний оролцоо багатай даалгавруудыг гүйцэтгэх боломжтой болж байна.

Артиллерийн буудлага, тагнуулд үйлчилж галын үр дүнг дээшлүүлж байна.

Цагийн байдал хүнд район руу нэвтрэх эрсдэлтэй даалгаварыг бууруулна.

Дроныг дэд бүтцийн шалгалт, мина илрүүлэх зэрэг ажилд ашигласнаар явган цэргүүд хохирол амсахгүйгээр газар орныг туулж байна. Бага, дунд оврын нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь хөөрөх, буухад нэмэлт тоног төхөөрөмж шаарддаггүй.

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙН СУЛ ТАЛ

Целийг эгц дээрээс хянахад илрэгдэх магадлалтай бөгөөд агаарын довтолгооны хамгаалах хэрэгсэлд хурдан өртдөг.

Артиллерийн батерейны алсын тусгалаас хамааран нисгэгчгүй нисэх хэрэгслэл нь ихэвчлэн хязгаарлагдмал нислэгтэй байдаг. Бага, дунд оврын нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь байгалийн хүчин зүйлсээс хамаардаг. Манан, салхи гэх мэт.

ДҮГНЭЛТ

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (ННХ)-ийн хөгжил нь артиллерийн байлдаанд стратегийн болон тактикийн түвшинд томоохон өөрчлөлт авчирч байна. Энэ нь артиллерийн цэргүүдийн байлдааны үр дүн, галын нарийвчлал, байлдааныг удирдахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь хямд өртгөөр нь их хэмжээний зардлыг хэмнэж, өвөр эгнээ, дайсны гүнд хүртэл цэргүүдэд бие махбодын болон сэтгэл зүйн байнгын аюул занал учруулж ялалтад хүргэх нөлөө үзүүлж байна.

Түүнчлэн нисдэг тэрэгний тусламжтай хийх тогтоол буудлагатай хийх буудлагатай харьцуулахад хямд өртгөөр эрсдэл багатайгаар цель солбих, тагнуулд үйлчлэх, гал засварлах, тактикийн арга ажиллагаанд өргөнөөр ашиглаж байна.

Манай Улсын Зэвсэгт хүчин нисгэгчгүй нисэх хэрэгслийн тоотыг тайван цаг, байлдааны цагийн орон тоонд шинэчлэн оруулж артиллерийн зэвсэглэл, техникийн боломжид тааруулан ашиглах нэн тэргүүний шаардлага тулгарч байна.

Ирээдүйд нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь автоматжсан /робот/ зонхилсон байлдааны гол бүрэлдэхүүн хэсэг болж артиллерийн байлдааны үр дүн, галын нарийвчлалыг нэмэгдүүлэх төлөв ажиглагдаж байна.

¹ http://militera.lib.ru/regulations/russr/1984_bu-vdv/08.html

**Ашигласан материал:**

1. "ИНД-101. Иргэний Нисэхийн Багц Дүрэм- Жиро-Глайдер Ба Парасэйл, хүнгүй агаарын хөлөг (Бөмбөлөг, Дроныг Багтаасан), цаасан шувуу, пуужингийн үйл ажиллагааны дүрэм." <https://mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/01/IND-101.pdf>.
2. ЗАЙНААС УДИРДДАГ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА – ИНЕГ. (2018, April 4). Иргэний нисэхийн ерөнхий газар, from <https://www.mcaa.gov.mn/?p=1294>
- 1.Авиация ВМФ России и научно-технический прогресс: Концепции А-20 создания, пути развития, методология исследований / В.М. Альховиков и др. –М:Дрофа, 2005г.
2. Беляев В.В., Ильин В.Е. Российская современная авиация. – М.: АСТ, «Астрель», 2001. – 320 с.
1. Zavrnsnik, A. (2018). Drones and Unmanned Aerial Systems Legal and Social Implications for Security and Surveillance. Springer International Publishing.
2. McNamee, W. (2013). "WILL I BE NEXT?" Amnesty International USA. from <https://www.amnestyusa.org/files/asa330132013en.pdf>
3. <https://breakingdefense.com/2023/12/high-tech-trench-warfare-5-hard-won-lessons-learned-for-the-us-from-ukraine/>
4. https://www.wilsonquarterly.com/quarterly/_do-drones-contradict-lessons-from-centuries-war



ХАМГААЛАЛТЫН IP, MIL-STD810-СТАНДАРТУУД

Т.ЭНХЗАЯА /ҮБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн ахлах багш, магистр/
Ц.БЯМБАЦОГТ /ҮБХИС, ЦНДС-ийн ЦХКАБТ-ийн ахлах багш, магистр/

Түлхүүр үг: Хамгаалалтын IP стандарт, MIL-STD 810 (Military Standart) стандарт

Key words: IP (Ingress Protection), MIL-STD 810 (Military Standart)

Оршил

Орчин үеийн тоног төхөөрөмжүүд, тухайлбал, радиостанц, гар утас нь хамгаалалтын IP (Ingress Protection), MIL-STD 810 (Military Standart) стандартуудад нийцсэн байх ёстой.

IP гэдэг нь төхөөрөмжийн эд ангиудыг хатуу биет болон ус нэвтрэхээс хамгаалах түвшнээр ангилдаг олон улсын стандарт юм.

Цэргийн стандарт MIL-STD-810 нь АНУ-ын Батлан Хамгаалах Яамнаас цэргийн тоног төхөөрөмжид зориулан боловсруулсан цуврал туршилтын стандарт юм. Тоног төхөөрөмжийн найдвартай байдал, удаан эдэлгээтэй байгаа эсэхийг тодорхойлохын тулд үйл ажиллагааны тодорхой хугацаанд нь загварчилсан янз бүрийн хүндэвтэр нөхцөлд туршиж үзсэн.

ОХУ-д үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж нь хамгаалалтын зэрэг ГОСТ-д (Государственный стандарт, улсын стандарт) нийцсэн.

Үндсэн хэсэг

IP гэдэг нь олон улсын хамгаалалтын тэмдэг бөгөөд эд ангиудын хамгаалалтын зэрэглэлийн кодыг IP болон хоёр тоо ашиглан тэмдэглэдэг: эхний тоо хатуу биет, 2 дэх тоо ус нэвтрэхээс хамгаалахыг заана.

Код нь IPXX гэж харагдана, X байрлал дээр тоонууд бичигдэнэ (Хүснэгт 1). Тоонуудын араас нэмэлт мэдээлэл өгдөг 1-2 үсэг бичигдсэн байж болно.

1 дүгээр хүснэгт.

IP СТАНДАРТ

Хатуу биет болон тоосонцрын хамгаалалт	
IP эхний тоо (Xx)	Хамгаалалтын төрөл
0	Хамгаалалт байхгүй
1	50 мм ба түүнээс дээш хэмжээтэй хатуу биетээс хамгаална
2	12.5 мм ба түүнээс дээш хэмжээтэй хатуу биетээс хамгаална
3	2.5 мм ба түүнээс дээш хэмжээтэй хатуу биетээс хамгаална
4	1 мм ба түүнээс дээш хэмжээтэй хатуу биетээс хамгаална

5	Тоосонцроос хэсэгчлэн хамгаалах
6	Тоосонцроос бүрэн хамгаалах
Усны хамгаалалт	
IP 2 дэх тоо (xx)	Хамгаалалтын төрөл
0	Хамгаалалт байхгүй
1	Босоо чиглэлтэй унаж буй усны дулаас хамгаална
2	15° өнцгөөр унаж буй дулаас хамгаална
3	60° өнцгөөр унаж буй дулаас хамгаална
4	Өнцөг үл хамааран цацарч буй уснаас хамгаална
5	Өнцөг үл хамааран урсаж буй уснаас хамгаална
6	Усны урсгалын динамик нөлөөнөөс хамгаална далайн давлагаа
7	Тодорхой гүн бүхий усанд 30 мин турш гэмтэхгүй байх
8	Тодорхой гүн бүхий усанд хугацаанаас үл хамааран гэмтэхгүй байх

Цахилгаан болон бага гүйдлийн утаснуудын холболтын цэгүүдийг механик гэмтэл, тоос шороо, чийгээс (дотор болон гадаа) хамгаалахын тулд тусгай хамгаалалтын зэрэгтэй хайрцаг ашигладаг (Зураг 1-3).



1 дүгээр зураг. IP 54 хамгаалалтын зэрэгтэй



2 дугаар зураг. IP 55 хамгаалалтын зэрэгтэй холболтын хайрцаг



3 дугаар зураг. IP 65 хамгаалалтын зэрэгтэй холболтын хайрцаг

Сүүлийн үеийн радиостанцууд ихэвчлэн IP 64–68 хамгаалалтын түвшинтэй байна. Одоогийн байдлаар хамгаалалтын хамгийн дээд зэрэг нь IP 69–K бөгөөд энэ нь уг төхөөрөмж халуун усаар, өндөр даралттай угаалтыг тэсвэрлэх чадварыг заадаг.

Цэрэг болон иргэний зориулалтаар өргөнөөр ашиглаж байгаа зарим нэгэн радиостанцуудын хамгаалалтын зэргийг хүснэгт №2–т харуулав.

2 дугаар хүснэгт .

Зарим нэгэн радиостанцуудын хамгаалалтын түвшин

Радио-станцын нэр/ Үйлдвэрлэсэн улс	Хамгаалалтын зэрэг	Тайлбар
“Motorola” DP1400 (АНУ)	IP54	Тоосонцроос хэсэгчлэн болон өнцөг үл хамааран цацарч буй уснаас хамгаалагдсан
“Kenwood” NX-3220/ (Япон)	IP55	Тоосонцроос хэсэгчлэн болон өнцөг үл хамааран урсаж буй уснаас хамгаалагдсан
“Hytera” PD-785 (Хятад)	IP57	Тоосонцроос хэсэгчлэн хамгаалагдсан, тодорхой гүн бүхий усанд 30 мин турш гэмтэхгүй байх чадвартай
ТЕРЕК РК-322 (ОХУ)	IP66	Тоосонцроос бүрэн болон усны урсгалын динамик нөлөөнөөс хамгаалагдсан
“Азарт”187 П1Е (ОХУ)	IP67	Тоосонцроос бүрэн хамгаалагдсан, тодорхой гүн бүхий усанд 30 мин турш гэмтэхгүй байх чадвартай
“Harris” (АНУ)	IP67	
“Motorola” DP4801E (АНУ)	IP67	
SDR 7200NH (Израил)	IP67	Тоосонцроос бүрэн хамгаалагдсан, тодорхой гүн бүхий усанд хугацаанаас үл хамааран гэмтэхгүй байх
“Anytone” AT-D878UV (Хятад)	IP68	
“Kirisun” DP 990 UHF (Хятад)	IP68	

ОХУ–д ашигладаг ГОСТ буюу улсын стандартын тайлбарыг хүснэгт № 3–5–т харуулав. IP–ийн адил эхний тоо хатуу биет, 2 дэх тоо ус нэвтрэхээс хамгаалахыг заана.

3 дугаар хүснэгт

Эхний тоогоор тэмдэглэгдсэн аюултай хэсгүүдэд нэвтрэх хамгаалалтын түвшин

Эхний тоо	Хамгаалалтын түвшин	
	Товч тайлбар	Тодорхойлолт
0	Хамгаалалт байхгүй	—
2	Хүнийг аюултай хэсгүүдэд гарынхаа араар хүрэхэд хамгаална (5.1–р зүйл, ГОСТ 14254–2015).	Сорьцын биет – 50 мм–ийн диаметртэй бөмбөрцөг нь аюултай хэсгүүдээс хангалттай зайд байх ёстой.
3	Хүнийг аюултай хэсгүүдэд хуруугаараа хүрэхэд хамгаална (5.1–р зүйл, ГОСТ 14254–2015).	12 мм диаметртэй, 80 мм урттай Туршилтын нугасны зүү нь аюултай хэсгүүдээс хангалттай зайд байх ёстой
4	Аюултай хэсгүүдэд ямар нэгэн хэрэгсэл хүрэхээс хамгаалагдсан (5.1–р зүйл, ГОСТ 14254–2015).	2.5 мм–ийн диаметртэй сорьцын биет – бүрхүүл дотор нэвтрэх ёсгүй
5	Аюултай хэсгүүдэд металл утас хүрэхээс хамгаалагдсан (5.1–р зүйл, ГОСТ 14254–2015).	1.0 мм–ийн диаметртэй сорьцын биет – бүрхүүл дотор нэвтрэх ёсгүй

4 дүгээр хүснэгт

Эхний тоогоор тэмдэглэгдсэн гаднын биет болон тоос нэвтрэхээс хамгаалах түвшин

Түвшин	Хамгаалалтын түвшин	
	Товч тайлбар	Тодорхойлолт
0	—	Хамгаалалт байхгүй
1	≥ 50 мм–ийн хэмжээтэй хатуу биетээс хамгаалагдсан (5.2–р зүйл, ГОСТ 14254–2015)	Сорьцын биет – 50 мм–ийн диаметртэй бөмбөрцөг – бүрэн нэвтэрч болохгүй
2	≥ 12.5 мм–ийн хэмжээтэй хатуу биетээс хамгаалагдсан (5.2–р зүйл, ГОСТ 14254–2015)	Сорьцын биет – 12.5 мм–ийн диаметртэй бөмбөрцөг – бүрэн нэвтэрч болохгүй (5.2–р зүйл, ГОСТ 14254–2015).
3	≥ 2.5 мм–ийн хэмжээтэй хатуу биетээс хамгаалагдсан (5.2–р зүйл, ГОСТ 14254–2015)	Сорьцын биет – 2.5 мм–ийн диаметртэй бөмбөрцөг – бүрэн эсвэл хэсэгчлэн нэвтэрч болохгүй (5.2–р зүйл, ГОСТ 14254–2015).



4	≥ 1.0 мм-ийн хэмжээтэй хатуу биетээс хамгаалагдсан (5.2-р зүйл, ГОСТ 14254-2015)	Сорьцын биет – 1.0 мм-ийн диаметртэй бөмбөрцөг – бүрэн эсвэл хэсэгчлэн нэвтэрч болохгүй.
5	Тоосноос хамгаалагдсан	Зарим нэгэн тоос тоосонцор нэвтэрч орох боломжтой боловч энэ нь төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлөхгүй.
6	Тоос нэвтрэхгүй	Тоос тоосонцор төхөөрөмжид нэвтрэх боломжгүй.

5 дугаар хүснэгт

2 дэх тоогоор тэмдэглэгдсэн уснаас хамгаалах түвшин

Түвшин	Хамгаалалтын түвшин	
	Товч тайлбар	Тодорхойлолт
0		Хамгаалалт байхгүй
1	Босоо дуслуудаас хамгаалагдсан	Босоо дуслууд ус нь төхөөрөмжийн үйл ажиллагаанд саад болохгүй
2	15° өнцгөөр босоо унах дуслуудаас хамгаалагдсан	Төхөөрөмжийг 15° хүртэл өнцгөөр хазайлгахад босоо унах дуслууд саад болохгүй
3	Доошоо цацарч буй дуслуудаас хамгаалагдсан	Борооны хамгаалалт. Борооны цацарч буй ус нь босоо чиглэлд эсвэл 60° хүртэл өнцгөөр унана
4	Цацарч буй уснаас хамгаалагдсан	Цацарч буй уснаас бүх чиглэлд хамгаална
5	Усны урсгалаас хамгаалагдсан	30 кПа даралттай усны урсгалаас хамгаалагдсан (6.3 мм цорго).
6	Усны хүчтэй урсгалаас хамгаалагдсан	100 кПа даралттай усны хүчтэй урсгалаас бүх чиглэлд хамгаалагдсан (12,5 мм цорго)
6к	Өндөр даралттай усны хүчтэй урсгалаас хамгаалагдсан	1000 кПа даралттай усны хүчтэй урсгалаас бүх чиглэлд хамгаалагдсан (6,3 мм цорго)
7	Богино хугацаагаар 1 минутаас ихгүй, 1 м хүртэлх гүн усанд дүрэх нөлөөллөөс хамгаалагдсан	Богино хугацаагаар усанд дүрэхэд ус нь төхөөрөмжийн ажиллагаанд саад болохуйц хэмжээгээр ордоггүй
8	1 метрээс илүү гүн усанд 30 минутаас дээш дүрэх нөлөөллөөс хамгаалагдсан (6-р зүйл, ГОСТ 14254-2015)	Усанд дүрсэн байдалд ажиллах боломжтой. Гэхдээ зарим төрлийн тоног төхөөрөмжийн хувьд ус нэвтэрсэн ч төхөөрөмжийн ажиллагаанд саад учруулахгүй

9	Халуун уснаас хамгаалагдсан	Өндөр даралттай, халуун усаар угаах боломжтой
9к	Халуун усны хүчтэй урсгалаас хамгаалагдсан	Өндөр даралттай халуун ус ойрын зайнаас цацагдахад хамгаалагдсан

P-107M радиостанцын стандарт болох ГОСТ-ыг дараах байдлаар тодорхойлсон байна:

1. Радиостанц нь цаг уурын ямар ч нөхцөлд –40 хэмээс +50 хэм хүртэл, агаарын чийгшил 98%-д ажиллах чадвартай;

2. Радиостанц нь бороонд тэсвэртэй, 0.5 м-ийн гүнд 1 цагийн турш байж чадна;

3. Радиостанц нь ямар ч зам дээр 50 км/цаг хүртэл хурдтай явж байх үедээ чичиргээ сэргрэлтэд тэсвэртэй байна.

Америкийн цэргийн стандарт MIL-STD-810

MIL-STD-810 нь тухайн тоног төхөөрөмж халуун, хүйтэн орчин, тоос шороо, доргио чичиргээ гэх мэт ажлын хүнд нөхцөлд хэвийн ажиллаж чадна гэсэн олон улсын шалгуур үзүүлэлт юм.

MIL-STD-810C стандартыг анх 1960-д онд боловсруулсан бөгөөд цаашид шинэ туршилтууд нэмэх бүрийд үсгийн дараалалтыг бас нэмж байсан. Тухайлбал, 1983 онд- D, 1989 онд- E, 2000 онд- F, 2008 онд- G. Стандартыг дурдах үед үсгүүдийг ихэвчлэн жагсааж бичдэг, тухайлбал, (MIL-STD C/D/E/F/G нийцэх).

Хамгийн сүүлчийн хувилбар болох MIL-STD-810G-ийг 2008 оны 10-сарын 31-д боловсруулсан бөгөөд одоог хүртэл үйлчилж байна. MIL-STD-810G тоног төхөөрөмжийн найдвартай байдлын тодорхой түвшинд баталгаажуулах ёстой. Энэ баталгааг авахын тулд аливаа тоног төхөөрөмж нь халуун, хүйтэн, цочрол, чичиргээ, чийгшил, тэр ч байтугай галт зэвсгээс хамгаалагдсаныг тодорхойлсон 29 тусгай туршилтын ядаж зарим нэгийг нь давсан ёстой (Хүснэгт 6).



6 дугаар хүснэгт

Mil– std– 810 сүүлчийн хувилбарт орсон сорилын жагсаалт

500.5	Бага даралт (Өндөр)	515.6	Дуу чимээ
501.5	Өндөр температур	516.6	Механик цочрол ба унах
501.5	Бага температур	517.1	Пиротехник цохилт
503.5	Дулааны цохилт	518.1	Хүчлийн нөлөөлөл
504.1	Шингэн зүйлээр бохирдох	519.6	Буу, зэвсэг
505.5	Нарны радиац	520.3	Температур, чийгшил, чичиргээ ба өндөр
506.5	Бороо	521.3	Хөлдөлт ба мөсдөлт
507.5	Чийгшил	522.1	Баллистик цохилт
508.6	Хөгц	523.3	Виброакустик/ Температур
509.5	Давсан манан	524	Хөлдөх–хайлах
510.5	Элс ба шороо	525	Хуулбарлах дохио
511.5	Дэлбэрэлтийн долгион	526	Төмөр замын нөлөөлөл
512.5	Битүүмжилсэн байдал	527	Өөр өөр тэнхлэгийн дагуух чичиргээ
513.6	Механик хурдасгуурт тэсвэртэй байх	528	Усан онгоцны төхөөрөмжийн механик чичиргээ
514.6	Чичиргээ		

Цохих

Бүтээгдэхүүний бат бөх байдал нь ихэвчлэн уг бүтээгдэхүүнийг гэмтээж болзошгүй цохих

(ялангуяа олон удаа давтагдаж байгаа) эсвэл сэгсрэх (ялангуяа тээврийн хэрэгсэлд байрлуулсан) үйлдэлд тэсвэрлэх чадвараар тодорхойлогддог (Хүснэгт 7).

7 дугаар хүснэгт

Цохих нөлөөлөл

Нөлөөлөл	Шаардлага	Арга	Тайлан
Механик цохилт	Асаалттай үе: 20 г, 11 мс, полу–синусоид. Унтраас–тай үе: 40 г, 11 мс, полу–синусоид	516.5	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Бүтээгдэхүүний ажиллах чадвар алдагдаагүй
Сэгсрэх	75 г, 11 мс, полусинусоид	516.5	Сорилыг бүтээгдэхүүн тээврийн хэрэгсэлд бэхэлсэн байдалтай, ажиллаж байгаа үед тавина

Мс –(миллисек 1/1000 сек)

Чичиргээ

Бүтээгдэхүүний тогтмол чичиргээнд тэсвэртэй байх чадварыг тодорхойлдог. Байнгын чичиргээ нь процессорын ажлыг хөндөж бүтээгдэхүүнийг эвдрэлд хүргэж болно.

Эдгээр сорилыг бартаат зам туулах чадвартай машинд радиостанцыг суурилуулахад үүссэн бий болох нөхцөлд ойртуулан гүйцэтгэсэн байна (Хүснэгт 8).

8 дугаар хүснэгт

Цохих нөлөөлөл

Нөлөөлөл	Шаардлага	Арга	Тайлан
Чичиргээ – автомашины гадна	Байнгын чичиргээ 0.04g ² /Hz, 20Hz – 1000Hz–6dB /идэвх. 1000Hz – 2000Hz	514.5	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Бүтээгдэхүүний ажиллах чадвар алдагдаагүй.
Чичиргээ автомашин дотор	Бартаат зам туулах чадвар бүхий машинтай адил байх	514.5	Үйл ажиллагааны түр зуурын алдагдлыг хүлээн зөвшөөрнө, дараа нь хэрэглэгчийн оролцоогүйгээр сэргэнэ.

Таагүй нөхцөлд тэсвэртэй байх

Тоног төхөөрөмжийн тоос, чийгшилт, манан, давс, нарны туяанд тэсвэртэй байх чадвар (Хүснэгт 9).

9 дүгээр хүснэгт

Таагүй нөхцөлд тэсвэртэй байх

Нөлөөлөл	Шаардлага	Арга	Тайлан
Харьцангуй чийгшилт	Чийгшилтийн 0–95 % (+3/–5 %), 23°C – 60°C, 10 цикл, 48 цаг	507.4	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Төхөөрөмж дотор ус чийг нэвтрээгүй байна.
Нарны туяа	1120 В/м ² (355 Втu/фт ² /цаг) UVB 50°C, 24 цагаар 7 цикл	505.4	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаагүй үед явуулна. Төхөөрөмжийн гаднах байдлын өнгө алдалт болон эвдрэл тогтоогдоогүй.
Бороо	Бороотой салхи 10л.куб./цаг 4 цикл	506.4 Процедур I	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Төхөөрөмж дотор ус чийг нэвтрээгүй байна.



Бороо	Том дусал 7 гал/фт2/цаг	506.4 Процедур III (дусал)	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Төхөөрөмж дотор ус чийг нэвтрээгүй байна.
Элс ба тоос	Биетийн хэмжээ <149 мм, 10 ± 7 г/м3. Биетийн нягтрал 1.5 мск. Салхины хурд 8.9 мс	510.4 Процедур I (элсэн шуурга)	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Төхөөрөмж дотор элс болон тоос шороо нэвтрээгүй байна.
Манан ба давсны нөлөөлөл	5%-ийн давсны уусмал 48 цаг хүртэл, (2 цикл бүхий 12 нойтон цаг)	509.4	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Төхөөрөмж эвдрээгүй, ус чийг нэвтрээгүй.

Температур

Ажлын горимд температурын өөрчлөлтөд эсэргүүцэл үзүүлэх чадвар Хүснэгт 10).

10 дугаар хүснэгт .

Температурын нөлөөлөл

Нөлөөлөл	Шаардлага	Арга	Тайлан
Ажлын температур	-20°C + 60°C	501.4, 502.4	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Түр зуурын, үйл ажиллагааны хямрал болон мэдээллийн алдагдал тогтоогдоогүй.
Хадгалах температур	-40°C + 75°C	501.4, 502.4	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаагүй үед явуулна. Мэдээллийн алдагдал гараагүй.
Дулааны цохилт	> 1.5°C < 5°C/минут -20° C + 60° C	Сорил нэг циклийн турш явагдана	Сорилыг бүтээгдэхүүн ажиллаж байгаа үед явуулна. Түр зуурын үйл ажиллагааны хямрал болон мэдээллийн алдагдал тогтоогдоогүй.

(Эх сурвалж <http://rugged-smart.ru/>).

MIL-STD 810 гэрчилгээ нь IP68 ангиллын дагуу ус нэвтрэхээс хамгаалагдсан, өндөр цохилтод тэсвэртэй, 1.5 метрийн өндрөөс унах үед гаднах блок нь хагардаггүй гэдгийг заана.

Дүгнэлт:

1. Орчин үеийн тоног төхөөрөмжүүд, тухайлбал, радиостанц, гар утас нь хамгаалалтын IP (Ingress Protection), MIL-STD 810 (Military Standard) стандартуудад нийцсэн байх ёстой.

2. Сүүлийн үеийн радиостанцууд ихэвчлэн IP 64–68 хамгаалалтын түвшинтэй байна.

3. Одоогийн байдлаар хамгаалалтын хамгийн дээд зэрэг нь IP 69–K бөгөөд энэ нь уг төхөөрөмж халуун усаар, өндөр даралттай угаалтыг тэсвэрлэх чадварыг заадаг.

Одоо үед цэргийн Harris (АНУ), Aselsan (Турк), Barrett (Австрали) серийн радиостанцууд, PRC 999K (Өмнөд Солонгос), PRC-930 (Израиль), MIL-STD-810 C,D,E,F,G нийцэж байна.

Ашигласан материал:

1. "IP Rating – Ingress Protection Explained, Tansun". www.tansun.com. Retrieved 8 May, 2024.
2. Ingress Protection: The System of Tests and Meaning of Codes, archived from the original on 22 May 2013.
3. ГОСТ 14254— 2015 (IEC 60529:2013) степени защиты, обеспечиваемые оболочками (код ip) (iec 60529:2013, mod) межгосударственный совет по стандартизации, метрологии и сертификации (mrc) interstate council for standardization, metrology and certification
4. ГОСТ википедия
5. <https://en.wikipedia.org/wiki/MIL-STD-810>
6. MIL-STD-810A, Military Standard, Environmental Test Methods and Engineering Guidelines. Министерство обороны США (23 июня 1964). Дата обращения: 19 октября 2013. Архивировано 2 января 2022 года.
7. <http://rugged-smart.ru>



ЗЭВСЭГТ ТЭМЦЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА РАДИО ЭЛЕКТРОНИКИЙН ТЕХНОЛОГИ

Э.ЭРДЭНЭБИЛЭГ /Зэвсэгт хүчний -013р ангийн РЭТСТ-ийн ерөнхий зохион бүтээгч, магистр/
Д.ЭНХБААТАР /Зэвсэгт хүчний -013р ангийн РЭТСТ-ийн мэргэжилтэн, судлаач/

Түлхүүр үг: Тоон системийн хөдөлгөөнт радио, программ хангамжийн нийцэлтэй радио, хугацааны зориулалттай хувиргалт, байршил тодорхойлогч систем

Key words: Digital mobile radio, Software define radio, Time Division Multiple Access, European, Global positioning system

Оршил

Дэлхий дахины даяарчлалын хувьсал, олон улсын улс төр, цэргийн бодлогын өөрчлөлт, нийгэм эдийн засгийн зүй тогтлын онцлог, цэргийн шинжлэх ухаан ба зэвсэг, зэвсэглэлийн техник технологийн хөгжил дэвшилттэй уялдан орчин үед зэвсэгт тэмцлийг явуулах арга хэлбэр өөрчлөгдөн уламжлалын бус /онолын бус/ болсоор байна. Ирээдүйн дайн, зэвсэгт мөргөлдөөний үйл ажиллагаа нь өндөр технологиор дэмжигдсэн, түүнээс ялалт, үр дүн нь асар их хамааралтай байх нь тодорхой болсоор байна.

Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, кибер, автоматик, электроник, сансар, хэт авианы пуужин, дрон зэрэг технологийн хэрэглээ нь орчин үеийн дайн, тулаанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэхээр байгаа бөгөөд эдгээрийн технологийн хөгжүүлэлт, хэрэглээ нь цаашид мэдэгдэхүйц боловсронгуй болон нэмэгдэх төлөвтэй байна.

Дэлхийн тэргүүлэх цэрэг, стратеги судлалын зарим төвөөс гаргасан сүүлийн үеийн тайлан, мэдээлэлд ирээдүйн дайнд ялахын тулд аюулгүйн нөөц сүлжээ, дэвшилтэд электроник, квантын технологи, био инженеринг, сансрын технологи, хиймэл оюун ухаан, их хүчин чадалтай робот+дрон гэсэн голлох технологиудыг шаардлагын түвшинд хөгжүүлж, эзэмших зайлшгүй шаардлагатай байгаа талаар дурдсан байдаг. Өндөр технологийн хэрэглээ өргөн ашиглагдсан дайнд ялахын тулд нэгдүгээрт техник технологийн давуу тал үүсгэх, хоёрдугаарт байлдааны арга тактик оновчтой

байх, гуравдугаарт хүчний зохистой бүтэц зэргээс ихээхэн шалтгаалахаар байна.

Цэргийн шинжлэх ухаан, технологийн хамгийн сүүлийн үеийн шинэчлэл, өөрчлөлтийг нэвтрүүлсэн өндөр цэцтэй, хэт авианы буюу гиберсоник пуужин, нисгэгчгүй нисэх төхөөрөмж-дрон, электроник, автоматжуулалтад суурилсан зэвсэг техник, өгөгдөл мэдээллийн нэгдсэн систем, робот, хиймэл оюун ухаан, лазер, төвлөрсөн энергитэй зэвсгийн систем, кибер, мэдээллийн орон зайг зэвсэгт тэмцэл, сөргөлдөөнд өргөнөөр ашиглаж эхэллээ.

Аюулгүй байдлын бодлого-цэрэг-стратегийн шинэ сэтгэлгээний шилжилт, олон талт тактикийн урлагийн хөгжүүлэлтэд нийцсэн тэргүүлэх техник технологи бүхий зэвсэглэлжилтийн өнөө цагт “одоо-ирээдүй” үеийнхээ батлан хамгаалахын бодлого, түүндээ цэргийн техник технологи, инновацыг дэмжин хэрэглээнд бодлогоор тусган нэвтрүүлж чадаагүй улс орон зэвсэгт мөргөлдөөн, сөргөлдөөнд ялагдах магадлал нь цаг хугацаагаар өссөөр байх болно.

Өөрөөр хэлбэл цэргийн шинжлэх ухаан, техник технологийг хөгжүүлэгч улс орнууд дайн тулааны талбарт болон тухайн тэмцлийн хамаарал бүхий орон нутагт техник технологийн хөгжүүлэлтийн түвшин, бололцоог ашиглан, ашигтай байдлын хяналтаа тогтоон амжилтын давуу нөхцөл үүсгэх, харин шинэлэг техник технологи, түүний хэрэглээгээр бага хөгжүүлэлттэй нь зарим аюулгүй байдлын асуудалдаа хамгаалалтгүй болох эрсдэлтэй



тулгахаар байна.

Иймд цэргийн шинжлэх ухаан, техник технологийн өргөн хэрэглээ, инновац, хөгжүүлэлтийн талаар онцгой анхаарч, бодлогоор дэмжих нь зүйн хэрэг юм. Цэргийн шинжлэх ухаан, техник технологийн хөгжүүлэлтийн бодлогод хамаарах, “тактикийн түвшний удирдлага, үйл ажиллагаа”-ны холбоонд сүүлийн үед өргөн нэвтэрч байгаа радио электроникийн онцлох технологийн талаар зарим мэдээллийг толилуулъя.

Үндсэн хэсэг

ЦЭРГИЙН РАДИО, РАДИОЭЛЕКТРОНИКИЙН ТЕХНОЛОГИ “DMR, SDR”

Зэвсэгт тэмцлийн уламжлалт бус, гибрид хэлбэр, түүний олон талт динамик үйл ажиллагааны амжилтын эх үүсвэрийн үлэмж нөлөөллийн нэг нь электроникийн шинжлэх ухаан, радио, радиоэлектроникийн техник технологийн инновац хөгжүүлэлт, оновчтой

хэрэглээ ба радио, радиоэлектроник ба түүнд үндэслэсэн шинэлэг техник, технологийн тасралтгүй хөгжил дэвшил нь эд зүйлс, цогц системүүдийн ашиглалт хэрэглээний өргөн боломжийг нийгэм эдийн засгийн бүхий л салбарт бий болгосоор байна. Хиймэл оюун ухаан, автоматжуулалт, роботжуулалтын “хүч” нь орчин үеийн электроникийн технологийн хөгжлөөс ихээхэн хамаарч, цэргийн шинжлэх ухаан, туршилт судалгааны ололт нээлтүүдийн үндэслэлийн нэгэн чухал хэсэг болж байна.

Орчин үеийн радио холбооны техник хэрэгсэл үйлдвэрлэлээр тэргүүлэгч компаниудад ашиглагдаж байгаа голлох технологид DMR, TETRA, P25, NXDN, dPMR загварчлал орно. Радио холбооны техник хэрэгслийн үйлдвэрлэлд байгаа тэргүүлэх технологиудын товч мэдээллийг 1 дүгээр хүснэгтэд харуулав.

№	Технологи (протокол)	Стандарт	Суваг хоорондын зай	Үндсэн хэрэглээ	Хэрэглээний үндсэн чиглэл
1	DMR	ETSI	12.5 kHz(TDMA)	Үйлдвэр, цэрэг, тусгай салбаруудад,	Дуу, өгөгдөл, нягтруулсан мэдээ
2	TETRA	ETSI	25kHz (TDMA)	Нийтийн үйлчилгээ, аюулгүй байдлын сүлжээнд	Сүлжээ хоорондын транкинг дамжуулалт
3	P25	APCO	12.5/6.25 kHz	Аюулгүй байдлын сүлжээнд	Шифрлэлт, харилцан ажиллагаанд
4	NXDN	JVC Kenwood/ com	6.25kHz(FDMA)	Аж үйлдвэр, нийтийн хэрэглээнд	Өртөг бага, энгийн холбооны сүлжээнд
5	dPMR	ETSI	6.25kHz(FDMA)	Тусгайлан чиглэсэн зориулалтад хэрэгцээнд	Нягтруулсан сүлжээнд

1 дүгээр хүснэгт: Радио холбооны техник хэрэгслийн тэргүүлэх технологи

Зэвсэгт тэмцлийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн зориулалтай радио холбооны үйлдвэрлэлийн техник, технологид тоон технологийн DMR, SDR загварыг өргөн ашиглаж байна. “2025–2030 оны байдлаар цэргийн салбарын техник, технологийн инновац, хөгжлийн тэргүүлэх үйл ажиллагаа дараах 10 чиглэлд байхаар харагдаж байна” гэж энэ салбарт ажилладаг 1000 компанид явуулсан судалгаа, санал асуулгад гарчээ. Эдгээр технологийн үндсэн эх нь тоон технологи, электроникийн дэвшил, инновац–хөгжүүлэлт

гэж тэмдэглэсэн байна. Үүнд:

1. Хиймэл оюун ухаан;
2. Цэргийн техник технологийг дараагийн шатлалд хөгжүүлэн–шилжүүлэлт, /жишээ нь: радио, радио электроникийн технологи, түүнтэй адилтгах технологиудын хөгжүүлэлт/;
3. Робот, автоматжуулалтын техник, системчлэл;
4. Цэргийн зориулалттай интернэт юмс;
5. Кибер тэмцлийн технологи;
6. Нягтрал, нэгдлийн ачааллын технологи;
7. 5G систем;
8. Их өгөгдлийн ашиглалт, автомат анализ;
9. Блокчайн;



10. Дэвшилтэт технологийн үйлдвэрлэл / Жишээ нь: полимер, 3D, шинэлэг металль гм /

Цэргийн технологийн хөгжүүлэлтийн дээрх тэргүүлэх чиглэлүүд нь зэвсэгт тэмцлийн тактикийн түвшний талбарт бүхий л үйл ажиллагааны харилцан нөлөөллийг сайжруулах, электроник-автоматжуулалт-нууцлал болон үйл ажиллагааны хамрах хүрээний боломжийг өргөсгөх, хэсэгчилсэн үйл ажиллагааны тогтвортой, найдвартай цаг хугацаандаа хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх болно гэж дурдсан байдаг.


Тактикийн түвшний зэвсэгт тэмцлийн удирдлага, харилцан үйл ажиллагааны радио холбоо нь өгөгдөл, мэдээлэл солилцооны гол хэрэгсэл нь хэвээр байгаа бөгөөд “DMR” болон “SDR” технологийн тусламжтай хэрэглээ, зориулалтын олон хувилбарыг үүсгэж байна. Эдгээр технологиудын стандарт бүтэц, хэлбэржүүлэлтийн зарчим, зарим онцлогуудын талаар товч мэдээлэл харья.

“DMR” технологи гэж 12.5 кГц зурвасын өргөнтэй сувгуудыг ашигладаг хоёр талын радио холбоо үүсгэх, тоон системийн дуу хоолой, өгөгдлийн холбооны хөдөлгөөнт радио үүсгэлтийн товчлол юм. Энэ нь Time Division Multiple Access (TDMA) загварчлалыг ихэвчлэн ашигладаг бөгөөд давтамжийг 12.5мс цагийн зайд хуваах замаар ижил давтамж дээр хоёр тусдаа харилцан яриа оруулах боломжийг олгодог.


“DMR” технологид хэрэглээний гурван онцлог хэлбэр бий болоод байна. Нэгдүгээр хэлбэр: DMR төхөөрөмжийн хамгийн энгийн хэлбэр бөгөөд зөвшөөрөлгүй 446 МГц давтамжийн зурваст ажилладаг. Энэ нь төхөөрөмжүүдийн хооронд үндсэн дуут холбоо тогтоох боломжийг олгодог боловч давталт болон бусад нэмэлт функцуудыг дэмждэггүй. Хоёрдугаар хэлбэр: DMR технологийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэлбэр бөгөөд VHF, UHF зэрэг лицензтэй ердийн давтамжийн зурваст ажилладаг. Энэ хэлбэр нь дохионы давталт, хос цагийн холболтоор өгөгдөл дамжуулах зэрэг дэвшилтэт функцуудыг дэмжих боломжтой.

Гуравдугаар хэлбэр: Транкинг системийн үйл ажиллагаанд нийцсэн DMR технологийн хамгийн дэвшилтэт хэлбэр бөгөөд өндөр хүчин чадал, өргөн хүрээг хамарсан томоохон системд ашиглах боломж өндөр. Энэ нь олон дахин давтан дамжуулалтыг дэмждэг бөгөөд сүлжээний удирдлага, дуу хоолойн өндөр чанар, өгөгдөл шифрлэлт, нууцлалын өргөн боломж, GPS хянах зэрэг дэвшилтэт функцуудыг хамтатгаж болдог.

DMR технологийн ерөнхий бүтэц, дохионы ачаалал, аналог болон тоон системийн техник хэрэгслийн техникийн өгөгдөхүүний үзүүлэлтийн боломж, ялгаа, зарим онцлог харьцуулалтыг 1, 2 дугаар зураг, 2 дугаар хүснэгтэд үзүүлэв.



1 дүгээр зураг. DMR технологийн ерөнхий бүтэц



2 дугаар зураг. DMR технологи, дохионы ачаалал


№	Техник, өгөгдөхүүний үзүүлэлт	DMR, тоон, чигийн холболт	Аналоги сүлжээ, чигийн холболт	DMR, тоон, / Дамжруулалт	Аналоги сүлжээ, /Дамжруулалт
1	Нэгж хугацаанд үүсгэх сувгийн тоо	1	1	2	1
2	Хувь хэрэглэгчийг код-лон дуудлага явуулах	+	-	+	-
3	Бүлгээр дуудлага явуулах	+	+	+	+
4	Дугаар харгалзахгүй ослын дуудлага явуулах	+	-	+	-
5	Үсгэн мэдээлэл явуулах	+	-	+	-
6	Ирсэн дуудлагыг дугаарлах	+	-	+	-



2 дугаар хүснэгтэд DMR технологийн аналог, тоон системийн радио хэрэгслийн техник өгөгдөхүүн, боломжуудын харьцуулалтыг үзүүлэв.

“SDR” технологи гэж радиостанц, техник төхөөрөмжийг бүрдүүлэгч хэсгүүдэд (жишээ нь: холигч, шүүлтүүр, өсгөгч, модулятор, демодулятор, детектор гэх мэт) компьютер эсвэл программ хангамж дамжуулагч төхөөрөмжийн тусламжтайгаар нөлөөлөх, тухайн хэсгүүдийн гүйцэтгэх үйлдлүүдийг өргөтгөх, хувирган сайжруулах, нийцүүлэн хамтатгах зэргээр радиостанцын үндсэн тактик, техникийн үзүүлэлтүүдийг өргөжүүлэх, ашиглалтын боломжуудыг нэмэгдүүлэх технологийг хэлнэ. SDR технологийн тусламжтай орчин үед радиостанцуудын өндөр хурдны өгөгдөл, дүрс, дуу, дохиоллыг дамжуулан солилцох боломж ихээхэн дээшлээд байна.

SDR болон тоон системийн технологитой радио хүлээн авагчийн ерөнхий бүдүүвчийг шууд хувиргалттай аналог системийн супергитредины хүлээн авагчийн ерөнхий бүдүүвчтэй харьцуулсан байдлыг 3 дугаар зурагт харж болно.



3 дугаар зураг: Супергитредины хүлээн авагчийн стандарт бүдүүвч, SDR технологитой хүлээн авагчийн бүдүүвчийн харьцуулалт

Орчин үед цэргийн болон тусгай зориулалттай радио холбооны систем, станц, төхөөрөмж, аппарат хэрэгсэл нь нийтийн хэрэглээний холбооны тоног төхөөрөмжөөс дараах шинж чанараар ялгаатай байх нийтлэг шаардлага үүсээд байна. Үүнд:

1. Тоон системийн байх
2. DMR, SDR технологитой байх
3. MIL стандарт хангасан байх
4. Нууцлал, кодлол шаардлагын түвшинд агуулсан байх
5. Радио электроник, кибер халдлагаас

хамгаалагдсан байх

6. Радиостанцын элемент блокууд тогтвортой ажиллагааны өндөр зэрэглэлд байх

7. Холбоо үүсгэх, тогтоох хугацаа бага байх

8. Өгөгдөл дамжуулах хурд, багтаамж их байх


9. Радио тагнуул, электрон даралтаас хамгаалагдсан байх

10. Тэжээл, энерги зарцуулалт бага байх

11. Өнгөлөн далдлалт, хамгаалалтын технологийн шаардлага хангах

12. Долгион, гэрэл цацруулалт, цацаргалт бага байх гм

DMR, SDR технологи нь дээрх 12 шаардлагыг хангах техник технологийн өргөн боломжийг хангадаг ба ирээдүйн үйлдвэрлэл, хөгжүүлэлт, хэрэглээнд зарцуулах төсөв хөрөнгийн төлөвлөлтийн үндсэн дээр цэргийн холбооны хэрэгцээнд эзлэх байдлыг тодотгон, судалж үзье. Сүүлийн жилүүдэд нийгэм эдийн засгийн бүхий л салбар, харилцаа холбооны зах зээлд SDR технологийн хэрэгцээ хурдацтай бөгөөд мэдэгдэхүйц өсөлттэй байгааг 4 дүгээр зургаас харж болох бөгөөд урьдчилсан тооцооллоор 2025–2031 онд уг технологийн ашиглалтын зах зээл 2–3 дахин тэлэхээр байгааг харж болно.



4 дүгээр зураг: SDR технологийн хэрэглээ, зах зээлийн ирээдүйн хэрэгцээний өсөлтийн төлөв байдал

АНУ-ын цэргийн салбарт тактикийн түвшинд SDR технологийн радиостанцын үйлдвэрлэл, ашиглалт, хэрэглээнд зарцуулах төсөв жил бүр өсөлттэй байгаа байдлыг 5 дугаар зургаас дүгнэлт хийж болно.



SDR ТЕХНОЛОГИЙН ТАКТИКИЙН ТҮВШИННИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ /тэрбум ам.доллар /



Европын орнуудад SDR технологийн нийт радиостанцын хэрэглээний дөрөвний нэг нь батлах хамгаалах зориулалттай байна. /6 дугаар зураг/ ОХУ-ын 2023 онд батлан хамгаалах салбарт зориулсан төсвийн зардлын зарцуулалт өсөн ДНБ-ий 7.1 хувьд, мөнгөн дүн нь 12,765 их наяд рубльд хүрсэн бөгөөд түүний дотор цэргийн холбооны техник технологийн хөгжүүлэлтэд 2023 онд төсөвлөсөн төсвөө 9 дахин өсгөсөн байна.



6 дугаар зураг: SDR технологийн радиостанцын батлан хамгаалах салбарт эзлэх хувь /Европын орнууд/

Дэлхийн хэмжээнд SDR технологийн радио холбооны техник хэрэгсэлд зарцуулагдах төсөв хөрөнгө, зах зээлийн өсөлтийн хэмжээ 2024 оноос 2031 онд 27,6–49,12 тэрбум доллар /\$/ буюу 8,5 хувийн өсөлт үүсэхээр байгаа урьдчилсан дүгнэлтийг 7 дугаар зургаас хийж болно.



7 дугаар зураг: SDR технологийн радиостанцад зарцуулах төсөвлөлтийн 2031 он хүртэлх зах зээлийн өсөлтийн байдал

Дээрх SDR-ийн технологийн радиостанцын төсвийн урьдчилсан тооцоо, хэрэгцээ, худалдааны урьдчилсан судалгаа-тайлан нь 2025–2031 онд SDR технологи радиогийн салбарт үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл байхыг бататган харуулж байна.

Цэргийн зориулалттай радиогийн DMR, SDR технологийг хөгжүүлэн үйлдвэрлэгч, дэлхийн голлох компани, туршилт судалгааны үйлдвэрлэлийн байгууллагууд:

1. Harris,
2. Thales defence & security inc.
3. Rohde & schwarz,
4. Barrett communications
5. Rusoboron
6. Itt корпорация
7. Flex radio systems inc.
8. Datasoft корпорация
9. Aselsan elektronik sanayi,
10. Benelec,
11. Datron,
12. Dicom,
13. Elbit systems,
14. lei,
15. Kongsberg,
16. Radmor,
17. Reutech,
18. Selex elsag
19. Hytera,
20. Anytone”
21. Baofeng
22. Jvckenwood,
23. Motorola

Сүүлийн үед SDR технологи нь бодит цаг хугацаанд янз бүрийн радио протоколуудыг удирдах, нийцүүлэх техник технологийн боломжтой тул энэ технологийг цэргийн салбар болон гар утасны үйлдвэрлэлд өргөн нэвтрүүлж байна. Цаашид SDR нь программ хангамжаар тодорхойлогдсон антенны байгууламжаасаа эхлүүлэн сонголтын туслах төхөөрөмжүүдийн хамт радио холбооны нягтарсан цогц үйлчилгээний иж бүрдлийг зохион бүтээх ажилд зонхилох “инновац технологи”-д зориулагдах төлөвтэй байна.



Батлан хамгаалах салбарт SDR технологид суурилсан янз бүрийн тусгай сүлжээ, системийн хэрэглээ, төрөл мэргэжлийн тусгай холбоо зохион байгуулалтад өргөн ашиглаж байна. Жишээ нь:

- Байлдааны талбарын харилцаа холбоо, нэгдсэн болон тусгай сүлжээнд;
- Тагнуул, тандалт, (ISR);
- Цэргийн агаарын хөдөлгөөний удирдлага (ATC);
- Радарын удирдлага;
- Хөдөлгөөн дээрх харилцаа холбоо (COTM);
- Удирдлагын систем;
- Хиймэл дагуулын холбоо гм.

Ирээдүйд, батлан хамгаалах салбарт SDR технологийн ашиглалт, хэрэгцээ дараах үйл ажиллагааны үндсэн чиглэлд өсөх төлөвтэй байна. Үүнд:

а/ Харилцан ажиллах чадвар ба хуучин системийн интеграцичлалд;

б/ Танин мэдэхүйн болон дасан зохицох “радио чадавх”-ийг үүсгэхэд;

в/ Аюулгүй, саатуулга, шуугианд тэсвэртэй харилцаа холбоонд;

г/ Шинээр хөгжиж буй технологиудтай нэгтгэхэд;

д/ Хиймэл дагуулын холбоо ба навигацид

е/ Нисгэгчгүй систем ба тулааны талбарын /юмс/ зүйлсийн интернэтэд (IoT):

ЦЭРГИЙН ЖИЖИГ БҮЛГИЙН АЖИЛЛАГАА, РАДИО ХОЛБОО

Сүүлийн үеийн дайн, зэвсэгт тэмцэл, сөргөлдөөнд тактикийн түвшний жижиг бүлгүүдийн ажиллагааг идэвхтэй ашиглах, дэмжлэгийн зорилгоор цэргийн үйл ажиллагаанд оруулах зэргээс улбаалан зэвсэгт тэмцлийн нэг бие даасан шинэлэг хэлбэр үүсэн хөгжиж байна. Жижиг бүлгийн ажиллагаанд богино болон хэт богино долгионы радио холбоо голлох үүрэг гүйцэтгэх ба зарим тохиолдолд тактикийн түвшнээс оперативын удирдлагаа алгасан шууд стратегийн удирдлагатай холбоо тогтоох /богино долгионоор/, ажиллагаа-холбооны мэдээллийн нууцлалын шаардлагын

үүднээс радио тор чиг эрс цөөн байх зэрэг онцлогтой зохион байгуулагддаг байна.

Орчин үеийн зэвсэгт тэмцлийн үйл ажиллагаанаас харахад жижиг бүлгийн холбооны онцлог нь дайсантай хэт ойр зах нийлсэн байдаг учраас долгионы саатуулга их байх ба энэ нь аналогийн системийн радио станцуудыг ашиглах тохиолдолд ихээхэн хүндрэл учруулдаг байна. Жижиг бүлэгт удирдлагын цомхон хэлбэртэй, хэрэгтэй цагт холбоо маш богино хугацаанд тогтоох боломжтой, өгөгдөл, мэдээллийн нууцлал хангасан, холбоо мэдээллийн тоон технологийн системийн /DMR,SDR/ радио холбоо шаардагдаж байдаг.

Жижиг бүлгийн радио холбоо зохион байгуулалтад дараах онцлогууд харагдаж байгаа бөгөөд энэ шаардлага хэрэгцээний дагуу техник, технологийн дэвшлийг ашиглах нь зүйн хэрэг болж байна.

Үүнд:

1. Удирдлагын тасралтгүй, нууц далд байх зарчмыг хангах, электрон даралтаас хамгаалагдсан, кибер нөлөөлд бага өртөх;

2. Харилцагч бүлгүүдэд байгаа холбооны техник, технологийн ялгаатай байж болох онцлогийг харгалзан холбооны систем зохион байгуулах;

3. Цэргийн үндсэн бүлэглэл, удирдлагатай холбоо зохион байгуулагдах онцлогт нийцүүлэх;

4. Удирдлагын байр, түүнтэй холбогдох сансрын холбоо ашиглагдах нөхцөл үүсэх онцлогийг харгалзах;

5. Нууцлалын түвшин өндөр, бага оврын, тэжээл бага зарцуулдаг, тоон системийн /DMR, SDR технологийн гм/ сүүлийн үеийн технологийн ололт дэвшлээр зохион бүтээгдсэн радио холбооны техник хэрэгсэл ашиглах зэрэг байна.

Сүүлийн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлагаас харахад жижиг бүлгүүд тулааны талбарын үндсэн нэгж болоод байгаа бөгөөд тэднийг холбооны дэвшилтэд технологийн, орчин үеийн бага оврын, хамгаалалт, нууцлалт өндөртэй радио холбооны хэрэгслээр хангах нь



цэргийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах гол нөхцөл гэдэг нь нотлогдсоор байна

DMR, SDR ТЕХНОЛОГИ БА ТАКТИКИЙН ТҮВШИНД ЦЭРГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ ОНЦЛОГ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тактикийн түвшний цэргийн холбоо зохион байгуулалтад DMR, SDR технологийг хэрэглэх үед дараах онцлогууд үүсэх боломжтой. Үүнд:

а/ DMR технологитой радио холбооны техник хэрэгсэл ашиглан цэрэг, тусгай хүчний радио холбоо зохион байгуулахад дараах давуу талууд үүсгэх боломжтой:

- Дууны чанар өндөр байх: DMR радио нь дижитал модуляцийг ашигладаг бөгөөд энэ нь дууны чанарыг сайжруулж, хөндлөнгийн чимээг багасгаж, мэдээний чанарыг илүү тодорхой болгодог;

- Нэвтрүүлгийн чадал харьцангуй их үүсэх: DMR радио нь цаг хуваах олон хандалтыг (TDMA) ашигладаг бөгөөд энэ нь радио давтамжийг илүү үр дүнтэй ашиглах боломжийг олгодог бөгөөд хуваарилагдсан сувгуудаар нэгэн зэрэг харилцах хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой ;

- Холбооны найдвартай аюулгүй байдлыг хангах: DMR радио нь зөвшөөрөлгүй радио хүлээн авалтаас урьдчилан сэргийлэхийн тулд AES 256 бит гэх мэт шифр, кодлоор дамжуулан илүү найдвартай холбооны суваг үүсгэдэг;

- Хялбар өөрчлөгдөх боломжтой систем үүсгэх;

- Хүлээн авах мэдрэх чадварыг сайжруулах өргөн боломж;

- Удирдлагын системийг өргөтгөх технологийн боломж;

- Сүлжээний бусад төхөөрөмжийн ашиглалтыг өргөжүүлэх боломж;

- Автомат ажиллагааны хугацааг уртасгах, чанар өндөр дуу дүрс үүсгэх боломж өндөр гм.

б/ DMR технологитой радио холбооны техник хэрэгслийг ашиглахад үүсэж болох сул талууд:

- Зохион бүтээх өртөг өндөр байх магадлалтай: DMR радио нь ихэвчлэн DPMR

эсвэл аналог радиогоос илүү үнэтэй байдаг;

- Сургалт дадлага илүү хугацаагаар шаарддаг: DMR радио нь илүү их сургалт шаарддаг бөгөөд dPMR радиотой харьцуулахад илүү төвөгтэй байдаг.

DMR, SDR технологийн тоон системийн радиостанцууд ихэвчлэн AM, FM, PM, FSKM, BPSK, QPSK, QAM, OFDM модуляци-хувиргалтуудтай байдаг ба радиостанцын техник, технологийн үзүүлэлт, үйл ажиллагааны боломжийг шинэчлэн сайжруулж, хөгжүүлснээр дараах ажлын горимуудад дэвшил гаргах бололцоотой. Үүнд:

- Хувийн дуудлагын төрөл шинэчлэгдэх;
- Бүлгээр сонгох дуудлагын боломж ихсэх;
- Бүлгээр дуудах кодлогдсон дуудлага сүлжээнд үүсгэх;

- Дуудлагыг ач холбогдлоор нь автоматаар эрэмбэлэх;

- Өргөн зурвасын нэвтрүүлэг үүсгэх;

- GPS дэмжих;

- Алсын удирдлагын өгөгдөл нэмэгдэх;

- Шифр кодын шийдэл сайжрах, шинэчлэх;

- «hands-free» горимын сайжруулалт;

- Дуу, текстэн материал зэрэг дамжуулах боломж өргөсөх;

- Хөндлөнгийн сонсголоос сайн хамгаалах боломж өндөрсөх;

- Давтамж, тэжээлийн хэрэглээний хэмнэлтэй байдал үүсгэх;

- Дахин дамжуулалт, холболт дамжуулалтын тоног төхөөрөмжийн тооны хувьд хэмнэлттэй байдал үүсгэх;

- Шуугиан дарагч тэргүүний технологийг ашиглах боломж үүсэх;

- Холбооны чанар дамжуулалтын бүх хэсэгт сайжруулах боломжтой;

- Яаралтай онцгой дуудлага шаардлагатай үед үүсгэх

- зайнаас удирдах, алсаас станцыг унтраах

- байрлал тогтоох, кодлон программчлалын шинэчлэл, автомат хяналт, сайжруулалт үүсгэх;

- мэдээний нягтарсан бүлэг үүсгэх нэвтрүүлэх горим үүсгэх;



• богино мэдээллийн–мессеж горим үүсгэх гм.

Цэргийн холбооны тактикийн түвшний радио станцад SDR, DMR технологийн тусламжтай олон шинэ инновац технологи нэвтэрч байгаа ба нууцлал, шифрлэлтийн шинэ хэлбэрүүд, шинэ төрлийн мэдээний хэлбэр,

гүйцэтгэх үүргийн өргөжүүлэлт, агаар–газар чиглэлд дуу өгөгдөл дүрс дамжуулалтын боломж олон дахин ихэссэн, технологийн нийцүүлэлтийн арга хэлбэр нэмэгдсэн, жин хэмжээ эрс багассан зэрэг ололтуудыг дараах 3 дугаар хүснэгтээс дүгнэж болно.

3 дугаар хүснэгт: DMR, SDR технологийн тоон системийн радиостанцуудын үндсэн техник өгөгдөхүүн, зориулалтын онцлог хэлбэрүүд

Загвар	Үйлдвэрлэгч улс /компани	Давтамжийн хүрээ /МГц/	Чадал /Вт/	Шифрлэлтийн хэлбэр	Дохионы модуляцийн хэлбэр	хэмжээс / мм/	Жин / кг/
AN/PRC-152	АНУ, Harris	30-512	5,0	Citadel@!, Ии AES	FM, AM, FSK, CPM*, PSK	73,6x244	1,2
НН-2100V	АНУ, Datron	30-33	5,0	COMSEC	FM	254x86x43	1,2
PRC-6809 MBITR	Франц, Thales	30-512	5,0	Гурь-III DES и AES	AM/FM ба тоон технологийн холболт FM/ECCM/FH/FC	214x66x33	0,37
PRC-71 OMB	Израиль, Elbit Systems	30-512	5,0	COMSEC	AM/FM/CVSD/FSK	180x75x55	0,8
UK7PRC-354	Англия, Selex ElsagUK	30-88	5,0	TRANSECи COMSEC	FM/CVSD/MELP	44x94x194	0,9
MR-3000P	ХБЭГУ, Rohde & Schwarz	25-146	5,0	ЕРМ, R&S SECOM-V/H/P	AM, FM, FH, DFF	97x217x44	1,15
MH-300	Норвеги, Kongsberg	30 - 88	1,0	CVSDи MELP	FM	240x86x50	1,055
RF-20	Чех, Dicom	25-146	5,0	TRANSEC, COMSEC	AM, FM, FH, DFF	97x217x44	1,15
R-3501	Польш, Radmor	30-88	3,0	скремблер	F3E (FM), F2D	212x91x43	0,94
PRC-9651	Турк, Aselsan	30-512	5,0	TRANSEC	FM/AM/TDMA0SSS/WBNR	97x217x44	1,2
Акведук	ОХУ	30 -88	1,0	скремблер	FM, AM	44x74x14	0,9-2
RTX-5051	Иран, IEL	47-56.975	1,0	•	FM	245x103	0,87
TRC-100	Малайз, STE	30-88	2,0	Хосолмол	FM	73x140x4	0,6
PRS-4	Хятад, CEIEC	30-88	2,0	+	FM	-	1,5
PRC-080	Австрал, Barrett	30-88	5,0	TRANSEC	FM	82x223x5	1,0
TR-610	АБНУ, Reutech	30-88	3,0	скремблер	F3E (FM) и F2D	91x43x21	0,94

ДУГНЭЛТ

Монгол Улс шинжлэх ухаан, технологийн тасралтгүй хөгжлийн өнөөгийн эрин үед эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлыг эрчимжүүлэх, орчин үеийн технологийн дэвшлийг нийгэм эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлэх, инновацыг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод: “...олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, энэхүү

зорилтын хүрээнд цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэрийг байгуулж, инновацыг нэвтрүүлэх замаар цэргийн зориулалттай зарим бүтээгдэхүүнийг зохион бүтээж, дотооддоо үйлдвэрлэнэ хэмээн батлан хамгаалахын судалгаа шинжилгээний алсын харааг тодорхойлсон байна.2

“Зэвсэгт хүчний зэвсэг техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого” УИХ-аар батлагдсанаар Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх



үйл ажиллагаа сайжирч, цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага, зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэгт нийцсэн, шинжлэх ухааны ололт, инновац, дэвшилтэт технологид суурилсан өндөр бүтээмжтэй зэвсэглэл, цэргийн техник нөхөн хангагдах эрх зүйн таатай орчин бүрдэх, орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурласан зарим нэр төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх гэсэн үйл ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байдаг.

Цэргийн холбооны шинэ үеийн DMR, SDR технологид суурилсан тоон системийн радио станцыг хэрэглээнд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байгааг дараах асуудлуудаар дүгнэж болно. Үүнд

1. Орчин үеийн дайн, зэвсэгт тэмцлийн тактикийн түвшинд цэргийн бүлгийн ажиллагаа голлох болсон ба түүний удирдлага, ажиллагааны холбооны үндсэн төрөл радио холбоо байгаа;

2. Цэргийн бүлгийн радио холбооны хэрэгслүүд DMR, SDR технологид суурилсан тоон системийн, нууцлал, шифр, хамгаалалтын шаардлагыг хангасан техник хэрэгсэлд бүрэн шилжсэн, цаашид хөгжүүлэн сайжирч байдаг;

3. Нийтийн болон цэргийн салбарт ойролцоогоор 15 мянга орчим, технологийн 5–6 үеийн тоон технологийн радиостанц

ашиглагдан, шийдвэр гаргах нэгдсэн мэдээллийн системийн анхдагч объект болдог;

4. Хиймэл оюун, кибер, холбоо мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, шифрлэлтийн үйл ажиллагааг радиохолбооны системтэй уялдуулан нэвтрүүлэх технологийн шинэчлэл дэвшлийг DMR, SDR технологийн дэмжлэгээр шийдвэрлэх боломжтой;

5. Цэргийн радио холбооны үйлдвэрлэл, техник технологийн инновац хөгжлийн нэвтрүүлэлтэд DMR, SDR технологи ойрын 5–6 жилд төсөвлөгдсөн төсөв нь 2024 оны төсвөөс 2–3 дахин өсөхөөр харагдаж байгаа нь энэ технологийн хэрэглээ, цэргийн холбоонд ирээдүйд голлох байр эзлэхийг харуулж байна.

Иймд Зэвсэгт хүчний хэрэглээнд байгаа аналог системийн радиостанцуудыг үе шаттайгаар тоон технологид шилжүүлэх, шинээр зохион бүтээх үйл ажиллагааг бодлогоор дэмжин, орчин үеийн зэвсэгт тэмцлийн сургамж, түүний удирдлага, ажиллагааны холбоо зохион байгуулалтын онцлог болон шифр–нууцлал, бүх талын аюулгүй байдал, хамгаалалтын шаардлага, технологи, программ хангамжийн хараат бус байдлыг хангасан DMR, SDR технологийн радио холбооны төхөөрөмж, станц хэрэгслийг зохион бүтээн, хөгжүүлэлт хийх шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Л.Оюун–Эрдэнэ. “Алсын хараа–2050”, 2021 он
2. М.Борбаатар. “Жижиг бүлгийн ажиллагаа” 2005 он
3. Орчин үеийн дайны хувьсал өөрчлөлт, зэвсэглэл техникийн хөгжил. Аюулгүй байдал, стратеги тойм, Дугаар №16, 2023/4
4. Интернет “10 most innovative military technologies in the world. TOI– ONLINE. 2023”
5. www. Военная экономика
6. www. Asia pacific defense forum /DMR SDR technology/
7. Compendium by armada /tactical radio/
8. www. Military technology /tactical communications overview/2020 ISSN 0722–3226
9. М.Борбаатар, “Жижиг бүлгүүдийн ажиллагаа”, Жижиг бүлгийн удирдлага, холбоо зохион байгуулалтын онцлог, хуудас 84–86, 2005 он,
10. Л. Оюун–Эрдэнэ, “Азийн хүлэг улс алсын хараа 2050” ISBN 978–9919–500–85–68 2021 он,

СОНИРХОГЧИЙН РАДИО ХҮЛЭЭН АВАГЧ УГСАРЧ ТУРШИХ НЬ

Л.ОДМАА /ҮБХИС-ийн ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор/

Түлхүүр үг: радио, хүлээн авагч, давтамж, сонирхогч, туршилт

Key words: radio, receiver, frequency, amateur, test

Оршил

Радио сонирхогчийн хүлээн авагч нь хэт богино долгионы болон богино долгионы гэж 2 янз байдаг. Радио сонирхогчийн нэвтрүүлэгч олох тэмцээн нь 144МГц, Фоксоринг, Спринт, Уламжлалт 3.5МГц-ийн төрлүүдэд тамирчид ойд нуусан 5–10 бага чадлын нэвтрүүлэгчийг газрын зураг, луужин, хүлээн авагч ашиглан олж барианд орох ёстой. 5–10 нэвтрүүлэгчийн цацсан морзын дохиог хүлээн авч байрлалыг урьдчилан тогтоож, олох дарааллыг тодорхойлж, явах маршрутаа төлөвлөж, нэвтрүүлэгчүүдийг олох зориулалттай юм. Тамирчид хэт богино долгионы хүлээн авагчийн тусламжтайгаар нэвтрүүлэгчийг илрүүлж байгаа байдлыг 1 дүгээр зурагт үзүүлэв.

Энэхүү тэмцээнд оролцооноор бие бялдраа хөгжүүлэх, газрын зурагтай ажиллах, зүг чиг олох, мэргэжлийн хувьд ахиж дэвших, авхаалж самбаа сорих гэх мэт олон сайн талуудыг олгодог. Манай сургуульд тэмцээнд оролцох хүсэлтэй оюутан, сонсогч олон байдаг ч хүлээн авагчийн тоо цөөн, мөн Монгол Улсад үйлдвэрлэдэггүй гаднаас өндөр зардлаар авдаг зэргээс болж орж чаддаггүй юм. Тиймээс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан анх удаа угсарч турших зорилго дэвшүүлсэн юм.




а. Тамирчид гарааны өмнө б. Нэвтрүүлэгч олж байгаа байдал
1 дүгээр зураг. Газар орон дээр нуусан пунктыг илрүүлсэн байдал

ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ ХҮЛЭЭН АВАГЧ

Сонирхогчийн хүлээн авагчийн схемийг

судалж, элементийг танин мэдэж, эрэл хайгуул хийж, гадаадаас болон Монголоосоо хүлээн авагчид орох элементүүдийг схемийн дагуу худалдан авсан. Хүлээн авагчийн бүтцийн схемийг 2 дугаар зурагт үзүүлэв. 144МГц-ийн давтамжийн цаараанд ажилладаг хэт богино долгионы сонирхогчийн хүлээн авагчийг дараах бүтцийн схемийн дагуу угсарсан болно.

Сонирхогчийн хүлээн авагчийн схемийг судлахад зарим бэрхшээлтэй асуудлууд гарч байсан. Гадаадад тэр дундаа БНСУ-д хэрэглэгддэг схемийг авч ашигласан учир мэдэхгүй, ойлгогдохгүй элемент, тэмдэглэгээнүүд байсан бөгөөд тухай бүр багш нарын дэмжлэг авч байсан. Энд онцлон дурдвал: ҮБХИС-ийн ЭШИХ-ын мэргэжилтэн, ахлах дэслэгч Л.Бямбажаргалд танд талархал илэрхийлье.



2 дугаар зураг. Хүлээн авагчийн бүтцийн схем

Үйлдвэрийн эх хавтанг олшруулахын тулд гар аргаар хавтан хийж (Зураг 1), элементүүдийг гагнаж, дадлагашиж, туршилт хийж хүлээн авагчийг асааж ажиллуулсан.


“SPRINT LAYOUT”-ЫН АШИГЛАЛТ

Жижиг, дунд зэргийн нарийн төвөгтэй хэвлэмэл хэлхээний хавтанг зохион бүтээх, хийхэд зориулсан нэгэн зэрэг маш үр дүнтэй программ хангамжийн багц юм. Sprint-Layout-ийн гол давуу тал нь түүний ухаалаг интерфейс бөгөөд 300x300мм хэмжээтэй хэвлэмэл хавтанг





бэлтгэхэд шаардлагатай элементийг багтаасан юм. Энэхүү программ нь хавтанг хоёр талт ажиллах боломжийг олгосон.

Sprint-Layout нь ажлын үр дүнг Excellon болон Gerber формат руу экспортлох, программ нь дээр хэлхээний хавтанг HPGL файлыг үүсгэх боломжийг олгодог.




3 дугаар зураг. Үйлдвэрийн эх хавтан



3 дугаар зураг. Гар аргаар хийсэн эх хавтан

Дотоодын сонирхогчид уг программын бүрэн ажиллагаатай орос хувилбарыг боловсруулсан бөгөөд энэ нь сүлжээнд Sprint-Layout 6 нэртэй бөгөөд тохиромжтой болгох үүднээс интерфэйсийг өөрчилсөн, олон тооны электрон бүрэлдэхүүн хэсгүүдийг нэмж, Sprint-Layout-ийн 5-р хувилбар хүртэл анхны бүх хувилбаруудтай нийцтэй байдлыг хангаж ажилласан. Sprint-Layout-ийн 6 дугаар хувилбараас дараах шинэлэг зүйлийг олж болно.



4 дүгээр зураг. Программын нүүр хуудас болон программ цэс

Спринт зохион байгуулалт- Энэ бол хоёр талт хэвлэмэл хэлхээний хавтанг хоёуланг нь хөгжүүлэх программ бөгөөд ийм ажилд

шаардлагатай бүх функцийг хангаж өгдөг. Excellon мэргэжлийн форматаар файл экспортлох үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнийг үйлдвэрлэлийн аргаар хэлхээний хавтанг үйлдвэрлэхэд ашигладаг, үүнд нүхлэх, өрөмдөх зэрэг юм. Sprint-Layout нь зам, зарчмын схем болон бүх схемийг зурах боломжийг олгоно. Янз бүрийн хэлбэр, хэмжээтэй элементүүдийг сонгохоос гадна тэдгээрийг өөрөө үүсгэж болно. Sprint Layout директорт Example.LAY файлыг нээж болно.

Хавтан ба гурван хэмжээт хэлбэрээр объектуудыг бүтээхэд инженерүүдийн ашигладаг программ юм. Энэ нь инженерийн график дизайны ажилд ашиглагддаг бөгөөд өргөн хүрээний функцүүдийг агуулдаг.


ХҮЛЭЭН АВАГЧИЙГ БОДИТООР УГСРАХ НЬ

Антен

Сонирхогчийн хүлээн авагчийн антенныг 3 төрлийн урттай /урт-55см, дунд-50см, богино-45см/ 6 ширхэг антен хийсэн /зураг 5а/. Хувааж бэлдсэн төмөр метрийг гадуур нь цахилгааны лентээр дангаар нь орооход хэтэрхий нимгэхэн туялзсан байсан тул кембрик материал ашиглан бүрсэн. Кембрикээр гадаргууг бүрж халааснаар төмрийн туялзсан байдал нь алга болж, хүн барихад боломжийн хатуу болсон.

Хайрцаг

Хайрцгийг хийхийн тулд 3D принтер дээр SOLIDWORKS программ ашиглан хэмжээ, загварыг гарган зурж принтерт плашанд суулган сануулж дамартай пила утасны тусламжтайгаар ойролцоогоор 11-12 цагийн дараа хайрцаг бэлэн болсон /зураг 5б/. Хайрцгийг хийхдээ нэг дор принтерлэж болохгүй учраас хайрцгаа 2 хувааж, тагаа 2 хэсэг болгон хэвлэсэн.



5 дугаар зураг. Антен болон гадна хайрцаг

Эх бие


Хүлээн авагч нь антенн, чихэвч, хайрцаг анги, тэжээлийн хэсэг, эх хавтан, чихэвчний оролт, түлхүүр гэсэн хэсгээс бүрдэж ажиллана. Энэ зурагт харагдаж байгаагаар эх хавтан дээрх

элементүүдийг хавтан болон схемд заагдсаны дагуу хийж угсарсан. Тэжээлийн хэсэг нь бол 9В батарей хэрэглэж их биеийг бүрэн тэжээлээр хангана. Тэжээлээр хангагдсан хүлээн авагчийг асаах, унтраах гэсэн товчлуурын тусламжтайгаар асааснаар хажуу талд нь хийгдсэн гэрэл асна. Энэ гэрэл ассанаар тэжээл их биед ирсэн байна гэсэн дохиог авч болно. Чихэвчний оролт нь газардуулга, нэмэх хасах гэсэн гурван шонгоор холбогдоно. Шон бүрд цахилгааны утас холбож, хавтан дээр байрлах чихэвчний оролт орох хэсэг рүү тус тусын зориулалттай утсыг гагнаснаар, нэвтрүүлэгчээс гарсан дохио хүлээн авагчийн антены тусламжтайгаар оролтын хэлхээнд ирж их биеэр дамжин шүүгдэж цэвэрлэгдсэнээр чихэвчний гаралтад дээр хүний чихэнд сонсогдох дохио буюу морз сонсогдоно.

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ

Гадна хэсэг

Сонирхогчийн хүлээн авагч нь бүтцийн хувьд их бие, антенны 6 оролт, давтамж болон дуу тохируулагч, чихэвчний оролт, асааж унтраах товчлуур, тэжээлийн үүсгүүр зэргээс /зураг 6/ бүрдэнэ.



- 1– Их бие
 - 2– Антены суурь
 - 3– Давтамж тохируулагч
 - 4– Дуу тохируулагч
 - 5– Антен
- Дотор тал

Хүлээн авагчийн эх хэсэг буюу хавтанг угсрахын тулд тус хавтанд заагдсаны дагуу хэмжих нэгж, заагдсан элементийг цуглуулж тус тусын үүрэнд гагнаж бэхэлсэн /Зураг 7/.



7 дугаар зураг. Хүлээн авагчийн дотор бүтэц

Гаднаас тэжээл, дуу, давтамж тохируулагч /потенциометр/, антены цахилгааны утаснуудыг оруулж нэмэх, хасах цэнэг, газардуулгыг ялган зориулалтын үүрэнд холбож гагнасан.

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАВУУ ТАЛ

Хүлээн авагчийг Монгол Улсад анх удаа угсарсан нь амжилттай болсон бөгөөд морзын дохиог маш цэвэрхэн, шуугиангүй сонсогдож байна. Мөн доор дурдсан давуу талуудыг олгоно.

1. Гар аргаар угсарч хийсэн учир эвдэрсэн, шатсан, ажиллагаагүй болсон элемент, эд ангийг солих, засварлах боломжтой.

2. БНСУ–д үйлдвэрлэсэн эх хавтанг дуурайж гар аргаар олшруулахдаа “*Sprint Layout-6*” программыг ашигласан нь сонсогч нарыг дадлагажуулах боломж олгосон.

3. Өөрсдийн угсарсан хүлээн авагч нь үнийн хувьд харьцангуй хямд болсон. Гадаадын улс орнуудаас 600.000–1.200.000 төгрөгөөр захиалдаг бол өөрсдөө эд анги элементээ худалдан авч 216.000–300.000 төгрөгөөр угсрах боломжтой болсон.

4. Хүлээн авагчийг угсрахад шаардлагатай эд анги, элементийн олдоц ихтэй хямд төсөр байсан.

5. Бүтээгдэх цаг хугацааны хувьд материалаа авсан байхад хурдан угсарна. Гаднын орноос захиалж, үйлдвэрт хийгдсэн, тээвэрлэгдэн ирэхэд ойролцоогоор 30–45 хоног байдаг бол 1 ширхэг хүлээн авагчийг туршлагатай 3–4 инженер 7–10 хоногт угсарна.

ДҮГНЭЛТ

1. Хэт богино долгионы сонирхогчийн хүлээн авагчийн бүтцийн бүдүүвчийг судалж, тооцоо судалгаа хийж, бодитоор угсарч амжилттай туршсан нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал боллоо.

2. Сонирхогчийн хүлээн авагчийг угсрахад шаардлагатай эд анги, элементийг схемийн дагуу Монголоос хайж зарим элементүүдийг авсан. Ихэнх элементүүдийг БНСУ–аас захиж авчирсан. Хүлээн авагч угсарсан 2 сонсогч анх схемтэйгээ цуг ирсэн үйлдвэрийн хавтанг олшруулахын тулд гар аргаар хавтан хийж, дадлагажсан.

3. Монгол Улсын оюуны өмчийн газраас “Сонирхогчийн хүлээн авагч” бүтээлээр “Ашигтай загварын патент” 2024 оны 2 дугаар



сарын 29-ний өдөр олгогдсон болно. Патентыг хавсралтаар оруулав.

4. Цаашид холбооны мэргэжлийн хичээлийн дадлагад ашиглах, угсрах,

олшруулах, нэвтрүүлэгчийн чиглэл олох тэмцээнд сонсогчдыг бэлтгэхэд үндсэн техник болгон хэрэглэх бүрэн боломжтой.

Ашигласан материал:

1. Оюун-Эрдэнэ С., Оюундарь Г., нар “Хүлээн авагчийг угсарч турших нь” бакалаврын дипломын ажил
2. Одмаа Л., Хүрэл Ж., нар “Цэргийн радио холбоо-1”
3. Одмаа Л., Оюун-Эрдэнэ С., Оюундарь Г., нар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өнөө ба ирээдүй-2024. УБ., “ҮБХИС-ийн хэвлэх үйлдвэр” 2024., т.101-106, ISBN978-9919-0-2693-6;
4. Бат-Отгон Б. “Электроникийн үндэс”
5. Буянхишиг З., Жавзансүрэн Ж., Эрдэнэтуяа Э., нар “Дохио дамжуулах онол”
6. Дамдинсүрэн Б. “Радио холбооны тоон системийн үндэс”
7. Цогбадрах Л. “Радио-Электроник” УБ., 2012 он
8. Дуу инженерүүдийн гарын авлага, 4-р хэвлэл. ISBN 978-1136122538
9. Электроникс сэтгүүл
10. Сонирхогчийн радио холбоо (mrsf.mn)
11. Радио— Википедиа нэвтэрхий толь (wikipedia.org)
12. <https://radiostorage.net/3815-skhema-ukv-priemnika-pryamogo-preobrazovaniya-na-diapazon-144mhz.html>
13. <https://www.qrz.ru/schemes/contribute/uhf/ljbitel-skij-priemnik-pramogo-preobrazovania.html>
14. <https://mn.wikipedia.org/wiki>
15. <https://msport.mn/associationdetail/a211200021>
16. <https://sport.gov.mn/radio/nc/1677/>
17. <https://sport.gov.mn/radio/n/6899/>

ДОТООД БАЛЛИСТИК

Ц.ЛХАГВАДОРЖ /УБХИС, ЦНДС-ийн АЗТ-ийн ахлах багш, магистр, дэд хурандаа/

Түлхүүр үг: Бууны гол төмрийн суваг дахь үзэгдэл

Key words: Ballistic phenomena that occurs inside a gun Barrell

Оршил

Гадаад, дотоод баллистикийг судалснаар буудлага, буудах үзэгдлийн мөн чанарыг сайн мэдэж, галын бэлтгэлийг зөв зохион байгуулан, мэргэн буудаж сургах, шинжлэх ухааны үндэслэлийг эзэмшинэ. Буудлагын тухай үндсэн мэдлэггүйгээр бүх галын системийг зөв зохион байгуулах, зэвсэг, галт хэрэглэлийг сонгох, эсрэг талд хамгийн их хохирол учруулах асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм.

Баллистик гэдэг үг нь ballo–шидэх гэдэг грек үгнээс үүсэлтэй. Баллистикийн шинжлэх ухаан нь сумны /гранат, мин, пуужин г.м/ хөдлөх хөдөлгөөнийг судалдаг шинжлэх ухаан юм. Баллистикийг дотор нь гадаад ба дотоод баллистик гэж хоёр хуваадаг. Буудлагын зэвсэг, гранатомёт болон байлдааны техник хэрэгсэл дээр байрлуулсан зэвсэглэлээр буудах арга барил, дүрмийг ухамсартай гүнзгий судалж мэдэхэд баллистикийн онолын үндсэн мэдэгдэхүүн чухал үүрэгтэй.

Дотоод баллистикийн зорилго нь гол төмрийн суваг дахь сумны хөдөлгөөн болон буудлагын үед болох үзэгдлүүдийг судлахад оршино. Дотоод баллистик нь дарин хийн даралтын хэмжээ, бууны гол төмөр дэх сумны хурдны өөрчлөлтийг шинжлэн судлахын зэрэгцээ гол төмрийн сувгийн (сувгийн урт, сумны байрны эзлэхүүн) болон цэнэглэх нөхцөлийн (цэнэгийн жин, дарин хэлбэр, хэмжээнүүд) хамгийн тохиромжтой өгөгдөхүүнийг тодорхойлдог. Тэгснээрээ тодорхой жин, калибртай суманд дарин хийн хамгийн их даралтын тодорхой хэмжээнд, шаардагдах анхны хурдыг олгож өгнө. Дотоод баллистик нь гол төмрийн сувагт буудах үзэгдлээр илэрнэ.

Үндсэн хэсэг

Дарин цэнэг шатах үед үүсэх хийн энергийн хүчээр гол төмрийн сувгаас сумны хошуу (гранат) шидэгдэн гарахыг буудалт гэнэ. Буудалт гэдэг нь дарин хийн энерги маш богино хугацаанд эхлээд дулааны, дараа нь буу болон сумны хошууг хөдөлгөх кинетик энергид шилждэг үзэгдэл юм. Буудах үзэгдлийн үед төрөл бүрийн загварын буунууд дээр дараах онцлогуудтай байна. Үүнд:

- Дарин хийн даралтын ихээхэн хэмжээ (2000–4500 кг/см²);

- Дарин хийн өндөр температур (2500–3500° С);

- Үзэгдлийн маш богино хугацаа (0,001–0,06 сек);

- Сумны анхны хурд – 315–1800 м/сек;

- Дарин хийн шаталт хурдан өөрчлөгдөх эзлэхүүнд явагдах;

- Хүчтэй дуу, дөл, тийрэлт үүсэх;

- Гол төмөр чичирч хэлбэлзэх;

- Бууны тийрэлт, ухрах хөдөлгөөн үүснэ.

Буудах үзэгдэл нь дараах үйл явцаас бүрдэнэ. Үүнд:

1. Дарь асах;

2. Дарь шатах;

3. Дарин хий үүсэх;

4. Дарин хийн бүтэц өөрчлөгдөх;

5. Дарин хийн тэлэлт явагдах;

6. Сумны /хошууны/ давших хөдөлгөөн;

7. Сумны эргэлдэх хөдөлгөөн;

8. Дарин хийн хөдөлгөөн;

9. Дарин цэнэгийн элементүүдийн (шатаагүй жижиг хэсгийн) хөдөлгөөн;

10. Гол төмрийн ухрах хэсгийн хөдөлгөөн;

11. Бянтанд сум зүсэгдэн орох;

12. Гол төмрийн гадаргууд сумны хөтлөх



хэсгийн үрэлт;

13. Гол төмрийн сувгийн шаталт ба элэгдэл;

14. Гол төмрийн ханан дахь дарийн хийн дулааны үйлчлэл;

15. Гол төмрийн уян харимхайн деформац явагдах;

16. Сумны уян харимхайн болон пластик деформац явагдах;

17. Гол төмрийн сувгаас агаарыг шахан гаргах;


18. Гол төмрийн сувгаас дарийн хий урсан гарах;

19. Гол төмрийн амны хэсэгт хүчтэй дөл ба дуу үүсэх.

Дээрх үйл явцаас дарини шаталт, дарин хийн үүсэлт ба тэлэлт, сумны хошууны давших хөдөлгөөн, гол төмрийн сувгаас дарин хийн урсан гарах зэрэг нь гол үйл явц болдог.

Буудах үзэгдлийн үе шатууд: Гол төмөр доторх сумны хөдөлгөөний хурд, дарин хийн даралтын өөрчлөлтийг судлах зорилгоор буудлагын үзэгдлийг 4 үе шатад хуваана.

1. Урьдчилсан үе шат;
2. Анхны буюу үндсэн үе шат;
3. Хоёрдугаар үе шат;
4. Гуравдугаар буюу дарийн хийн үйлчлэлийн дараах үе шат.



1 дүгээр зураг. Дотоод баллистикийн үе шатууд, дарийн хийн даралтын ба сумны хошууны хурдны график /7,62мм автомат

Урьдчилсан үе шат: Буудлага үйлдэхийн тулд сумыг сумны байранд оруулж, замгаар гол төмрийн сувгийг нягт сайн хаалган буулгах гохыг дарах хэрэгтэй. Гохыг дарснаар цохих

буулгах механизмын ажиллагаагаар /чавх, цохигчийн шөвөг төмөр.г.м/ сумны бялтыг цохино. Бялт асан, түүний галын дөл хонгионы ёроолын нүхнүүдээр дамжин дарин цэнэгийг шатаана. Дарин цэнэг шатах үед дарийн хий үүсэн цэнэг шатах тусам хий нэмэгдэнэ. Үүссэн хий зүг бүхэндээ даралт үүсгэн тэлэхийг эрмэлзэнэ. Хийн даралт хонгионы ёроол руу даран замгийн аяганы хонхорт түүнийг нягт дардаг бол хонгионы доторх хана руу дарсан хийн даралт хонгиог сумны байрны хананд нягт дарснаар хийг хойш алдахгүй барьж байдаг. Хэдийгээр дарин хий нэмэгдэн ихэсдэг боловч шаталт нь тогтмол эзлэхүүнд явагддаг онцлогтой байна. Сумны хошууны гадарга дээр бянтны мөр гарах үеийн хошууны араас дарах даралтыг гатлах даралт (P_0) гэнэ. Буудлагын зэвсэгт гатлах даралт нь $P_0=250-500$ кг/см² байдаг. Жишээлбэл: 1943 оны хэлбэрийн суманд $P_0=300$ кг/см² байдаг. Урьдчилсан үе шат нь дарин цэнэг шатаж эхлэхээс эхлээд сумны хошуу гол төмрийн сувгийн бянт руу зүсэгдэн орж хошууны гадаргуу дээр бянтны мөр гарах үе хүртэл үргэлжилнэ.

Анхны буюу үндсэн үе шат: Энэ үе нь сумны хошуу хөдөлж эхлэхээс дарин цэнэг бүрэн шатах агшин хүртэл үргэлжилнэ. Энэ үе шатанд дарин цэнэгийн шаталт хурдан өөрчлөгдөх эзлэхүүнд явагдана. Үе шатын эхэнд гол төмрийн сувгаар сумны хошууны хөдлөх хурд их биш байдаг бөгөөд хийн хэмжээ нь сумны ар талын зайн багтаамжийг (сумны хошууны ёроол, хонгионы ёроол хоёрын хоорондох зай) бодвол хурдан нэмэгдэж, хийн даралт ихсэн хамгийн дээд хэмжээндээ хүрнэ. Жишээлбэл 1943 оны сум 2800 кг/см², винтовын сумных 2900 кг/см² байна. Энэ даралтыг туйлын даралт (P_{max}) гэнэ. Буудлагын зэвсэгт туйлын даралт сумны хошуу 4-6 см явсны дараа үүснэ. Сумны хошууны хөдөлгөөний хурд түргэн нэмэгддэг учраас сумны ар талын зайн багтаамж, шинэ хийн урсгалын улмаас хурдан ихсэж, даралт унаж эхэлдэг бөгөөд энэ үе шатын төгсгөлд туйлын их даралт барагцаалбал 2/3-той тэнцүү болно. Сумны хошууны хөдөлгөөний хурд



байнга нэмэгдэж үе шатын төгсгөлд анхны хурдны $V_0 / 3/4$ -г хүрнэ. Гол төмрийн сувгаас сумны хошуу нисэн гарахаас өмнөхөн дарин цэнэг бүрэн шатаж дуусна.

Хоёрдугаар үе шат: Хоёрдугаар үе шат нь дарин цэнэг шатаж дуусахаас эхлээд гол төмрийн сувгаас сумны хошуу нисэн гарах агшин хүртэл үргэлжилнэ. Энэ үе шат эхэлмэгц дарин хийн урсгал зогсдог боловч хүчтэй шахагдаж, халсан хий тэлж сумны хошууны ёроолд даралт үзүүлэн хурдыг нэмэгдүүлнэ. Энэ үед даралт хурдан унаж гол төмрийн амны хэсэгт $P_d=300-500$ кг/см² болно. Үүнийг амны даралт гэнэ. Зарим богино гол төмөртэй буунд сумны хошуу нисэн гарах агшинд дарин цэнэг гүйцэд шатаж дуусдаггүй учир энэ үе шат байдаггүй /ПМ, АПС, ТТ гэх мэт/. Гол төмрийн сувгаар сумны хошуу гарах үеийн хурдыг анхны (V_0) хурд гэнэ.

Гуравдугаар үе шат: Гуравдугаар үе шат буюу хийн нөлөөллийн дараах үе шат нь гол төмрийн сувгаас сумны хошуу нисэн гарах агшнаас эхлээд сумны хошуунд дарин хийн үйлчлэл зогсох агшин хүртэл үргэлжилнэ. Энэ үе шатын туршид гол төмрийн сувгаас 1200–2000 м/с хурдтай гардаг дарин хий нь суманд нөлөөлөн түүний хурдыг нэмэгдүүлнэ. Сумны энэхүү хурдыг туйлын (V_{max}) хурд гэнэ. Сумны хошуу туйлын хурданд хүрэх тэрхүү агшинд араас нь түрсэн дарин хийн үйлчилгээ нь агаарын эсэргүүцэлтэй тэнцэж суманд үйлчлэхгүй болдог. Буудлагын зэвсэгт энэ үе шат нь гол төмрийн аман хэсгээс урагш 50 см орчимд байдаг.


Буудах үзэгдлийн үед үүсэх сөрөг хүчин зүйлс: Гол төмрийн сувагт дараах сөрөг хүчин зүйлс илэрдэг. Үүнд:

- Гол төмрийн элэгдэл;
- Гол төмрийн цүлхийлт;

Буудлагын явцад гол төмөр элэгдэнэ. Энэхүү элэгдэх шалтгааныг химийн, механикийн, дулааны гэж гурван үндсэн бүлэгт хуваана. Химийн шинж чанартай шалтгааны нөлөөгөөр гол төмрийн сувагт хаг (тортог) үүсэж, суваг элэгдэнэ. Механикийн шинж чанартай

шалтгааны нөлөөгөөр буудлага болгонд гол төмөр тэлэгдэн эргэж хэвэндээ ордогч гэсэн олон дахин буудсанаас металлын чанар алдагдаж, сувгийн гадаргууд гүн биш хагархайн тор үүснэ. Энэ нь буудлага болгонд нэмэгдэж талбай нь ихэснэ. Дулааны шинж чанартай шалтгааны нөлөөгөөр дарин хийн өндөр температур (гангийн хайлах температураас бараг хоёр дахин их) маш бага хугацаанд болдогч гэсэн гол төмрийн сувгийг хэсэгчлэн хайлуулна. Хайлсан хэсэг хийн урсгалтай хамт сувгаас гадагшилна. Температурын огцом ба хурдан өөрчлөлт нь гол төмрийг тэлэх буюу агшааж, үүний улмаас гол төмрийн ан цав, хагархайг ихэсгэнэ.

Хийн даралт хэтэрхий огцом ихсэхийн улмаас гол төмөр деформацид орсноор цүлхийх буюу задрах үзэгдэл бий болдог. Ялангуяа гол төмрийн сувагт гаднын зүйл орсон үед буудахад, сум түүнд тээглэн хөдөлгөөнөө удаашруулахад, араас түрсэн дарин хий, өндөр даралт үүсгэснээр гол төмрийн бат бэх чанарын тооцоолсон хэмжээнээс хэтэрч гол төмөр цүлхийх буюу задарна.



Гаднын зүйл

2 дугаар зураг. Гол төмрийн цүлхийлт

Зэвсгийн бие анги, аюулгүй байдалд хохирол учруулж, буудлагын үр дүнг бууруулахгүйгээр тодорхой тооны завсарлагаатай буудах, буудлагын хамгийн олон тоог галын горим гэнэ.

Бууны гол төмрийн сувгийн доторх сумны хөдөлгөөнийг судалдаг шинжлэх ухааны дотоод баллистик гэнэ. Шинжлэх ухааны эерэг болон сөрөг хүчин зүйлийг судалснаар буудлагын эцсийн үр дүнд нөлөөлнө. Сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлж чадсанаар гол төмрийн амьдрах чадвар уртсах боломжтой харагдаж байна. Үүнд:

Буудлагын үед дарин хийн ихээхэн даралт



гол төмрийн хананд үйлчилнэ. Ийм үйлчлэл нь гол төмрийн сувагт элэгдлийг бий болгодог. Гол төмөр элэгдэл нь сумны цацралтыг ихэсгэж, сумны хурдыг бууруулдаг. Орчин үед элэгдлийг бууруулах зорилгоор хромлогдсон гол төмрийг ашиглах болсон энэ нь бууны загвар бүр дээр өөр өөр тооны буудалт тэсвэрлэж чадах төдийгүй гол төмрийн насжилтыг уртасгаж байна.

Бууны загвар бүр өөр өөр тооны буудалтыг тэсвэрлэх гол төмрийн даацтай үйлдвэрлэгдэж байна. Гол төмрийн даац элэгдэж зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхээр сумны цацралт ихсэж, сумны хурд буурч байна. Тийм учраас гол төмрийн бат бэх чанарыг хангах үүднээс 1,5–2 дахин нөөц бат бэх чанартай хийдэг болсон байна.

Ашигласан материал:

1. Б.Хадбаатар, “Баллистикийн тухай үндсэн ойлголт” 2014 он, Улаанбаатар хот
2. А.Хүү–Ухна, “Цэргийн зэвсэглэлийн галт хэрэглэл” 2015 он, Улаанбаатар хот
3. С.Түвшинбаяр, “Мэргэн буудагч бэлтгэх гарын авлага” 2011 он, Улаанбаатар хот
4. www.booksite.ru Баллистика
5. www.kaznu.kz Внешняя баллистика



УУЛЫН КАРАБАХЫН РАЙОНД ЯВАГДСАН БАЙЛДААНЫ ТУРШЛАГА, СУРГАМЖ

Б.ЭРДЭНЭБАТ /Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хошууч генерал/
Н.ЛХАМЖАВ /Магистрант

Түлхүүр үг: дайн, технологи, цэрэг, зэвсэг, мөргөлдөөн, туршлага

Key words: war, technology, soldier, weapon, conflict, experience

Оршил:

Монгол орны нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь далайн түвшнөөс 1000 м, түүнээс дээш өргөгдсөн байх бөгөөд түүний дотор баруун бүс нутгийн газар орон нийтдээ далайн төвшнөөс дээш 2500–3500 м өндөр уулархаг районоос бүрддэг. Уламжлалт бус аюул заналхийлэл арилаагүй, харин ч зарим бүс нутагт эрсдэл улам бүр нэмэгдэж байгаа жишээ цөөнгүй. Украинд явуулж буй Оросын цэргийн тусгай ажиллагаа бэлхнээ нотлон харуулж байна. Уулархаг районы онцлог шинж чанар, сүүлийн жилүүдэд явагдсан байлдааны ажиллагааны туршлага сургамжийг чадамгай ашиглах нь байлдааны үүргээ амжилттай биелүүлэхэд эерэг нөлөөтэй.

Үндсэн хэсэг:

Уулын Карабахын улс төр, хүн ам зүйн түүх ширүүн маргаантай байдаг. Бүс нутгийн дийлэнх үндэстэн Армян хүн амын дийлэнх нь Уулын Карабах дахь түүхэн оршин суугчид давамгайлсан гэж үздэг. 18–р зууны сүүлийн хагаст энэ бүс нутаг нь 19–р зууны эхээр Оросын эзэнт гүрэнд эзлэгдэхээс өмнө Иранд албан ёсоор захирагдаж байсан хагас бие даасан Түрэгийн (эрт Азербайжан) хаант улсын томоохон Карабах хант улсын төв болжээ. 1832 он гэхэд тус бүс нутгийн нэгэн эрдэмтний үзэж байгаагаар Армянчууд Уулын Карабахын өндөрлөг газарт "хүн амын дийлэнх хувийг бүрдүүлсэн" бөгөөд өмнө нь Уулын Карабахын нэг хэсэг байсан томоохон нутаг дэвсгэрийн хүн амын гуравны нэг орчим хувийг эзэлж байжээ¹.

Кавказад богино бөгөөд шийдэмгий дайн 2020 оны 9–р сарын 27–нд дэгдсэн нь ирээдүйд болох дайн байлдааны ажиллагааны дүр төрхийг харуулж өгсөн юм. Азербайжан, Армени хоёрын дунд үргэлжилсэн дайн уулархаг газар оронд 44 хоног үргэлжилж, Армени бууж өгч, Азербайжаны ялалтаар өндөрлөсөн².

Зөвлөлт холбоот улс /ЗХУ/ задарч олон тусгаар улс байгуулагдсанаас хойших үед гарсан хамгийн хөнөөлтэй зэвсэгт мөргөлдөөн бол Уулын Карабахын мөргөлдөөн болно. Үүнийг зарим эх сурвалжид Карабахын хоёрдугаар дайн, гэж нэрлэсэн байдаг. Энэ дайн Кавказ орчмын уулархаг газар орон дээр явагдсан бөгөөд 2020 оны 9 дүгээр сарын 27–ноос 10 дугаар сарын 10–ыг хүртэл үргэлжилсэн байна.

Жин, овор ихтэй байлдааны хүнд техникийг ийм газар орны нөхцөлд ашиглах нь байлдааны ажиллагаанд ихэнхдээ сөрөг нөлөө үзүүлэх ба зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй нэгтгэл, ангиуд нь эсрэг талдаа гэнэтийн хүчтэй цохилт өгөх боломжоор эрс хязгаарлагддаг байна. Үүнд нөлөөлж байгаа голлох хүчин зүйл нь, зам харилцаа, уул даваа, байгалийн бартаа зэрэг болно.

Байлдааны ажиллагааны эхний үе шатанд Армяны тал, хөнгөн зэвсэглэсэн явган цэргийн байлдаан явуулахаас илүүтэйгээр хүнд техник бүхий мотобуудлагын салбарыг байлдаанд оруулж байснаас уулын хавцал, даваа ихтэй газарт отолтод орж багагүй хохирол амсаж байв. Ингэж газар орны хүчин зүйлийг зөв авч үзээгүйн учир Азербайжаны талд давуу байдал, илүү боломж олгосон байдаг.

¹ George A. Bournoutian, trans., *Two Chronicles on the History of Karabagh* (Costa Mesa, CA: Mazda Publishers, 2004), p. 24 (n. 1).

² <https://api.army.mil/e2/21-655-nagorno-karabakh-2020-conflict-catalog-aug-21-public.pdf> (army.mil)



Армянчууд сүүлд нь маневрлах чадвар сайтай хөнгөн зэвсэглэсэн анги, салбарыг байлдаанд оруулах оролдлого хийж байлдааны ажиллагааны театр руу илгээж эхэлсэн хэдий боловч, тэдний шилжилт хөдөлгөөнийг урьдчилан тооцож, ашигтай зааг эзэлж амдан байлдаж чадсан Азербайжан илэрхий давуу боломжтой болсон байлаа.

Эх сурвалж: Конгрессын судалгааны алба (CRS), өгөгдлийг ашиглан АНУ-ын Төрийн департамент, ESRI, Garmin, ArcWorld.

Энэ нь уулархаг газар орон дээр бол зөөврийн хөнгөн зэвсэгтэй, тусгай зориулалтын агсамж, тоноглол бүхий, уулархаг газар оронд байлдах сургууль дадлага хийж бэлтгэгдсэн уулын хөнгөн явган цэрэгтэй тал нь илэрхий давуу байдалтай болж, байлдааны санаачилгыг гартаа авч болдгийг энэ дайны тактикийн ажиллагааны туршлага харуулсан байна.

2020 оны Карабахын мөргөлдөөнд, танкийн цэргийн ангийн үүрэг багасаж, харин байлдааны дрон, танк эсэргүүцэх пуужингийн цогцолбор, өөрөө явагч артиллерийн хэрэгцээ шаардлага нэмэгдэж, улмаар ач холбогдол нь өссөн байгааг ажиглаж болох байна.

Азербайжан, Армян хоёр улс, аль аль нь нэлээд тооны сөнөөгч, бөмбөгдөгч онгоцтой боловч тэдгээрийг байлдаанд ашиглахгүй байсан шалтгаан нь, Уулын Карабах хавь нутгийн районд, агаарын довтолгооноос хамгаалах цэргийн зэвсэг техник олон тоогоор байрласан, өөрөөр хэлбэл, агаарын довтолгооноос хамгаалах системийг тэр хавьд нь маш сайн төхөөрөмжилж бэлтгэсэн байсныг харуулж байна.

Энд, юуны өмнө ОХУ-д үйлдвэрлэсэн С-300, С-400 цогцолборууд Карабахын агаарын орон зайг хянаж байдаг ажээ. Нөгөөтээгүүр уулархаг районд буюу уулын бүсэд болж буй тулалдаанд нисэх хүчнийг ашиглах явдал үр дүн муутай байдгийг бас давхар нотолсон нэг туршлага гэж болно.

Эдгээр шалтгааны улмаас, галын шугам дээр бодит байдалд, танкийн ангиуд, танк эсэргүүцэх салбарын хооронд гол тулалдаан

явагдаж, дайтагч талууд эсрэг талын танк, хуягт машиныг болон пуужин харвах төхөөрөмжийг устгах зорилгоор янз бүрийн зориулалтын, том жижиг олон янзын дроныг өргөн ашигласан байдаг.

1 дүгээр хүснэгт

Д/д	Улс орон	Зенит пуужингийн цогцолбор	Нисдэг тэрэг	Байлдааны онгоц
1.	Азербайжан	45	35	57
2.	Армян	20	31	19

Азербайжан, Армяны зэвсэгт хүчний бүтэц дэх АДХ хэрэгслийн харьцаа

Дайны эхлэл үед, Азербайжаны АДХ цэргийн хүч хэрэгсэл, цогцолбор нь Армяны талын цэрэг зэвсэглэлд бараг бүрэн шахам гэхээр хохирол учруулсан байдаг. Оперативын хувьд үүссэн хүч хэрэгслийн энэ тэнцвэргүй байдал дайн дуустал шахам хадгалагдсан байна.

Үүний гол шалтгаан нь Армяны тал, өөрийн АДХ цэргийн зэвсэглэл бусад цогцолборыг оновчгүй байрлуулж, хүч хэрэгслээ тооцоо муутай ашиглаж байсан явдал гэж үздэг. Армяны хувьд хүчин чадлыг ийнхүү үлэмж бууруулахад хүргэсэн гол нөхцөл бол Азербайжаны талын нисгэгчгүй нисэх аппаратууд энэ байлдааны туршид Карабахын агаарын орон зайд ноёлж байсан явдал гэж үздэг.

Уулархаг районд нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашигласан байлдааны туршлага сургамж

Азербайжан улс нисгэгчгүй нисэх онгоцны систем (UAS) –ийг ашигласан нь уулархаг нутаг дахь Арменийн хүчний галын шууд болон шууд бус давуу талын боломжийг бууруулсан. UAS (нисгэгчгүй нисэх онгоцны систем)–ын аюулын эсрэг үр дүнтэй агаарын довтолгооноос хамгаалах хэрэгсэл байхгүй байсан нь Азербайжаны хүчинд фронтын шугамыг бэхжүүлэх, фронтын аль нэг довтолгооны байрлал руу шилжих Арменийн нөөцийн ангиудыг илрүүлж, довтлох боломжийг олгосон³.

³ How Secure Tactical Video Transmission Impacted the Second Nagorno-Karabakh War By John Antal

Азербайжанчууд хамгаалагдсан, шийдэмгий дайсны эсрэг хурдан бөгөөд шийдэмгий ялалт байгуулахын тулд хөндлөнгийн маневр хийх хувилбараа гүйцэтгэсэн. Үүнд хүрэхийн тулд Азербайжанчууд 24 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийж, Турк, Израилын хамгийн сүүлийн үеийн нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV) болон тэнхлэгийн зэвсгийг (LMs) худалдан авч, хүчээ сайжруулсан. Азербайжан эдгээр зэвсгийг дайнд үр дүнтэй ашигласан нь гайхалтай байв.



BAYRAKTAR TB2 нь цахилгаан оптик тагнуул, тандалт, зорилтот зорилгод Aselsan Common Aperture Targeting системийг (CATS) ашигладаг Туркийн дунд өндрийн урт тэсвэрлэх чадвартай (ЭРЭГТЭЙ) нисгэгчгүй байлдааны хөлөг (UCAV) юм. TB2 дээрх гэрэл багатай, хэт улаан туяаны өндөр нягтралтай камерууд нь байлдааны орон зайн нүдийг анивчихгүй болгодог. Азербайжанчууд 2-р Уулын Карабах дайнд TB2-ийн Full Motion Video (FMV) чадварыг ашигласан.

Азербайжаны агаарын довтолгоонуудын няцашгүй хурд, нарийвчлал, эсрэг талдаа хохирол үзүүлэх чадвар нь Армянчуудыг сүйрүүлж, мохоож, Азербайжаны ялалтад тодорхой үүрэг гүйцэтгэсэн. Эдгээр системүүд дайнд дангаараа алж чадаагүй бөгөөд дайны үеийн олон хэвлэлд UAV-уудыг хэт их шуугиан дэгдээсэн боловч дээд зэргийн довтолгооны системүүдийн өгсөн өндөр нарийвчлалтай бүрэн хөдөлгөөнт видеоны (FMV) нөлөөлөл нь энэхүү мөргөлдөөнийг " нисгэгчгүй онгоцны дайн." Азербайжанчууд мэдрэгч-буудагчийн нэгдлийг сайжруулах, байлдааны хохирлын үнэлгээг авах, мэдээллийн дайнд ялахын тулд суртал ухуулгын зорилгоор өөрсдийн системийн аюулгүй FMV чадавхыг ашигласан.

Азербайжаны тал нисгэгчгүй нисэх төхөөрөмжийнхөө FMV видео өндөр чанартай бичлэгийг нийгмийн цахим сүлжээнд

байршуулж ашигласан нь эсрэг талдаа сэтгэл зүйн дайралт хийх шинэ тактик байсан бөгөөд ирээдүйн дайн мөргөлдөөнд ч ашиглагдаж байна.

Азербайжаны хүчин чармайлтын эхний үе шат нь Арменийн агаарын довтолгооноос хамгаалах, команд, удирдлагын (C2) сүлжээг устгахад ердийн их буу, пуужингаас гадна шинээр олж авсан өндөр технологийн UAV болон LM-ийг ашиглах явдал байв. Тэд дайны эхний долоо хоногт үүнийг хийсэн. Орост үйлдвэрлэсэн хуучин системүүдээс бүрдсэн Арменийн агаарын довтолгооноос хамгаалах хэрэгсэл нь Азербайжаны нисгэгчгүй нисэх онгоц болон LM-ийн довтолгоог зогсоож чадаагүй юм. Арменийн агаарын довтолгооноос хамгаалах систем ажиллаж байх үед ч агаарын дээд довтолгооны зэвсэг агаарын орон зайд нэвтэрч, хамгаалагчдыг устгасан. Азербайжан улс дайны үед олон төрлийн UAV ашиглаж байсан бөгөөд хамгийн үр дүнтэй, алдартай нь Туркт үйлдвэрлэсэн BAYRAKTAR TB2 (Туркийн хамгаалалтын компани Baykar), Израилд үйлдвэрлэсэн HAROP (Israel Aerospace Industries), Израилын бүрэн бие даасан SKYSTRIKER (Elbit Systems).



HAROP-ыг ачааны машинаас хөөргөх боломжтой бөгөөд нэг ачааны машинд 12 ширхэг байлдааны сум, эсвэл агаараар хөөргөх боломжтой. (IAI зураг)

Азербайжанд ашигладаг хамгийн боловсронгуй UAV болон LM-ийн цахилгаан оптик мэдрэгчүүд нь хамгийн сүүлийн үеийн хэт улаан туяаны (IR) болон бага гэрэлтэй, өндөр нарийвчлалтай телевизийн (HDTV) камерууд бөгөөд тактикийн видео тагнуул, тандалт, зорилтот чиглэлтийг гүйцэтгэдэг өгөгдөл. Дайны үед TB2 нь довтолгооны платформ болон бусад UAV, LM, их буу, пуужин,



танк эсэргүүцэх ухаалаг пуужингийн байг тодорхойлж, тодорхойлоход зориулсан "тэнгэр дэх нүд" болж ажиллаж байсан. TB2 нисгэгчгүй нисэх онгоц нь тусгайлан цохилт өгөх бүс дэх Арменийн хүчнийг тодорхойлж байх хооронд LM-ууд бие даан эргэлдэж, тэдний байг автоматаар баталгаажуулж, улмаар хохирогчид руу шумбаж 23 кг (51 фунт) байлдааны хошуугаа камиказе маягийн дайралтаар дэлбэлэв. Харвахаасаа өмнө HAROP-уудыг хөөргөхөөс өмнө урьдчилан тодорхойлсон цохилтын бүс рүү бие даан нисэхээр програмчилсан. Тэнд очсон хойноо тэд тэнүүчилж, хүний оператор зорилтот хайлт, довтолгоонд зориулж нэг LM сонгох боломжтой бол бусад нь үе үе хянагддаг. IAI-ийн мэдээлснээр, "Оператор сонгосон LM-ийг зорилтот хэсэг рүү чиглүүлж, видео дүрсийг ашиглан байг сонгож, довтолоход ашигладаг. HAROP нь байг мөрдөж, дараа нь түүн рүү шумбаж, цохих үед байлдааны хошуугаа дэлбэлдэг. Шаардлагатай бол халдлагыг зогсоож, оператор ижил LM-ээр дахин довтолж болно." Хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь HD камерын систем бөгөөд оператор нь байлдааны талбарын нөхцөл байдлын талаар ойлголттой болж, LM-ийг операторын тодорхойлсон бай

руу довтолоход чиглүүлэх боломжийг олгодог.

Дүгнэлт

Карабахын мөргөлдөөний явц туршлагаас харахад тэд агаарын цэргийн хүчнээ буюу байлдааны онгоц, галын дэмжлэгийн нисдэг тэрэг зэргийг байнга бэлэн байдалд байлгаж үндсэндээ оновчтой ашиглаж чадсан гэхдээ хязгаарлагдмал хүрээнд хэрэглэж байсан ажиллагаа болно.

Цэрэг, зэвсгийн хүчин чадлын хувьд ялангуяа агаарын довтолгооноос хамгаалах цэргийн зэвсэг, техник, бусад хэрэгслийн хувьд ойролцоо түвшинд байсан хоёр улс, орчин үеийн цэргийн ажиллагааны түүхэнд анх удаа нисгэгчгүй нисэх хэрэгслийг буюу дроныг олноор нь байлдаанд өргөнөөр хэрэглэсэн туршлага эндээс харагдаж байна. Гэхдээ дроныг олноор нь хэрэглэж чадсан Азербайжан байлдаанд давамгайлсан нь бас анхаарч тооцох ёстой туршлага сургамж гэж үзнэ.

Үүнийг анхаарч тооцвол ойрын ирээдүйд явагдаж болзошгүй зэвсэгт мөргөлдөөн, байлдааны ажиллагаа зэрэгт янз бүрийн зориулалтын дронууд ихээхэн үүрэгтэй байх нь ажиглагдаж байна.

Ашигласан материал:

1. George A. Bournoutian, trans., *Two Chronicles on the History of Karabagh* (Costa Mesa, CA: Mazda Publishers, 2004), p. 24 (n. 1).
2. *How Secure Tactical Video Transmission Impacted the Second Nagorno-Karabakh War* By John Antal
3. <https://api.army.mil/e2/21-655-nagorno-karabakh-2020-conflict-catalog-aug-21-public.pdf> (army.mil)
4. U.S.ARMY GUIDE TO MILITARY MOUNTAINEERING 2014. Infantry Small-Unit Mountain Operations Army Tactics Techniques Procedures 3-21.50

